



GOVERNMENT OF
MONGOLIA
MINISTRY OF LABOUR AND
SOCIAL PROTECTION



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ (ОБҮДХЭТ)

P174116

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРЫН
АВЛАГЫН ХАВСРАЛТ D.

БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГМИЙН
УДИРДЛАГЫН ХҮРЭЭ

Улаанбаатар хот

2021 оны 06 дугаар сар

Агуулга

| | |
|---|-----------|
| 1. Танилцуулга | 4 |
| 1.1. Төслийн хөгжлийн зорилго | 5 |
| 1.2. Төслийн бүрэлдэхүүн хэсэг | 5 |
| 1.3. Газар зүйн хамрах хүрээ болон төслийн үр шим хүртэгчид | 7 |
| 1.4. Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөлөл | 9 |
| 2. Байгаль орчин ба нийгмийн удирдлагын хүрээ | 13 |
| 2.1. Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн бодлого, стандартууд ба төслийн уялдаа | 14 |
| 2.2. Монгол улсын хууль, эрх зүйн орчин болон Дэлхийн банкны холбогдох шаардлагын зөрүүтэй байдлын шинжилгээ | 18 |
| 2.3 Төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн үндсэн мэдээлэл | 28 |
| 3. Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийг удирдахтай холбоотой үндсэн чиг үүрэг | 31 |
| 3.1 Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний хэрэгжилт | 31 |
| 3.2 Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн нөхцөл | 31 |
| 3.3 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх жижиг хэмжээний барилгын ажлын байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах | 32 |
| 3.4 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дэмжигдсэн бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчны эрсдэлийг арилгах, нийгэмд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх | 34 |
| 3.5 КОВИД-19 цар тахлаас ажилтны болон нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ | 39 |
| 3.6 Авлига, хээл хахууль | 40 |
| 3.7 Талуудын оролцоо болон мэдээллийн ил тод байдал | 40 |
| 4. Гомдол барагдуулах механизм (ГБМ) | 41 |
| 4.1 Гомдол барагдуулах үндэсний механизм | 42 |
| 4.2 (ОБҮДХЭТ)-ийн тусгай өргөдөл, гомдол барагдуулах механизм | 42 |
| 4.3 Өргөдөл, гомдлын мэдээлэл болон тайлагналт | 45 |
| 4.4 Гомдол барагдуулах механизмын талаарх мэдээлэл, сурталчилгааны ажил | 46 |
| 5. БОНУХ-г хэрэгжүүлэх байгууллагын зохион байгуулалт | 46 |
| 6. БОНУХ-ны хэрэгжилтийн хяналт, хяналт-шинжилгээ, тайлагналт | 47 |
| 7. Чадавх бэхжүүлэх | 48 |

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

| | |
|---------|--|
| ЁЗД | Ёс зүйн дүрэм |
| БОУАД | Байгаль орчны үйл ажиллагааны дүрэм |
| БОЭМАБ | Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал |
| БОНБУ | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ |
| БОН | Байгаль орчин ба нийгмийн |
| БОНХ | Байгаль орчин ба нийгмийн хүрээ |
| ХЭДСГА | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлага |
| БОНХТ | Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө |
| БОНУХ | Байгаль орчин ба нийгмийн удирдлагын хүрээ |
| БОНС | Байгаль орчин ба нийгмийн стандарт |
| БОНТ | Байгаль орчин ба нийгмийн тойм |
| БОНУС | Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем |
| СБ | Санхүүгийн байгууллага |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| ЖСХ | Жендерт суурилсан хүчирхийлэл |
| ГБМ | Гомдол барагдуулах механизм |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| ОУСБХБ | Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк |
| ОУХА | Олон улсын хөгжлийн ассоциаци |
| ХУТ | Хөдөлмөрийн удирдлагын төлөвлөгөө |
| ХХҮХ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс |
| БОНБҮТХ | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль |
| БОХТХ | Байгаль орчныг хамгаалах тухай хууль |
| ХШҮ | Хяналт-шинжилгээ, үнэлгээ |
| ОБҮДХЭТ | Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| СЯ | Сангийн яам |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХАБЭА | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй |
| ОСБ | Оролцогч санхүүгийн байгууллага |
| ТХЗ | Төслийн хөгжлийн зорилго |
| ТХН | Төсөл хэрэгжүүлэх нэгж |
| ӨАТТА | Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал |
| ХНХСИ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт |
| НД | Нийгмийн даатгал |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| УОК | Улсын онцгой комисс |
| ТОТ | Талуудын оролцооны төлөвлөгөө |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| АД | Ажлын даалгавар |
| МТБОС | Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |

1. Танилцуулга

Монгол Улсад хэрэгжүүлэх “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)¹-ийг Дэлхийн банкны санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) хэрэгжүүлэн ажиллана.

Төслийг 2020 оны 6-р сарын 19-ний өдөр баталсан бөгөөд 2020 оны 11-р сарын 9-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. ОБҮДХЭТ нь ХНХЯ-аас хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн үргэлжлэл байх болно. ХНХЯ-аас ОБҮДХЭТ-ийн үйл ажиллагааны гарын авлагыг бэлтгэсэн бөгөөд энэхүү гарын авлагын Хавсралт D-д “Байгаль орчин ба нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-г авч үзсэн. ОБҮДХЭТ-ийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээг ХНХЯ бүрэн хариуцах бөгөөд энэхүү БОНУХ нь төсөлд оролцогч талуудын “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” (БОНХТ)-г хэрэгжүүлэх цар хүрээг тодорхойлох зорилготой юм. Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-д дараах зүйлсийг хамруулан авч үзсэн. Үүнд:

- (i) төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн эрсдэл болон эдгээрийн нөлөөллийг тогтоох;
- (ii) хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн болон оролцогч талуудын үйл ажиллагаатай холбоотой удирдамж болон дүрэм, журмыг тодорхойлох;
- (iii) дэд төсөл болон гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээний үр нөлөө, эрсдэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тодорхойлох
- (iv) төслийг хэрэгжүүлэх хугацааны туршид КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлыг удирдах төслийн менежментийг тодорхойлох
- (v) БОНУХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа.

БОНУХ-ний гол хэрэглэгчид нь төслийг хэрэгжүүлэгч буюу ХНХЯ, яамны харьяа байгууллагууд болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд болон төслийн хэрэгжилтэд оролцож буй гол оролцогч талууд болох оролцогч санхүүгийн байгууллагууд (ОСБ), сургалтын байгууллага, жижиг хэмжээний засварын ажлын гэрээт гүйцэтгэгчид болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байна.

ХНХЯ нь холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Дэлхийн Банктай харилцах бүх зохицуулалтын үүргийг гүйцэтгэх бөгөөд ТХН-ээс БОНУХ-д тусгагдсан асуудлуудын хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэх ажлыг дэмжиж ажиллана. БОНУХ нь хэд хэдэн баримт бичгээс бүрдэх бөгөөд дараах хавсралтуудыг багтаасан болно.

Хавсралт 1: Хөдөлмөрийн удирдлагын төлөвлөгөө (ХУТ);

Хавсралт 2: Дэлхийн банкны асбестын менежментийн удирдамж (жижиг хэмжээний дотоод засварын ажилд зориулагдсан);

Хавсралт 3: Байгаль орчны үлгэрчилсэн дүрэм (БОУД) (жижиг хэмжээний дотоод засварын ажилд зориулагдсан);

Хавсралт 4: Засварын ажил гүйцэтгэгчийг хянах хяналтын хуудас (жижиг хэмжээний дотоод засварын ажилд зориулагдсан);

Хавсралт 5: Хориглох үйл ажиллагааны жагсаалт (бичил зээлийн хувьд);

Хавсралт 6: Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдамж (жижиг зээл

¹ ОБҮХХЭДТ нь ХНХЯ-аас хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн үргэлжлэл байна.

олгоход зориулсан);

Хавсралт 7: Талуудын оролцооны төлөвлөгөө (ТОТ) болон гомдол барагдуулах механизм.

Хавсралт 8: Бичил бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тайлангийн маягт

ХНХЯ болон түүний Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь Банкны урьдчилан сэргийлэх арга хэмжээний бодлогын талаар тодорхой туршлагатай боловч 2018 онд батлагдсан Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ) болон Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)–ын талаар туршлага багатай байна. Энэхүү туршлага багатай байдал нь төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй тул БОНУХ-нд төслийн чадавхыг бэхжүүлэх тусгайлсан төлөвлөгөөг боловсруулсан болно (Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний дагуу).

Энэхүү БОНУХ нь тогтсон баримт бичиг биш бөгөөд төслийн үйл ажиллагааны цар хүрээ, нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөх боломжтой юм. Энэ тохиолдолд Дэлхийн банктая нягт зөвлөлдөж, БОНУХ-ний өөрчлөлтийг баталгаажуулна.

1.1 Төслийн хөгжлийн зорилго

“Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) хэрэгжүүлэн ажиллана. Уг төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлд хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

1.2 Төслийн бүрэлдэхүүн хэсэг

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл (ОБҮДХЭТ) нь дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1-р бүрэлдэхүүн хэсэг: Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх

2-р бүрэлдэхүүн хэсэг: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх

3-р бүрэлдэхүүн хэсэг: Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон төслийн менежментийг сайжруулах

4-р бүрэлдэхүүн хэсэг: КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан заавал даатгуулагчдад түр хугацааны шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг болно.

Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хүрээнд хийгдэх ажлуудыг товч байдлаар дурдвал:

1-р бүрэлдэхүүн хэсэг: Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх

1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй, ил тод бус байдал болон хангалттай, бүрэн гүйцэт мэдээлэлгүйгээс ажил хайхад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх бөгөөд энэ хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- (а) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн ажлын зохион байгуулалтыг боловсронгуй, оновчтой болгох;
- (б) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем (ХЗЗМС)² -ийг турших, нэвтрүүлэх ажлыг зохицуулах;
- (в) ХХҮЕГ-ын хөдөлмөр, эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх хэсгийг (сонгосон) тохижуулах, шинэчлэх
- (г) Техникийн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах замаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ хариуцсан ажилтнуудын (төрийн) чадавхыг бэхжүүлэх;
- (д) Хөдөлмөрийн эрхлэлтийн төрийн үйлчилгээг хөдөлмөрийн хувийн биржүүдийн үйл ажиллагаатай уялдуулан хамрах хүрээг өргөжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх (чиг үүргийн шинжилгээ хийх, хувийн болон төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг сурталчлах гэх мэт арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.)

2-р бүрэлдэхүүн хэсэг: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх

2-р бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн загвар, хамаарал, эрэлт, хэрэгцээг бэхжүүлэхэд чиглэнэ. Энэ хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- (а) (Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.1) Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг үзүүлэх замаар бичил бизнес эрхлэгчдэд цогц дэмжлэг үзүүлэх. Энэхүү дэд бүрэлдэхүүн хэсэг нь одоогоор бичил бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа болон шинээр бизнесээ эхлүүлж буй хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт зориулан жижиг зээл олгох, жижиг зээлд хамрагдахаар хүсэлт гаргагч болон үр шим хүртэгчдэд зээл авахаас өмнө болон зээл авсны дараа санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх (бизнесийн ур чадварыг хөгжүүлэх сургалт болон менторын үйл ажиллагаа). Жижиг зээлийн дэмжлэгийг Ковид-19 цар тахлын үед хүүгийн хөнгөлөлт байдлаар хэрэгжүүлнэ.
- (б) (Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.2) Ур чадварын инновацын хөтөлбөрийг турших. Энэхүү хөтөлбөр нь ажил хайгч иргэдэд нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадвар олгох гэх мэт зах зээлд эрэлт, хэрэгцээтэй чадварыг олгоход чиглэгдэх болно.

3-р бүрэлдэхүүн хэсэг: Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон төслийн менежментийг сайжруулах

3-р бүрэлдэхүүн хэсэг нь Засгийн газар болон бусад оролцогч талуудад илүү үнэн бодит шийдвэр гаргахад нь туслах хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, тайлагналт, дүн шинжилгээний хамрах хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулах болон төслийн менежмент, хяналт-шинжилгээ, үнэлгээг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. Энэ хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- (а) Ажилгүйдлийн судалгааг гүйцэтгэх;
- (б) Барометрийн судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх
- (в) Ур чадварын инновацын хөтөлбөр болон үүний үйл ажиллагааны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх;

² ХЭДТ-ийн хүрээнд хөгжүүлсэн.

(г) Төслийн удирдлага, хяналт-шинжилгээний үйл ажиллагаа.

4-р бүрэлдэхүүн хэсэг: КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан заавал даатгуулагчдад түр хугацааны шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх

4-р бүрэлдэхүүн хэсэг нь КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажил олгогч болон заавал даатгуулагчдад түр хугацааны шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхэд чиглэгдэнэ. Төслийн хүрээнд шаардлага хангасан ажил олгогч болон тэдгээрийн ажилчдад нэг сарын нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.

1.3 Газарзүйн хамрах хүрээ болон төслийн үр шим хүртэгчид

Монгол Улс нь Азийн хойд хэсэгт оршдог далайд гарцгүй орон бөгөөд 1.6 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Монгол Улс нь гурван сая гаруй хүн амтай бөгөөд үүний 1.3 сая нь тус улсын нийслэл болох Улаанбаатар хотод амьдардаг. Хүн амын нягтралын хувьд нэг хавтгай дөрвөлжин километр 1.9 хүн оногддог буюу хүн амын хамгийн сийрэг суурьшилтай орон юм. Монгол Улс нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хот болон 21 аймаг (муж)-т хуваагддаг бөгөөд Улаанбаатар хот нь дүүрэгт, дүүрэг нь хороодод (хотын тойрог) хуваагддаг.

Харин аймаг нь сумдад (муж), сум нь багт (тосгон) хуваагддаг. Бүрэлдэхүүн хэсэг 1, 2, 3-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт (Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг) хэрэгжинэ. 2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үзэж буй бичил бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа нь үндсэндээ төв, суурин газрын оршин суугчдад чиглэнэ (хөдөлмөрийн зах зээлийн хүндрэл, бэрхшээлийн шинж байдал нь өөр тул хөдөө орон нутагт шууд хэрэгжүүлэхгүй). Гэхдээ суманд оршин суудаг иргэд³ бичил бизнесийн санал, төслөө тухайн аймаг дах урьдчилсан байдлаар дүгнэлт гаргах Ажлын хэсэгт хүргүүлэх боломжтой юм. Бүрэлдэхүүн хэсэг 4-ийн хувьд санхүүжилтийн хязгаарлагдмал байдлаас хамааран Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх боломжгүй байна. Иймээс ядуурлын түвшин хамгийн өндөр байгаа аймаг, дүүргүүдэд хэрэгжүүлнэ.

Төсөл нь 2 төрлийн үр шим хүртэгчтэй байна. Төслийн эхний үр шим хүртэгч нь төслийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн холбогдох үйлчилгээ, дэмжлэгт хамрагдах хүн амын эмзэг бүлгийн ажил хайгч иргэн болон бичил бизнес эрхлэгч байна. Ерөнхийдөө Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан “ажил хайгч” буюу ажилгүй, ажилтай боловч шинэ ажил хайж байгаа иргэн, “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” буюу 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн хамрагдана. Мөн хүн амын эмзэг бүлгийн иргэд гэдэгт “ажил олоход хүндрэлтэй иргэн”, 18-34 насны залуучууд, амьжиргааны түвшин тогтоох судалгааны дүнг үндэслэн тогтоосон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн” орно. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар “ажил олоход хүндрэлтэй иргэн” гэж 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ажилгүй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд (18 нас) хүрээд асрамжийн газраас гарсан иргэнийг хэлнэ.

³ Эдгээр иргэдийг хөдөөгийн оршин суугчид гэж үзнэ.

Төслийн үйл ажиллагааны хүрэх үр дүнг "Хөдөлмөрийн зах зээл дээрх боломжийг хүртээмжтэй хүргэх" гэж тодорхойлсон бөгөөд энэ хүрээнд ажиллах хүчний эрэлт, ур чадварын дутмаг байдал, сул ажлын байрны талаарх мэдээлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломжуудын талаар хангалттай ил тод мэдээлэл хүрч чадахгүй байгаа зэрэг хөдөлмөрийн зах зээлийн нэгдмэл байдалд саад болж буй хүчин зүйлсийг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах болно.

Хоёрдох төслийн үр шим хүртэгч нь сонгогдсон аймаг, дүүргийн зохих шалгуур хангасан түр хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдах ажил олгогч болон түүний ажилтан байна. Монгол Улсын Их Хурлаас (2020 оны 4-р сарын 9-ний өдөр) "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль"-ийг баталсан. Засгийн газраас уг хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг баталсан бөгөөд төслийн хүрээнд авч үзэж буй "шаардлага хангасан ажил олгогч" болон "шаардлага хангасан ажилтан" гэдэг нь уг журамд заасан "Ковид-19 цар тахлын улмаас эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа нь хүндэрч байгаа хэдий ч ажлын байраа хадгалж буй хувийн хэвшлийн байгууллагууд" болон түүний "заавал даатгуулагч ажилтан" байна. Энэхүү хөнгөлөлт, чөлөөлөлтөд 2020 оны 4-р сарын 1-ээс 2020 оны 10-р сарын 1 хүртэлх хугацааны цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогод ногдуулсан нийгмийн даатгалын шимтгэлийг хамруулах бөгөөд даатгуулагчийг энэ хугацаанд шимтгэл төлсөн гэж тооцно.

Хуулийн дагуу нийгмийн даатгалын чөлөөлөлтөд төрийн өмчит их, дээд сургууль, коллежоос бусад төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, тэдгээрийн харьяа байгууллагад ажилладаг даатгуулагч болон гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламжаар бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэж буй хуулийн этгээдийн тухайн төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс хөдөлмөрийн хөлс авч байгаа даатгуулагч хамрагдахгүй.

Хүснэгт 1-т төслийн үр шим хүртэгчдийг харуулав.

| № | Бүлэг | Тодорхойлолт | Бүрэлдэхүүн хэсэг |
|---|-------------------------------------|--|---------------------------|
| 1 | Ажил хайгч | <ul style="list-style-type: none"> Ажилгүй иргэн Ажилтай боловч шинэ ажил хайж байгаа буюу нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэн | Бүрэлдэхүүн хэсэг 1, 2, 3 |
| 2 | Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч | <ul style="list-style-type: none"> 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн | Бүрэлдэхүүн хэсэг 2 |
| 3 | Ажил олоход хүндрэлтэй иргэн | <ul style="list-style-type: none"> 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн, Хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хорих ангиас суллагдсан иргэн Хөдөлмөрийн насанд (18 нас) хүрээд асрамжийн газраас гарсан иргэн | Бүрэлдэхүүн хэсэг 1, 2 |
| 4 | 18-34 насны залуучууд | <ul style="list-style-type: none"> Коллеж, их дээд сургууль төгсөгчид МСҮТ, коллеж, их дээд сургууль төгсөгчид | Бүрэлдэхүүн хэсэг 1, 2 |

| | | | |
|--|--|---|------------------------|
| | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн буюу иргэн | <ul style="list-style-type: none"> Амьжиргааны түвшин тогтоох судалгааны дүнг үндэслэн тогтоосон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны гишүүн | Бүрэлдэхүүн хэсэг 1, 2 |
| | Шаардлага хангасан заавал даатгуулагч | <ul style="list-style-type: none"> “Ковид-19 цар тахлын улмаас эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа нь хүндэрч байгаа хэдий ч ажлын байраа хадгалж буй хувийн хэвшлийн байгууллагууд” болон түүний ажилтнууд | Бүрэлдэхүүн хэсэг 4 |

1.4 Төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөлөл

ОБҮДХЭТ-д учирч болзошгүй байгаль орчин болон нийгмийн эрсдэл, нөлөөлөл болон эдгээр эрсдэлийг удирдах институтийн чадавхад үүсэх эрсдэлийг төслийн бэлтгэл ажлын явцад үнэлсэн.

(i) Байгаль орчны эрсдэл

Төслийн нийт байгаль орчны эрсдэл нь **дунд зэрэг** байна. Төслийн үйл ажиллагаанаас хүлээгдэж буй нөлөөлөл нь ерөнхийдөө орон нутгийн шинжтэй, хязгаарлагдмал, түр зуурын шинжтэй тул боломжит арга хэмжээг авах замаар эрсдэлээс зайлсхийх, багасгах боломжтой бөгөөд урт хугацааны, их хэмжээний эсвэл эргэлт буцалтгүй сөрөг нөлөөлөл байхгүй байна. Төсөл нь эрчим хүч, ус, олборлох аж үйлдвэрлэлийн нөлөө бүхий хэрэглэгч биш бөгөөд агаарын бохирдлыг үүсгэгч утааны эх үүсвэрт хамааралгүй юм. Мөн төсөл нь биологийн олон төрөлт байдал болон байгалийн амьдрах орчны бүсэд их хэмжээний сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж тооцож байна.

Байгаль орчны эрсдэл болон нөлөөллийг даван гарахад дараах үйл ажиллагаануудыг авч үзнэ. Үүнд:

1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжих Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын оффисын сонгогдсон хэсэгт гүйцэтгэх богино хугацааны буюу жижиг хэмжээний засвар, шинэчлэлийн (үүнд хурлын өрөө, уулзалтын өрөө, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний танхим орно.) ажлын явцад үүсэж болзошгүй дуу чимээ, тоос шороо, хатуу хог хаягдал болон ХАБЭА-н асуудлуудыг иргэний барилга болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны үйл ажиллагааны холбогдох журмыг хэрэгжүүлэх замаар багасгах боломжтой. Энэ хүрээнд бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал болон хог хаягдлыг зайлуулах менежмент сул байх зэргээс байгаль орчны асуудал үүсгэж болох юм. Төв, суурин газрын зарим бизнес эрхлэгчид нь хотын ногоон байгууламж (жишээлбэл, цэцэрлэгт хүрээлэн) болон усан санг өөрийн хэрэгцээнд ашиглах болон хил хязгаарыг давах зэрэг эрсдэл гарч болох юм. Мөн ажилчдын болон хүрээлэн буй орчинд амьдарч буй иргэдийн амар тайван байдлыг алдагдуулахгүй байх нь чухал асуудал юм.

(ii) Нийгмийн эрсдэл болон нөлөөлөл

Төслийн нийгмийн эрсдэл нь **дунд зэрэг** байна. Төслийн хүрээнд хүмүүсийг нүүлгэн

шилжүүлэх, албадан тараан суурьшуулах, хувийн эзэмшлийн газар худалдаж авах зэрэг эрсдэл байхгүй байна. Төсөлд хамгийн эмзэг бүлгийн иргэд болон аж ахуйн нэгжийг хамруулж байгаа тул хүн амын эмзэг бүлгийн иргэд болон аж ахуйн нэгжийг хамруулахгүй байх эрсдэл бага байна. Өөрөөр хэлбэл, төслийн үр шим хүртэгчид буюу ялангуяа ажилгүй иргэд, ажил олоход хүндрэлтэй иргэд, залуучууд, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд эерэг нөлөө үзүүлнэ. Дээр дурдсан Хүснэгт 1-т үндсэн үр шим хүртэгчдийн бүлгийг харуулсан.

Бүрэлдэхүүн 1 нь нэн ялангуяа эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн 2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийн үр шим хүртэгчдийг (одоо үйл ажиллагаа эрхэлж байгаа болон үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа бичил бизнес эрхлэгчид) тэдгээрийн эмзэг байдал, хөтөлбөрөөс үр шим хүртэх магадлалыг тэнцвэртэй авч үзэн сонгох болно.

2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 1400 орчим үр шим хүртэгчид дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд нэг үр шим хүртэгчид 5-10 сая төгрөгийн зээлийг олгоно. Зээлийн эрсдэл өндөр, эрсдэлтэй эмзэг бүлгийн иргэдийг зээлд хамруулахдаа өргөдөл гаргагчийн бизнесийн туршлага болон тодорхой бизнесийн оновчтой төлөвлөгөө, аж ахуйн нэгжийн амжилтад хүрэх магадлал, эмзэг байдал зэргийг харгалзан 3-5 сая төгрөгийн зээлийг олгоно.

Жижиг зээлийг бичил бизнес эрхлэгч нарт олгохтой холбоотой тухайн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх зарим нийгмийн эрсдэл үүсэж болох бөгөөд үүнийг холбогдох хяналт болон сонгон шалгаруулалтын шалгуураар шийдэх боломжтой юм. Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.2 нь эмзэг бүлгийн ажил хайгч иргэн, ялангуяа залуучуудад чиглэгдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 3-т хийгдэх судалгааны ажил нь ажилгүйдэл, ур чадварын үл нийцэл, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх зэрэг бодлогын тулгамдсан асуудлуудад чиглэгдэх бөгөөд энэ нь төслийн үр шим хүртэгчдэд шууд бус нөлөө үзүүлэх болно.

Төслийн 4-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй КОВИД-19 цар тахлын үед албан журмын даатгалд хамрагдагч шаардлага хангасан ажил олгогч болон түүний ажилтнуудыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх асуудлыг шууд дэмжиж ажиллана. Уг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 150,000 орчим ажиллагсад болон тэдгээрийн ажил олгогч нарын өмнөөс нэг сарын хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх болно. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн үр шим хүртэгчид нь Үндэсний статистикийн хорооноос зарласан ядуурлын түвшин хамгийн өндөр байгаа аймаг, дүүргийн иргэд байна.

Төслийн хүрээнд төслийн үр шим хүртэгчдийг хүйсийн хувьд адил тэгш байдлаар хамруулах, тэгш боломж хүртэх нөхцөлийг бүрдүүлэхийг эрмэлзэх бөгөөд төслийн үйл ажиллагаанд шууд оролцогч болон зөвлөхийн ажил гүйцэтгэх эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш боломжийг олгох болно. Төслийн эцсийн болон явцын үр дүнг хэмжихдээ эдгээр үзүүлэлтийг анхаарч үзэх болно.

2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд олгож буй жижиг зээлийн үр шим хүртэгчдийн 50-иас доошгүй хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчид байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Мөн төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эерэг нөлөө үзүүлэх болно. Нэгдүгээрт, ХХҮЕГ-ын оффисын барилгын сонгосон хэсэгт жижиг хэмжээний засвар, шинэчлэлийн ажлыг хийхдээ ХЭДТ-ийн туршлага дээр үндэслэн тэргэнцэртэй иргэд үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх болно. Хоёрдугаарт, хүн амын эмзэг бүлгийн ажилчид, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төрөөс үзүүлж буй

хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллана. Монгол улсын баруун хязгаарт буюу Баян-Өлгий аймагт голчлон оршин суудаг Казах иргэдийг үндэстний цөөнх гэж үздэг бөгөөд төсөл нь олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны материалыг эдгээр иргэдэд зориулан Казах хэл дээр бэлтгэн гаргах болно.

Төслийн хүрээнд хүмүүсийг биечлэн нүүлгэн шилжүүлэх, албадан нүүлгэн шилжүүлэх зэрэг ажил хийгдэхгүй. Мөн төслийн үйл ажиллагааны хүрээнд болон ялангуяа ХХҮЕГ-ын оффисын барилгын сонгосон хэсэгт хийгдэх засвар, шинэчлэлийн ажилд газар шорооны ажил гүйцэтгэх, соёлын өвийг нүүлгэн шилжүүлэх, соёлын өвтэй харьцах, хадгалахтай холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа хийгдэхгүй тул соёлын өвд үзүүлэх нөлөө байхгүй байна.

2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ирүүлсэн бичил зээлийн саналыг сонгон шалгаруулах, шалгахдаа соёлын өвд үзүүлэх нөлөөллийг харгалзаж үзэх (Хавсралт 5-д заасны дагуу) бөгөөд ямар нэгэн байдлаар соёлын өвд нөлөөлөх бол зээлд хамруулахгүй. Төсөл нь ямар нэгэн газар чөлөөлөх үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд нийгмийн эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс дэд бүрэлдэхүүн хэсэг 2.1-ийн хүрээнд жижиг зээл олгохдоо газар чөлөөлөх асуудлыг анхааран үзэж шалгах болно (Хавсралт 5-д заасны дагуу).

КОВИД-19 цар тахлын цаашдын тодорхойгүй байдал нь төслийн гүйцэтгэлд эрсдэл учруулж болзошгүй нөхцөлийг үүсгэж байна. Энэхүү гарын авлагыг боловсруулж байх үед (2020 оны 9-р сар) КОВИД -19 цар тахал Монгол улсын нутаг дэвсгэрт (дотооддоо) тархаагүй байсан боловч 2020 оны 11-р сарын эхэн үеэс Монгол улсад (дотооддоо) халдвар гарч эхэлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор Улсын Онцгой Комисс болон Монгол Улсын Засгийн газраас улс орныг хамарсан болон хэсэгчилсэн хэд хэдэн удаагийн хөл хориог тогтоосон. 2020 оны 4-р сард өдөрт дунджаар 1100-1300 шинэ халдварын тохиолдол бүртгэгдэж байсан. 2021 оны 3-р сараас халдварын тархалт нэмэгдэж байгаатай зэрэгцэн Засгийн газраас вакцинжуулалтыг эхлүүлээд байна.

Вакцинжуулалтын төлөвлөгөөний дагуу Засгийн газраас эхний ээлжид эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай үйлчилгээний ажилтнууд, төрийн захиргааны албан хаагчид, нийслэл болон аймгийн төвүүдийн шаардлагатай үйлчилгээний ажилтнууд болон ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийг вакцинд хамруулсан бөгөөд 2021 оны 3-р сараас эхлэн вакцинжуулалтыг улс орон даяар хийж, насанд хүрсэн нийт хүн амыг хамруулж эхэлсэн. Засгийн газрын зүгээс вакцинжуулалтыг 2021 оны 6-р сарын эцэс гэхэд дуусгахаар төлөвлөж байна. 2021 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 811,480 хүн вакцинжуулалтын 1-р тунд (насанд хүрсэн хүн амын 38,6%), 327,251 хүн (насанд хүрсэн хүн амын 15,6%) 2-р тунд хамрагдсан байна.

ТХН нь төслийн дизайны үе шатанд талуудын оролцооны төлөвлөгөөг (ТОТ) боловсруулсан. Үүнд төслийн баг оролцогч талуудтай хэрхэн харилцах талаар тусгасан бөгөөд төсөл болон төсөлтэй холбоотой аливаа үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэх, гомдол гаргах механизмын талаар багтаасан. Энэхүү БОНУХ-ний гарын авлагын нэг хэсэг болгон талуудын оролцооны төлөвлөгөөг шинэчилсэн (Хавсралт 7).

Хүснэгт 2: Эрсдэл, нөлөөллийн жагсаалт, бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр

| Бүрэлдэхүүн хэсэг | Байгаль орчны эрсдэл, нөлөөлөл | Нийгмийн эрсдэл, нөлөөлөл |
|---|--|---|
| <p>Бүрэлдэхүүн хэсэг 1.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгох үйл ажиллагааг дэмжих</p> <p>(а) ХХҮЕГ-ын хөдөлмөр, эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байрыг (сонгосон) тохижуулах, шинэчлэх</p> <p>(б) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем (ХЗЗМС)-ийг нэвтрүүлэх замаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн ажлын зохион байгуулалтыг боловсронгуй, оновчтой болгох</p> <p>(в) Төрөөс үзүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх</p> <p>(г) Хөдөлмөрийн эрхлэлтийн төрийн үйлчилгээг хөдөлмөрийн хувийн биржүүдийн үйл ажиллагаатай уялдуулан хамрах хүрээг өргөжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх (чиг үүргийн шинжилгээ хийх, хувийн болон төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг сурталчлах гэх мэт арга хэмжээг зохион байгуулах)</p> | <p>Эрсдэл: Дунд зэрэг ХХҮЕГ-ын оффист богино хугацааны буюу жижиг хэмжээний засвар, шинэчлэлийн ажил хийх.</p> <p>Нөлөөлөл: Дуу чимээ, тоос шороо, хатуу хог хаягдал үүсэх, ХАБЭА-н асуудал.</p> <p>Эрсдэлийг бууруулах арга хэмжээг энэхүү гарын авлагын 3.3 хэсэгт тусгасан болно.</p> | <p>Нийгмийн эрсдэл: Бага (Эмзэг бүлгийн иргэд болон эмзэг бүлгийн ажил хайгч нарт нийгмийн эерэг нөлөөлөл үзүүлнэ гэж таамаглах байна).</p> <p>Хөдөлмөрийн эрсдэл: Бага</p> <p>Хөдөлмөрийн удирдлагын журмыг Хавсралт 2-т тусгасан болно.</p> |
| <p>Бүрэлдэхүүн хэсэг 2.</p> <p>Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн загвар, хамаарал, эрэлт, хэрэгцээг бэхжүүлэх</p> <p>(а) Бичил бизнес эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй жижиг зээлийг санхүүжүүлэх, зээлийн өмнөх болон дараах санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх зэрэг цогц дэмжлэг үзүүлэх.</p> <p>(б) ТХН-ийн удирдлага дор зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадварыг олгох хөтөлбөрийг турших</p> | <p>Эрсдэл: Дунд зэрэг Байгаль орчинд нөлөөлөхүйц, эргэлт буцалтгүй, урт хугацааны нөлөөлөл гарахгүй гэж таамаглаж байна.</p> <p>Төсөл нь байгаль орчинд ихээхэн хэмжээний эрсдэл учруулах бичил үйлдвэрүүдийг санхүүжүүлэхгүй.</p> <p>Бичил үйлдвэрүүдийн хэв шинж нь дараах байдалтай байхаар төлөвлөж байна. Үүнд: хүнсний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн</p> | <p>Нийгмийн эрсдэл: Бага</p> <p>(Бичил бизнес эрхлэгчдэд нийгмийн эерэг нөлөөлөл үзүүлнэ гэж таамаглаж байна.).</p> <p>Хөдөлмөрийн эрсдэл: Бага</p> |

| | | |
|---|--|-----------------|
| | <p>худалдаа, үйлчилгээ (үсчин, цэвэрлэгээ, гутал засвар, цаг засвар, цахилгаан хэрэгслийн засвар); боловсруулах болон бусад үйлдвэрлэл (оёдол, сүлжмэл, нэхмэл, арьс ширэн эдлэл, мужаан, төмөр эдлэл, барилгын материалын үйлдвэрлэл); хөдөө аж ахуй, газар тариалан, сүү, цагаан идээ боловсруулах; авто засвар, авто угаалга, сэлбэгийн худалдаа.</p> <p>Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой зарим эрсдэл үүсэж болох юм. Эрсдэлийг бууруулах, багасгах арга хэмжээг энэхүү гарын авлагын 3.3-т тусгасан болно.</p> | |
| <p>Бүрэлдэхүүн хэсэг 3. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, тайлагналт, дүн шинжилгээний хамрах хүрээ, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.</p> <p>(а) Ажилгүйдэлтэй холбоотой бодлого боловсруулахад шаардлагатай бүрэн гүйцэт дүн шинжилгээ хийх</p> <p>(б) Ур чадварын инновацын хөтөлбөрийн бодит нөлөөллийн үнэлгээ хийх</p> <p>(в) Хөдөлмөр эрхлэлт болон ур чадварын эрэлт хэрэгцээг тодорхойлох бодлогын дүн шинжилгээ хийх</p> <p>(г) Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ</p> | Эрсдэл байхгүй. | Эрсдэл байхгүй. |
| <p>Бүрэлдэхүүн хэсэг 4. КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажил олгогч болон заавал даатгуулагчдад түр хугацааны шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх</p> | Эрсдэл байхгүй. | Эрсдэл байхгүй. |

2. Байгаль орчин ба нийгмийн удирдлагын хүрээ

Энэхүү байгаль орчин ба нийгмийн удирдлагын хүрээний (БОНУХ) зорилго нь:

- (i) ОБҮДХЭТ-д хамаарал бүхий Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартуудыг танилцуулах
- (ii) Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн зөрүүтэй байдал болон уялдаа холбоонд дүн шинжилгээ хийх, төслийн хүрээнд үүсэх хууль, тогтоомжийн зөрүүтэй байдлыг шийдвэрлэх арга, замыг тодорхойлох
- (iii) Төслийн үйл ажиллагаанд хамааралтай байгаль орчин, нийгмийн суурь

нөхцөлийг бүрдүүлэх;

Эдгээр нь Монгол Улсын хууль, тогтоомж болон Дэлхийн банкны холбогдох стандартуудтай нийцсэн байна. Хэрэв Монгол улсын хууль, тогтоомж болон Дэлхийн банкны холбогдох шаардлагуудын хооронд ялгаатай байдал үүсвэл аль илүү хатуу, чанга шаардлагыг дагаж мөрдөх ёстой (жишээлбэл: хэрэв Монгол Улсын дуу чимээний стандарт Дэлхийн банкнаас илүү байвал Монгол улсын стандартыг хэрэглэнэ. Эсрэгээрээ Дэлхийн банкны стандарт илүү хатуу, чанга байвал Дэлхийн банкны стандартыг дагана). Харин тавигдах шаардлагуудын хооронд зөрчилтэй байдал үүссэн тохиолдолд ХНХЯ нь Дэлхийн банктай зөвшилцөж шийдвэрлэнэ.

2.1 Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн бодлого, стандартууд болон төслийн уялдаа

Дэлхийн банкнаас өөрийн санхүүжүүлж буй төслүүдийн хувьд Зээлдэгч нарыг байгаль орчин, нийгмийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, бууруулах зорилготой байгаль орчин, нийгмийн 10 стандартыг (БОНС) тодорхойлсон байдаг. Төслийн байгаль орчин болон нийгмийн үнэлгээнд үндэслэн байгаль орчны болон нийгмийн стандарт тус бүрийн хамаарлын ерөнхий шинжилгээг доорх Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандарттай уялдсан байдлын талаарх ерөнхий дүн шинжилгээ

| Байгаль орчин, нийгмийн стандартууд | Хамаарал | Хэрэгцээ |
|---|--|---|
| БОНС 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн үнэлгээ, менежмент | Энэхүү стандарт нь төсөлд хамааралтай байгаа бөгөөд төслийн бэлтгэл үе шатанд Дэлхийн банкны баг төслийн байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийн талаарх шуурхай үнэлгээг гүйцэтгэсэн. Үнэлгээний үр дүнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хураангуйг (БОННУХ) бэлтгэн гаргасан. Үнэлгээгээр төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл нь дунд зэрэг гэж үнэлэгдсэн. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний зүгээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (ХЭДТ)-д зориулан бэлтгэсэн БОНУХ-г шинэчлэх шаардлагатай гэж үзсэн. | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хураангуйд (БОННУХ) авч үзсэнээр төслийн БОНУХ-д дараах асуудлуудыг оруулах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. <ul style="list-style-type: none">• Төслийн байгаль орчин, нийгмийн удирдлагатай холбоотой Монгол Улсын одоогийн зохицуулалтын хамрах хүрээ болон тэдгээрийн шаардлага (2.2 дах хэсэг);• Байгаль орчин, нийгмийн суурь үзүүлэлтүүд (2.3 дах хэсэг);• Бичил үйлдвэрүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг арилгах талаарх журам болон арга хэрэгсэл (2.2 дах хэсэг);• Жижиг хэмжээний засварын ажилд зориулсан “Асбесттэй холбоотой мэргэжлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд”-ыг тодорхойлсон сайн туршлагын тэмдэглэл (Хавсралт 2)• КОВИД-19 цар тахлаас ажилчид, ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ (3.5 дах хэсэг Хавсралт 1); |

| | | |
|---|---|---|
| | | <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгмийн удирдлагын талаарх зохион байгуулалтын чадавхын үнэлгээ болон төслийн тодорхой чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөөний санал; • Хяналт-шинжилгээ болон тайлагналтын шаардлагууд |
| <p>БОНС 2: Хөдөлмөрийн болон ажиллах нөхцөл</p> | <p>Энэхүү стандарт нь төсөлд хамааралтай байна. Уг төслийн хүрээн дэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) асуудал нь 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх засварын ажил, 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх дэмжигдсэн бичил үйлдвэрүүдийн ажиллах нөхцөлтэй ихээхэн холбоотой байна.</p> | <p>БОНУХ нь дараах зүйлсийг харгалзан авч үзэх хэрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> • Төсөлд хамрагдсан бичил бизнес эрхлэгчдийн нийтлэг үйл ажиллагааны төрлүүдэд зориулсан Дэлхийн банкны ерөнхий болон салбарын онцлогтой холбоотой байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдамж (Хавсралт 6); • Асбесттэй холбоотой мэргэжлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлуудын талаарх сайн туршлагын талаарх тэмдэглэл (Хавсралт 2); • Дэлхийн банк болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан КОВИД-19 цар тахлаас хамгаалах, сэргийлэх талаарх холбогдох удирдамж. <p>Төсөлд зориулж бэлтгэсэн худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд ХАБЭА-н холбогдох шалгуурыг заавал оруулна. Хөдөлмөрийн удирдлагын төлөвлөгөөг (ХУТ) боловсруулсан байх шаардлагатай (Хавсралт 1).</p> |
| <p>БОНС 3: Нөөцийн үр ашиг болон бохирдлоос урьдчилан сэргийлэх менежмент</p> | <p>Энэхүү стандарт нь төсөлд хамааралтай байна. 1-р бүрэлдэхүүн хэсгийн засварын ажилд асбест агуулсан материалыг ашиглаж болох юм. Бичил үйлдвэрүүдийн байгаль орчны эрсдэл болон нөлөөллийг авч үзсэн байх шаардлагатай.</p> | <p>Асбест агуулсан материалын хаягдал болон менежмент нь БОНУХ-д тусгагдсан БОУАД (Хавсралт 3) болон Дэлхийн банкны “Асбесттэй холбоотой мэргэжлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд”-ын талаарх сайн туршлагын тэмдэглэлд заасан шаардлагыг дагаж мөрдөнө (Хавсралт 2). Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст тухайн бичил бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны мэдээллийг нягталж үзэх бөгөөд хүрээлэн буй орчныг ихээхэн хэмжээгээр бохирдуулж байгаа бичил үйлдвэрүүдийг төсөлд хамруулахгүй.</p> <p>Оролцогч санхүүгийн байгууллага нь батлагдсан загварын дагуу тухайн бичил бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг БОНС 3-ын дагуу үнэлж, зээлийн зөвшөөрөл олгоно. Мөн оролцогч санхүүгийн байгууллага нь эцсийн зээлдэгч нарт Дэлхийн банкны ерөнхий болон салбарын онцлогтой холбоотой байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын</p> |

| | | |
|--|--|---|
| | | удирдамж (Хавсралт 6) болон ХЭДТ-ийн хүрээнд ХНХЯ-аас боловсруулсан дэд салбаруудын удирдамжийг өгөх бөгөөд зээлдэгч нарт эдгээр удирдамжийг дагаж мөрдөх шаардлага тавина. |
| <p>БОНС 4: Нийтийн эрүүл мэнд болон аюулгүй байдал</p> | <p>Энэхүү стандарт нь төсөлд хамааралтай байна. Төсөл нь нийтийн экосистемд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй бөгөөд ямар нэгэн далан барих ажил байхгүй.</p> <p>1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх засварын ажлын цар хүрээ, шинж чанараас харахад уг төслийн хүрээнд хийгдэх барилгын ажил нь ойролцоох оршин суугчдад мэдэгдэхүйц хүндрэл учруулахгүй байна. Засварын ажилд орон нутгийн цөөн тооны ажилчдыг оролцуулна. Ажилчдын түр байр, ажилчдын шилжилт хөдөлгөөн, замын хөдөлгөөнд саад учруулах зэрэг эрсдэл үүсэхгүй гэж таамаглаж байна.</p> <p>Эдгээр үйл ажиллагаатай шууд холбоотой халдварт өвчин тархах, жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) гарах эрсдэл бага байна. Асбест агуулсан материал нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй юм. Засварын ажилтай холбоотой өөр хортой материал болон хог хаягдал байхгүй байна.</p> | <p>Дуу чимээ, тоос шороо, хатуу хог хаягдлаас үүссэн түр зуурын болон орон нутагт үүсэх нөлөөллийг иргэний барилгын ажлын сайн туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах боломжтой (Хавсралт 3).</p> <p>Ажилчид болон олон нийтийг аль алийг нь хамгаалахын тулд асбест агуулсан материалын менежмент болон хаягдлыг устгахад Дэлхийн банкны “Асбесттэй холбоотой мэргэжлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд”-ын талаарх сайн туршлагын тэмдэглэлд заасан шаардлагыг дагаж мөрдөнө (Хавсралт 2).</p> |
| <p>БОНС 5: Газар ашиглах болон албадан нүүлгэхтэй холбоотой хязгаарлалт хийх болон газар худалдаж авах</p> | <p>Энэхүү стандарт нь хамааралгүй бөгөөд хүмүүсийг биечлэн нүүлгэн шилжүүлэх, албадан нүүлгэн шилжүүлэх, хувийн хэвшлийн газар худалдаж авах зэрэг үйл ажиллагааг төслийн хүрээнд санхүүжүүлэхгүй.</p> | <p>Төслийн хүрээнд газар худалдаж авах, албадан нүүлгэн шилжүүлэх ажлыг санхүүжүүлэхгүй байх үүднээс бичил бизнесийн үйл ажиллагаанд зээл олгохдоо энэхүү асуудлыг хориглох үйл ажиллагааны жагсаалтад оруулах болно (Хавсралт 5).</p> |
| <p>БОНС 6: Амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент, биологийн төрөл зүйл болон байгаль хамгаалал</p> | <p>Төслийн хүрээнд шинээр барилга барих ажил хийгдэхгүй. Мөн төслийн хүрээнд ховор амьтдыг нутагшуулах, байгалийн гаралтай бүтээгдэхүүн худалдан авах, ашиглах зэрэг үйл ажиллагаа байхгүй байна. Иймээс одоогийн байдлаар энэхүү стандарттай хамааралгүй байна.</p> | <p>Амьдрах орчин болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийхийн тулд бичил бизнесийн үйл ажиллагаанд зээл олгохдоо хориглох үйл ажиллагааны жагсаалтад тусгах болно.</p> |
| <p>БОНС 7: Уугуул иргэд болон Сахарын Африкийн уламжлалт орон нутгийн бүлгүүд</p> | <p>Энэхүү стандартыг хамааралтай гэж үзсэн. Монгол улс бол үндсэндээ нэгэн төрлийн цөөн хүн амтай орон бөгөөд монгол үндэстний 85 орчим хувь нь монгол хэлийг үндсэн хэл болгон ашигладаг. Монгол улсын баруун хэсэгт Казах хэлээр ярьдаг</p> | <p>БОНУХ-нд тусгагдсан ТОТ-нд төслийн үйл ажиллагаанаас үр шим хүртэгч казак иргэдэд зориулсан арга хэмжээг боловсруулан оруулна (Хавсралт 7). Эдгээр арга хэмжээний хүрээнд төслийн гол баримт бичиг болон мэдээллийг Казах хэл дээр боловсруулах, орон</p> |

| | | |
|---|---|---|
| | цөөн тооны мусульман шашинтай иргэд оршин суудаг. Казах хэлээр ярьдаг иргэд жижиг зээл авах, ажилчдын нийгмийн хамгааллын дэмжлэг авах зэрэг төслийн үр шимийг мөн адил хүртэх эд хувь нэмэр оруулах болно. | нутгийн сувгийг ашиглан олон нийтэд мэдээлэл хүргэх болон санал хүсэлт гаргах боломжийг багтаасан байна. |
| БОНС 8: Соёлын өв | Энэхүү стандартыг одоогийн байдлаар хамааралгүй гэж үзэж байна. Энэхүү төсөл нь газрыг ямар нэгэн байдлаар ухаж (ингэснээр соёлын биет өвд нөлөөлж болзошгүй) барилга байгууламж барих болон нөхөн сэргээхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжихгүй. Мөн биет бус соёлын өвд нөлөөлж болзошгүй бусад үйл ажиллагааг дэмжихгүй. | Соёлын өвд үүсэх сөрөг нөлөөллөөс зайлсхийхийн тулд бичил бизнесийн үйл ажиллагаанд зээл олгохдоо хориглох асуудлуудын жагсаалтад оруулах болно (Хавсралт 5). Үүнийг тодорхойлох, тогтоох журмыг гаргах болно (Хавсралт 3). |
| БОНС 9: Оролцогч санхүүгийн байгууллага | Энэхүү стандартыг төсөлд хамааралтай гэж үзсэн. Шаардлага хангасан нийт санхүүгийн байгууллагуудын дунд нээлттэй тендер зарлах замаар бичил бизнес эрхлэгчдэд зээл олгох (Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд) оролцогч санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулна. | Банкны баг сонгогдсон санхүүгийн байгууллагын одоогийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чадавхын талаар нарийн үнэлэлт, дүгнэлт гаргана. Оролцогч санхүүгийн байгууллагын дэмжсэн дэд төслүүдэд ямар нэгэн сөрөг үр дагавар гаргахгүй байх үүднээс төслийн зүгээс үнэлгээний үр дүнд үндэслэн тухайн санхүүгийн байгууллагыг БОНС-ыг бий болгох эсвэл тухайн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг ижил түвшинд авч үзэхээр одоогийн БОНС-ыг сайжруулах шаардлага тавина. Оролцогч санхүүгийн байгууллагын БОНУС нь БОНС 9-ийн шаардлагуудыг багтаасан байх бөгөөд уг БОНУС-ыг хэрэгжүүлэх хангалттай хүний нөөцтэй байна. БОНУС-ын үндсэн элементүүдийг 3.4 хэсэгт авч үзсэн бөгөөд энэхүү БОНУС-ыг аливаа бичил бизнесийг санхүүжүүлэхээс өмнө боловсруулсан байна. Мөн эдгээр санхүүгийн байгууллага нь дэд төслүүдийн шинж чанар болон байгаль орчин, нийгмийн эрсдэлийг нэгэн адил багтаасан БОНС-тай байхаас гадна БОНС-ын хэрэгжилтийг хангаж чадахуйц хангалттай боловсон хүчний нөөцтэй байх шаардлагатай. |
| БОНС10: Талуудын оролцоо ба | Энэхүү стандартыг төсөлд хамааралтай гэж үзсэн. ОБҮДХЭТөсөл нь одоогийн хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн (ХЭДТ) өргөтгөл буюу | Төслийн түвшний гомдол барагдуулах механизмыг ажиллуулах бөгөөд төсөл хэрэгжүүлэх нэгжийн ХШҮ-ний мэргэжилтэн хэрэгжилтийг хариуцан ажиллана. |

| | | |
|---------------------------------|--|---|
| <p>мэдээллийн ил тод байдал</p> | <p>дараагийн үе шат юм. Одоогийн хэрэгжиж буй төслийн оролцогч талуудын оролцоо хэвээр байгаа бөгөөд КОВИД-19-д зориулсан төслийн шинэ цар хүрээг харгалзан оролцогч талуудыг шинэчлэх шаардлагатай.</p> <p>Төслийн үргэлжлэх хугацааны туршид эмзэг бүлгүүд болон Монгол улс дахь КОВИД-19-ийн нөхцөл байдлыг онцгой анхаарч үзэн тасралтгүй зөвлөгөө, мэдээллээр хангах болон одоогийн оролцогч талуудын оролцоог илүү ач холбогдолтой байлгах үүднээс оролцогч талуудын урьдчилсан төлөвлөгөөг гаргасан.</p> <p>Талуудын оролцооны төлөвлөгөөний төсөлд төслийн 1-р үе шат буюу одоогийн үйл ажиллагаанд ашиглаж буй гомдол барагдуулах механизм (ГБМ)-ийг багтаасан.</p> | <p>Шаардлагатай гэж үзвэл ХНХЯ болон төсөл хэрэгжүүлэгч нэгж талуудын оролцооны төлөвлөгөөг тухай бүр шинэчлэх бөгөөд энэ нь нээлттэй, ил тод байна (Хавсралт 7).</p> <p>Шинэчлэгдсэн талуудын оролцооны төлөвлөгөө нь уламжлалт болон КОВИД-19 цар тахлаас сэргийлэх үүднээс олон нийтийг хамарсан цугларалт, бөөгнөрийг бий болгохгүй байх шинэ арга хэрэгслийг аль алийг нь авч үзнэ.</p> <p>Төслийн вэбсайт дээр санал хүсэлт болон гомдол мэдээлэх хэсэг байх бөгөөд энэхүү хэсгээр дамжуулан төсөлд хамрагдсан иргэд төслийн үйл ажиллагааны талаарх аливаа гомдол, санал, хүсэлтээ гаргана.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн гомдол барагдуулах механизмын талаар олон нийтэд зориулсан материал бэлтгэнэ.</p> |
|---------------------------------|--|---|

2.2 Монгол улсын хууль, эрх зүйн орчин болон Дэлхийн банкны холбогдох шаардлагын зөрүүтэй байдлын шинжилгээ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчны болон нийгмийн хамгааллын дараах гол хууль, тогтоомжууд байна. Үүнд:

- 1) Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995, хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон);
- 2) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 оны 5 дугаар сард шинэчлэгдсэн) болон бусад холбогдох журам, стандарт;
- 3) Агаарын тухай хууль (2012 онд шинэчлэн найруулсан, хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон)
- 4) Усны тухай хууль (2012 он)
- 5) Усны нөөцийн тухай хууль (2007 оноос хойш нэмэлт, өөрчлөлт орсон)
- 6) Хог хаягдлын тухай хууль (2013 он)
- 7) Хөдөлмөрийн тухай хууль (1999, хэд хэдэн удаа шинэчлэн найруулсан);
- 8) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008 он, хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон);
- 9) Барилгын тухай хууль (2016 онд шинэчлэн найруулсан)
- 10) Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995 он, нэмэлт, өөрчлөлт орсон)
- 11) Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011 он)
- 12) Төрийн аудитын тухай хууль (2015 он) болон бусад.

Монгол улсын болон Банкны байгаль орчин болон нийгмийн шаардлагын хооронд зарим ялгаатай зүйл байна. Доорх Хүснэгт 4-т Монгол улсын холбогдох хууль, тогтоомж болон Дэлхийн банкны стандартуудын хүрээнд авч үзсэн байгаль орчны болон нийгмийн үндсэн шаардлага болон эдгээрийн зөрүүтэй байдлыг арилгах стратегиудыг тодорхойлсон болно.

Хүснэгт 4. Монгол улсын хууль, тогтоомж, Дэлхийн банкны стандартуудын хүрээнд авч үзсэн байгаль орчны үндсэн шаардлага болон зөрүүтэй байдлыг арилгах төслийн стратеги

| Нэр | Дэлхийн банкны шаардлага | Зөрүүтэй байдал | Шаардлагуудын зөрүүтэй байдлыг арилгах төслийн стратеги |
|--|---|---|---|
| <p>Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежмент</p> | <p>БОНС 1: Зээлдэгч нарт дараах байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийн үнэлгээ, менежментийн шаардлага тавигдана.</p> <ul style="list-style-type: none"> - Банкнаас санхүүжүүлэхээр санал болгож буй төслүүд (оролцогч талуудыг оролцуулан) нь эрсдэл болон нөлөөллийг аль алийг нь авч үзсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх; - Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (БОНХТ) боловсруулан албан ёсны гэрээ болон БОНХТ-д заасан бүх үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх - Төслийн хэрэгжих хугацааны туршид төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийг удирдах; - Төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх, тайлагнах | <p>Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь зөвхөн хүний эрүүл мэнд болон байгаль орчинд их хэмжээний болон мэдэгдэхүйц нөлөөтэй байж болох томоохон төслүүд болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хувьд үнэлгээ хийхийг шаарддаг.</p> <p>Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн хувьд бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад заавал оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлагагүй бөгөөд харин хяналт-шинжилгээ, үнэлгээний шатанд зөвлөлдөх шаардлагатай байна.</p> <p>Монгол улсын холбогдох хууль, тогтоомжоор иргэдийн өргөдөл, гомдол, саналыг хүлээж авах, шийдвэрлэхэд хангалттай механизмыг бүрдүүлж өгсөн байна.</p> | <p>Төсөл нь Дэлхийн Банкны холбогдох БОНС-ыг багтаасан холбогдох арга хэмжээ бүхий БОНХТ-г хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.</p> <p>Төслийн зүгээс төслийн санхүүжилтийн эх үүсвэрээр олгох жижиг зээлийн саналыг шалгахдаа байгаль орчин, нийгмийн асуудлыг харгалзаж үзэх боломжоор хангана.</p> <p>Төсөл нь талуудын оролцооны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.</p> <p>Төсөл нь Засгийн газрын гомдол барагдуулах механизм дээр суурилсан Гомдол барагдуулах механизмтай байна.</p> <p>Төсөл нь БОНХТ-ний хэрэгжилтийг тогтмол тайлагнана.</p> |
| <p>Хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй</p> | <p>БОНС 2: Зээлдэгч нарт тавигдах ажлын болон хөдөлмөрийн нөхцөлийн шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн үйл ажиллагаанд хамаарах хөдөлмөрийн удирдлагын журмыг (ХУЖ) боловсруулан хэрэгжүүлэх; - ХУЖ нь ажилд орох нөхцөл, түүний дотор | <p>Монгол улсын хууль, тогтоомж нь БОНС 2-ын дийлэнх хэсэгтэй нийцэж байна. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999) болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухайн хуульд (2008) ОУХБ-ын хөдөлмөрийн үндсэн стандартууд (хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлт, ялгаварлан</p> | <p>Хөдөлмөрийн удирдлагын журам (ХУЖ)-ыг боловсруулсан (Хавсралт 1). Ажлын байрны ХАБЭА-тай холбоотой гол зохицуулалтуудыг ХУЖ-д тусгасан. Мөн ХУЖ-д ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл болон гэрээгээр ажил гүйцэтгэгч нарын ажилтнуудад зориулсан ХАБЭА-н</p> |

| | | | |
|--|---|---|---|
| | <p>төслийн ажилчдын ХАБЭА, эмзэг бүлгийн ажилчдын эрх ашгийг хамгаалах, гомдол гаргах механизм, төслийн ажилчдыг (шууд, гэрээт, хангамжийн, олон нийтийн ажилчид) хамгаалах.</p> <p>- ХАБЭА-н арга хэмжээнд БОНС 2-ийн шаардлагыг багтаах бөгөөд БОН-ын ерөнхий салбарын удирдамжийг харгалзаж үзэх</p> | <p>гадуурхахгүй байх, эвлэлдэн нэгдэх эрх, хамтын хэлэлцээр гэх мэт) тусгагдсан байдаг. Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогч болон ажилтан хоорондох харилцааг хөдөлмөрийн гэрээгээр зохицуулсан байдаг бол ХАБЭА-н тухай хууль нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон иргэний гэрээнд оролцогч талуудын харилцаанд нэмэлтээр үйлчилдэг. ХАБЭА-н тухай хуульд ажил олгогчийн зүгээс аюулгүй, эрүүл ажлын байраар хангах хариуцлагыг тусгасан байдаг. ХАБЭА-н тухай хуулийн 28.3-т даасны дагуу Захиалагч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь ХАБЭА-н тухай хуульд тусгагдсан зүйл, заалтыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх харилцан үүрэг хүлээдэг. Хэрэв гэрээнд энэ талаар тусгаагүй бол тухайн асуудлыг буюу бүх хохирол, төлбөрийг ерөнхий гүйцэтгэгч хариуцдаг. Хөдөлмөрийн тухай хуульд ажилтанд гэмтэл учрах, цочмог хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртөх, ажилчин нас барах зэрэг тохиолдолд ажил олгогч нь ажилчин эсвэл түүний ар гэрт нөхөн олговор олгох хариуцлагыг тусгасан байдаг. ХАБЭА-н тухай хуулиар хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл, байдал үүссэн тохиолдолд тухайн ажилтан ажлаа зогсоох, ажлаас гарах эрхийг баталгаажуулсан байдаг. ХАБЭА-тай холбоотой эрсдэлийг бууруулах талаарх тодорхой шаардлагыг</p> | <p>шаардлага, нөхцөлийг тусгасан. Гэрээний үндсэн дээр ажилчдын эрх ашгийг хамгаалах асуудал нь Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд хийгдэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний танхимыг тохижуулах, шинэчлэх засварын ажлыг гэрээгээр гүйцэтгэгч нарт мөн адил хамаарна. Хөдөлмөрийн удирдлагын шаардлагыг тендерийн шаардлага, гэрээ байгуулах, гэрээний хяналт, эцсийн үнэлгээний шатанд багтаан авч үзэх болно. Ажлын байрны ёс зүйн дүрмийг (ХУЖ-д хавсаргасан) ажилчдын аюулгүй байдлын хариуцлага болон хариуцсан чиг үүргийн хүрээнд аюулгүй байдлаар ажлаа гүйцэтгэх эерэг зан төлөв, ажлын байран дах бэлгийн болон бие махбодын дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг зорилгоор боловсруулсан болно. Түүнчлэн, компани, бараа материал нийлүүлэгчид болон оролцогч санхүүгийн байгууллагатай зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн компани болон оролцогч санхүүгийн байгууллага нь ажилтныг ажилд авах болон ажилтны эрх, ашгийг хамгаалахад Хөдөлмөрийн тухай хуульд заасан шаардлагыг дагаж мөндөх үүргийг тусгасан байх болно.</p> |
|--|---|---|---|

| | | үндэсний стандарт болон холбогдох дүрэм, журмаар зохицуулдаг. | |
|---|--|--|---|
| Нөөцийн үр ашиг болон бохирдлын хяналт | <p>БОНС 3: Нөөцийн үр ашиг болон бохирдлоос урьдчилан сэргийлэх менежмент нь дараах зүйлийг шаарддаг.</p> <ul style="list-style-type: none"> Зээлдэгч нь боломжит нөөцийг (эрчим хүч, ус, түүхий эдийн хэрэглээ) техникийн болон санхүүгийн хувьд үр дүнтэйгээр ашиглах бөгөөд бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн аливаа эрсдэл, нөлөөлөлтэй адил байдлаар авч үзнэ. Зээлдэгч нь бохирдуулагч бодисыг гаргахаас зайлсхийх бөгөөд зайлсхийх боломжгүй тохиолдолд буюу ердийн, ердийн бус, санамсаргүй байдлаас үүдэн бүс нутгийн хэмжээд болон хил дамнан бохирдуулагч бодисын агууламж, хэмжээ агаар, ус, газарт тархах урсгалыг багасгах болон хязгаарлах бүхий л боломжит арга хэмжээг авна. Зээлдэгч нь аюултай болон аюулгүй аливаа хог хаягдал үүсэхээс зайлсхийнэ. Хог хаягдал үүсэхээс зайлсхийх боломжгүй тохиолдолд зээлдэгч хог хаягдлыг хамгийн бага хэмжээнд байлгана. Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, нөхөн сэргээх боломжгүй тохиолдолд зээлдэгч нь энэхүү хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй, аюулгүй байдлаар устгаж, цэвэрлэнэ. | <p>Монгол Улсын агаарын болон усны тухай хуулиудад эдгээр нөөцийг ашиглах, хамгаалахтай холбоотой ерөнхий шаардлагууд болон иргэд, аж ахуйн нэгжийн нийтлэг хүлээх үүрэг, хариуцлагыг тусгасан байдаг. Хог хаягдлын тухай хуулиар иргэд, аж ахуйн нэгжүүд хог хаягдлыг зохих ёсоор зайлуулах үүрэг болон хог хаягдлыг зайлуулахад хориглосон үйл ажиллагааг тусгасан байдаг. Гэхдээ эдгээр хуулиудад аливаа эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотойгоор бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгайлан заагаагүй байна.</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хуульд (БОХХ) газар, хөрс, шороо болон түүний доорх ашигт малтмал, ус, агаар, ургамал, биологийн төрөл зүйлийг байгаль орчны сөрөг нөлөөллөөс хамгаалах талаар тусгасан байдаг. Энэхүү хуулиар хувь хүн болон аж ахуйн нэгжүүдийг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлаас үүдэлтэй байгаль орчинд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, аливаа бохирдуулах арга хэмжээ гарахаас зайлсхийх, хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчныг бохирдуулах аливаа үйлдлийг арилгах зэрэг байгаль орчныг хамгаалах талаарх үндэсний хууль тогтоомж, холбогдох</p> | <p>Төслийн хүрээнд бохирдлоос зайлсхийх, урьдчилан сэргийлэх талаарх Монгол улсын хууль, тогтоомж болон Дэлхийн банкны стандартуудын шаардлагыг авч үзэх боломжтой. Эдгээр шаардлагуудыг төслийн 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх жижиг хэмжээний засварын ажил болон 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хамаарах бичил бизнес эрхлэгчдэд бичил зээлийн санхүүжилт олгоход авч үзнэ. Төсөл нь хог хаягдлын менежмент болон агаар, усыг бохирдуулагч бодист хяналт тавихад анхааран ажиллах бөгөөд жижиг хэмжээний засварын ажлын явцад асбест агуулсан материалтай харьцах болон үүнийг устгахад онцгой анхаарал хандуулах болно. Гэрээгээр ажил гүйцэтгэгч нар асбест агуулсан материалтай зөв харьцах, эдгээрийг зайлуулах зэрэгт Дэлхийн банк группийн "Асбест-мэргэжлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд" - ийн сайн туршлагын тэмдэглэлийг лавлагаа болгон ашиглах болно. Мөн гэрээгээр ажил гүйцэтгэгч нар нь Дэлхийн Банкны байгаль орчны үлгэрчилсэн дүрмийг дагаж мөрдөх болно.</p> |

| | | | |
|--|--|---|---|
| | | <p>хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаарддаг. Мөн хуулиар шаардлагатай гэж үзсэн аж ахуйн нэгж, байгууллагыг үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эдгээр арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэхийг шаарддаг. Хуульд байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байгаль орчны байцаагчдын эрх, үүргийг тусгасан байна. Хуульд мөн байгаль орчны аудитын механизмыг тусгаж өгсөн бөгөөд энэ нь байгалийн баялгийг шууд олборлох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжид хамаарна. Энэхүү аудитыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.</p> | <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн зохих шаардлагын дагуу оролцогч санхүүгийн байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учруулж болзошгүй аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх шаардлагыг төсөлд тусгасан. Төслийн зүгээс тухайн орон нутгийн ХХҮ-ний газар, хэлтэс, сонгогдсон санхүүгийн байгууллага нь төслийн бүрэлдэхүүн хэсэг 2-ийн хүрээнд эцсийн зээлдэгч нарт жижиг зээл олгохдоо бичил зээлийн санхүүжилт авах төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянан үзэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээрх зохих арга хэмжээнүүдийг (3.4 хэсэгт тайлбарласан) тохиролцсон байх зэрэг шаардлагыг тавих болно. Түүнчлэн бичил бизнес эрхлэгчдээс байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх ерөнхий болон салбарын удирдамжийг дагаж мөрдөхийг шаардах болно (Хавсралт 6).</p> |
| | | <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар (БОНБҮХ) төслийн шинж чанар, цар хүрээний дагуу хийгдэх дөрвөн төрлийн байгаль орчны үнэлгээг тодорхойлсон байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг (БОНБҮ)</p> | |

| | | | |
|---|--|---|---|
| | | <p>мэргэжлийн байгууллагууд эсвэл тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд хийж гүйцэтгэнэ. Энэхүү үнэлгээ нь уул уурхай, хүнд үйлдвэр, хүнс, хөнгөн үйлдвэр (томоохон аж ахуйн нэгжүүд), дэд бүтэц, иргэний барилга, хот байгуулалт, химийн болон цацраг идэвхт хаягдлын менежмент, үйлчилгээ (50-аас дээш ортой зочид буудал, сувилал) гэх мэт тодорхой салбар, чиглэлээр хэрэгжүүлэх төслүүд болон улсын тусгай хамгаалалттай болон хил орчмын бүс нутагт хэрэгжүүлэх, биологийн төрөл зүйлийг нутагшуулах төслүүдэд хийгдэнэ. БОНБҮХ-нд заасанчлан санхүүгийн байгууллагууд нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учруулах аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байхаар заасан.</p> | |
| <p>Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал</p> | <p>БОНС 4: Зээлдэгч нь төслийн нөлөөлөлд хамаарах иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг үнэлж тодорхойлох бөгөөд эдгээрийг бууруулах арга хэмжээг санал болгоно.</p> | <p>Монгол улсад нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд тусгайлан чиглэсэн хууль байхгүй. Гэхдээ Барилгын тухай хуульд (11-р зүйл) барилгын тоног төхөөрөмж, үйл ажиллагаа нь барилгын үйл ажиллагаанд шууд бус хамааралтай иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх тухай заасан байдаг.</p> | <p>БОНУХ-д КОВИД-19 цар тархалтын эрсдэлийг ажлын байранд болон нийгэмд хамгийн бага байлгах талаарх удирдамжийг тусгасан. Мөн жижиг хэмжээний засварын ажил гүйцэтгэгч нь ажилтнууддаа ёс зүйн дүрмийг (Хавсралт 1-т) ажилтнууддаа танилцуулан баталгаажуулж гарын үсэг зуруулахаар төлөвлөсөн. Энэхүү ёс зүйн дүрэм нь нийгэм, олон нийтэд дарамт шахалт үзүүлэх ялангуяа бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.</p> |
| <p>Албадан нүүлгэн шилжүүлэлт</p> | <p>БОНС 5: Газар чөлөөлөх, газар ашиглахтай холбоотой хязгаарлалт</p> | <p>Энэхүү стандартыг төсөлд хамааралгүй гэж үзсэн. Төсөлд газар</p> | <p>Төслийн хүрээнд газар чөлөөлөх, албадан нүүлгэн</p> |

| | | | |
|--|--|---|---|
| | болон албадан нүүлгэн шилжүүлэх | чөлөөлөх, газар эзэмших эрх, албадан нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагааг байхгүй. Хүмүүсийг биечлэн нүүлгэн шилжүүлэх, албадан нүүлгэн шилжүүлэх, хувийн хэвшлийн газар чөлөөлөхтэй холбоотой аливаа үйл ажиллагааг жижиг бичил зээлийн санхүүжилтэд хамруулахгүй. | шилжүүлэх ажлыг санхүүжүүлэхгүй байх үүднээс бичил бизнесийн зээл олгоход хориглох үйл ажиллагааны жагсаалтад тусгагдсан асуудлыг төсөлд хамруулахгүй байх болно (Хавсралт 5). |
| Биологийн олон зүйл байдал болон нөөцийн тогтвортой менежмент | БОНС 6: Биологийн олон зүйл байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент | Энэхүү стандартыг төсөлтэй хамааралгүй гэж үзсэн. Төслийн хүрээнд шинээр баригдах барилга байгууламж байхгүй бөгөөд төсөл нь ховор төрөл зүйлийг нутагшуулах, байгалийн гаралтай бүтээгдэхүүн худалдан авах болон ашиглахгүй болно. | Хасах шалгуурыг бичил бизнесийн саналыг сонгон шалгаруулахдаа авч үзэх хориглосон үйл ажиллагааны жагсаалтад оруулах болно (Хавсралт 5). |
| Нутгийн уугуул иргэд | БОНС 7: Уугуул иргэд болон Сахарын Африкийн уламжлалт орон нутгийн бүлгүүд | Монгол Улсын Үндсэн хуулинд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан байдаг. Гэхдээ үндэстний цөөнхийн талаар өөр тодорхой хууль тогтоомж байхгүй байна. Монгол Улсын “Хүний эрхийн үндэсний комисс”-ын авч үзсэнээр Монгол улсад Казахууд болон Духа цаатнууд гэсэн хоёр үндэстний цөөнх байдаг гэж үздэг. Халх монгол хэл бол төрийн албан ёсны хэл юм. Монгол Улс ардчилалд шилжсэнээс хойш Баян-Өлгий аймагт (дийлэнх Казах иргэд амьдардаг) амьдардаг Казах хүүхдүүд Казак хэл дээр сурч эхэлсэн. Гэхдээ Баян-Өлгий аймагт сурч | Төсөл нь мэдээлэл, сурталчилгааны материал болон Гомдол барагдуулах механизмтай холбоотой материалыг Казах хэл дээр бэлтгэн эдгээр иргэдийг төслийн үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулах болно. Эдийн засгийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан цаатан иргэдийг (зөвхөн Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд байдаг бөгөөд ихэвчлэн өндөр ууланд амьдардаг) төслийн боломжит зорилтот бүлэгт оруулаагүй. |

| | | | |
|--|--|---|---|
| | | <p>буй хүүхдүүд бусад аймагт сурч буй хүүхдүүдтэй адил Монгол хэлийг сайн сурах боломж хязгаарлагдмал байгаа тул Казах залуучууд цаашид суралцах, ажил, хөдөлмөр эрхлэхэд хэлний бэрхшээлээс шалтгаалсан саад, бэрхшээлүүдтэй тулгарч байна. Цаатан иргэд өөрсдийн угсаатны хэл болон Монгол хэлээр ярьдаг.</p> | |
| Соёлын өв | <p>БОНС 8: Соёлын өв Зээлдэгч нь төслийн хүрээнд төлөвлөж буй үйл ажиллагааны үр дүнд соёлын өвд учирч болзошгүй эрсдэл болон үүний нөлөөллийг тодорхойлох бөгөөд соёлын өвд үзүүлэх аливаа нөлөөллөөс зайлсхийх болно. Энэхүү нөлөөллөөс зайлсхийх боломжгүй тохиолдолд Зээлдэгч зохих дарааллын дагуу нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлнэ.</p> | <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийн тухай хууль зэрэг холбогдох хуулиудад хамаарна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд зөвшөөрөгдсөн болон хориглогдсон үйл ажиллагаа, газар ашиглах зөвшөөрөл олгоход Засгийн газрын бүх түвшинд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байдаг. Соёлын өвийн тухай хуульд биет соёлыг бүртгэх үйл ажиллагаа болон биет соёлыг хамгаалах чиг үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгсөн байдаг.</p> | <p>Энэхүү стандартыг одоогийн байдлаар хамааралгүй гэж үзэж байна. Энэхүү төсөл нь газрыг ямар нэгэн байдлаар ухаж (ингэснээр соёлын биет өвт нөлөөлж болзошгүй) барилга байгууламж барих болон нөхөн сэргээхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжихгүй. Мөн биет бус соёлын өвд нөлөөлж болзошгүй бусад үйл ажиллагааг дэмжихгүй.</p> <p>Соёлын өвд үүсэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх үүднээс бичил бизнесийн үйл ажиллагаанд зээл олгохдоо хориглох асуудлуудын жагсаалтад уг асуудлыг оруулах болно (Хавсралт 5). Үүнийг тодорхойлох, тогтоох журмыг гаргах болно (Хавсралт 3).</p> |
| Оролцогч санхүүгийн байгууллага | <p>БОНС 9: Оролцогч санхүүгийн байгууллага Оролцогч санхүүгийн байгууллагын дэмжсэн дэд төслүүдэд ямар нэгэн сөрөг үр дагавар гаргахгүй байх үүднээс төслийн зүгээс үнэлгээний үр дүнд үндэслэн тухайн санхүүгийн байгууллагыг БОНУС-ыг бий болгох эсвэл тухайн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай</p> | <p>Банкны тухай хууль (2010 онд шинэчлэн найруулсан) болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд (1995 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) Банк болон санхүүгийн байгууллагууд нь зээл олгож буй төслүүдийн</p> | <p>Төслийн зүгээс ОСБ-ууд нь БОНУС-тэй байх шаардлага тавих бөгөөд 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үзэх жижиг зээлийн дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, тодорхойлох ажлыг гүйцэтгэнэ.</p> |

| | | | |
|---|---|---|--|
| | <p>холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг ижил түвшинд авч үзэхээр одоогийн БОНУС-ыг сайжруулах шаардлага тавьдаг.</p> <p>БОНУС нь ОСБ-ын дэд төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэлийн шинж чанар, хэмжээ, нөлөөлөл зэрэгтэй таарч байх бөгөөд бүтээгдэхүүний нийт эрсдэлтэй тохирч байна.</p> | <p>байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах</p> <p>БОНУС-тэй байх талаарх үүрэг байхгүй байна.</p> <p>БОНУ-ий тухай хуульд санхүүгийн байгууллагууд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байхаар заасан.</p> | <p>ОСБ-уудыг сонгох журам болон сонгогдсон ОСБ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааг ХЭДС-ийн гарын авлагад тусгана (хэсэг 3.4).</p> <p>Жижиг зээлийн дэд төслүүдийн байгаль орчны эрсдэл дунд зэрэг байх тул төслийн зүгээс бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаардах болно. Түүнчлэн бичил бизнес эрхлэгчид байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын ерөнхий удирдамж (Хавсралт 6) болон салбарын тусгай удирдамжийг дагаж мөрдөх шаардлагатай.</p> |
| <p>Төсөлд оролцогч талуудын хамтын ажиллагаа</p> | <p>БОНС 10: Зээлдэгч нь төсөл хэрэгжих хугацааны туршид оролцогч талуудын оролцоо болон мэдээллийн ил тод байдлыг хангана.</p> <p>Талуудын оролцооны мөн чанар, хамрах хүрээ, давтамж нь төслийн мөн чанар, цар хүрээ, түүний болзошгүй эрсдэл, нөлөөлөлтэй шууд хамааралтай байна.</p> <p>Зээлдэгч нь бүх оролцогч талуудтай үр дүнтэй зөвлөлдөх уулзалт хийх, оролцогч талуудыг цаг тухайд нь холбогдох мэдээллээр хангах шаардлагатай.</p> | <p>Хууль тогтоомжийн тухай хуульд (2015 он) хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлэхээс өмнө олон нийт болон оролцогч талуудтай зөвлөлдөж саналыг тусгахыг шаарддаг.</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд (2011) төрийн байгууллагууд олон нийтэд тогтмол мэдээлэх мэдээллийн төрлийг зааж өгсөн байдаг бөгөөд захиргааны журмын төслийг оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлагыг тусгаж өгсөн байдаг. Иймээс бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо ялгаатай байна.</p> <p>Төрийн аудитын тухай хууль (2015) -д хууль санаачлагч, төрийн байгууллага, албан тушаалтан, нутгийн захиргааны</p> | <p>Төслийн БОНУХ-нд төслийн үйл ажиллагааны үйл ажиллагааны болон үнэлгээний явцад гол оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах шаардлагыг тусгасан.</p> <p>Талуудын оролцооны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан бөгөөд БОНУХ-нд олон нийтэд мэдээлэх болон төслийн нөөцийг ил тод мэдээлэх журмыг тодорхойлсон (хэсэг 3.7).</p> <p>Төслийн үйл ажиллагааны явц, хяналт-шинжилгээний үр дүнг бүх оролцогч талуудад тайлагнаж, мэдээлнэ.</p> <p>Төсөл нь Засгийн газрын өргөдөл гомдол барагдуулах механизмыг ашиглах</p> |

| | | | |
|--|--|---|--|
| | | <p>байгууллагууд шийдвэр гаргахаасаа өмнө дараах асуудалд аудит хийхээр заасан байна. Үүнд:</p> <p>Хууль, тогтоомжийн төсөл, нийтийн ашиг сонирхлыг хөндөх асуудал, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх., татварын тухай хууль, төсвийн орлого, зарлагын асуудлыг хянах.</p> <p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995 он, нэмэлт, өөрчлөлт орсон) нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, санал, хүсэлтээ илэрхийлэхтэй холбоотой иргэдийн эрхийг тогтоож өгсөн бөгөөд бүх шатны төрийн байгууллагуудын гомдол барагдуулах механизм, үйл явцыг тодорхойлсон байдаг.</p> | <p>бөгөөд ТХН-д тодорхой үүрэг оногдуулах болно (4-р хэсэг).</p> |
|--|--|---|--|

2.3 Төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн үндсэн мэдээлэл

Хүн ам: Монгол Улс нь нийт 3.2 сая орчим хүн амтай бөгөөд үүний 2.2 сая (68%) нь хот суурин газарт амьдарч байгаа бөгөөд эдгээрийн 1,3 сая хүн нь улсын нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Сүүлийн хорь гаруй жилийн хугацаан дах байгаль орчин, эдийн засгийн хямралаас үүдэн хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн улам бүр нэмэгдсээр байна.

Байршил, уур амьсгал: Монгол улс нь Азийн хойд хэсэгт оршдог далайд гарцгүй орон бөгөөд 1.6 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Хүн амын нягтралын хувьд нэг хавтгай дөрвөлжин километр 1.9 хүн оногддог буюу хүн амын хамгийн сийрэг суурьшилтай орон юм. Монгол орны газарзүйн байршил нь дийлэнхдээ далайн түвшнээс дээш 914 м-ээс 1524 м-ын хооронд өргөгдсөн байдаг. Монгол улс нь эх газрын уур амьсгалтай бөгөөд жилийн хур тунадасны хэмжээ 50 мм-ээс 450 мм-ийн хооронд хэлбэлздэг бөгөөд болзошгүй ууршилтын тархалт ихэнх нутгаар 500 мм-ээс дээш байдаг. Эдгээр газарзүйн болон цаг уурын шинж чанарууд нь орчны агаарын чанарын асуудлыг улам бүр хурцатгаж байгаа бөгөөд ялангуяа энэхүү асуудал нь Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд их байна.

Байгаль орчны тулгамдсан асуудал: Улаанбаатар хот болон төв, суурин газруудын хувьд агаарын бохирдол нь байгаль орчны тулгамдсан асуудлуудын нэг юм. Агаарын чанарт олон тооны бохирдуулагч эх үүсвэрүүд нөлөөлдөг. Үүнд:

- Нүүрсээр ажилладаг цахилгаан станцууд,
- Хүйтний улирал дах айл өрхүүдийн халаалт,
- Тээврийн гол зорчих хэсэг болох шороон зам гэх мэт.

Түүнчлэн Монгол орны өмнө тулгараад байгаа байгаль орчны бусад томоохон асуудалд цөлжилт (өмнөд болон баруун бүсэд өндөр мэдрэмжтэй), хот суурин газрын усны бохирдол, хог хаягдлыг боловсруулах хүчин чадал дутмаг байдал зэрэг орж байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх эдийн засгийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, жендерийн тэгш байдал. Монгол улсын нийт ажиллах хүч 1.3 сая хүн байгаагийн 53.5% нь эрэгтэйчүүд, 46.5% нь эмэгтэйчүүд байна. Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) буурч байгаа бөгөөд 2009 онд 61.4% байсан бол одоо 60.5% байна. Эмэгтэйчүүдийн АХОТ, ялангуяа хот суурин газрын эмэгтэйчүүдийн хувьд буурч байгаа нь нийт АХОТ-ний бууралтад ихээхэн хэмжээгээр нөлөөлж байна гэж үзэж байна. Энэ нь 2009 онд 56.5% байсан бол 2019 онд 53.4%-ийг эзэлж байна. Эмэгтэйчүүдийн хувьд АХОТ бага байгаа нь хүүхэд төрүүлэх болон хүүхдийн цэцэрлэгийн хүрэлцээ муу байгаагаас хүүхдээ өөрөө асрах зэрэг үүрэг хүлээж байгаа зэрэгтэй холбоотой гэж үздэг.

Хүснэгт 5-д Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтийг харуулсан. Монгол Улсын хувьд ажилгүйдлийн түвшин тогтмол өндөр хэвээр байсаар байна. 2019 онд ажилгүйдлийн түвшин 10.0% байсан бөгөөд хот суурин газрын иргэдийн хувьд мөн өндөр байна. Бусад насны бүлгүүдтэй харьцуулахад 15-24 насны залуучуудын хувьд ажилгүйдлийн түвшин өндөр (25.3%) байгаа бөгөөд залуу эмэгтэйчүүдийн ажилгүйдэл залуу эрэгтэйчүүдээс их байна. Ажлын байрны хомсдол, ялангуяа ажлын туршлага багатай залуучууд болон бусад эмзэг бүлгийнхний хувьд урт хугацааны шинж чанартай байна. КОВИД-19 цар тахлын

хямралаас өмнө ч ажилгүй залуучуудын 40 хувь нь хоёроос дээш жил ажилгүй байсан бөгөөд дунджаар залуучуудын 30 хувь нь хоёр жил гаруй хугацаанд хүлээсний дараа анхны ажилдаа орсон байна.

Хүснэгт 5: Хөдөлмөрийн зах зээлийн зарим гол үзүүлэлтүүд, хүйсээр болон байршлаар

| | Улсын түвшинд | | | Хот, суурин газар | | | Хөдөө | | |
|--------------------------|---------------|---------|---------|-------------------|---------|---------|-------|---------|---------|
| | Нийт | Эрэгтэй | Эмэгтэй | Нийт | Эрэгтэй | Эмэгтэй | Нийт | Эрэгтэй | Эмэгтэй |
| Ажиллах хүчний оролцоо % | 60.5 | 68.3 | 53.4 | 56.8 | 65.3 | 49.4 | 71.0 | 76.3 | 65.6 |
| Ажил эрхлэлт % | 54.4 | 60.8 | 48.7 | 49.8 | 56.3 | 44.3 | 67.4 | 72.5 | 62.1 |
| Ажилгүйдэл % | 10.0 | 11.0 | 8.9 | 12.2 | 13.8 | 10.4 | 5.1 | 5.0 | 5.3 |

Эх сурвалж: ҮСХ-ны 2019 оны ажиллах хүчний судалгаа

2019 оны байдлаар хөдөө аж ахуйн бус салбарын нийт ажиллагсдад албан бус ажил эрхлэгчдийн эзлэх хувь 22.8 % байгаа бөгөөд энэ нь сүүлийн 10 жилийн хугацаанд аажмаар буурч байна (2009 онд 24.9%). Хөдөө аж ахуйн бус салбарт ажилчдын 25.6% нь эрэгтэйчүүд, 19.8% нь эмэгтэйчүүд байна.

КОВИД-19 цар тахал нь Монгол Улсын ажиллах хүчний эрэлт, хэрэгцээтэй холбоотой асуудалд улам бүр дарамт болж байна. Түүхий эдийн үнийн огцом уналт, дэлхий нийтийн эрэлт багассан, цар тахлын тархалтыг зогсоох зорилгоор хөдөлгөөн, эдийн засгийн үйл ажиллагааг хязгаарласан зэрэг нь олон тооны ажил олгогч болон ажилтнуудын хувьд сэтгэл зовоосон асуудал болж байна. КОВИД-19 цар тахлын хямралаас өмнө ч эмэгтэйчүүд, улирлын чанартай ажилчид, хөдөөгөөс хот руу шилжиж ирэгсэд, залуучууд гэх мэт хүн амын бүлгүүдэд албан бус хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл болон хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй байдлын түвшин харьцангуй өндөр байсан.

Ядуурал. Хүн амын ядуурлын түвшин 2018 онд 28.4% байсан бөгөөд хүн амын 15% нь ядуурлын түвшинтэй ойр амьдарч байна. Ядуурлын түвшин байнгын өндөр байгаа нь Засгийн газрын хөгжлийн хөтөлбөрт байнгын сорилт болсоор ирсэн. 2016-2018 онд ядуурлын түвшин харилцан адилгүй байсан буюу хөдөө орон нутагт буурч байсан бол хотод буураагүй байна. Ядуурал нь хот, суурин газраас (27.2 хувь) хөдөө орон нутагт (30.8 хувь) илүү өндөр байгаа боловч хүн амын гурван хүн тутмын хоёр нь хотод амьдардаг буюу арав ядуу иргэний зургаа нь хот суурин газарт амьдарч байна. Хот суурин газрын ядуурлыг бууруулах ажилд тодорхой ахиц гарахгүй байгаа бөгөөд үүнд хүн амын хамгийн ядуу хэсгийн цалингийн өсөлт зогсонги байдалтай байгаа нь ихээхэн нөлөөлж байна. Харин мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан орлогын өсөлттэй зэрэгцэн ядууралд чиглэсэн нийгмийн хамгааллын хөтөлбөрийг өргөжүүлсэн нь хөдөө орон нутагт ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулсан байна. Хөдөлмөрийн насны хүн амын дунд (15-аас дээш насныхан) ажилгүй, эдийн засгийн идэвхгүй хүн ам хамгийн ядуу байна⁴.

⁴ <https://www.worldbank.org/en/country/mongolia/publication/mongolia-poverty-update>

Үндэстний ба цөөнхийн бүлэг. Монгол улсад уугуул иргэдийн албан ёсны бодлого гэж байхгүй бөгөөд Монголын улсын хүн амын дийлэнх хувийг халх монголчууд (уугуул иргэд) эзэлдэг. Монгол улс 30 орчим угсаатны бүлэгтэй бөгөөд угсаатны дийлэнх нь монгол хэлээр (давамгайлсан халх аялгаар) ярьдаг. Монголчуудын үндэстний цөөнхөд Тувачууд, Цаатнууд (цаа бугачид) багтдаг. Монгол улсад амьдардаг түрэг угсаатны хамгийн том төлөөлөгч бол Казахууд юм. 1940 онд Казахын зарим овог аймгууд Монгол улсад оршин суухыг хүссэн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас тэдэнд Баян-Өлгий аймагт байнгын оршин суух зөвшөөрөл олгосон. Одоогийн байдлаар Баян-Өлгий аймаг нь 93,000 хүн амтай бөгөөд тэдний 93.0% нь Казахууд, 7% нь тувачууд болон бусад монгол хэлээр ярьдаг угсаатнууд байна. Монгол улс ардчилалд шилжсэнээс хойш Баян-Өлгий аймгийн Казах хүүхдүүд голчлон казак хэл дээр сурч эхэлсэн. Гэхдээ эдгээр хүүхдүүдэд Монгол хэлийг чанартай, сайн сурах боломж хязгаарлагдмал байгаагаас Казах залуучууд цаашид суралцах, хөдөлмөр эрхлэхэд хэлний бэрхшээлээс шалтгаалсан саадтай тулгарсаар байна. Өөр нэг аймаг бол Ховд аймаг бөгөөд хамгийн олон үндэстэн, угсаатны өлгий нутаг юм.

Ковид-19 цар тахал. Монгол Улсын эдийн засаг, ажил эрхлэлт, амьжиргаанд КОВИД-19 цар тахлын үзүүлэх нөлөө мэдэгдэхүйц их байна. Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөө нь их бөгөөд өргөн цар хүрээг хамарсан. 2020 онд эдийн засаг -5.3% -иар буурч, КОВИД-19 цар тахал нь жижиг болон үйл ажиллагаа нь дөнгөж эхэлж байгаа аж ахуйн нэгжүүд, аж үйлдвэр, аялал жуулчлал, худалдаа, тээвэр, барилга, боловсролын салбар зэрэг дэх бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт ихээхэн нөлөөлсөн.

Гэхдээ Засгийн газраас үзүүлж буй эдийн засгийн дэмжлэг нь бизнесээ хаах, зогсоох хүндрэлээс сэргийлж чадсан юм⁵. Иймээс албан салбарт ажиллагсад цар тахлын үзүүлэх нөлөө харьцангуй бага байсан. 2020 оны 3, 4-р улирлын ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 2019 оны мөн үеийнхээс бага байсан. Гэхдээ ажилгүйдлийн тэтгэмж авч буй цөөн хүний тооны цаана ажилгүй болж байгаа залуу ажилчид болон албан салбарт шинээр элсэгчдийн бодит нөхцөл байдал нуугдаж байж болох юм. Учир нь тэд хамгийн сүүлд ажилд орж, хамгийн түрүүнд халагдсан байх магадлалтай⁶.

Албан салбарын аж ахуйн нэгжүүдийг дэмжих эдийн засгийн дэмжлэгт ажил олгогч болон тэдний ажилтны 2020 оны 4-р сараас 2021 оны 6-р сар хүртэлх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн хөнгөлөх, аж ахуйн нэгжүүдийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг хойшлуулах, 2020 оны 12-р сараас 2021 оны 6-р сар хүртэлх хугацааны аж ахуйн нэгжийн цахилгаан, нийтийн аж ахуйн төлбөрийг хөнгөлөх зэрэг дэмжлэгүүд орж байна. Мөн 2021 оны 3-р сараас эхлэн Засгийн газраас бичил бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрүүдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр (2.0 их наяд төгрөг) болон ноолуур, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Гэхдээ эмзэг бүлгийн ажилчдын хувьд тийм ч сайнгүй байна. Хамгийн бага ур чадвар шаардах албан бус салбарт ажилладаг, эдийн засгийн хязгаарлагдмал нөхцөл байдал болон ажлын байрны хамгаалалт муутай нөхцөлд ажилладаг гишүүнтэй өрхүүдийн болон ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр амьдарч буй

⁵ Дэлхийн банк, Монгол Улсын эдийн засгийн тойм, 2021 оны 2-р сар

⁶ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2021 оны 3, 4-р улирлын хөдөлмөрийн зах зээлийн эмхэтгэл (mesr.mn хаягаар орж үзэх боломжтой).

өрхүүдийн хувьд ядууралд өртөх эрсдэл хамгийн өндөр байна⁷. Засгийн газраас өрхөд шууд мөнгөн тэтгэмж олгох нь өрхийн орлогод үзүүлэх сөрөг цочролыг хэсэгчлэн бууруулахад тусалдаг. Энэ хүрээнд төрөөс айл, өрхөд дараах дэмжлэгийг үзүүлж байна. Үүнд: 2021 оны 4-р сараас 2021 оны 6-р сар хүртэлх хугацаанд Монгол улсын 18-аас доош насны хүүхэд бүрт сар бүр 100,000 төгрөгийг (33 орчим доллар) бэлэн мөнгөөр олгох, зорилтот бүлгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 188,000 төгрөг байсныг 2020 оны 5-р сараас 2021 оны 6-р сар хүртэл 288,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн, 2020 оны 5-р сараас 2021 оны 1-р сар хүртэл ядуу өрхүүдийн хоол хүнсний дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлсэн, 2021 оны 4-р сард Монгол улсын иргэн бүрд 300,000 төгрөгийг (105 орчим ам.доллар) олгосон, сайн дураараа нийгмийн даатгал төлөгчдийн шимтгэлийг 2020 оны 4-р сараас 2021 оны 6-р сар хүртэлх хугацаанд бүрэн буюу хэсэгчлэн хөнгөлсөн, 2020 оны 12-р сараас 2021 оны 6-р сар хүртэл айл өрхийн цахилгаан, байр, орон сууцны төлбөрийг хөнгөлсөн зэрэг болно.

3. Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллийг удирдахтай холбоотой үндсэн чиг үүрэг

3.1 Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөний хэрэгжилт

ХНХЯ болон төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төслийн үнэлгээний үе шатанд боловсруулсан “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” (БОНХТ)-г хэрэгжүүлж ажиллана (Дэлхийн банкны вэбсайт дээр 2020 оны 6-р сарын 2-ны өдөр, ХНХЯ-ны вэбсайт дээр 2020 оны 5-р сарын 27-нд нийтлэгдсэн). БОНХТ-нд төсөл хэрэгжих хугацааны туршид БОНС-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлсон. БОНХТ-г Дэлхийн банкны БОНС-тай нийцүүлэн боловсруулсан бөгөөд төсөлтэй холбоотой БОНС-ын шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан. БОНХТ нь албан ёсны гэрээний нэг хэсэг болох бөгөөд ХНХЯ болон түүний хэрэгжүүлэгч агентлагууд нь БОНХТ-д заасан хугацааны дагуу тодорхойлсон арга хэмжээ, үйл ажиллагааг хичээнгүйлэн хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хяналт-шинжилгээ, тайлагналтын нэг хэсэг болгон авч үзнэ.

ХНХЯ нь БОНХТ-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарч үзнэ. Үүнд:

- БОНХТ-д заасан арга хэмжээ, үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу үр дүнтэйгээр хэрэгжүүлэх;
- БОНХТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардал болон боломжит санхүүгийн нөөцийг бүрдүүлэх
- БОНХТ-г хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, журмаар хангах болон мэргэшсэн ажилтнуудын тогтвортой байдлыг хангах;
- БОНХТ-ний хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.

Дараах хэсгүүдэд БОНУХ болон БОНХТ-г хэрэгжүүлэх, хянах, тайлагнах арга хэлбэрийг танилцуулах болно.

3.2 Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн нөхцөл

ОБҮДХЭТ-д зориулсан “Хөдөлмөрийн удирдлагын журам” (ХУЖ)-ийг

⁷ Дэлхийн банк, Монгол Улсын эдийн засгийн тойм, 2021 оны 2-р сар

боловсруулсан (Хавсралт 1). Хөдөлмөрийн удирдлагын журам нь төслийн үйл ажиллагаанд оролцож буй ажилчдад хамаарах бөгөөд үүнийг төслийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийн шинж чанар, түвшнийг харгалзан авч үзэж боловсруулсан.

Хөдөлмөрийн удирдлагын журам нь дараах асуудлуудыг хамарна. Үүнд:

- Төслийн ажилчдын төрлийг тодорхойлох
- Төслийн ажилчдад учирч болох эрсдэлийн шинж чанар, түвшнийг тайлбарлах,
- Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, тогтоомж болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн удирдлагын сайн туршлагыг танилцуулах;
- КОВИД-19 цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах талаар анхаарах,
- Төслийн ажилчдыг төслийн гомдол барагдуулах механизмыг ашиглах боломжоор хангах
- Хөдөлмөрийн удирдлагын журмын жишээ

Хөдөлмөрийн удирдлагын журам нь хатуу тогтсон баримт бичиг биш бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад шинэчилж, өөрчилж болно.

ХНХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгж нь холбогдох худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд эдгээр холбогдох шаардлагыг багтаах бөгөөд хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.3 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх жижиг хэмжээний барилгын ажлын байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах

Үйл ажиллагаа. 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ОБҮДХЭТ нь ХХҮЕГ-ын барилгын засварын ажлыг санхүүжүүлнэ. Энэхүү барилгын засвар нь ХХҮЕГ-ын сургалтын өрөө, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний танхим, серверийн өрөөний жижиг хэмжээний засвар, шинэчлэлийн ажлыг хамарна.

Болзошгүй эрсдэл болон нөлөөлөл. ХХҮЕГ-ын оффис нь хүмүүсийн хөл хөдөлгөөн ихтэй хотын хэсэгт байрладаг бөгөөд амьд биетийн амьдрах орчин болон хуулиар хамгаалагдсан соёлын өвийг хамарсан газарт хамаарахгүй. Тиймээс засварын ажил нь биологийн төрөл зүйл болон соёлын өвд сөргөөр нөлөөлөхгүй байна. Ажилчдын түр байр, ажилчдын шилжилт хөдөлгөөн, замын хөдөлгөөнд саад учруулах зэрэг эрсдэл үүсэхгүй гэж таамаглаж байна. Энэхүү богино хугацааны засвар, шинэчлэлийн ажлын явцад үүсгэж болзошгүй байгаль орчны нөлөөлөлд иргэний барилгын үйл ажиллагаатай холбоотой дуу чимээ, тоос шороо, хатуу хог хаягдал гарах асуудлууд багтана. Эдгээр нөлөөлөл нь бага хэмжээтэй, орон нутгийн шинжтэй, түр зуурынх бөгөөд цэвэрлэх арга хэмжээ авах, материалын зөв хадгалалт, байгууламжийг түр хугацаагаар хаах, хатуу хог хаягдлыг зайлуулах, бохирдлыг хянах зэрэг иргэний барилгын ажлын зөв дадлыг нэвтрүүлэх замаар эрсдэлийг багасгах боломжтой юм. Гарч болзошгүй ХАБЭА-н асуудлууд нь ихэвчлэн иргэний барилгын ажлын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх ХХҮЕГ-ын барилгын засварын ажил нь дулаан хадгалах хана, тасалгааг ашиглавал асбест агуулсан материалыг ашиглах магадлалтай юм. (Асбест агуулсан материалтай холбоотойгоор үүсэж болох эрүүл мэндийн асуудлыг Хавсралт 2-оос үзнэ үү).

Нөлөөллийг бууруулах стратеги. ХНХЯ болон төсөл хэрэгжүүлэгч нэгж нь засвар, шинэчлэлийн ажлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 1) Төсөл хэрэгжүүлэх нэгж нь шинэчлэл, тохижилтын зураг төслийг боловсруулах гэрээт зөвлөхүүдийн ажлын даалгавар болон зөвлөхийн гэрээнд дараах үүргийг тусгасан байна. Үүнд:
 - Дэлхийн банкнаас гаргасан “Асбест, үйлдвэрлэлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд”-ийн сайн туршлагауудын талаарх тэмдэглэлийн Хавсралт 2 буюу засвар шинэчлэлийн ажилд асбест агуулсан материалыг ашиглахаас зайлсхийх гэснийг дагах
 - Холбогдох байгууламжуудыг шалган төлөвлөсөн ажлуудын хүрээнд асбестын аюул учруулах эсэхийг тодорхойлох;
 - Асбестын аюултай зүйл байгаа эсэх талаар тодорхой дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж төсөл хэрэгжүүлэх нэгжид бичгээр мэдэгдэх
 - Шинэчлэлт, засварын ажилд асбестын аюул учруулж буй ажлын тодорхой байршил, хэсгийг зааж өгөх.
- 2) Төсөл хэрэгжүүлэх нэгж нь барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах баримт бичиг болон гэрээнд дараах гүйцэтгэгчийн хүлээх үүргийг тусгана. Үүнд:
 - Нийт ажилчдад Монголын улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон асбест агуулсан материалтай зөв харьцах, зайлуулах талаарх холбогдох хууль, тогтоомж, шаардлагыг мөрдүүлэх.
 - Засварын ажлын явцад асбест агуулсан материалыг шилжүүлэх, хог хаягдлыг зайлуулах, ашиглахад Дэлхийн банк группийн “Асбест, үйлдвэрлэлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд”⁸ (Хавсралт 2)-ын сайн туршлагауудын тэмдэглэлийг дагах
 - Байгаль орчны жишиг практик дүрэм (Хавсралт 3)⁹ -д заасан иргэний барилгын ажлын сайн туршлагыг хэрэгжүүлэх
 - Хөдөлмөрийн удирдлагын журамд тусгагдсан гэрээт ажилчидтай холбоотой холбогдох заалт, хэсгүүдийг зөвлөлдөх, хэрэгжүүлэх.
- 3) Барилгын засварын ажлыг гүйцэтгэгчийн ажлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хяналт тавих зорилгоор гэрээгээр ажил гүйцэтгэж буй бүх зөвлөхүүдийн ажлын даалгавар болон гэрээнд дараах үүргийг тусгана. Үүнд:
 - Дэлхийн банкнаас гаргасан “Асбест, үйлдвэрлэлийн болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд” (Хавсралт 2)-ын сайн туршлагауудын зөвлөмжийг дагах
 - Асбестын эрсдэлийн менежментийг хянах, үнэлэх (хэрэв тухайн засварын ажилд асбестын аюул тогтоогдсон бол)
 - Гэрээгээр ажил гүйцэтгэгчдийн үйл ажиллагаа муу, гэрээний үүргээ зөрчсөн талаар төсөл хэрэгжүүлэх нэгжид тухай бүр мэдээлэх.

Энэхүү үйл ажиллагааг хариуцсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан болон

⁸ Тэмдэглэлд асбестын хортой холбоотой эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлох, эдгээр эрсдэлийг багасгах олон улсын сайн туршлагын талаарх мэдээллийг жагсаасан байх бөгөөд асбест агуулсан бүтээгдэхүүний оронд ашиглаж болох зарим хувилбарыг тайлбарласан. Энэхүү тэмдэглэл нь Дэлхийн банк группийн байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны үндсэн суурь, агуулга бүхий гарын авлагын нэмэлт мэдээлэл юм. Дэлхийн банк группээс зээл олгох болон бусад хэрэгслээр дэмжлэг үзүүлж буй төслүүдэд ихэвчлэн хүлээн зөвшөөрдөг асбестын талаарх ерөнхий туршлагауудыг энэхүү байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамжид тусгасан болно.

⁹ Барилгын жижиг хэмжээний засварын ажил хэрэгжүүлэх төслийн хүрээнд байгаль орчны жишиг практик дүрмийг тохируулан ашиглаж болно.

зөвлөхүүд нь 1-р бүрэлдэхүүн хэсгийн (Хавсралт 4) хүрээнд хийгдэх засварын ажлын байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа болон нийгмийн үйл ажиллагааны хяналтын жагсаалтад орсон шалгуур тус бүрээр хяналт тавьж ажиллана.

4) Гүйцэтгэгчийн зүгээс асбест агуулсан материалыг зайлуулах аргачлалыг боловсруулна. Энэхүү аргачлал нь ажилчид болон олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэх бөгөөд Банкны удирдамж болон Монгол улсын “Асбестыг ашиглах аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г (2020 оны 2-р сарын 03-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооноос баталсан) дагаж мөрдөнө. Аргачлалд дараах зүйлийг анхаарч үзнэ:

- i. Эрсдэлийн үнэлгээ - асбестын агууламж, ажилчдад учруулах эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.
- ii. Ажил эхлэхээс өмнө буулгах, сэргээн засварлах, засвар үйлчилгээ хийх ажлын талаар хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын асуудал хариуцсан байгууллагад (Мэргэжлийн хяналтын газар, НМХГ) мэдэгдэх.
- iii. Ажлын зааварчилгаа бүхий ажлын төлөвлөгөө - ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын техникийн болон хувийн хамгаалалтын арга хэмжээг тодорхойлно. Ажилчдад өгөх ажлын зааварчилгааг товч бөгөөд тодорхой томъёолсон байх ёстой.
- iv. Төслийн оролцогч талуудын сургалт, гүйцэтгэгч ба ажилчдын сургалт: анхан шатны болон одоо явуулж буй сургалтыг төлөвлөж баримтжуулсан байх ёстой.
- v. Асбестыг тээвэрлэх, хадгалах, зайлуулах асуудал

Аргачлалыг НМХГ-ын ХАБЭА-н хэлтэс хянан батална.

5) Төслийн хүрээнд хийгдэх засварын ажлын гүйцэтгэгчээр сонгогдсон байгууллагын ажилчид “Ажлын байрны ёс зүйн дүрэм”-тэй танилцан гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Ажлын байрны ёс зүйн дүрэм нь ажиллагсад олон нийтийн газар болон ажлын байран дээр хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийллийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ёс зүйн болон үүрэг, хариуцлагын асуудлыг тусгасан байна. ХНХЯ-ны зүгээс гэрээгээр ажил гүйцэтгэгч нар нь “Ажлын байрны ёс зүйн дүрэм”-ийн зорилго, агуулгын талаар өөрсдийн ажилчдадаа мэдээлэл өгөх, ажилчин тус бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих гэсэн шаардлага тавих бөгөөд үүнийг тендерийн баримт бичиг болон гэрээнд тусган баталгаажуулна. “Ажлын байрны ёс зүйн дүрэм”-ийн жишээг ХУЖ-ын Хавсралт 1-д тусгасан.

3.4 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дэмжигдсэн бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчны эрсдэлийг арилгах, нийгмийн нөлөөллийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа. 2.1 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсөл нь бичил бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг (ихэвчлэн бичил зээл хэлбэрээр) болон төрөл бүрийн санхүүгийн бус үйлчилгээг үзүүлнэ. Бичил зээлийн хэмжээ 1,750-3500 ам.долларын хооронд байх бөгөөд зээлийн хугацаа 24 сар хүртэл байна. Жижиг зээлийг КОВИД-19 цар тахлын эдийн засгийн хямралын нөлөөнд хамгийн их өртөж буй хөдөлмөрийн зах зээл дээрх хүндрэл, бэрхшээлтэй илүү их тулгарч байгаа одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр үйл ажиллагаа эхэлж буй бичил бизнес эрхлэгчдэд олгоно. Нөгөөтээгүүр төсөл нь ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, ялангуяа өсөн нэмэгдэж буй бүтээмжтэй бичил бизнесийн салбарыг хөгжүүлэхэд тулгарч буй

хөдөлмөрийн зах зээлийн хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх болно. Жижиг зээлийн хүрээнд тухайн бичил бизнес эрхлэгч шаардлагатай байгаа тоног төхөөрөмж болон бараа материал, түүхий эд худалдан авах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл нь ХЭДТ-ийн хүрээнд авч үзсэн үр шим хүртэгчдийн үйл ажиллагааны чиглэлтэй төстэй байх болно¹⁰.

ХЭДТ-ийн үр шим хүртэгчдийн 39% нь хүнсний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч, 22% нь үйлчилгээ (үсчин, цэвэрлэгээ, гутал, цаг, цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ), 19% нь боловсруулах болон бусад үйлдвэрлэл (оёдол, сүлжмэл, нэхмэл, арьс ширэн эдлэл, мужаан, төмөр хийц, барилгын материалын үйлдвэрлэл), 11% нь хөдөө аж ахуй, газар тариалан, сүү, цагаан идээ боловсруулах, 9% нь авто засвар, авто угаалга, сэлбэг хэрэгслийн худалдаа эрхлэгч байсан.

Бичил бизнесийн саналыг шалгах, жижиг зээл олгох болон батлахдаа энэ хэсэгт дурдсан тодорхой стратегиудыг харгалзан үзэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлагад заасан журмын дагуу зохион байгуулна. ХЭДС-ий гарын авлагыг ХНХЯ батална.

Болзошгүй эрсдэл болон нөлөөлөл. Төсөл нь байгаль орчин болон нийгэмд их хэмжээний эрсдэл учруулахуйц бичил үйлдвэрүүдийг санхүүжүүлэхгүй тул төслийн хүрээнд байгаль орчин болон нийгэмд ямар нэгэн мэдэгдэхүйц болон эргэлт буцалтгүй, их хэмжээний нөлөө үзүүлэх магадлал бага байна. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санхүүжүүлэх үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн үр дагаврын хувьд бага буюу дунд зэргийн эрсдэлтэй байх болно. Эцсийн байдлаар бичил бизнес эрхлэгчдэд зээл олгох ажлыг сонгогдсон санхүүгийн байгууллага гүйцэтгэх бөгөөд төслийн хүрээнд дэмжлэг авах бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчны асуудлыг анхааран үзэх болно.

Нөлөөллийг бууруулах стратеги. Нэгт, бичил бизнесийн саналын байгаль орчин болон нийгэмд учруулах эрсдэлийг нягталж үзэх бөгөөд төслийн хүрээнд байгаль орчин болон нийгэмд ихээхэн эрсдэл учруулахуйц бичил бизнесийг санхүүжүүлэхгүй. Сонгон шалгаруулалт хийхдээ төслийн хүрээнд санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг ашиглах бөгөөд зөвхөн дунд болон бага эрсдэлтэй бичил бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Энэхүү зорилгоор ХЭДС-ын гарын авлагад¹¹ бичил зээлийн хүсэлт гаргагчийн ашиглах загварыг тусгах болно. Хоёрт, ОСБ-ын зүгээс тухайн хүсэлт гаргагч нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ерөнхий удирдамж болон салбарын удирдамжийг дагаж мөрдөхийг шаардах болно. Мөн адил энэ хүрээнд ХЭДС-ын гарын авлагад бичил зээлийн хүсэлт гаргагчийн ашиглах загварыг тусгах болно. Гуравт, ОСБ нь байгаль орчинд "дунд зэргийн нөлөөтэй" гэж тодорхойлогдсон салбаруудад хамаарах бичил аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны сөрөг нөлөөллийн үнэлгээг ХЭДС-ын гарын авлагад тусгагдсан загварыг ашиглан гүйцэтгэнэ. Энэхүү үйл ажиллагааг зөвхөн батлагдсан дэд төслүүдийн хүрээнд авч үзэх болно.

Дөрөвт, ОСБ нь бичил бизнес эрхлэгчтэй байгуулах жижиг зээлийн гэрээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, эдгээрийг зохицуулах талаарх зээлдэгчийн хариуцлагыг тодорхой тусгаж өгөх болно. Түүнчлэн, ОСБ нь бичил бизнес эрхлэгчдийг Дэлхийн банкны ерөнхий болон ХНХЯ-аас баталсан салбарын байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн удирдамжаар хангаж ажиллах болно.

¹⁰ 2019-2020 онд ХЭДТ-ийн хүрээнд 21 аймагт бичил үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлсэн.

¹¹ ХЭДС-ын гарын авлага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталсан ОБУДХЭТ-ийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам юм.

Төсөл нь бичил зээл олгоход оролцох санхүүгийн байгууллагуудыг байгаль орчин, нийгмийн менежментийн чадавхтай байх асуудлыг хариуцан ажиллана. Доорх дэд бүлгүүдэд ХНХЯ, төсөл хэрэгжүүлэх нэгж болон оролцогч санхүүгийн байгууллагын зүгээс бичил бизнес эрхлэгчдийг байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллөөс хамгаалах, хяналт тавих стратеги, алхмуудыг танилцуулсан болно.

БОНУХ-ний дагуу оролцогч санхүүгийн байгууллагад тавигдах шаардлага:

- (i) Төслийн тендерийн бичиг баримтад оролцогч санхүүгийн байгууллага нь бичил зээл олгох үйл явцдаа байгаль орчин, нийгмийн удирдлагын системийг (БОНУС) нэвтрүүлэх болон ашиглах шаардлага тавина. Санхүүгийн байгууллагын энэхүү шаардлагад дараах зүйлс орно.
 - ✓ БОНУС-ийг шинээр бий болгох эсвэл санал болгож буй бичил санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, эрүүл ахуйн эрсдэлийн түвшинтэй ижил байхаар одоогийн БОНУС-ийг сайжруулах бөгөөд бичил санхүүгийн дэмжлэг авсан дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагаатай холбоотой нийт хариуцлагыг хүлээх ахлах түвшний төлөөлөгчийг томилох зэрэг БОНУС-ийн хэрэгжилтэд хяналт тавих хангалттай институтийн зохицуулалтыг бий болгоно. Сонгогдсон санхүүгийн байгууллагын БОНУС нь дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд:
 - Байгаль орчин, нийгмийн бодлого;
 - Дэд төслүүдийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, удирдах тодорхой журам;
 - Зохион байгуулалтын чадавх, чадамж;
 - Нийт төслүүд болон тодорхой төрлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянах, үнэлэх;
 - Гадаад харилцааны механизм.
- (ii) Бичил бизнес эрхлэгчийн зээлд хамрагдах бизнесийн саналыг хүлээн авахдаа хүсэлт гаргагч нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ерөнхий удирдамж болон салбарын удирдамжийг дагаж мөрдөх шаардлага тавина.
- (iii) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлагад (ХЭДСГА) тусгагдсан загварыг ашиглан байгаль орчны эрсдэлийн хувьд "дунд зэргийн нөлөөтэй"¹² гэж тодорхойлогдсон салбаруудад хамаарах бичил бизнесийн байгаль орчны эрсдэл, нөлөөллийг үнэлнэ.
- (iv) Бичил бизнес эрхлэгчтэй байгуулсан жижиг зээлийн гэрээний дагуу үр шим хүртэгчээс зээлийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны ерөнхий болон салбарын удирдамжийг¹³ нарийн харгалзан үзэж, хэрэгжүүлэхийг шаардана.
- (vi) Бичил бизнес эрхлэгчдийн нөлөөллийг шалгах болон үнэлгээ хийсэн талаарх тайланг ХХҮЕГ-т хүргүүлнэ. (ХХҮЕГ нь ХНХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлнэ).

¹² Төслийн хүрээнд бичил зээлд хамрагдах бизнес эрхлэгчид нь маш жижиг хэмжээний аж ахуйн нэгжүүд, тэр дундаа гэртээ аж ахуй эрхэлдэг. Иймээс сонгосон ОСБ-д тавих хяналт шинжилгээний шаардлагууд нь хүлээгдэж буй эрсдэл, нөлөөллүүдтэй адил байх бөгөөд зөвхөн "дунд зэргийн эрсдэл"-тэй үйл ажиллагаанд төвлөрөх болно. Бичил зээлийн санхүүжилтэд хамрагдах төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинж чанар, түвшнийг харгалзан дээр дурдсан шаардлагуудыг тодорхойлсон болно. Мөн тэдгээрийг БОНУАТ-ний шаардлагуудтай нийцэж байна гэж үзсэн.

¹³ Эдгээр удирдамжийг дараагийн хэсгүүдэд иш татсан болно.

Оролцогч санхүүгийн байгууллага болон холбогдох бүх үйл ажиллагаанд ашиглах БОНУХ-ний шаардлага, нөхцөл, гэрээ болон байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох үнэлгээний маягтуудын талаар доорх дэд хэсгүүдэд авч үзсэн. Эдгээр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлагад бүрэн туссан байх бөгөөд Дэлхийн банкны зүгээс хүлээн зөвшөөрсөн байна. Ялангуяа, төсөл хэрэгжүүлэх нэгж нь дараах шаардлага, нөхцөл, үйл явцыг тендерийн баримт бичигт тусган батлах бөгөөд бүрэлдэхүүн хэсэг 2.1-ийн хүрээнд хэрэгжүүлэх бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийн үе шатанд хэрэглэнэ.

Зээлийн өмнөх сургалт:

- I. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс (ХХҮХ) нь хариуцсан албан тушаалтнаар дамжуулан зээлийн өмнөх сургалтад хамрагдах хүсэлтэй бичил бизнес эрхлэгчдийг бүртгэх бөгөөд үүний дараа бичил зээлийн санал хүлээж авах ажлыг хэрэгжүүлнэ.
- II. ХХҮЕГ нь зээлийн өмнөх сургалтад оролцогчдод төслийн БОНУХ-ний шаардлага болон бусад хяналт, шалгалт, үнэлгээний хэрэгсэл, үйл явцын талаар хангалттай ойлголт олгоход анхаарах бөгөөд зээлийн өмнөх сургалтын чанарыг сайжруулах, холбогдох мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх ажлыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, зээлийн өмнөх сургалтын хүрээнд Дэлхийн банкны авлигын эсрэг удирдамж болон төслийн гомдол барагдуулах механизм (ГБМ) -ын талаарх ойлголтыг өгнө.

Үр шим хүртэгч болон бизнесийн саналыг шалгах болон эрсдэл, нөлөөллийн үнэлгээ хийх

Жижиг зээлд хамрагдах талаар ирүүлсэн төслийн саналын байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шалгах бөгөөд энэхүү үйл явцыг дор тайлбарласны дагуу гүйцэтгэнэ.

- (i) Жижиг зээлийн саналыг урьдчилж шалгах, сонгон шалгаруулах зорилго бүхий ХХҮХ дээр байгуулагдсан ажлын хэсэг болон энэ асуудлыг хариуцсан мэргэжилтэн нар дараах байдлаар ажил үүргээ гүйцэтгэнэ:
 - Ирүүлэн санал тус бүрийг зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны жагсаалтын дагуу байгаа эсэхийг шалгана. Хэрэв жижиг зээлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь энэхүү зөвшөөрөгдсөн жагсаалтад ороогүй байвал санхүүжүүлэхээс татгалзана (Хавсралт 5-д заасан жагсаалтыг ашиглана).
 - Онооны системийг ашиглан санал тус бүрийн техникийн чадавхыг үнэлнэ.
 - Өргөдөл гаргагчийг "ажилгүй иргэн" эсвэл "хувиараа хөдөлмөр эрхлэгч"-ийн аль статуст хамаарч байгааг ХНХЯ-ны нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн холбогдох мэдээллийн систем (мэдээллийн сан)¹⁴-ийн өгөгдөлтэй тулган шалгаж баталгаажуулна.

Эдгээр шаардлага болон холбогдох зохицуулалт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлагад тусгагдсан. Шаардлага

¹⁴ Төслийн нийгмийн үр нөлөөг бэхжүүлэхийн тулд ХХҮЕГ-ын ажилгүйдэл болон хувиараа хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэлд үндэслэсэн үр шим хүртэгчийг урьдчилж сонгон шалгаруулах системийг ашиглана. Хөдөлмөрийн насны хүмүүс санал ирүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

хангасан өргөдөл гаргагчдын нэрсийн жагсаалтыг сард ядаж нэг удаа эсвэл шаардлагатай гэж үзэл богино хугацааны давтамжтайгаар оролцогч санхүүгийн байгууллагын тухайн орон нутгийн салбарт илгээнэ.

- (ii) Оролцогч санхүүгийн байгууллага нь орон нутгийн ХХҮ-ний газар, хэлтсээс ирүүлсэн шаардлага хангасан өргөдөл гаргагчдын жагсаалтыг хүлээн авсны дараа төслийн санал тус бүрийн зээлийн чадавхыг шалган зээл олох шийдвэр гаргана. Оролцогч санхүүгийн байгууллага нь зээлийн хүсэлт гаргагч бичил бизнес эрхлэгчийн бизнесийн саналыг хүлээж авахдаа тухайн хүсэлт гаргагч нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ерөнхий удирдамж (Хавсралт 6-ын хүснэгт 6.1) болон салбарын тухайлсан удирдамж (Хавсралт 6-ын Хүснэгт 6.2)-ийг дагаж мөрдөх шаардлага тавьж, баталгаажуулна.
- (iii) Оролцогч санхүүгийн байгууллагын зүгээс ХЭДС-ын гарын авлагад тусгагдсан загварыг ашиглан "Дунд зэргийн нөлөөлөлтэй" гэж тодорхойлогдсон салбаруудад хамаарах зөвшөөрөгдсөн бичил төслүүдийн жижиг зээлийн санхүүжилт авах үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлно. "Дунд зэргийн нөлөөлөлтэй" гэж тодорхойлогдсон салбарын жагсаалтыг холбогдох загварт тодорхойлж өгөх болно.

Байгаль орчны эрсдэлийг бууруулахад чиглэсэн бичил бизнес эрхлэгчдийн үүрэг, хариуцлагыг хянах

- i. Оролцогч санхүүгийн байгууллага нь батлагдсан жижиг зээлийн үр шим хүртэгч тус бүрийг Дэлхийн банкны ерөнхий (Хавсралт 6-т заасан) болон салбарын байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамжаар¹⁵ хангана.
- ii. Оролцогч санхүүгийн байгууллага нь байгаль орчин, нийгмийн сайн туршлагыг бичил бизнес эрхлэгчдэд мөрдүүлэхийн тулд эцсийн зээлдэгчтэй байгуулах гэрээнд дараах үүрэг, хариуцлагыг тусгана.
 - a) Зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд тухайн бичил бизнес эрхлэгчд нь байгаль орчин, ажиллагсад, нийгмийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх үүднээс оролцогч санхүүгийн байгууллагаас гаргасан байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамжийг дагаж мөрдөх талаарх үүрэг, хариуцлага;
 - b) Оролцогч санхүүгийн байгууллагаас зээлд хамрагдагч хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих болон их хэмжээний зөрчлийн талаар холбогдох байгууллагуудад мэдээлэх эрх
- iii. Аймаг, дүүргийн ХХҮХ, газар нь төслийн хүрээнд дэмжлэг авч буй бичил үйлдвэрлэл, үйлчилгээнд очиж хяналт, шалгалт хийхдээ тухайн бичил үйлдвэрлэл, үйлчилгээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг хянан үзнэ. Хэрэв ноцтой зөрчлийн тохиолдол илэрвэл оролцогч санхүүгийн байгууллагын төлөөлөгч үүссэн сөрөг нөлөөллийг үндэсний хууль

¹⁵ Өмнөх төсөл болох ХЭДТ-ийн хүрээнд ХНХЯ-наас 20 салбарын удирдамжийг боловсруулсан. Шаардлагатай гэж үзвэл ХНХЯ эдгээр салбарын удирдамжийг шинэчилнэ.

- тогтоомжийн хүрээнд арилгах талаар эрх бүхий байгууллагад тайлагнана.
- iv. Оролцогч санхүүгийн байгууллага нь зохих бүрдлийг хөтлөн ХХҮЕГ-т тайланг хүргүүлнэ¹⁶. БОНУХ-ний тайлангийн бүрдэл хэсгүүд нь оролцогч санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээнд хавсаргагдах бөгөөд үйл ажиллагаатай танилцсан хяналт-шинжилгээний тайлан болон бусад тайлангийн загваруудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын Хавсралт-8-д тусгасан.
 - v. Аймаг, дүүргийн ХХҮХ, газрууд нь бичил бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа бичил үйлдвэрлэл, үйлчилгээний байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөлөлд хийсэн хяналт-шинжилгээний үр дүнг оруулсан байна.

БОНУХ болон дээр тайлбарласан үйл ажиллагаануудын хувьд оролцогч санхүүгийн байгууллагад тавигдах шаардлагыг харгалзан үзэж БОНУА-ны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахын тулд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд боловсруулсан арга хэрэгсэл, загвар, БОНС-ын удирдамжийг¹⁷ хянан үзэж шаардлагатай бол сайжруулалт хийнэ.

3.5 КОВИД-19 цар тахлаас ажилчид, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ

Корона вирус дотоодод тархсан буюу 2020 оны 11 дүгээр сарын эхэн үеэс Улсын Онцгой комиссоос улсын хэмжээнд болон тодорхой хэсэгт бүсчилсэн байдлаар хэд хэдэн удаагийн хөл хорио тогтоох шийдвэр гаргасан.

Улсын хэмжээнд тогтоосон хөл хорионы үеэр эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний ажилтнуудаас бусад засгийн газрын болон төрийн захиргааны ажилтнууд үйлчилгээ үзүүлээгүй. Түүнчлэн, хөл хорионы хооронд засгийн газрын ажилтнууд хэсэгчилсэн байдлаар буюу нийт ажилчдын 10%-30% хувь нь үйл ажиллагаа явуулж байсан ба төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд мөн адил хатуу хяналт, шаардлага тавьж байсан. Энэ нөхцөлд эдгээр төрийн үйлчилгээний албан хаагчдын ажиллах нөхцөл нь төрийн үйлчилгээний хөдөлмөрийн гэрээний дагуу болон УОК болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан журмын дагуу хэвээр байна. ТХН болон ХНХЯ-ны хэрэгжүүлэгч агентлагууд нь УОК болон Засгийн газрын шийдвэрийг дагаж мөрдөнө.

Төсөл нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ цар тахлын тархалт, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах талаар УОК болон Засгийн газраас гаргасан заавар, чиглэлийг чанд дагаж мөрдөх бөгөөд виртуал хэрэгслүүд болон олон нийтийн мэдээллийн сувгаар дамжуулан хүргэх сургалт, мэдээлэл түгээх, зөвлөлдөх үйл ажиллагааг тохируулан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Төсөл нь КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хязгаарлах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж, хариу арга хэмжээг авч ажиллах болно. Төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний танхимыг шинэчлэх, засварлах гэх мэт талбайд биечлэн гүйцэтгэх шаардлагатай ажлуудыг гүйцэтгэхдээ үйл ажиллагааг зогсоох болон үргэлжлүүлэхтэй холбоотой УОК-ын шийдвэрийг дагаж мөрдөх бөгөөд гэрээгээр ажил гүйцэтгэгчийн зүгээс хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэхийг баталгаажуулна.

УОК-ын шийдвэрийн дагуу төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг

¹⁶ Хот суурин газарт худалдаа, үйлчилгээ, жижиг үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон бизнес эрхлэгчид байдаг. Эдгээр нь ихэвчлэн хагас нийтийн буюу давхардсан орон зайд байрлан үйл ажиллагаа явуулдаг. Оролцогч санхүүгийн байгууллагаас санамсаргүй байдлаар зээлдэгчийн үйл ажиллагаа нь холбогдох ерөнхий болон салбарын БОНС-ын удирдамжтай нийцэж байгаа эсэхийг шалгах ёстой. Төслийн үр шим хүртэгчид ойролцоо байрладаг бусад бичил бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хариуцлагыг хүлээхгүй.

¹⁷ Үүнд ХНХЯ-наас боловсруулсан 20 салбарын удирдамж орно.

ажил үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрсөн буюу төслийн үйл ажиллагаанд хамрагдах боломжтой болсон тохиолдолд ХНХЯ, ТХН болон холбогдох төрийн байгууллагууд, орон нутгийн байгууллагууд тухайн ажлын байран дээр ажиллаж байгаа ажилчид болон үйлчлүүлэгчдийг КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. Ингэхдээ УОК болон Эрүүл мэндийн яамнаас гаргасан удирдамж, зөвлөмжийг дагаж мөрдөх бөгөөд холбогдох үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Төсөлд ДЭМБ-ын дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

Төсөл нь ажлын байр болон нийгэмд цар тахал тархахаас урьдчилан сэргийлэх эсвэл эрсдэлийг багасгахын тулд ДЭМБ-ын КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх удирдамжийг¹⁸ авч үзнэ. Шаардлагатай тохиолдолд төсөл нь КОВИД-19-ээс урьдчилан сэргийлэх, хянах талаарх Монгол Улсын онцгой комисс (УОК) болон Эрүүл мэндийн яам (ЭМЯ) -ны удирдамжийг дагаж мөрдөнө. Хариу арга хэмжээний төлөвлөгөөнд талуудын оролцооны төлөвлөгөөний төсөлд тусгагдсанаас бусад харилцаа холбооны арга хэрэгслийг авч үзнэ.

3.6 Авлига, хээл хахууль

Төсөл нь авилгаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах бүхий л шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- I) Авлигыг үл тэвчих зарчмыг бүх оролцогч талууд, төслийн үйл ажиллагаанд оролцож буй гуравдагч этгээд, гэрээгээр ажил гүйцэтгэгчид болон төслийн үр шим хүртэгчдэд тарилцуулах, хүргэх
- II) Дэлхийн банкны ОУСБХБ-ны зээл болон ОУХА-ийн зээл, буцалтгүй тусламжаар санхүүжүүлж буй төслүүдэд залилан мэхлэлт, авлигын асуудал гарахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх удирдамжийг (2016 оны 7-р сарын 1-ний өдөр шинэчлэн найруулсан) зөвлөхүүд, зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлж буй компаниуд, гэрээт ажил гүйцэтгэгч нартай хийх гэрээнд тусгах
- III) Төслийн гомдол барагдуулах механизмд авлигатай холбоотой ирүүлсэн гомдлыг үр дүнтэй, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх асуудлыг тусгах.

3.7 Талуудын оролцоо болон мэдээллийн ил тод байдал

Төсөл нь “Оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах төлөвлөгөө” (Хавсралт 7)-ний дагуу төслийн үргэлжлэх хугацааны туршид төсөлд оролцогч тал бүртэй тухай бүр, үр дүнтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах ажлыг хариуцна. Энэхүү “Оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах төлөвлөгөө” нь Дэлхийн банкаар зөвшөөрөгдсөн бөгөөд 2020 оны 5-р сарын 27-ны өдөр ХНХЯ-ны вэбсайт дээр олон нийтэд нээлттэй нийтлэгдсэн. Шаардлагатай тохиолдолд энэхүү оролцогч талуудтай зөвлөлдөх төлөвлөгөөг шинэчлэх бөгөөд ХНХЯ энэхүү шинэчилсэн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэх гол асуудлууд:

- (i) Төслийн хамгийн эмзэг бүлгийн үр шим хүртэгчдэд цаг тухай бүр, үр дүнтэй хүрч үйлчлэх,

¹⁸ Эдгээр техникийн удирдамжийг <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/technical-guidance> хаягаар орж үзнэ үү.

- (ii) Төслийн үйл ажиллагааны дизайн болон төслөөс үзүүлэх үйлчилгээг нарийн тодорхойлохын тулд оролцогч талууд, зорилтот буюу энэхүү төслийн үр шим хүртэгчид, эмзэг бүлгүүдийн холбогдох асуудал, хэрэгцээг ойлгох
- (iii) Үр ашигтай, асуудлыг шийдвэрлэх гомдол барагдуулах механизмыг нэвтрүүлэх болон байнгын ажиллагаатай байлгах,
- (iv) Мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр мэдээлэх. Оролцогч талын холбогдох оролцоо болон зөвлөлдөх уулзалт нь ерөнхийдөө эмзэг бүлгүүдэд хүрч үйлчлэх үр дүнтэй ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чиглэнэ. Ялангуяа Баян-Өлгий аймаг дахь Казак иргэдийн цөөнхийн хэрэгцээг авч үзнэ.

Энэхүү олон нийтэд мэдээлэл хүргэх ажлын гол нөлөөлөл нь ядуу олон эмзэг бүлгийн иргэд (урт хугацааны ажилгүйчүүд, нийгмийн халамжийн үйлчилгээ эрхлэгчид, ядуурлын шугамаас доош оноотой өрхүүд, эмэгтэйчүүд гэх мэт) хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар мэдлэгтэй болсон байх явдал юм. Төслийн хүрээнд авч үзэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар холбогдох үр шим хүртэгчдэд мэдээлэл хүргэх зорилгоор харилцаа холбоо, мэдээлэл түгээх стратегийг боловсруулна. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэх нэгж нь энэхүү БОНУХ-ний гарын авлага болон бусад холбогдох баримт бичгийг өөрийн вэбсайт дээр олон нийтэд нээлттэй байршуулна. Энэхүү стратегийн хүрээнд нийт аймаг, дүүргийн (21 аймаг, 9 дүүрэг) хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь төслийн талаарх ерөнхий мэдээлэл болон тодорхой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдээллийг харьяа нутаг дэвсгэрийн холбогдох үр шим хүртэгчдэд хүргэх шаардлагатай. (Жишээ нь: хэрхэн төсөлд хамрагдах талаар)

Төсөл нь талуудын оролцооны төлөвлөгөөний дагуу мэдээллийг ХНХЯ-ны вэбсайтаар дамжуулан тогтмол ил тод мэдээлнэ. ХНХЯ нь төслийн үнэлгээний шатанд БОНУАТ болон талуудын оролцооны төлөвлөгөөг ил тод мэдээлсэн. <https://mlsp.gov.mn/content/detail/736> холбоосоор үзнэ үү.

БОНУХ болон талуудын оролцооны төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч нэгж болон ХНХЯ-тай зөвлөлдөж олон нийтэд нээлттэйгээр хүргэсэн. Ингэхдээ гурван удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Эхний зөвлөлдөх уулзалтаар БОНУХ болон хөдөлмөрийн удирдлагын журмын анхны төслийг (2020 оны 10-р сарын эхний хагаст), хоёр дахь зөвлөлдөх уулзалтаар эдгээр баримт бичгийн шинэчилсэн төслийг (2020 оны 11-р сарын эхээр) хэлэлцсэн. Гурав дахь уулзалтыг 2021 оны 4-р сарын сүүлчээр Дэлхийн банканд баримт бичиг хүргүүлэхээс өмнө зохион байгуулсан.

Төслийн хүрээнд оролцогч талууд болон олон нийтэд дараах баримт бичгийг ил тод болгоно. Үүнд:

- 1) БОНУХ болон ГБМ-ын эцсийн хувилбар (шинэчлэгдэх бүрд мэдээлнэ)
- 2) Шинэчлэгдсэн талуудын оролцооны төлөвлөгөө;
- 3) Хөдөлмөрийн удирдлагын журам (шинэчлэгдэх бүрд мэдээлнэ);
- 4) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн гарын авлага;
- 5) Олон нийтэд зориулан бэлтгэсэн төслийн тайлан;
- 6) Сонгогдсон оролцогч санхүүгийн байгууллагын БОНУС.

4. Гомдол барагдуулах механизм (ГБМ)

Гомдол барагдуулах механизм (ГБМ) нь үр шим хүртэгчид, орон нутгийн иргэд болон бусад оролцогч талууд өөрсдийн санал, хүсэлтээ илэрхийлэх гол хэрэгсэл юм. ГБМ-ийн гол зорилго нь талуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр үр дүнтэй, түргэн шуурхай шийдвэрлэхэд туслах явдал юм. Ялангуяа энэхүү механизм нь шударга, үр дүнтэй, тогтвортой байдлыг бий болгодог ил тод, найдвартай арга хэрэгсэл юм.

4.1 Гомдол барагдуулах үндэсний механизм

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995) нь гомдлыг барагдуулах үндэсний механизмыг зохицуулдаг.

Монгол Улсын иргэн өргөдөл, гомдлоо төрийн байгууллага болон албан тушаалтанд дангаар болон хамт гаргаж, хүргүүлсэн өргөдөл, гомдлын хариуг авах эрхтэй. Иргэн өргөдөл, гомдолд нь өгсөн хариуг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй¹⁹. Мөн төрийн байгууллага, албан тушаалтан иргэний гомдлын дагуу харьяа болон доод шатны байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцах болон шийдвэрлэсэн гомдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах үүрэгтэй. Өргөдөл, гомдлыг бичгээр болон аман хэлбэрээр эсвэл цахим системээр гаргаж болно. Хуулийн дагуу төрийн бүх байгууллагыг вэбсайттай байхыг шаарддаг. Төсөл нь төслийн хэрэгжилттэй холбоотой аливаа өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ үндэсний өргөдөл, гомдол барагдуулах механизм болон төслийн тусгай өргөдөл, гомдол барагдуулах механизмд тулгуурлана.

4.2 ОБҮДХЭТ-ийн тусгай өргөдөл, гомдол барагдуулах механизм

Зорилтот үр шим хүртэгчид, гэрээгээр ажил гүйцэтгэгчид, төслийн ажилтнууд, эрх бүхий байгууллагууд болон бусад оролцогч талуудын зүгээс төслийн үйл ажиллагаатай холбоотой аливаа өргөдөл, гомдлыг гаргаж болно. Жишээ нь: тэдгээрийн мэдээлэл авах эрх нь зөрчигдсөн, төслийн зүгээс хэрэгжүүлж буй байгаль орчин, нийгмийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа, залилан, авлига, хахууль гарсан эсвэл төслийн аливаа зарчим, журам зөрчигдсөн гэх мэт.

Төсөл хэрэгжих хугацааны туршид хэзээ ч өргөдөл, гомдлоо гаргаж болно. Өргөдөл, гомдлын систем нь гомдол гаргагч болон мэдээллийн нууцын зэрэглэлийг байнга хадгална. Гомдлыг олон нийтэд ил тод зарлаж болох боловч гомдол гаргагчийн хувийн нууцыг хадгална. Төсөл нь тухайн асуудлаар гомдол гаргагчид хандсаны дараа гомдол гаргагч нь өөрийн хувийн мэдээллийн талаар олон нийтэд мэдээлж болох талаар бичгээр зөвшөөрөл олгосон тохиолдолд л хувийн мэдээллийг олон нийтэд мэдээлж болно.

Өргөдөл, гомдол хүлээж авах суваг

ОБҮДХЭТ-ийн тусгай ГБМ нь доорх Хүснэгт 2-т үзүүлсний дагуу дөрвөн сувгаар

¹⁹ Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хуулийн хугацаа хуанлийн 30 хоног бөгөөд өргөдөл, гомдол хүлээж авсан төрийн байгууллага үүнийг 30 хоногоор сунгаж болно. Засгийн газрын хэрэг эрхлэх газар нь төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын гомдлыг барагдуулах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хариуцдаг. Харин Сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар гаргасан өргөдөл, гомдлын эцсийн хариуг өгч барагдуулах асуудлыг хариуцдаг.

өргөдөл, гомдлыг хүлээж авна. Гомдол гаргагч нь аль ч байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрх нь нээлттэй тул аль ч сувгаар гомдол хүлээж авах боломжтой юм. ХЭД төслийн хүрээнд ашиглагдаж байсан дараах өргөдөл, гомдол гаргах сувгуудыг ОБҮДХЭТ-ийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах болно.

| Хүснэгт 5. Төслийн ГБМ-ийн сувгууд | | | |
|--|--|--|--|
| <p>Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн (ХХҮХ) түвшинд:</p> <p>Холбоо барих: Хариуцсан мэргэжилтэн</p> <p>Имэйл: Бүх ХХҮХ-ийн вебсайд дээр бүх холбоо барих мэдээлэл орсон бөгөөд ХХҮЕГ-ын доорх вебсайт дээрх холбоосоор орж болно.</p> <p>http://hudulmur-halamj.gov.mn/</p> | <p>Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын (ХХҮЕГ) түвшинд:</p> <p>Холбоо барих: Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн</p> <p>Имэйл: info@hudulmur-halamj.gov.mn</p> <p>Вебсайт: http://hudulmur-halamj.gov.mn/</p> <p>Утас: +976 77315091</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон</p> | <p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн (ТХН) түвшинд:</p> <p>Холбоо барих: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>Төсөл нь төслийн вэбсайтаар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээж авна. (Веб сайт аль хэдийн хийгдсэн.) Энэхүү вэбсайт нь ГБМ, санал хүсэлтийн хэсэгтэй.</p> <p>Мөн түүнчлэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар хүлээн авах боломжтой.</p> <p>Утас: +976-75057570</p> <p>Имэйл: info@mesp.mn</p> <p>Хаяг: Монгол улс, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 14200, Ерөнхий сайд Амарын гудамж, “САН” бизнес төв, 501 тоот.</p> | <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны (ХНХЯ) түвшинд:</p> <p>Холбоо барих: Хариуцсан мэргэжилтэн</p> <p>Имэйл: info@mlsp.gov.mn</p> <p>Вебсайт: www.mlsp.gov.mn</p> <p>Утас: +976-51-261553 +976-51-267635</p> <p>Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, НҮБ-ын гудамж</p> |

ТХН нь төслийн вэбсайтаар, И-мэйл хаягаар, утсаар болон амаар, бичгээр өргөдөл, гомдлыг хүлээж авна. ТХН нь төслийн оролцогч талуудад мэдээлэл хүргэх төслийн вэбсайтыг ашиглалтад оруулсан. Вэбсайт нь төслийн үр шим хүртэгчдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг бүртгэхэд зориулагдсан тусгай цэстэй байна. Өргөдөл, гомдлын дийлэнх хувийг аймаг, дүүргийн түвшинд хамаарах өргөдөл, гомдол эзэлнэ гэж таамаглаж байна. Иймээс энэ түвшинд өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, тайлагнахад хялбар байлгах үүднээс ТХН-ийн вэбсайтын ГБМ-ын цэсэд орон нутгийн түвшинд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн аймаг, дүүргийн ХХҮХ-ийн ГБМ-ийн холбогдох и-мэйлд шууд илгээж байхаар боловсруулан тохируулна.

Төсөл хэрэгжих хугацааны туршид хэзээ ч өргөдөл, гомдлыг ирүүлж болно. Өргөдөл, гомдлыг илгээхэд ямар нэгэн төлбөр төлөхгүй. Өргөдөл, гомдлыг

холбогдох хууль, тогтоомжийн дагуу бичгээр, амаар болон цахим хэлбэрээр гаргаж болно. Бичгээр гаргасан гомдолд цахим хэрэгслээр ирүүлсэн гомдлыг хамааруулна. Холбогдох үндэсний хууль, тогтоомжийн дагуу бичгээр гаргасан гомдолд овог, нэр, оршин суугаа хаяг, шуудангийн хаягийг тодорхой бичнэ. Засгийн газрын шууд утсаар (уг системийн дагуу өргөдөл, гомдлыг ХНХЯ, ХХҮЕГ, НДЕГ болон тэдгээрийн салбар хэлтсүүд рүү дамжуулдаг) болон дээрх дөрвөн сувгийн утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг амаар гаргасан гомдол гэж үзнэ.

Төсөлд ямар төрлийн гомдлыг ямар сувгаар гаргахыг тодорхой заагаагүй. Үндэсний хууль, тогтоомжид заасан ерөнхий зарчим үйлчлэх бөгөөд өргөдөл, гомдлыг дараах байдлаар гаргана. Үүнд:

- ✓ Гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтныг харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтанд,
- ✓ харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад,
- ✓ эсхүл гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллагад гаргана.

Гэсэн хэдий ч гомдол гаргагч аль ч сувгаар гомдол гаргах эрхтэй бөгөөд аль ч асуудлаар, аль ч хэрэгслийг ашиглан гомдол гаргаж болно. Гомдол гаргагч нь гомдлыг шийдвэрлэсэн байгууллагын шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд хуулийн дагуу дээд шатны байгууллага болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Төслийн хүрээн дэх үр дүнтэй ГБМ-ийн гол зарчим нь:

- i) Засгийн газрын ГБМ-ыг боломжийн хэмжээнд ашиглах;
- ii) Талууд төслийн вэбсайтаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд өөрсдийн ГБМ-аар дамжуулан шалгаж, шийдвэрлэх гомдлыг төрөл, сэдвийг тохиролцоно.

ГБМ-ийн шат дараалал

Өргөдөл, гомдлыг бичгээр эсвэл амаар (жишээлбэл утсаар) хүлээн авах бөгөөд тухайн өргөдөл, гомдлыг хүлээж авч буй сувгийн ГБМ-ийн өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

ОБҮДХЭТ-ийн ГБМ нь дараах үе шаттай байна. Үүнд:



ТХН-ийн ХШҮ-ний ажилтан болон холбогдох байгууллага бүрийн өргөдөл, гомдол хариуцсан ажилтан нь өргөдөл, гомдлыг бүртгэх, гомдол гаргагчид анхан шатны хариу өгөх, гомдлыг шийдвэрлэх үйл явцыг зохицуулах, гомдол гаргагчид эцсийн хариу өгөх болон ГБМ-ийн үйл ажиллагааны талаар тайлагнах үүрэгтэй.

Гомдол барагдуулах механизм дах ТХН-ийн үүрэг.

ТХН нь хуулиар үүрэг хүлээсэн байгууллага биш бөгөөд түүний ажилтнууд нь төрийн албан хаагчид биш юм. Иймээс ТХН нь өргөдөл, гомдлыг дангаар бие даан шийдвэрлэх эрхгүй. Гэхдээ ТХН нь ГБМ-ийн хүрээнд дараах үүрэгтэй байна. Үүнд:

- a. ГБМ-тай холбоотой тодорхой мэдээлэл, сурталчилгааны ажлыг дэмжих болон хэрэгжүүлэх;
- b. Өргөдөл, гомдлын сувгийг тасралтгүй ажиллуулах, өргөдөл, гомдлын дэвтрийг хөтлөх,
- c. өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх (ХНХЯ, ХХҮЕГ, болон аймаг, дүүргийн ХХҮХ), гомдлыг барагдуулах байгууллагын талаар гомдол гаргагчид мэдэгдэх;
- d. Холбогдох бүх байгууллагуудын ГБМ-ын гол цэгүүдтэй холбогдож өргөдөл, гомдолтой холбоотой мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх болон ГБМ-ын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн талаар тайлагнах.

4.3 Өргөдөл, гомдлын мэдээлэл болон тайлагналт

Төрийн байгууллагуудын тасралтгүй үйл ажиллагааны дагуу ХНХЯ болон ХХҮЕГ нь өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэр, мэдээллийн санг хөтлөн явуулдаг. ОБҮДХЭТ-д хамаарах тодорхой өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг ХНХЯ-ны

ТХН-д улирал бүр мэдэгдэж байх шаардлагатай. ТХН нь төслийн талаарх өргөдөл, гомдлын мэдээллийг улирал бүр цуглуулж нэгтгэнэ. ГБМ-ын мэдээлэл цуглуулах, тайлагнах ажлыг үр дүнтэй зохион байгуулахын тулд ТХН нь 21 аймаг, 9 дүүргийн ХХҮХ, ХХҮЕГ, НДЕГ болон ХНХЯ-ны холбогдох өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтнүүд болон ГБМ-ийн төвлөрсөн цэгүүдтэй тогтмол ажлын уялдаа холбоотой ажиллана. Мөн өргөдөл, гомдлын улирал тутмын мэдээний маягтыг боловсруулах бөгөөд энэхүү маягтын дагуу өргөдөл, гомдлын мэдээг гарган улирал тутам Дэлхийн банканд тайлагнана.

ТХН нь ГБМ-ын үйл ажиллагааны тайланг Дэлхийн банканд улирал бүр бэлтгэж хүргүүлэх бөгөөд хагас жилийн тайланг төслийн хэрэгжилтийн тайлангийн нэг хэсэг болгон хүргүүлнэ. Мөн жилийн эцсийн төслийн хэрэгжилтийн тайлангийн нэг хэсэг болгон ХНХЯ-нд тайлагнана.

4.4 Гомдол барагдуулах механизмын талаарх мэдээлэл, сурталчилгааны ажил

ТХН нь ГБМ-ын үр дүнтэй ажиллагааг хангахад чиглэсэн тодорхой мэдээлэл, сурталчилгааны ажлыг дэмжиж ажиллана. Үүнд:

- Оролцогч талуудад гомдол барагдуулах систем болон холбогдох үйл явцын талаар мэдээлэл өгнө. Энэхүү мэдээллийг чадавх бэхжүүлэх сургалт болон төсөлтэй холбоотой арга хэмжээнүүдийн үеэр хүргэнэ.

ТХН, 21 аймаг, 9 дүүргийн ХХҮХ болон ХХҮЕГ-аар дамжуулан төслийн үр шим хүртэгч нарт гомдол барагдуулах систем болон холбогдох үйл ажиллагааны талаар мэдээлэл өгнө. Төслийн үйл ажиллагаа, өргөдөл гомдлын журмыг тодорхойлсон товхимол, зурагт хуудас, видео клипийг боловсруулан үр шим хүртэгчдэд хүргэнэ. Тэдгээр мэдээллийг төслийн вэбсайт болон ХХҮЕГ-ын олон нийтийн мэдээллийн самбар дээр байршуулах бөгөөд мэдээлэл, сургалтын үеэр танилцуулах болон хэвлэл мэдээллийн сувгуудаар дамжуулан мэдээлнэ. Мэдээллийг ил тод болгох стратегийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ТОТ-ны 3.3 хэсгээс үзэх боломжтой.

5. БОНУХ-г хэрэгжүүлэх байгууллагын зохион байгуулалт

ХНХЯ нь энэхүү төслийг өөрийн холбогдох харьяа байгууллагууд болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ), орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (ХХҮХ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ) болон Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ)-аар дамжуулан төсөл хэрэгжүүлэх нэгжийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ. Тодруулбал, ХНХЯ-ны харьяа агентлаг, хэлтсүүд дараах байдлаар төслийн хэрэгжилтэд оролцоно.

- 1) ХХҮЕГ нь 1 болон 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх үүрэгтэй;
- 2) Орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд нь 1 болон 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийг газар дээр нь хэрэгжүүлэхэд оролцоно;
- 3) ХНХСИ нь ТХН-тэй хамтран 3.1 дэд бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд оролцоно.
- 4) Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) нь 4-р бүрэлдэхүүн хэсгийг

хэрэгжүүлэх үүрэгтэй.

ТХН нь төслийн бүх бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд ялангуяа 1, 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг болон 2.1 дэд бүрэлдэхүүн хэсэгт түлхүү оролцоно. ТХН нь бүх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд чадавхыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хэрэгжүүлнэ. Ажил олгогч, хувийн хөдөлмөрийн бирж, оролцогч санхүүгийн байгууллагууд зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд нь төслийн хэрэгжилтэд ойр ажиллах түншүүд юм. Сургалтын үйлчилгээ үзүүлэгч, оролцогч санхүүгийн байгууллагууд зэрэг төрөл бүрийн ажил, үйлчилгээ гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан ажиллана.

ХНХЯ нь төслийн захирал болон ТХН-ээр дамжуулан төслийг хэрэгжүүлэх бөгөөд БОНУХ болон БОНУАТ-ний хэрэгжилт, зохицуулалт, тайлагналтын ажлыг хариуцаж ажиллана. Төслийн зохицуулагчаар удирдуулсан ТХН нь БОНУХ болон БОНУАТ-ний хэрэгжилт, зохицуулалт, тайланд хяналт тавих ажлыг хариуцана. ТХН-ийн ХШҮ-ний мэргэжилтэн нь БОНУХ, БОНУАТ-ний хэрэгжилтийг хянах, тайлагнах үүрэгтэй бөгөөд төслийн түвшний ГБМ-ийн гол хэсгийг хариуцан ажиллуулж ТНХ-д тайлагна. ТХН-ийн ажилтнууд нь хариуцсан ажил үүрэгт хамаарах төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд БОНУХ-г үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг хариуцана.

Зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн ТХН-ийн бүрэлдэхүүнийг Сангийн сайдын тушаалаар батална. Үүний дагуу ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны тушаалаар ХЭДТ-ийн ТХН-ийн бүрэлдэхүүнийг баталсан. ХЭДТ-ийн ТХН нь ОБҮДХЭТ-ийн ТХН-ээр үргэлжлүүлэн ажиллах бөгөөд ажилтнуудын бүрэлдэхүүн хэвээр байх болно. Одоогийн байдлаар ТХН-ийн бүрэлдэхүүнд Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтны орон тоо байхгүй байна. Иймээс ОБҮДХЭТ-ийн ТХН нь төслийн хэрэгжилтийн эхний үе шатанд төслийн байгаль орчин, нийгмийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний зөвлөхүүдийг ажиллуулах болно.

6. БОНУХ-ны хэрэгжилтийн хяналт, хяналт-шинжилгээ, тайлагналт

Энэхүү БОНУХ-ний хяналт, хяналт-шинжилгээ нь дотоод болон гадаад хяналтын үйл ажиллагааг аль алийг нь багтаана. ХНХЯ болон түүний ТХН-ийн хэрэгжүүлэх дотоод хяналт-шинжилгээнд дараах зүйлс орно:

- ✓ БОНУХ-ний хэрэгжилтийн явцад хагас жил тутам хянах-шинжилгээ, үнэлгээ хийх (төслийн явц, байгууллагын зохион байгуулалт, дэд төслийн үйл ажиллагааны хяналтын үр дүн, шаардлага хангасан дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлууд болон эдгээрийг бууруулах арга хэмжээ, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа, ГБМ-ын үйл ажиллагаа, залруулах арга хэмжээний төлөвлөгөө гэх мэт),
- ✓ Өргөдөл, гомдлын бүртгэл болон өргөдөл, гомдлын дагуу зохих арга хэмжээ авагдсан эсэхийг шалган үр дүнд нь сэтгэл ханамжтай байгаа эсэхийг баталгаажуулах
- ✓ ТХН болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) нь БОНУХ-ний сонгосон чиглэлүүдийн хэрэгжилтэд (бичил бизнес эрхлэгчдийн сонгон шалгаруулалт, үнэлгээний талаарх хяналт орно) хяналт-шинжилгээ хийнэ.

Дэлхийн банкнаас хэрэгжүүлэх гадаад хяналт-шинжилгээний ажил нь дараах асуудлыг хамарна. Үүнд:

- ✓ Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүргийнхээ хүрээнд бие даасан үнэлгээ хийх эсвэл ТХН-ийн зүгээс БОНУХ-ний хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийхэд тойм даалгавар боловсруулахад дэмжлэг үзүүлэх хэлбэрээр оролцох;
- ✓ Төслийн дунд хугацааны болон эцсийн ерөнхий үнэлгээг хийх

Дунд хугацааны үнэлгээ нь БОНУХ-ний хэрэгжилт, нийцлийг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлно. ХНХЯ болон ТХН нь төслийн байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааны хэрэгжилт (БОНУХ-ний хэрэгжилтийг оролцуулан) болон ГБМ-ын байдал (ГБМ-ын хүртээмжтэй байдал болон ГБМ-д ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээж авч шийдвэрлэж байгааг нотлох баримт) гарган төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлангийн нэг хэсэг болгон хагас жил тутам Дэлхийн банканд тайлагнана.

ХНХЯ нь БОНУХ-ний дагуу байгаль орчин, олон нийт, ажилчдад ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн эсвэл нөлөөлөх магадлалтай нөхцөл байдал, осол, аваарын талаар и-мэйлээр эсвэл зохих хэрэгслээр Дэлхийн банкны тухайн асуудлыг хариуцсан ахлагчид нэн даруй мэдэгдэнэ.

7. Чадавхыг бэхжүүлэх

ХНХЯ болон түүний ТХН нь Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн хүрээ болон байгаль орчин, нийгмийн стандартын талаар хязгаарлагдмал туршлагатай байгааг харгалзан тодорхой чадавхыг бэхжүүлэх дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- ✓ Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хэрэгслийн талаарх холбогдох сургалтыг бэлтгэх, шинэчлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгаль орчин, нийгмийн зөвлөхийг ажиллуулна.
- ✓ Төслийн дунд хугацааны үнэлгээтэй уялдуулан БОНХТ-ний хэрэгжилтийн аудит хийхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны болон нийгмийн аудитор ажиллуулна.
- ✓ БОНХТ-ний хэрэгжилтэд үр дүнтэй дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилгоор ХНХЯ (ХХҮЕГ болон аймаг, дүүргийн ХХҮХ-ийн ажилтнууд орно) болон ТХН-ийн ажилтнуудыг зохих ёсоор сургаж бэлтгэнэ. 2.1 дэх бүрэлдэхүүн хэсгийн БОНУХ-г хэрэгжүүлэх зорилгоор ХХҮЕГ болон аймаг, дүүргийн ХХҮХ-ийн мэргэжилтнүүдийг мөн адил энэ чиглэлээр сургана. БОНУАТ-г харгалзан боловсруулсан сургалтын төлөвлөгөөг Хүснэгт 6-т харуулсан.

Дэлхийн банк нь БОНУХ-ний байгаль орчин, нийгмийн менежментийн шаардлагыг дагаж мөрдөх талаар ХНХЯ болон ТХН-д техникийн удирдамж, дэмжлэг үзүүлнэ.

| Хүснэгт 6. БОНУХ-ний чадавхыг бэхжүүлэх сургалт болон ОБҮДХЭТ-ийн мэдлэгийг дээшлүүлэх төлөвлөгөө | | | |
|---|--|-----------------------|---------------------------------|
| | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны төсөв | Хугацаа |
| 1. | Сургалтын үйл ажиллагааг бэлтгэх, дэмжих зорилгоор БОНУХ дээр үндэсний зөвлөх ажиллуулах | 8,000 ам. доллар | 2021 оны 10-р сарын 30-ны дотор |

| | | | |
|-------------|---|----------------------------------|---|
| 2. | ОБҮДХЭТ-ийн БОНУХ болон ГБМ-ын талаар богино хэмжээний видео, постер болон олон нийтэд шаардлагатай материалыг боловсруулах, түгээх. | 5,000 ам.доллар | 2021 оны 9-р сарын 30-ны дотор |
| 3 | ХНХЯ, ХХҮЕГ болон ТХН-ийн ажилтнуудад зориулсан сургалт: <ul style="list-style-type: none"> • Дэлхийн банкны байгаль, орчин нийгмийн хүрээ болон стандартууд • ОБҮДХЭТ-ийн БОНУАТ • ОБҮДХЭТ-ийн БОНУХ • ОБҮДХЭТ-ийн Хөдөлмөрийн удирдлагын журам • Бичил зээл олгоход зориулсан БОНУХ-ний журам • Гэрээгээр ажил гүйцэтгэгч, тэдгээрийн ажилчид, зөвлөхүүд болон холбогдох төрийн албан тушаалтнуудад зориулсан засварын ажлын БОНУХ болон асбестын менежмент, ХАБЭА-ын талаарх журам. • ОБҮДХЭТ-ийн БОНУАТ • ОБҮДХЭТ-ийн БОНУХ • КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хянах болон харилцаа холбоо, олон нийтийг хамарсан арга хэмжээний эрсдэлийн талаарх ДЭМБ-ын удирдамж | 2,000 ам.доллар | 2021 оны 11-р сарын 30-ны дотор |
| 4. | Аймаг, дүүргийн ХХҮХ, газрын ажилтнууд болон сонгогдсон ОСБ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалт: <ul style="list-style-type: none"> • Дэлхийн банкны байгаль, орчин нийгмийн хүрээ болон стандартууд • ОБҮДХЭТ-ийн БОНУАТ • ОБҮДХЭТ-ийн БОНУХ • ОБҮДХЭТ-ийн Хөдөлмөрийн удирдлагын журам • Бичил зээл олгоход зориулсан БОНУХ-ний журам • ОБҮДХЭТ-ийн БОНУАТ • ОБҮДХЭТ-ийн БОНУХ • КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хянах болон харилцаа холбоо, олон нийтийг хамарсан арга хэмжээний эрсдэлийн талаарх ДЭМБ-ын удирдамж | 10,000 ам.доллар | 2021 оны 12-р сарын 30-ны дотор |
| 5. | Асбестын менежмент болон ХАБЭА-н асуудлыг багтаасан БОНУ-ийн талаарх мэдээлэл олгох | ТХН-ийн үйл ажиллагааны зардлаар | Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 5 хоногийн дотор |
| 6. | БОНУХ-ний хэрэгжилтэд аудит хийх үндэсний зөвлөх ажиллуулах | 5,000 ам.доллар | 2022 оны 12-р сараас өмнө |
| Нийт | | 30,000 ам.доллар | |

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ
(БОНУХ)**

Хавсралт 1

**ХӨДӨЛМӨРИЙН УДИРДЛАГЫН
ЖУРАМ (ХУЖ)**

2021 он 06 дугаар сар

АГУУЛГА

| | | |
|------|---|----|
| 1 | Төслийн ажиллах хүчний тойм | 3 |
| 1.1 | Төслийн ажилчдын тоо, шинж чанар..... | 3 |
| 2. | Хөдөлмөрийн тухай болон ХАБЭА-н тухай хуулийн тойм | 9 |
| 2.1. | Хөдөлмөрийн тухай хуулийн тойм | 9 |
| 2.2. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн тойм | 15 |
| 3. | Хөдөлмөрийн эрсдэл ба түүнийг бууруулах арга хэмжээ | 17 |
| 3.1. | Шууд хамаарал бүхий ажиллагсад | 17 |
| 3.2. | Гэрээт ажиллагсад..... | 19 |
| 3.3. | Хөдөлмөр эрхлэх нас..... | 21 |
| 4. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болзошгүй эрсдлийг үнэлэх, бууруулах арга хэмжээ | 21 |
| 4.1. | Шууд хамаарал бүхий ажиллагсад | 21 |
| 4.2. | Гэрээт ажиллагсад | 21 |
| 5. | КОВИД-19 цар тахалтай холбоотой анхаарч үзэх асуудлууд | 24 |
| 6. | Үүрэг хариуцлага | 25 |
| 7. | Гомдол барагдуулах механизм | 26 |

ХӨДӨЛМӨРИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

Энэхүү хөдөлмөрийн удирдлагын журам (ХУЖ) нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Дэлхийн банкны “Байгаль орчин, нийгмийн стандарт 2” (БОНС 2) -ын заалтууд, ОБҮДХЭТ (# Р174116)-ийг хэрэгжүүлэх явц дах хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрсдэл болон үүсэх асуудлыг хэрхэн зохицуулах талаар тоймлон авч үзсэн.

Энэхүү хөдөлмөрийн удирдлагын журмын талаар оролцогч талуудтай (ХНХЯ, ТХН) хэд хэдэн удаа зөвлөлдсөн. Эхний зөвлөлдөх уулзалтаар журмын анхны төслийг (2020 оны 10-р сарын 14-нд), хоёр дахь уулзалтаар журмын шинэчилсэн төслийг хэлэлцсэн (2020 оны 11-р сарын 10-нд) бөгөөд гурав дахь зөвлөлдөх уулзалтыг Дэлхийн банканд баримт бичиг хүргүүлэхээс өмнө буюу 2021 оны 4-р сарын сүүлчээр зохион байгуулсан.

1. Төслийн ажиллах хүчний тойм

Монгол Улсад хэрэгжүүлэх “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) хэрэгжүүлэн ажиллана. Уг төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлд хөнгөлөлт үзүүлэх зорилготой. Энэхүү зорилго нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй хөтөлбөрийг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн хяналт-шинжилгээ, судалгааг сайжруулах, КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажиллагсдад түр хугацааны хөнгөлөлт үзүүлэх гэсэн 4 арга хэмжээний хүрээнд хэрэгжинэ.

1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй, ил тод бус байдал болон хангалттай, бүрэн гүйцэт мэдээлэлгүйгээс шалтгаалан ажил хайхад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх болно. 2-р бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн загвар, хамаарал, эрэлт, хэрэгцээг бэхжүүлэхэд чиглэнэ. 3-р бүрэлдэхүүн хэсэг нь Засгийн газар болон бусад оролцогч талуудад илүү үнэн бодит шийдвэр гаргахад нь туслах үүднээс хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, тайлагналт, дүн шинжилгээний хамрах хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулах болон төслийн менежмент, хяналт-шинжилгээ, үнэлгээг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. 4-р бүрэлдэхүүн хэсэг нь КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан заавал даатгуулагчдад түр хугацааны шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.1 Төслийн ажилчдын тоо, шинж чанар

Төслийн үйл ажиллагаанд хоёр төрлийн ажилчид хамрагдана. Үүнд:

(i) **Шууд хамаарал бүхий ажиллагсад**¹ - ХНХЯ болон түүний шууд харьяанд үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтнууд:

а. ХНХЯ-ны удирдлага дор ажилладаг төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн ажилтан буюу төслийн хэрэгжилтэд шууд оролцдог ажилтнууд,

б. ХНХЯ болон түүний харьяа байгууллагуудын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтнууд. Үүнд:

- i. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)
- ii. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар (НХЭГ)
- iii. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)
- iv. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)
- v. Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ),
- vi. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс
- vii. Мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд (боломжит),

в. Үндэсний статистикийн хороо (ҮСХ) –ны төрийн албан хаагчид

г. ХНХЯ-тай гэрээ байгуулсан зөвлөхүүд(үндэсний болон олон улсын)

(ii) **Гэрээт ажиллагсад**² - дор дурдсан гуравдагч этгээдээр дамжуулан гэрээ байгуулсан ажилчид:

- а. Жижиг хэмжээний иргэний барилгын ажлын засвар болон дотоод заслын төлөвлөгөө боловсруулах гэрээт компани;
- б. Жижиг хэмжээний барилгын ажил гүйцэтгэх гэрээт компани
- в. Бичил бизнес эрхлэгчдэд зээл олгохоор сонгогдон гэрээ байгуулсан оролцогч санхүүгийн байгууллагууд
- г. Төслийн тодорхой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, чадавхжуулах чиглэлээр зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллага;
- д. Хувийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (ур чадварыг хөгжүүлэх шинэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гэрээ байгуулах боломжтой)

Төсөлд тасралтгүй бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх шууд ханган нийлүүлэгч³ оролцохгүй бөгөөд ямар нэгэн шууд ханган нийлүүлэлтийн ажилтан байхгүй. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний оффисуудад (үүнд засвар хийгдсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний өрөө, тасалгаа орно) зориулсан албан тасалгааны болон сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн нийлүүлэгч нарын

¹ Төслийн тодорхой үйл ажиллагаатай холбоотойгоор зээлдэгчийн шууд удирлага дор ажилладаг эсвэл төслийн үйл ажиллагаанд шууд оролцдог хүмүүс (төсөл хэрэгжүүлэгч болон төсөл хэрэгжүүлэгч агентлагуудыг оролцуулан)

² Төслийн үндсэн чиг үүрэгтэй холбоотой ажил гүйцэтгэх зорилгоор гуравдагч этгээдээр дамжуулан ажил гүйцэтгэж буй хүмүүс юм. Энэ нь төслийн "үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд"-ийн тодорхой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үйлдвэрлэлийн болон үйлчилгээний үйл явцыг хангана.

³ Энэ нь төслийн үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, материалыг тасралтгүй шууд нийлүүлж байдаг нийлүүлэгчид юм.

ажилчдыг (энэ нь тасралтгүй, байнгын ажиллагаатай биш) гуравдагч этгээдийн ажилчид гэж үзнэ. Төслийн хүрээнд бичил зээлийн дэмжлэгт хамрагдаж буй бичил бизнесийн үйл ажиллагааны ханган нийлүүлэгчид нь ихэвчлэн жижиг хэмжээний, албан бус салбарын бизнес эрхлэгчид байх бөгөөд эдгээр нь хангамжийг тасралтгүй нийлүүлж чадах эсэх нь эргэлзээтэй юм.

Төсөлд ямар нэгэн шилжин ирэгсэд болон нийгмийн тодорхой бүлгийн иргэдийг ажиллуулахгүй бөгөөд богино хугацааны барилгын засварын ажилд тухайн орон нутгийн ажиллах хүчнийг ажиллуулах боломжтой.

Төслийн нийт үргэлжлэх хугацааны туршид ажиллах шууд хамаарал бүхий ажилчид болон гэрээт ажилчдын нарийн тоо гараагүй бөгөөд урьдчилсан байдлаар 700-720 хүн ажиллана гэж таамаглаж байна.

Доорх Хүснэгт 1-д төслийн ажилчдын төрөл, тодорхойлолт, урьдчилсан тоог товч байдлаар харуулсан. Төслийн ажилчдын тодорхойлолтыг төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр гаргасан.

Хүснэгт 1. Төслийн ажилчдын тодорхойлолт, урьдчилсан тоо болон ажиллах хугацаа

| Тодорхойлолт | Урьдчилсан тоо болон байршил | Шаардлагатай хугацаа | Төслийн бүрэлдэхүүн хэсэг дэх оролцоо | | | |
|---|---|--|--|---|--|---------------------|
| | | | Бүрэлдэхүүн хэсэг 1 | Бүрэлдэхүүн хэсэг 2 | Бүрэлдэхүүн хэсэг 3 | Бүрэлдэхүүн хэсэг 4 |
| Шууд хамаарал бүхий ажиллагсад | | | | | | |
| ТХН-ийн ажилтан | Улаанбаатар хотод ажиллах 8 үндсэн ажилтан | Төслийн нийт үргэлжлэх хугацааны туршид | Төслийн бүх бүрэлдэхүүн хэсэгт оролцоно. | | | |
| ХНХЯ-ны харьяа байгууллагуудын төрийн албан хаагчид | Ойролцоогоор 290 хүн гэж тооцож байна. Эдгээр ажилчид нь Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд байрлах хэлтсүүдэд үйл ажиллагаагаа явуулна. | Төслийн төлөвлөгөөний дагуу шаардлагатай үед оролцоно. (2020 оны 4 дүгээр улиралд оролцоо шаардагдах НДЕГ болон түүний салбар нэгжүүдийн ажилтнуудаас бусад) | <ul style="list-style-type: none"> • ХНХЯ-ны албан хаагчид (10) • ХХҮЕГ-ын албан хаагчид (10) • 21 аймаг, 9 дүүргийн ХХҮХ-ийн албан хаагчид (150) • НХЭГ-ийн албан хаагчид (5) • МСҮТ-үүдийн ажилчид (боломжит) (30) • Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв болон бүсийн арга зүйн төвүүдийн ажилчид (боломжит) (10) | <ul style="list-style-type: none"> • ҮСХ болон түүний 21 аймаг, 9 дүүргийн салбар нэгжүүдийн албан хаагчид (35) • ХНХСИ-ийн албан хаагчид (5) | НДЕГ болон түүний Улаанбаатар хот, 21 аймаг дах салбар, нэгжийн албан хаагчид (35) | |
| Зөвлөхүүд | Таамаглаж буй тоо: 20 Үндэсний зөвлөхүүд нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулна (богино хугацааны томилолтоор ажиллаж болно). Олон улсын зөвлөхүүд нь өөрийн улс орондоо болон Монгол улсад үйл ажиллагаагаа явуулна (КОВИД-19 цар тахлаас шалтгаалан томилолт цуцлагдсан.) | Төслийн төлөвлөгөөний дагуу шаардлагатай үед оролцоно. | Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ХЗЗМС-ийг шинэчлэн хөгжүүлэх, хувийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үүрэг оролцоог нэмэгдүүлэх гэх мэт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зөвлөхүүд. | Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн зөвлөхүүд. | Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, төслийн үнэлгээ зэрэг ажилд дэмжлэг үзүүлэх зөвлөхүүд. | |

Гэрээт ажилчид

| | | | | | | |
|---|--|--|---|---|---|--|
| Дотоод засал болон засварын ажил гүйцэтгэх компаниудын ажиллагсад | Таамаглаж буй тоо: 30 | 2021 оны 3-4 дүгээр улирал | ХХҮЕГ-ын барилгад жижиг хэмжээний засвар хийх ажилчид | | | |
| Оролцогч санхүүгийн байгууллагуудын ажиллагсад (Хамгийн багадаа 2 байгууллага) | Таамаглаж буй тоо: 70 (Оролцогч санхүүгийн байгууллагын төв болон салбар, нэгжүүдэд ажиллана.) | 2021 оны 2 дугаар улирлаас 2023 оны 4 дүгээр улирал | | Бичил бизнес эрхлэгчдэд бичил зээлийн санхүүжилт олгох ажиллагсад. | | |
| Санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгчдийн ажиллагсад (Хувийн хэвшлийн байгууллагууд болон ТББ байж болно) | Таамаглаж буй тоо: 100 (Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд) | 2021 оны 2 дугаар улирлаас 2022 оны 4 дүгээр улирал | | Бичил бизнес эрхлэгчдэд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэхэд оролцож ажиллана. | | |
| Хувийн мэргэжлийн сургалтын байгууллагуудын ажилчид (боломжит) | Таамаглаж буй тоо: 50 (Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд) | 2021 оны 3 дугаар улирлаас 2023 оны 1 дүгээр улирал | | | | |
| Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч компаниуд болон бараа материал нийлүүлэгчдийн ажиллагсад (хувийн компаниуд эсвэл | Таамаглаж буй тоо: 130-150 (Улаанбаатар хотод) | 2020 оны 4-р улирлаас 2023 оны 3-р улирлын хооронд Төслийн төлөвлөгөөний дагуу шаардлагатай үед оролцоно. | • ХХҮЕГ-ын барилгын дотоод засал болон засварын төлөвлөгөөг боловсруулах гэрээ байгуулсан компанийн | | <ul style="list-style-type: none"> • Мэдээлэл цуглуулах байгууллагуудын ажилтнууд • Төслийн материалыг хэвлэх хэвлэлийн | |

| | | | | | | |
|-----------------|--|--|--|--|---|--|
| ТББ байж болно) | | | <p>ажилтнууд</p> <ul style="list-style-type: none"> • ХЗЗМС-ийг шинэчлэн хөгжүүлэхээр гэрээ байгуулсан компанийн ажилтнууд • Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний оффисуудад шаардлагатай бараа, тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээ байгуулсан нийлүүлэгчийн ажилтнууд | | <p>компаниудын ажилтнууд</p> <ul style="list-style-type: none"> • Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны бүтээгдэхүүн, үйл ажиллагаа явуулах чиглэлээр гэрээ байгуулсан байгууллагуудын ажилтнууд | |
|-----------------|--|--|--|--|---|--|

2. Хөдөлмөрийн тухай болон ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн тойм

2.1. Хөдөлмөрийн тухай хуулийн тойм

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль (1991), Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) болон Засгийн газар, гурван талт байгууллагуудаас баталсан холбогдох журам, дүрэм нь ажилчдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон эрх, хөдөлмөрийн нөхцөлийн талаарх тойм мэдээллийг дор харуулсан. Одоогийн байдлаар ХНХЯ-аас хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар ажиллаж байгаа бөгөөд хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан тохиолдолд энэхүү хөдөлмөрийн удирдлагын журмыг шинэчлэн батална.

Ажлын байран дээрх үндсэн эрх

| | |
|--|---|
| Ажил, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар | Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж болох насны доод хязгаар 16 нас байна. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж болох насны доод хязгаар 18 нас байна. |
| Албадан хөдөлмөрөөс хамгаалах | Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөр эрхлүүлж болохгүй. |
| Ялгаварлан гадуурхахаас хамгаалах болон ижил тэгш хандах, тэгш боломж олгох эрх | <ul style="list-style-type: none">• Яс үндэс, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах, хязгаарлах, давуу эрх олгохыг хориглоно.• Ажил олгогч нь иргэнийг ажилд авахдаа эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавихыг хориглоно. |
| Эвлэлдэн нэгдэх болон хамтын хэлэлцээр хийх эрх (Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд заасан) | <ul style="list-style-type: none">• Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.• Үйлдвэрчний эвлэл нь захиргаа, эзэдтэй хэлэлцээ хийж хамтын болон бусад гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих, хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагад гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлөн хамгаалах болон бусад эрхийг эдэлнэ. |

Цалин хөлс

| | |
|------------|--|
| Цалин хөлс | <ul style="list-style-type: none">• Ажилтны цалин хөлсийг өөрт нь сард хоёр ба түүнээс дээш удаа мөнгөн хэлбэрээр олгоно.• Ажилтны цалин хөлснөөр хууль бусаар болон хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн суутгал хийхийг хориглоно.• Ажил олгогч нь хуулийн дагуу ажилтанд ээлжийн амралтын |
|------------|--|

| | |
|--|---|
| | <p>олговрыг олгоно.</p> <ul style="list-style-type: none"> Ажилтан бүх нийтийн амралтын өдөр, илүү цагаар, долоо хоногийн амралтын өдөр, шөнийн цагаар ажилласан тохиолдолд нэмэлт цалин авах эрхтэй. |
| Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ | Монгол Улсад одоо мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь сард 420,000 төгрөг (226 доллар) байна. Тодорхой боловсрол, тусгай мэргэжил байхгүй ажилтанд олгох цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна. |
| Ижил үнэ цэнэтэй ажилд ижил цалин хөлс олгох | Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно. |
| Цагийн ажилтны цалин хөлс | Цагаар ажиллах ажилтны цагаар болон хийснээр нь олгох сарын цалингийн нийт хэмжээ ижил ажил гүйцэтгэсэн бүрэн цагаар ажилладаг ажилтнахаас бага байж болохгүй. |

Ажлын цаг, долоо хоног бүрийн амралт, ээлжийн амралт

| | |
|----------------------------------|---|
| Ажлын цаг | <ul style="list-style-type: none"> Өдөрт 8-аас илүүгүй, долоо хоногт 40-өөс илүүгүй цагаар ажиллана. Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна. |
| Долоо хоног бүрийн амралтын өдөр | Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан Бямба, Ням гаригт амрах боломжгүй ажилтныг долоо хоногийн өөр дараалсан хоёр өдөр амруулна. |
| Нийтээр амрах баярын өдөр | Ажил олгогч нь үндэсний баяр наадам (7-р сарын 11, 12, 13-ны өдрүүдэд), Хүүхдийн баяр (6-р сарын 1) болон бусад хуулиар тогтоосон баярын өдрүүдэд ажилтнуудаа хуулийн дагуу амрах зохицуулалт хийнэ. |
| Ээлжийн амралт | <ul style="list-style-type: none"> Ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр (насанд хүрээгүй буюу 18-аас доош настай, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр) байх бөгөөд ажилтны ажилласан жилээс хамааран ээлжийн амралтын хугацаа нэмэгдэнэ. |

Ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш эрх олгох

1. Ажилчдыг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, итгэл үнэмшлээр ялгаварлахгүйгээр ажиллуулна.
2. Талууд хамтын гэрээ, хэлэлцээрт эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, мэргэжлийн эрх ашиг, гэр бүлийн үүргээ хослуулах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, түүнчлэн ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, ижил нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгана.
3. Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах ба Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу

эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглоно.

4. Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар дараах үүрэг хүлээнэ:
 - 4.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай хуульд зааснаас бусад тохиолдолд нээлттэй ажлын ажлын байрны сул орон тооны зар мэдээнд хүйсийг онцлон дурдахгүй, эсхүл аль нэг хүйсийг давуу гэж үзсэн агуулгыг тусгахгүй байх (Уг хуулийн 6.5, 7 дугаар зүйл).
 - 4.2 Иргэнийг ажилд авахдаа тухайн байгууллага болон түүний бүтцийн нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох
 - 4.3 Адил хөдөлмөр буюу адил чанарын ажил эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил тэгш цалин хөлс олгох, ижил нөхцөл тогтоохтой холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах
 - 4.4 Хүний нөөцийн бүртгэлд үндэслэн эрэгтэй, эмэгтэй ажилтныг албан тушаал дэвшүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэшлийн ур чадварыг ахиулах, цалин хөлсийг нэмэгдүүлдэг байх;
 - 4.5 Бүтцийн өөрчлөлтийн улмаас нийт ажилтны гуравны нэгээс доошгүйг чөлөөлөх тохиолдолд чөлөөлөгдөх ажилтнуудын хүйсийн харьцааг ажилласан хугацаанаас нь үл хамааран нийт ажилтны хүйсийн харьцаатай адил тогтоох;
5. Ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан болон энэ хуулийн 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд ажлаас халахыг хориглоно.
6. Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар дараах арга хэмжээ авна:
 - 6.1 Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах;
 - 6.2 Бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх.
7. Ажил олгогч нь иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлог шаардлагын улмаас ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол энэ тухай үндэслэлээ нотлох үүрэгтэй.

Хөдөлмөрийн гэрээ ба гэрээг цуцлах

Хөдөлмөрийн гэрээ

1. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажил олгогч хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд хөдөлмөрийн гэрээнд дараах үндсэн нөхцөлүүдийг тохиролцоно:
 - а. ажлын байрны буюу албан тушаалын нэр;
 - б. гэрээний нөхцөл;
 - в. үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ;
 - г. ажлын байрны нөхцөл
2. Ажил олгогч нь ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж нэг хувийг өгөх үүрэгтэй.
3. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажилтнаас ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй.
4. Байнгын ажлын байр дээр хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулна.
5. Хөдөлмөрийн хугацаатай гэрээний хугацаа дуусмагц талууд түүнийг цуцлах санал тавиагүй бөгөөд ажилтан ажлаа гүйцэтгэсээр байгаа бол уг гэрээг анх заасан хугацаагаар сунгагдсанд тооцно.
6. Ажил олгогч буюу түүний эрх олгосон албан тушаалтан иргэнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй. Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно.
7. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй бол ажил олгогч ажилтнаас ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахгүй.

Контракт (Хувь хүнтэй байгуулах гэрээ)

1. Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг хэрэгжүүлэхдээ бусдын хөдөлмөрлөх үйл ажиллагааг, мөн ажил олгогч нь иргэний гоц буюу ховор авьяас, өндөр ур чадварыг хөлслөн авч ашиглах зорилгоор иргэнтэй контракт байгуулна.
2. Энэ хуулийн 22.1-д заасны дагуу контракт байгуулж иргэнийг авч ажиллуулж болох ажил, албан тушаалын жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.
3. Контрактыг бичгээр үйлдсэн байх бөгөөд хугацаа нь 5 жилээс ихгүй байна.
4. Талууд контракт байгуулах үедээ хугацаа, ажилтны гүйцэтгэх ажлын эцсийн үр дүн, ажил олгогчийн өмнө хүлээх үүрэг, контрактыг дүгнэх журам, ажилтны мэдэлд олгож буй хөрөнгийн хэмжээ, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам, ажилтанд олгох урамшуулал, хангамж, хөнгөлөлт болон үйл ажиллагааны хүрсэн үр дүн, ашгаас олгох хувь хэмжээ, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан байна.
5. Контрактыг дүгнэх үед ажилтан үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэж үзвэл цаашид сунгаж болно.

Гэрээг цуцлах

Хөдөлмөрийн гэрээ дараах үндэслэлээр дуусгавар болно:

- а. талууд харилцан тохирсон;
- б. ажил олгогч иргэн, ажилтан нас барсан;
- в. хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;
- г. хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;
- д. ажлаас буруу халагдсан ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон;
- е. ажилтан цэргийн жинхэнэ албанд татагдсан;
- ё. ажилтан гэмт хэрэг үйлдсэний улмаас уг ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
- ж. хөдөлмөрийн гэрээг ажилтны буюу ажил олгогчийн санаачилгаар цуцалсан.

Ажлаас халах

а. Ажил олгогч нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажил хүлээлгэн өгөх хугацааг тогтоож, уг хугацааг ажлаас халах тухай шийдвэрт заана.

б. Ажилтан ажил хүлээлгэн өгсөн сүүлчийн өдрийг ажлаас халагдсан өдөр гэж үзнэ.

в. Ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн гэрээ цуцалсан тухай шийдвэр, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хуульд заасан бол ажлаас халагдсаны тэтгэмжийг халагдсан өдөрт нь өгөх үүрэгтэй.

г. Ажил олгогч нь ажилтны хүсэлтээр ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаал, цалин хөлсний тухай тодорхойлолтыг гаргаж өгөх үүрэгтэй.

Эмзэг бүлгийн ажиллагсад

Эмзэг бүлгийн ажиллагсдыг хамгаалах асуудал нь Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг. Төсөлд 18-аас доош насны хүүхдийг ажиллуулахгүй. Монгол улсад хөдөлмөрийн тухай хуулийн (1999, 109-р зүйлийг үзнэ үү) дагуу хор хөнөөлгүй буюу хориглоогүй ажлын байранд ажил хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь 16 нас байдаг. Гэхдээ насанд хүрээгүй хүнийг эмнэлгийн үзлэгт орсны дараа ажилд авах бөгөөд тэдгээрийг 18 нас хүртэл нь шөнийн цагаар ажиллуулахгүй, батлагдсан хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлэхгүй гэх мэт хориглосон шаардлагууд байдаг. 18-аас доош насны хүүхдийг хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалд хортой ажил хийхийг хориглодог бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 18 нас хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар баталсан (2008). Мөн хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах талаар хэд хэдэн зохицуулалт орсон байдаг.

Хүснэгт 2. Хамгаалах арга хэмжээний төрөл

| Хамгаалах арга хэмээний төрөл | Тодорхойлолт | Хуулийн заалт |
|-------------------------------|--|---------------------------------|
| Ялгаварлан гадуурхахгүй байх | Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй бол тэдгээрийг уг шалтгаанаар ажилд авахаас татгалзахыг | Хөдөлмөрийн тухай хуулийн 111.5 |

| | | |
|--|---|--|
| | хориглоно. | |
| ХБИ ажиллуулах квот | 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд зохих төлбөр төлнө. | Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2 болон 111.1 |
| Хөдөлмөрийн нөхцөл | Ажил олгогч нь хөгжлийн бэрхшээлтэй хүний гүйцэтгэж байгаа ажлын шинж байдлаас хамааран ажилтны саналыг харгалзан ажлын цагийг богиносгож болно (долоо хоногт 36 цагаас хэтрэхгүй). Энэ тохиолдолд ажилтны ажлын богиносгосон цагийг ажилласан цагт тооцож дундаж цалин хөлсийг олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна (ердийн ажилтны амралт ажлын 15 өдөр байдаг.) | Хөдөлмөрийн тухай хуулийн 71.1, 67.1, 79.3 |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтанд учирсан хохирлыг нөхөх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогч нь нөхөн төлбөр олгох үүрэгтэй. Хөдөлмөрийн тухай хуулиар тусгайлан зохицуулагдаагүй ХБИ-ний хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахтай холбоотой асуудлыг хамтын гэрээгээр зохицуулна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 |

Хөдөлмөрийн тухай хуульд заасан ХБИ-ний эрх ашгийг хамгаалах заалтаас гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд (2016 онд батлагдсан) ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх дэмжлэгийн шинэ хэлбэрүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувиараа хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материал худалдаж авахад дэмжлэг үзүүлэх зэрэг зохицуулалтууд тусгагдсан. Тодруулбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5.1, 17.1-д ХБ-тэй хүний хөдөлмөрлөх эрхийн тухай, 6.4 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх; 17.3 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд тавигдах шаардлага; 18.1, 19-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулахад төрөөс үзүүлэх дэмжлэг, ажилд зуучлах, сонгон шалгаруулах зарчмуудыг тус тус тусгасан байна.

ХБ-тэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Хөдөлмөрийн тухай хууль (1999), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд (2011) заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар зохицуулсан тодорхой арга хэмжээг авч үзнэ.

Төслийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүн төслийн үр шимийг хүртэх тэгш боломжоор хангаж өгөх бөгөөд ХБИ-ний хөдөлмөр эрхлэх эрх, ялгаварлан гадуурхахгүй байх, хөдөлмөрийн нөхцөл, ХАБЭА-тай холбоотой хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.

Монгол улс нь жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуультай (2011) бөгөөд Засгийн газрын зүгээс ялгаварлан гадуурхахгүй байх, жендерийн тэгш байдлыг хангах, дэмжих чиглэлд ихээхэн анхаарч энэхүү хуулийг илүү хүчтэй хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж байна.

2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн тойм

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар (2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, зарчмууд болон ХАБЭА-н удирдлага, хяналтын тогтолцоонд тавигдах шаардлагыг тодорхойлж өгсөн.

Өргөх, зөөх, тээвэрлэх механизмд тавигдах шаардлага

а. Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.

б. Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд мэргэжлийн байгууллагаар техникийн магадалгаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авсан байна.

в. Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд засвар үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага тодорхой хугацаанд хийж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.

Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих шаардлага

а. Ажил олгогч нь химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис, түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

б. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн явцад хэрэглэж байгаа химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын талаар тэмдэглэл хөтөлж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн хяналтын болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлнэ.

в. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцан ажиллагч нь тухайн

бодисын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг, дадлагатай байна.

г. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэх, харьцах аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавигдах бусад шаардлагыг холбогдох хуулиар зохицуулна.

д. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын хэрэглээтэй холбоотой осол, хурц хордлого гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн ослын нэгэн адил судлан бүртгэнэ.

Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах

а. Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.

б. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.

в. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ.

г. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар ажил олгогч дүгнэлт гаргуулсан байна. Олон улсын стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд энэ заалт хамаарахгүй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт

- Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.
- Өөр ажлын байранд шилжиж байгаа иргэн, ажилтны сургалт;
- үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт.
- Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авч байна.
- Ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон дараах нийтлэг эрхтэй:
 - i. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;
 - ii. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах;

- iii. ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах;
 - iv. ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;
 - v. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хэлэлцэхэд өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох.
- Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараах нийтлэг үүрэгтэй байна:
 - i. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;
 - ii. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;
 - iii. хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;
 - iv. эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;
 - v. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;
 - vi. ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;
 - vii. өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;
 - viii. ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.

3. Хөдөлмөрийн эрсдэл ба түүнийг бууруулах арга хэмжээ

3.1. Шууд хамаарал бүхий ажиллагсад

ТХН-ийн ажилтнууд. ОБҮДХЭТ-ийн хувьд ХНХЯ нь ТХН-ийн ажилтнуудыг томилно. ТХН-ийн ажилтнууд эрэгтэй, эмэгтэй ажилчдаас бүрдэх бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 1) Төслийн зохицуулагч,
- 2) Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мэргэжилтэн
- 3) Хөдөлмөрийн зах зээлийн мэргэжилтэн
- 4) Санхүүгийн удирдлагын мэргэжилтэн,
- 5) Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн,
- 6) Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн
- 7) Төслийн туслах ажилтан
- 8) Төслийн жолооч.

ТХН-ийн ажилтнуудыг хугацаатай гэрээгээр ажиллуулах бөгөөд ажлын гүйцэтгэлээс хамааран жилээр сунгагдана. Тэдний гэрээний хугацаа, нөхцөлийг

Монгол улсын Сангийн яамнаас баталсан журмаар⁴ зохицуулна. ТХН-ийн ажилтнууд Монгол улсын нийгмийн хамгааллын салбарт хамаарах бөгөөд тэдний ажиллах нөхцөл ерөнхийдөө Хөдөлмөрийн тухай хуультай нийцсэн байна. ТХН-ийн ажилтнуудын хөдөлмөрийн эрсдэлийг бага гэж үзсэн.

Төрийн албан хаагчид

Төслийн нийт дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанд дараах байгууллагуудын төрийн албан хаагчид оролцоно. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)
- ХХҮЕГын хэрэгжүүлэгч нэгж болох 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс;
- Нийгмийн даатгалын ерөнхий газар (ХНХЯ-ны харьяа) болон түүний орон нутаг дах 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХЯ-ны харьяа)
- Үндэсний статистикийн хороо болон түүний 21 аймаг, 9 дүүргийн харьяа нэгжүүд;
- Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүд - ХНХЯ-ны харьяа МСҮТ-ийн төвүүд (2.2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжих ур чадварын инновацын хөтөлбөрт хамрагдах боломжтой);
- ХНХЯ-ны харьяа мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв болон түүний харьяа бүсийн арга зүйн төвүүд (2.2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжих ур чадварын инновацын хөтөлбөрт хамрагдах боломжтой).

Эдгээр төрийн албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн дагуу ажиллах бөгөөд тэдгээрийн ажиллах хугацаа, нөхцөлийг (ажлын цаг, амралтын хугацаа, цалин хөлс, ээлжийн амралт, чөлөө авах, ажлаас халах зэрэг асуудлыг багтаасан) Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох журмаар зохицуулдаг. Гэрээний нөхцөл, гэрээг цуцлах, ажлаас халах зэрэгтэй холбоотой үүссэн асуудлыг Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллага болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

Төслийн энэхүү дэд бүлгийн ажилчдын хөдөлмөрийн эрсдэлийг бага гэж үзсэн. Нийт шууд хамаарал бүхий ажиллагсад хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурсан байна. Төрийн албан хаагчид тэдгээрийн хуулиар олгогдсон эрх нь зөрчсөн гэж үзвэл эрхээ нөхөн сэргээх, засах арга хэмжээ авахыг шаардах эрхтэй. Шууд хамаарал бүхий ажилчдын хувьд хөдөлмөрийн зарим эрсдэл үүсэж болох юм. Жишээлбэл, өдөр тутмын ажлын цаг уртсах эсвэл жилийн ээлжийн амралтаа бүрэн эдэлж чадахгүй байх, ажлын байрны дарамт шахалт гэх мэт. Гэхдээ эдгээр эрсдэлийг төслийн тодорхой эрсдэл гэж үзэхгүй харин хөдөлмөрийн зах зээлийн давтагдашгүй хүчин зүйлийн тусгал гэж үздэг. Төслийн үйл ажиллагааны зорилгоор засгийн газрын агентлаг болон байгууллагуудаас ажилтнуудыг нэмж ажиллуулахыг шаардлагагүй.

⁴ Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам №196 (2015).

Зөвлөхүүд (Үндэсний болон олон улсын)

Төсөлд үндэсний болон олон улсын зөвлөхүүд оролцоно. Зөвлөхүүдийг ихэвчлэн сонгон шалгаруулалтын журмаар авч ажиллуулах бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ялгаварлан гадуурхахгүйгээр зөвхөн нэр дэвшигчдийн чадварыг харгалзан шийдвэрийг гаргана. Зөвлөхүүд нь хамгийн багадаа 18 настай байна. Төслийн энэ дэд бүлгийн ажиллагсдын хөдөлмөрийн эрсдэлийг бага гэж үзэж байна. Төсөл нь зөвлөх тус бүртэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах бөгөөд энэхүү гэрээний загварыг төслийн “Худалдан авах ажиллагааны гарын авлага”-д тусгасан байна. Зөвлөх үйлчилгээний гэрээний үндсэн нөхцөлд дараах зүйлсийг оруулна.

- Зөвлөх нь төслийн шаардлагын дагуу хүлээлгэн өгөх ёстой материалаа ирүүлсний дараа төлбөрийг нь хойшлуулах нөхцөлгүйгээр төлбөрөө шаардах эрхээ эдлэх;
- Монгол улсын Татварын тухай хуульд заасны дагуу төлбөрөөс зөвхөн хүн амын орлогын албан татварыг суутгах;
- Олон улсын зөвлөхийн хувьд агаарын тээврийн зардал, томилолтын мөнгө, визний зардлыг буцаан олгох
- Зөвлөх нь хувийн даатгал эсвэл нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдах үүрэгтэй;
- Зөвлөх нь шаардлагатай бол төслийн оффисыг ашиглах эрхтэй
- Зөвлөх нь төслийн гомдол барагдуулах механизмаар дамжуулан зөвлөх үйлчилгээний гэрээтэй холбоотой асуудлыг тавих эрхтэй;
- Зөвлөх нь гэрээний дагуу тохиролцсон аливаа ажил, үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй;

3.2. Гэрээт ажиллагсад

Жижиг хэмжээний засварын ажлын ажиллагсад.

1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ХХҮЕГ-ын оффисын барилгын сонгосон хэсэгт хийх жижиг хэмжээний засварын ажилд ойролцоогоор 30 орчим ажилтан оролцоно. Эдгээр ажилчид нь жижиг хэмжээний барилгын ажлыг гүйцэтгэхээр сонгогдсон компанийн (гэрээт гүйцэтгэгч) ажиллагсад юм. Энэхүү гэрээгээр ажил гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулалтаар сонгоно. Тендерийн үе шатанд гүйцэтгэгчийн хөдөлмөрийн удирдлагын шаардлагыг хянаж үзэх бөгөөд үүнд дараах зүйлс багтсан байна.

- Тендерт оролцогч байгууллага нь ажилчдаа хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулдаг эсэх талаарх нотлох баримт;
- Тендерт оролцогч нь улирлын чанартай ажилтан нэг бүртэй хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг тохиролцож гарын үсэг зурсан байх талаарх үүрэг, амлалт
- Тендерт оролцогч нь ажлын байран дээр ХАБЭА-н шаардлагыг хангаж ажиллах чадвартай байх бөгөөд ялангуяа ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах чадвартай байх;
- Ажлын байрны ёс зүйн дүрмийг ажлын талбарт ажиллаж буй ажилтан, менежерт танилцуулан газрын үсэг зуруулан баталгаажуулах.
- Ажилчдад ГБМ-д хандах болох тэдний эрхийн талаар мэдээлэх талаарх үүрэг амлалт

Засвар, шинэчлэлийн ажил нь жижиг хэмжээний барилгын ажил тул гүйцэтгэгч нь заавал барилгын инженер, ХАБЭА-н орон тооны инженертэй байх албагүй боловч ийм төрлийн хүний нөөцтэй байх нь давуу тал болно. Ажлын байрны ёс зүйн дүрэм нь ажилчдын хариуцлагатай зан үйлийн талаарх дараах арга хэмжээг багтаана (үүгээр хязгаарлахгүй).

Гэрээгээр ажил гүйцэтгэгч нь ажлын байрны ёс зүйн дүрмийг засварын ажил гүйцэтгэж буй ажилтан бүрд танилцуулан гарын үсэг зуруулах бөгөөд ажилтан бүрийг дагаж мөрдөхийг шаардана. Ажлын байрны ёс зүйн дүрэм нь хамт ажиллагсад, ажил олгогч болон олон нийттэй хүндэтгэлтэй, ёс зүйтэй, хариуцлагатай харьцахад чиглэсэн болно. Ажлын байрны ёс зүйн дүрмийн загварыг энэхүү ХУЖ-ын хавсралт 1-д тусгасан.

Оролцогч санхүүгийн байгууллагын ажилтнууд (хувийн хэвшлийн байгууллагууд)

Төслийн бичил зээлийн санхүүжилтийг бичил бизнес эрхлэгчдэд олгохоор сонгогдсон санхүүгийн байгууллагуудын ажилтнуудыг гэрээт ажилчид гэж үзнэ. Төсөл хэрэгжих нийт хугацааны туршид нийтдээ 70 хүн шаардагдана гэж тооцсон. Оролцогч санхүүгийн байгууллагууд нь төслийн хүрээнд зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлтээр ажилтан авах шаардлагагүй. Иймээс эдгээр гэрээт ажилчид нь оролцогч санхүүгийн байгууллагад одоо ажиллаж байгаа ажилчид байна. Оролцогч санхүүгийн байгууллагууд нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажилтнуудаа ажилд авч, хуулийн дагуу тэдний эрхийг хамгаалах бөгөөд ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний нөхцөл болон гэрээний явцад үүссэн асуудлууд нь Монгол улсын холбогдох эрх бүхий байгууллага, шүүхээр шийдвэрлэгддэг.

Энэхүү бичил зээл олгох үндсэн ажилтнууд нь зээлийн өргөдлийг хянан шалгадаг ажилтнууд болон зээлийг олгох шийдвэр гаргадаг менежерүүд байна. Гүйцэтгэх гол ажлуудад баримт бичиг, тэмдэглэл, урьдчилсан хяналт үнэлгээний үр дүнг хянах, бэлтгэх, танилцуулах, өргөдөл гаргагч, үр шим хүртэгчидтэй харилцах, зээлийн гэрээ байгуулах, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих гэх мэт үйл ажиллагаа орно. Эдгээр ажилчдын хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой эрсдэлийг бага гэж үзсэн. Гэхдээ оролцогч санхүүгийн байгууллагаар дамжуулан зээл олгох гэрээнд ажилтныг ажилд авах болон гэрээ байгуулахдаа хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангаж биелүүлсэн байх үүргийг тусгана.

Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажиллагсад, бараа нийлүүлэгч

Төсөлд бараа, үйлчилгээ нийлүүлэхээр сонгогдсон зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажилтнууд (2.2 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх шинэлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах тохиолдолд хувийн сургалтын үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд орно) нь мөн гэрээт ажилчин гэж тооцогдоно. Эдгээр ажилчид нь ихэвчлэн мэдээллийн системийг хөгжүүлэх, мэдээлэл цуглуулах, тайлан гаргах, дүн шинжилгээ хийх, төслийн холбогдох материалыг боловсруулах, олон нийтэд хүргэх, сурталчлах, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах гэх мэт чиглэлээр ажиллана.

Эдгээр ажилчдын хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой хөдөлмөрийн эрсдэлийг бага гэж үзсэн. Гэхдээ эдгээр байгууллага, нийлүүлэгч нартай байгуулсан зөвлөхийн болон зөвлөхийн бус гэрээнд тухайн байгууллага,

нийлүүлэгч ажилтнуудыг ажил авах болон гэрээ байгуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагыг хангаж биелүүлэх талаарх үүргийг тусгана.

3.3. Хөдөлмөр эрхлэх нас

Төслийн үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүүхдүүдийг татан оролцуулах эрсдэл огт байхгүй буюу хамаагүй байна. Монгол улсад Хөдөлмөрийн тухай хуульд (1999 он, 109-р зүйл) заасны дагуу хөдөлмөрийн ердийн нөхцөлд ажиллаж болох насны доод хэмжээ нь 16 нас байдаг. Гэхээ 18 нас хүрээгүй хүнийг ажилд авахдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд даацын ачаа өргөх болон шөнийн цагаар ажиллахыг хориглох гэх мэт хэд хэдэн шаардлагууд байдаг. Төслийн ажлын онцлог шинжийг харгалзан зөвхөн 18 ба түүнээс дээш насны хүмүүсийг төсөлд ажиллуулна. Хэрэв төсөлд 18-аас доош насны хүүхдийг ажиллуулж байгааг илрүүлбэл хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хариуцлагатайгаар ажил эрхлэлтийг зогсоох арга хэмжээ авна. ТХН (Төслийн зохицуулагч болон ХШҮ-ний мэргэжилтэн) нь гэрээг цуцлахдаа гэрээгээр ажил гүйцэтгэгч, хүүхэд болон хүүхдийн гэр бүлтэй хариуцлагатайгаар хамтран ажиллана.

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээ

4.1. Шууд хамаарал бүхий ажиллагсад

Шууд хамаарал бүхий ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг бага гэж үзсэн. Тэдний гол үүрэг нь бодлого, хууль журам, үйл ажиллагааны баримт бичиг, тайланг бэлтгэх, хэрэглэх, гаргах болон судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг юм. Мөн төрийн байгууллагууд, оролцогч талууд, олон нийт, үр шим хүртэгч нартай зөвлөлдөх уулзалт, зөвлөгөөн хийх, харилцах зэрэг асуудлууд орно. Төслийн үйл ажиллагаанд зориулан засгийн газрын байгууллага, агентлагуудаас нэмэлтээр ажилтан ажиллуулах шаардлагагүй.

Эдгээр ажилчидтай холбоотой ажлын байрны аюулгүй байдал, ажилчдын эрүүл мэндэд учирч болзошгүй зарим эрсдэлүүд байна. Жишээлбэл: илүү цагаар ажиллах, ажлын байрны ажиллах орчин муу байх, ажлын дарамтаас үүдэлтэй стресс, албан томилолттой холбоотой аюулгүй байдлын эрсдэл зэрэг байж болно. Эдгээр эрсдэлийг төслийн тусгайлсан эрсдэл гэж үзэхгүй бөгөөд эдгээр ажилчид нь төслийн үйл ажиллагаанд оролцоноор нэмэгдэх эрсдэл гэж үзэхгүй. Гэхдээ эдгээр эрсдэлийг ажлын үр дүнтэй, сайн зохион байгуулалт, жолоочийн аюулгүй байдлыг хангах, тээврийн хэрэгслийн тогтмол үзлэг, засвар үйлчилгээ хийх, тээврийн хэрэгслийн жолоочийг ажилд авахад тавигдах шаардлагыг нарийн тогтоох, ажлын байранд ашиглагдах тоног төхөөрөмжийг худалдан авахад хийгдэх гэрээний (холбогдох төрийн байгууллагууд) нөхцөлийг анхаарах зэрэг арга замаар бууруулах боломжтой.

4.2. Гэрээт ажилчид

4.2.1. 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх жижиг хэмжээний барилгын ажлын ажилчид

Шууд хамаарал бүхий ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг дунд зэрэг гэж үзсэн. Энд хүнд даацын машин механизм, даралтат контейнер, өндрийн болон хүнд даацын ажил, шороог зайлуулах, хоолой суурилуулах гэх мэт ажил шаардагдахгүй. Ажилчид жижиг хэмжээний барилгын ажил, дотоод засал чимэглэл, арматуртай холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Эдгээр ажилчдын аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг дунд зэрэг гэж үзсэн. Энд цахилгааны аюулгүй байдал, тоос шороонд өртөх (болзошгүй), асбест агуулсан материалыг шилжүүлэх, ашиглах, зайлуулах явцад асбестын эрсдэлд өртөх (энэ төрлийн эрсдэл нь талбайн үнэлгээгээр тогтоогдоно), халтиргаа, уналт, материалыг өргөх зэргээс үүсэх гэмтэл, согтууруулах ундаа хэрэглэх, зодоон хийх гэх мэтээс шалтгаалсан эрсдэлийг оруулсан боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ

ХНХЯ-ны үнэлгээний хороо нь ажилчдынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг удирдан зохион байгуулах чадвартай жижиг хэмжээний барилгын ажил гэрээлэгчийг сонгон шалгаруулна. Түүнчлэн, ХНХЯ болон түүний ТХН нь асбестын нөлөөлөлд өртөх эрсдэлийг хянахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ХХҮЕГ-ын барилгын зураг төслийг боловсруулах, шинэчлэх ажлын төлөвлөгөө гаргахаар сонгогдож гэрээ байгуулсан компанид засвар, шинэчлэлийн ажилд асбест агуулсан материалыг ашиглахтай холбоотой эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох, барилгыг шалгах шаардлага тавих
- Хэрэв асбесттой холбоотой эрсдэл тогтоогдвол тус компани нь Дэлхийн Банк Группийн “Асбест - Хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн эрүүл мэндийн асуудлууд⁵”-ын сайн туршлагын зөвлөмжийг харгалзан үзэж асбест агуулсан материалыг аюулгүй шилжүүлэх, боловсруулах, зайлуулах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулна. Энэхүү удирдамжийг төслийн БОНУХ-ны гарын авлагад хавсаргасан бөгөөд төлөвлөгөөнд ажилчдыг хамгаалах арга хэмжээг багтаана.
- Тендерийн баримт бичиг, ажил гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд ажил олгогч нь холбогдох сургалт болон хувийн хамгаалах хэрэгслээр ажилчдыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажлын байран дах ажилтан нэг бүрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, барилгын ажлыг осол авааргүй гүйцэтгэх талаарх үүргийг тусгана.
- Зөвлөхийн үйлчилгээ үзүүлж буй компани асбесттой холбоотой эрсдэлийг тодорхойлсон тохиолдолд ХНХЯ болон ТХН нь тендерийн баримт бичиг, гэрээнд гүйцэтгэгч нь асбест агуулсан материалыг аюулгүй зөөх, хэрэглэх,

⁵ Зөвлөмжид асбестын хортой холбоотой эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлсон. Эдгээр эрсдэлийг багасгах талаарх эхүүний зарим хувилбарыг тайлбарласан. Энэхүү зөвлөмж нь Дэлхийн банк группийн БОНС-ын удирдамжид олон улсын сайн туршлагыг жагсаасан бөгөөд ашиглах боломжтой асбест агуулсан бүтээгд тусгагдсан үндсэн агуулгыг хэрэгжүүлэх талаар тусгасан. Дэлхийн банк группийн зүгээс зээл олгох болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлж буй төслүүдэд ихэвчлэн хүлээн зөвшөөрдөг асбестын талаарх ерөнхий туршлагуудыг БОНС-ын удирдамжид тусгасан болно.

хог хаягдлыг зайлуулах талаар тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх шаардлага, үүрэг хариуцлагыг тусгана.

- Гүйцэтгэгч нь ажлын явц болон ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, хяналт тавих, ажилчдын биеэ авч явах байдалд хяналт тавих, барилгын ажлын гүйцэтгэлийг хариуцан ажиллах талбайн менежерийг томилон ажиллуулах үүрэгтэй.
- Гүйцэтгэгч нь гэрээнд гарын үсэг зурсан ажлын аль нэг хэсгийг дэд гэрээгээр гүйцэтгүүлэхийг хориглоно.
- Шаардлагатай бол ТХН нь гэрээгээр ажил гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, ажилчдыг аюулгүй, эрүүл ажлын байраар хангах, асбест агуулсан материалыг аюулгүй зөөх, хэрэглэх, хог хаягдлын менежмент зэрэг иргэний барилгын ажилд мэргэшсэн хянагч ажилтныг ажиллуулна.

4.2.2. Оролцогч санхүүгийн байгууллагын ажилтнууд

Оролцогч санхүүгийн байгууллагын ажилчид нь баримт бичиг, гэрээг хянах, бэлтгэх, хувилах, хадгалах, архивлах, оффисын тоног төхөөрөмжтэй ажиллах, зээл хүсэгчид буюу төслийн үр шим хүртэгчидтэй харилцаа холбоо тогтоох, удирдах, үр шим хүртэгчдийн зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих зэрэг ажлуудыг голчлон гүйцэтгэнэ (магадгүй албан томилолтоор ажиллаж болох юм). Оролцогч санхүүгийн байгууллагуудын ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг бага гэж үзсэн. Гэхдээ оролцогч санхүүгийн байгууллагатай байгуулах зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэх гэрээнд ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учрах эрсдэлийн хариуцлагын талаар тусгана.

4.2.3. Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллага, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн ажилтнууд

Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч компаниудын ажилчид нь баримт бичиг болон тайланг хянах, бэлтгэх, хувилах, түгээх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, судалгаанд оролцогч нартай нүүр тулан харилцах, утсаар ярилцлага авах, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, олон нийт болон үр шим хүртэгч нартай харилцах, мэдээллийн систем боловсруулах, турших, олон нийтэд чиглэсэн тараах материал боловсруулах, хэвлэх гэх мэт үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг голлон гүйцэтгэнэ. Эдгээр гэрээгээр ажил гүйцэтгэгч нарын ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг ерөнхийдөө бага гэж үзсэн.

Гэхдээ ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд дунд зэргийн эрсдэл үүсгэж болзошгүй тодорхой төрлийн үйл ажиллагаанууд байна. Жишээлбэл, бараа, тоног төхөөрөмж нийлүүлэгч нарын ажилтнууд нь Улаанбаатар хот дотор болон орон нутаг руу бараа тээвэрлэх, хүргэхтэй холбоотой ажлуудыг голчлон гүйцэтгэнэ. Улаанбаатар хот болон орон нутаг руу явах замын нөхцөл, байдал сайжирсан тул (баруун бүсэд хийгдэж буй цөөн хэдэн аймгийг холбосон замаас бусад) бараа, тоног төхөөрөмж хүргэх ажилтнуудтай холбоотой зам тээврийн ослын эрсдэлийг дунд зэрэг гэж үзэж байна. Эрсдэлийг

удирдахын тулд ХНХЯ болон ТХН нь хангалттай тээврийн хэрэгсэл, туршлагатай жолоочтой илүү сайн найдвартай ханган нийлүүлэгчийг сонгох ажлыг зохион байгуулна. Мөн зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг шийдвэрлэх хариуцлагыг тусгасан байна.

5. КОВИД-19 цар тахалтай холбоотой анхаарч үзэх асуудлууд

Төсөлд эрүүл мэндийн ажилтнууд, хог хаягдлын менежментийн ажилтнууд болон КОВИД-19 цар тахлын эрсдэлд өртөж болзошгүй шилжин суугч иргэдийг хамруулахгүй. Мөн цэргийн албан хаагчид төслийн үйл ажиллагаанд оролцохгүй. Төслийн хүрээнд ажилчдыг нэг газраас нөгөөд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхгүй.

Төслийн 4-р бүрэлдэхүүн хэсэг нь КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэгдэх бөгөөд зохих шалгуур хангасан ажил олгогч болон заавал даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ. Төслийн үйл ажиллагааны хүрээнд ажилчид болон үр шим хүртэгчид нь шууд биечлэн оролцох болон холбогдох хөнгөлөлт, дэмжлэгийн арга хэмжээ авахдаа олноороо бөөгнөрөх, нүүр тулан харилцах шаардлагагүй. Төслийн үр шим хүртэгчдийг тодорхой шалгуурын дагуу НДЕГ-ын одоо байгаа мэдээллийн санг ашиглан тодорхойлно.

Корона вирус дотоодод тархсан буюу 2020 оны 11 дүгээр сарын эхэн үеэс Улсын Онцгой комиссоос улсын хэмжээнд болон тодорхой хэсэгт бүсчилсэн байдлаар хэд хэдэн удаагийн хөл хорио тогтоох шийдвэр гаргасан. Улсын хэмжээнд тогтоосон хөл хорионы үеэр эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний ажилтнуудаас бусад засгийн газрын болон төрийн захиргааны ажилтнууд үйлчилгээ үзүүлээгүй. Түүнчлэн, хөл хорионы хооронд засгийн газрын ажилтнууд хэсэгчилсэн байдлаар буюу нийт ажилчдын 10%-30% хувь нь үйл ажиллагаа явуулж байсан ба төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд мөн адил хатуу хяналт, шаардлага тавьж байсан. Энэ нөхцөлд эдгээр төрийн үйлчилгээний албан хаагчдын ажиллах нөхцөл нь төрийн үйлчилгээний хөдөлмөрийн гэрээний дагуу болон УОК болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан журмын дагуу хэвээр байна. ТХН болон ХНХЯ-ны хэрэгжүүлэгч агентлагууд нь УОК болон Засгийн газрын шийдвэрийг дагаж мөрдөнө. Төсөл нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ цар тахлын тархалт, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах талаар УОК болон Засгийн газраас гаргасан заавар, чиглэлийг чанд дагаж мөрдөх бөгөөд виртуал хэрэгслүүд болон олон нийтийн мэдээллийн сувгаар дамжуулан хүргэх сургалт, мэдээлэл түгээх, зөвлөлдөх үйл ажиллагааг тохируулан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Төсөл нь КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хязгаарлах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж, хариу арга хэмжээг авч ажиллах болно. Төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний танхимыг шинэчлэх, засварлах гэх мэт талбайд биечлэн гүйцэтгэх шаардлагатай ажлуудыг гүйцэтгэхдээ үйл ажиллагааг зогсоох болон үргэлжлүүлэхтэй холбоотой УОК-ын шийдвэрийг дагаж мөрдөх бөгөөд гэрээгээр ажил гүйцэтгэгчийн зүгээс хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэхийг баталгаажуулна.

УОК-ын шийдвэрийн дагуу төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрсөн буюу төслийн үйл ажиллагаанд хамрагдах боломжтой болсон тохиолдолд ХНХЯ, ТХН болон холбогдох төрийн

байгууллагууд, орон нутгийн байгууллагууд тухайн ажлын байран дээр ажиллаж байгаа ажилчид болон үйлчлүүлэгчдийг КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. Ингэхдээ УОК болон Эрүүл мэндийн яамнаас гаргасан удирдамж, зөвлөмжийг дагаж мөрдөх бөгөөд холбогдох үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Улсын онцгой комиссоос төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг төрийн үйлчилгээг тасралтгүй явуулахыг зөвшөөрсөн тохиолдолд ХНХЯ, ТХН болон холбогдох төрийн байгууллагууд, үйлчилгээ үзүүлэгчид нь КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Энэхүү авч хэрэгжүүлж буй арга хэмжээг ажилчид болон үйлчлүүлэгчид бүрэн сахин хэрэгжүүлнэ. Мөн Улсын онцгой комисс болон эрүүл мэндийн яамнаас гаргасан удирдамж, зөвлөмжийн дагуу шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

Төсөл нь ажлын байр болон нийгэмд цар тахал тархахаас урьдчилан сэргийлэх эсвэл эрсдэлийг багасгахын тулд ДЭМБ-ын КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх удирдамжийг⁶ авч үзнэ. Шаардлагатай тохиолдолд төсөл нь КОВИД-19-ээс урьдчилан сэргийлэх, хянах талаарх Монгол Улсын онцгой комисс (УОК) болон Эрүүл мэндийн яам (ЭМЯ) -ны удирдамжийг дагаж мөрдөнө. Төсөл нь ДЭМБ-ын дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

- Төсөл нь ДЭМБ-ын КОВИД-19 цар тахлын үед ажлын байран дахь нийгмийн эрүүл мэнд, нийгмийн арга хэмжээнд анхаарч үзэх асуудлууд⁷
- КОВИД-19 цар тахлын үед олон нийтийг хамарсан арга хэмжээ, цугларалтад анхаарах үзэх асуудлууд⁸

Төслийн зохицуулагч нь ТХН-ийн ажилтнуудыг КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ авна. Мөн халдвар дамжих эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээний талаар ХНХЯ болон төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд оролцож буй агентлагуудтай харилцан уялдаатай ажиллах бөгөөд гэрээгээр ажил гүйцэтгэгч нартай байнгын холбоотой байна. ТХН нь ХНХЯ-наас тусгайлан өгсөн чиглэл болон УОК-оос өгсөн ерөнхий зааврын дагуу гүйцэтгэгч бүртэй анхаарах зүйлс болон үйл ажиллагааны талаар бичгээр харилцана.

6. Үүрэг хариуцлага

ХНХЯ болон ТХН нь дараах асуудлыг хариуцан ажиллана. Үүнд:

- Төслийн шууд хамаарал бүхий ажилчдын оролцоо, удирдлага;
- Худалдан авах, тендерийн үйл явцыг зохицуулах, гэрээний дагуу үйл ажиллагааг зохицуулах, гүйцэтгэгчдэд хяналт тавих, удирдах

⁶ Эдгээр техникийн удирдамжийг <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/technical-guidance> хаягаар орж үзнэ үү.

⁷ <https://www.who.int/publications/i/item/considerations-for-public-health-and-social-measures-in-the-workplace-in-the-context-of-covid-19>

⁸ <https://www.who.int/publications/i/item/considerations-for-mass-gatherings-in-the-context-of-covid-19-annex-considerations-in-adjusting-public-health-and-social-measures-in-the-context-of-covid-19>

- Төслийн түвшин дэх ГБМ-ыг бий болгох, холбогдох талууд болон төслийн ажилчид ГБМ-д хандах, өргөдөл гаргах эрхийн талаар олон төрлийн арга замаар мэдээлэл түгээх (ГБМ нь бэлгийн дарамт, хүчирхийлэлтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээж авах боломжтой);
- Төслийн оролцогч талуудад зориулан ГБМ-ын талаар сургалт зохион байгуулах;
- Ажилчдын гомдлыг шийдвэрлэх;
- Монгол улсад цар тахал гарсан тохиолдолд КОВИД-19-ын тархалтаас урьдчилан сэргийлэх, хянах талаар тавигдах шаардлага, удирдамжийн биелэлтийг хянах.

Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэгч, гэрээгээр ажил гүйцэтгэгч нь төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд оролцогч ажилтнуудын шууд ажил олгогч тул дараах асуудлыг хариуцна. Үүнд:

- Хуулиар тогтоосноор доош насны хүнийг ажилд авахгүй байх бөгөөд тухайн хүний насыг нотлох баримт бичгийг үндэслэн ажилд авах
- Ажилтан нэг бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулах
- Ажилчдыг эрүүл, аюулгүй ажлын байраар хангах
- Төслийн гомдол барагдуулах механизмын талаар ажилчдад мэдээлэх
- Нийт ажилтан, албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар зааварчилгаа, чиглэл өгөх
- Хөдөлмөрийн гэрээд заасан нөхцөл, шаардлагын дагуу ажилчдын хууль ёсны шаардлагыг шийдвэрлэх
- Барилгын ажил гүйцэтгэгч нь ажилтан албан хаагчдад Ажлын байрны ёс зүйн дүрмийг танилцуулах, зааварчилгаа өгөх болон барилгын засварын ажил гүйцэтгэж буй ажилтан нэг бүрд ажлын байрны ёс зүйн дүрмийг танилцуулсан эсэхийг баталгаажуулж гарын үсэг зуруулах

ХНХЯ болон ТХН нь гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэгч нартай байгуулах гэрээнд дээр дурдсан үүрэг хариуцлагыг тусгаж өгнө. ХНХЯ болон ТХН нь гэрээгээр ажил, үйлчилгээ үзүүлэгч нараас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй. Үүнд ажилтны гаргасан гомдолтой холбоотой асуудал орно. Хөдөлмөрийн удирдлагын журмын талаар оролцогч талууд болох ХНХЯ, ТХН-тэй хэд хэдэн удаа зөвлөлдсөн. Эхний зөвлөлдөх уулзалтаар журмын анхны төслийг (2020 оны 10-р сарын 14-нд), хоёр дахь уулзалтаар журмын шинэчилсэн төслийг хэлэлцсэн (2020 оны 11-р сарын 10-нд) бөгөөд гурав дахь зөвлөлдөх уулзалтыг Дэлхийн банканд баримт бичиг хүргүүлэхээс өмнө буюу 2021 оны 4-р сарын сүүлчээр зохион байгуулсан.

7. Хөдөлмөрийн харилцаатай холбоотой гомдлыг барагдуулах

Ажилчдаас гаргасан гомдлыг төслийн байгаль орчин, нийгмийн удирдлагын гарын авлагад (4-р хэсэг) авч үзсэн төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулан шийдвэрлэнэ. Төслийн бүх ажилчид гомдол барагдуулах механизмыг ашиглах боломжтой байна. Гомдол барагдуулах механизм нь үндэсний хууль тогтоомж, одоогийн арбитрын журмаар дамжуулан өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэхэд саад болохгүй бөгөөд хамтын гэрээний дагуу гомдол барагдуулах механизмыг орлохгүй.

Доор дурдсан сувгуудаар дамжуулан хөдөлмөрийн харилцаатай холбоотой гомдлоо гаргах боломжтой.

Хүснэгт 3. Төслийн ажилчид хөдөлмөрийн харилцаатай холбоотой гомдол гаргах сувгууд

| | | | |
|--|--|---|--|
| <p>Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн (ХХҮХ) түвшинд:</p> <p>Холбоо барих: Хариуцсан мэргэжилтэн</p> <p>Имэйл: Бүх ХХҮХ-ийн вебсайд дээр бүх холбоо барих мэдээлэл орсон бөгөөд ХХҮЕГ-ын доорх вебсайт дээрх холбоосоор орж болно.</p> <p>http://hudulmur-halamj.gov.mn/</p> | <p>Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын (ХХҮЕГ) түвшинд:</p> <p>Холбоо барих: Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн</p> <p>Имэйл: info@hudulmur-halamj.gov.mn</p> <p>Вебсайт: http://hudulmur-halamj.gov.mn/</p> <p>Утас: +976 77315091</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн ергөн чөлөө, Хөдөлмөрийн ордон</p> | <p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн (ТХН) түвшинд:</p> <p>Холбоо барих: Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>Төсөл нь төслийн вэбсайтаар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээж авна. (Веб сайт хийгдсэн байна.): Энэхүү вэбсайт нь ГБМ, санал хүсэлтийн хуудастай байна.</p> <p>Мөн түүнчлэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар хүлээн авах боломжтой.</p> <p>Утас: +976-75057570</p> <p>Имэйл: info@mesp.mn</p> <p>Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 14200, Ерөнхий сайд Амарын гудамж, “САН” бизнес төв, 501 тоот.</p> | <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны (ХНХЯ) түвшинд:</p> <p>Холбоо барих: Хариуцсан мэргэжилтэн</p> <p>Имэйл: info@mlsp.gov.mn</p> <p>Вебсайт: www.mlsp.gov.mn</p> <p>Утас: +976-51-261553 +976-51-267635</p> <p>Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, НҮБ-ын гудамж</p> |
|--|--|---|--|

ТХН нь төслийн тусгай вэбсайтаар байх бөгөөд төслийн үр шим хүртэгчдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг бүртгэх зориулалттай тусгай цэстэй байна. Өргөдөл, гомдлын дийлэнх хувийг аймаг, дүүргийн түвшинд хамаарах өргөдөл, гомдол эзэлнэ гэж таамаглаж байна. Иймээс энэ түвшинд өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, тайлагнахад хялбар байлгах үүднээс ТХН-ийн вэбсайтын ГБМ-ын цэсэд орон нутгийн түвшинд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн аймаг, дүүргийн ХХҮХ-ийн ГБМ-ийн холбогдох и-мэйлд шууд илгээж байхаар боловсруулан тохируулна.

Төсөл хэрэгжих хугацааны туршид хэзээ ч хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдөл, гомдлыг ирүүлж болно. Өргөдөл, гомдлыг илгээхэд ямар нэгэн төлбөр төлөхгүй. Өргөдөл, гомдлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бичгээр, амаар болон цахим хэлбэрээр гаргаж болно. Бичгээр гаргасан гомдолд цахим

хэрэгслээр ирүүлсэн гомдлыг хамааруулна. Холбогдох үндэсний хууль, тогтоомжийн дагуу бичгээр гаргасан гомдолд овог, нэр, оршин суугаа хаяг, шуудангийн хаягийг тодорхой бичнэ. Засгийн газрын тусгай утсаар (уг системийн дагуу өргөдөл, гомдлыг ХНХЯ, ХХҮЕГ, НДЕГ болон тэдгээрийн салбар хэлтсүүд рүү дамжуулдаг) болон дээрх дөрвөн сувгийн утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг амаар гаргасан гомдол гэж үзнэ. Засгийн газрын тусгай утсаар ирүүлсэн өргөдөл, гомдолд гомдол гаргагчийн нэр, хаягийг тодорхойлоогүй байсан ч гомдлын талаарх мэдээллийг бүртгэнэ.

| Хүснэгт 3. Үндэсний хууль, тогтоомжид заасан хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдөл, гомдлыг барагдуулах чиг үүрэг | | |
|--|--|---|
| Сэдэв | Хууль тогтоомж | Гомдлыг барагдуулах |
| Жендерийн ялгаварлан гадуурхал, бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэл, бэлгийн дарамт | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), | Төрийн албан дахь жендерийн ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавих (21 дүгээр зүйл) Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх бөгөөд хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгана. (11 дүгээр зүйл) 23 дугаар зүйл, Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно. |
| Буруу ажлаас халах, нөхөн төлбөр, гэрээ, шийтгэл | Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), 128 дугаар зүйл | Хөдөлмөрийн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэнэ. |
| Бусад хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргаан | Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), 126 дугаар зүйл | Хөдөлмөрийн хуулийн дагуу (1999, 126 дугаар зүйл) шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс хянан шийдвэрлэнэ. |

Хөдөлмөрийн удирдлагын журмын Хавсралт 1.

Ажлын байрны ёс зүйн дүрэм

ОБҮДХЭТ-ийн хүрээнд үйлчилгээний газруудад жижиг хэмжээний завар, шинэчлэлийн ажил гүйцэтгэхээр сонгогдсон гэрээгээр ажил гүйцэтгэгчийн ажилтнууд энэхүү ажлын байрны ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурна.

Гүйцэтгэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- i) Ажил гүйцэтгэхээр томилогдсон ажилтан бүрд ажлын байрны ёс зүйн дүрмийг танилцуулан гарын үсэг зуруулах
- ii) Ажилтанд гарын үсэг зурсан хуулбарыг өгөх,
- iii) Ажилчдын ажлын байран дээр биеэ авч явах байдалд хяналт тавих.

Энэхүү ажлын байрны ёс зүйн дүрэм нь хамт ажиллагсад, ажил олгогч болон олон нийттэй хүндэтгэлтэй, ёс зүйтэй, хариуцлагатай харьцахад чиглэнэ.

Ажилтан ажлын байран дээр дараах зүйлсийг мөрдөж ажиллах шаардлагатай.

1. Ажилтнууд болон нийтийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахтай холбоотой заавар, зөвлөмжийг дагаж мөрдөнө.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд:
 - ажил олгогчоос өгсөн хамгаалалтын малгай, хамгаалах хэрэгслийг өмсөх;
 - шал, шатыг халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх;
 - галын аюулгүй байдлыг хангаж, гарцад саад учруулахгүй байх;
 - хурц үзүүртэй зүйлтэй харьцахдаа анхаарал болгоомжтой байх;
 - ажлын цагаар агаарын солилцоог сайн хангах;
 - хамтран ажиллагсдын тусламжгүйгээр хүнд зүйлийг өргөхөөс зайлсхийх;
 - ажлын байран дээр осол, гэмтэлд хүргэж болзошгүй эрсдэлтэй зан үйлээс зайлсхийх;
 - аливаа осол, аваарын талаар удирдлагад мэдэгдэх;
3. Хариуцсан чиг үүргийг хамтран хариуцлагатайгаар гүйцэтгэх;
4. Бусадтай хүндэтгэлтэй, ялгаварлалгүй харьцах;
5. Ажлын байран дээр хамтран ажилладаг аль ч түвшний эрэгтэй, эмэгтэй болон бусадтай хамтран ажиллагсад, олон нийттэй харьцахдаа ажлын байран дах дарамт шахалт үзүүлэхгүй байх.
6. Олон нийт, хамт ажиллагсад, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд бэлгийн дарамт үзүүлэхээс зайлсхийх;
7. Ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэхээс зайлсхийх;
8. Ажлын байран дээр хэрүүл маргаан, зодоон хийхээс зайлсхийх;
9. Өөрийн тээврийн хэрэгслээр ажилдаа ирж, очихдоо зогсоол болон гарцан дээр осол гаргахаас болгоомжлох
10. Удирдлагаас өгсөн зааврын дагуу хог хаягдлыг зохих ёсоор зайлуулах, хог хаягдлын зориулалтын цэг дээр хаях;
11. Агаар, усыг бохирдуулах ямар нэгэн үйлдэл хийхгүй байх.

Гарын үсэг: _____

Ажилтны овог, нэр: _____

Огноо: _____

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Хавсралт 2

Дэлхийн Банк Группийн сайн туршлагын тэмдэглэл: “Асбест – Ажил мэргэжлийн болон олон нийтийн эрүүл мэндийн асуудлууд”

1. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү тэмдэглэл нь Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл (ОБҮДХЭТ)-ийн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд хийгдэх жижиг хэмжээний засвар, заслын ажлын явцад асбестод өртөхтэй холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эдгээр эрсдэлийг бууруулахад чиглэсэн олон улсын сайн туршлагын талаарх мэдээллийг өгөх, зах зээлд ашиглагдаж буй асбестыг орлуулж болох зарим өөр бүтээгдэхүүний талаар тойм танилцуулга мэдээллийг өгөх зорилготой.

Асбесттой холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах ажилчдыг асбестын нөлөөнөөс болж эрүүл мэндэд нь учрах аюулаас хамгаалах олон улсын болон дотоодын стандарт, журмыг 3-р хэсэгт тайлбарласан. 4-р хэсэгт асбест агуулсан материалыг орлуулж болох боломж болон асбестын эрүүл мэндэд учруулж болох эрсдэлийн талаарх Дэлхийн банкны чиг хандлагын талаар тусгасан.

2009 оны 05 дугаар сард Дэлхийн Банкны Үйл ажиллагааны Бодлого ба Улс орны үйлчилгээнээс гаргасан сайн туршлагын тэмдэглэл нь шинэ барилга барих, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд Асбест агуулсан материал (ААМ) ашиглахаас зайлсхийх буюу хэрвээ асбест агуулсан материал ашиглах шаардлага тулгарвал тэдгээрийн нөлөөллийг бууруулахын тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт ба сайн туршлагыг ашиглах замаар ААМ-тай холбоотой эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахад чиглэнэ. 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх засварын ажилд ААМ-ыг ашигласан тохиолдолд энэхүү тэмдэглэлд заасан асбест агуулсан материалын менежмент болон түүнийг зайлуулах талаарх шаардлагыг дагаж мөрдөнө.

Энэхүү сайн туршлагын тэмдэглэлийг засварын ажлын гэрээнд хавсаргаж гэрээ байгуулагч тал болон бичил бизнес эрхлэгчид дагаж мөрдөнө. Засварын ажлын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон нийгмийн нөлөөллийн байдлыг үнэлэх хуудас (ОБҮДХЭТ-ийн БОНУХ-ний Хавсралт 4)-д тусгасан шаардлагыг хангасан эсэхийг шалгахад ашиглана. Дээрх шаардлагыг хангаагүй байдал нь гэрээг цуцлахад хүргэж болно (Бүрэлдэхүүн хэсэг 1). Энэхүү тэмдэглэлийг практикт хэрэгжүүлэхэд хяналт тавих ажлыг ХШҮ-ний ажилтан болон барилгын ажлын хяналтын инженер хариуцна.

2. АСБЕСТ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛ

Асбест гэж юу вэ? Асбестын ашиглалтад яагаад анхаарах ёстой вэ?

Асбест нь байгаль дээр тархсан маш нарийхан утсархаг силикат эрдсийн бүлэг нэгдэл юм. Нэгэн цагт асбестыг галд тэсвэртэй, дулаан, цахилгааныг бага дамжуулдаг, химийн урвал болон дулаанд эдэлгээ даах чадвартай, сунах чадвар өндөр зэрэг ашигтай шинж чанаруудын улмаас үйлдвэрийн болон ахуйн олон

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өргөн ашиглаж байсан удаатай. Харин өнөөдөр, асбестыг төрөл бүрийн өвчин, хорт хавдрыг үүсгэгч гэж үзэж байгаа бөгөөд асбестоор амьсгалах нь эрүүл мэндэд аюул учруулдаг болохыг тогтоожээ¹. Сүүлийн хэдэн арван жилийн туршид асбестод өртсөний улмаас дэлхий даяар 100 мянга гаруй хүн нас барсан² болохыг ОУХБ тооцож гаргасан бол ДЭМБ ажил мэргэжлийн шаардлагаар асбесттай харьцсаны улмаас жилд дэлхий даяар 90 мянган хүн нас барж байна³ гэж тэмдэглэжээ.

Өнөөдөр үйлдвэрлэгдэж буй асбест буюу шилэн хөвөнгийн маш нарийхан утсархаг биетийн 90% гаруй хувь⁴ нь хризолит бөгөөд үүнийг барилгын асбест-цементийн (А-Ц) материалд ашигладаг: Үүнд А-Ц гөлгөр буюу доргиот хавтан, А-Ц хоолой, А-Ц ус хадгалах сав гэх мэт. Тээврийн хэрэгслийн тоормос ба консны (авцуулах холбооны) дөрөөний бүрээс, дээврийн материал ба жийргэвч гэх мэт одоо үйлдвэрлэгдсээр байгаа бусад бүтээгдэхүүн асбест агуулсан байна. Хэдийгээр асбест-цементэн бүтээгдэхүүнээс өөр барилгын материалд асбестыг ашиглахаа бараг больсон боловч хуучны барилгуудад асбест барилгын уян хатан гадаргуутай материал, дулаалгын материал, шалны шахмал материал зэрэг бусад хэлбэрээр байсаар байна. Эдгээр материалыг ашиглах болон зайлуулахдаа онцгой анхаарах шаардлагатай.

Асбестод өртсөний улмаас үүсэх эрүүл мэндийн эрсдэлийн талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн учраас дэлхийн эрүүл мэнд, үйлдвэрчний эвлэл, судалгааны институт, болон зарим төрийн байгууллагууд асбестыг арилжаанд хэрэглэхийг хориглож (Хүснэгт 1-ийг үзнэ үү), Олон Улсын Конвенцод нэгдэх замаар асбестод өртсөн ажилчид, тэдний гэр бүл, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үндэсний стандартыг дагаж мөрдөхийг шаардаж байна⁵.

ХҮСНЭГТ 1. АСБЕСТ БА АСБЕСТ АГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ

Асбестыг арилжааны зорилгоор ашиглахыг дэлхий нийтээр хориглохыг Барилга болон Мужааны Холбоо (IFBWW), Олон улсын металлээр бүтээгдэхүүн хийгчдийн холбоо, Олон улсын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Францын засгийн газар, эрдэм шинжилгээний нэр хүндтэй Collegium Ramazzini гэх зэрэг байгууллагуудаас уриалж байна. Европын Холбооны бүх гишүүн орнууд болон дэлхийн 40 гаруй улс (Хавсралт 1-ийг үзнэ үү) асбест агуулсан материал, түүний дотор хризотилийг хориглоод байна⁶. 2006 оны 6-р сард ОУХБ-ын Ерөнхий бага хурлаар “Бүх хэлбэрийн асбест болон асбест агуулсан материалыг устгахыг дэмжих” тогтоолыг батлав.

- Landrigan PJ, Soffritti M. “Collegium Ramazzini асбестыг олон улсад хориглохыг уриалав.” *Am. J. Ind. Med.* 47: 471-474 (2005).

¹ http://www.who.int/occupational_health/publications/draft.WHO.policy.paper.on.asbestos.related.diseases.pdf. See also Stayner L, et al., “Exposure-Response Analysis of Risk of Respiratory Disease Associated with Occupational Exposure to Chrysotile Asbestos.” *Occupational Environmental Medicine*. 54: 646-652 (1997).

² http://www.ilo.org/wow/Articles/lang--en/WCMS_081341

³ http://www.who.int/occupational_health/publications/asbestosrelateddiseases.pdf

⁴ Asbestos defined in Castleman, B. *Asbestos: Medical and Legal Aspects* 5th Ed. New York: Aspen, 2005, 894 pp.

⁵ ILO Asbestos Convention No. 162, (see <http://www.ilo.org/ilolex> or http://www.itcilo.it/actrav/osh_es/m%F3dulos/legis/c162.htm)

⁶ http://www.euro.who.int/document/aicq/6_2_asbestos.pdf

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

- Олон улсын хориглох асбестын нарийн бичгийн дарга нарын газар нь үндэсний хориглох асбестын бүртгэлийг хөтөлдөг.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий хурал, “Асбестын тухай тогтоол”, Олон улсын хөдөлмөрийн бага хурал, Ерэн тавдугаар хуралдаан, Тэмдэглэл, Женев, 2006, 299-р зүйл, хх 20/47-48.
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага:
http://www.who.int/occupational_health/publications/asbestosrelateddiseases.pdf

Асбест агуулсан бүтээгдэхүүнтэй холбоотой эрүүл мэндийн асуудлууд

Асбестын тоосоор амьсгалсны улмаас үүсэх эрүүл мэндийн аюулд асбестосис, уушиг гэмтээх өвчнүүд, төрөл бүрийн хорт хавдар (үүнд уушгины хорт хавдар, хэвлий болон цээжний гялтан хальсны зузааралт мезотелиом ба перитонеум зэрэг) багтана.⁷ Эдгээр өвчнүүд нь ихэнхдээ асбестаад өртсөнөөс хойш олон арван жилийн дараа илэрдэг. Мезотелиом нь асбестод өртсөний шинж тэмдэг бүхий хоргүй хавдар бөгөөд гол төлөв ажилчдын хувцасны тоосоор амьсгалсны улмаас тэдгээр ажилчдын гэр бүлийн гишүүд болон асбест бүхий агаар бохирдуулах эх сурвалж бүхий цэгүүдэд амьдарч буй хөрш айлуудын дунд элбэг тохиолддог.⁸ Амьтанд хийсэн зарим туршилтын судалгаанаас харахад бүх төрлийн асбестаар хэдхэн цаг их хэмжээгээр амьсгалахад л хорт хавдар үүсгэдэг болохыг тогтоожээ.⁹ Асбест-цементэн бүтээгдэхүүнийг хуваах, тоормосны дөрөөний бүрээсийг жижиглэн нунтаглахад цахилгаан хэрэгсэл ашиглахад агаарт маш их хэмжээний асбест дэгддэгийг тэмдэглэсэн байна. Хамгийн нийтлэг төрөл зүйл болох хризолит асбестын хувьд хорт хавдар үүсгэх эрсдэл байхгүй байна гэж байдаггүй. Олон тооны ажилчид барилгын худалдааны салбарт ажиллаж байгаа, асбест хянаж, хэмжээг тогтооход хэцүү, барилгын талбайг өөрчлөх, засах, устгах шаардлагатай материалууд байгаа нь байнгын аюул учруулж буй учраас барилгын материал нь санаа зовоох онцгой асуудал болоод байна.¹⁰ Асбест-цементэн материал бүхий барилга байгууламжид засвар, заслын ажлыг гүйцэтгэх нь тухайн барилгад оршин суугчдад мөн аюул учруулах магадлалтай. Арилжааны зориулалттай асбест бүхий бүтээгдэхүүний улмаас үүсэх бэрхшээлээс гадна асбест нь чулуу, гялтгануур, вермикулит, төмрийн хүдэр болон бусад эрдсийн зарим ордуудад бохирдуулагч бодис байдлаар оршдог. Энэ нь тухайн уурхайн талбайд ажиллаж буй ажилчид, оршин суугчдад, зарим тохиолдолд үйлдвэрлэлийн үйл явцад ажиллаж буй ажилчид, тухайн материалыг ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид ашиглах явцад эрүүл мэндийн аюул учруулж болох юм. Асбестаар амьсгалах нь карцероген буюу хорт хавдар үүсгэгч хүчин зүйл болох магадлалтай гэдгийг мэддэг боловч асбест агуулсан бүтээгдэхүүнийг идэх, тухайлбал ийм агууламжтай

⁷ http://www.euro.who.int/document/aic/6_2_asbestos.pdf

⁸ “Asbestos.” *World Health Organization IARC Monographs on the Evaluation of Carcinogenic Risks to Humans/ Overall Evaluations of Carcinogenicity: An Updating of IARC Monographs 1 to 42, Suppl. 7.* Lyon: International Agency for Research on Cancer, 1987, pp. 106-116.

⁹ Wagner JC, Berry G, Skidmore JW, Timbrell V. “The Effects of the Inhalation of Asbestos in Rats.” *Br. J. Cancer* 29: 252-269 (1974).

¹⁰ International Program on Chemical Safety, “Conclusions and Recommendations for Protection of Human Health,” *Chrysotile Asbestos*, Environmental Health Criteria 203. Geneva: World Health Organization, 1998, p. 144.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ (ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

ус уух нь хорт хавдар үүсгэгч хүчин зүйл болдгийг бид мэддэггүй,¹¹ гэхдээ “зэвтэй” ус гаргадаг асбест-цементэн хоолойн стандартууд байдаг болохыг дурджээ.¹²

Үйлдвэрийн эрүүл ахуйн үзэл баримтлалын хувьд олборлолт эхэлсэн цагаас эхлээд газарт булах, эсвэл зөвшөөрөгдөөгүй газарт зайлуулж хаях хүртэлх хугацаанд олон хэлбэрээр асбестадад өртөж харьцах гинжин тохиолдлууд гардаг. Асбесттай харьцах тохиолдол тус бүрд ажил мэргэжлийн шаардлагаар болон олон нийт асбестадад өртөхийн аль аль нь давхар тохиолддог. Хүдэр олборлох явцад уурхайн ажилчид файбер буюу нарийхан утсархаг хөвөнтэй таардаг; эдгээр ажилчдын ажлын хувцсанд наалдсан хөвөн биетээр тэдний гэр бүлийн гишүүд амьсгалдаг; бутлуур болон үйлдвэрийн ажилчид эдгээр утсархаг хөвөн биетийг боловсруулж, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг; үйлдвэрийн ажилчдын гэр бүлийн гишүүд нь ч мөн асбестадад дам өртдөг. Түүнчлэн уурхай, бутлуур болон үйлдвэрийн ойр орчмын иргэд, олон нийт үйлдвэрийн хаягдлаас бохирддог; хүүхдүүд асбестаар бохирдсон сургуулийн талбай болон хаягдлын овоолго дээр тоглодог; утсархаг хөвөн биет болон бүтээгдэхүүнийг тээвэрлэх явцад зам, олон нийтийн газрыг бохирдуулдаг.¹³ Зохих хяналт тавигддаггүй тохиолдолд ААМ-ыг угсарч суурилуулдаг, засдаг, салгаж зайлуулдаг ажилчид ажил үүргээ гүйцэтгэх явцдаа асбестын дам нөлөөнд өртдөг. Асбесттай хог хаягдлыг зайлуулах ажлын аль ч үе шатанд зөвхөн тухайн хог хаягдалтай харьцаж буй ажилтан асбестын нөлөөнд өртөөд зогсохгүй бөгөөд хог хаягдлыг хангалттай бүтээгээгүй, хог хаягдал хийсэж хаягдах хяналтыг зохих ёсоор хийгээгүй тохиолдолд утсархаг хөвөн биет агаарт дэгдсэнээс орон нутгийн оршин суугчид ч өртдөг. Эцэст нь хог хаягдлаас ААМ-ыг ялгаж хаях, зайлуулах арга хэмжээ аваагүй эсвэл ААМ-ыг зохих ёсоор хаяж зайлуулаагүй бол хог ухах, тухайн хаясан материалыг дахин ашиглах гэх мэт явцад энэ цикл дахин давтагддаг.¹⁴

Асбестийн утсархаг хөвөн биетийн ашиглалт өсөн нэмэгдэж байна

Асбестийн нарийхан утсархаг хөвөн биетийн хэрэглээ 1990-ээд онд буурч байсан боловч дэлхий даяар эргээд өсөн нэмэгдэх болсон тухай нотолгоо бий. Сүүлийн үеийн судалгаагаар¹⁵ 2000-2004 оны хооронд 12 улс оронд асбестын ашиглалт /метр.тонн хэмжигдэхүүнээр/ 59%-иар өссөн байна.

3. АСБЕСТТАЙ ХАРЬЦАЖ АЖИЛЛАХ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ БА СТАНДАРТ

¹¹ http://whqlibdoc.who.int/hq/2000/a68673_guidelines_3.pdf

¹² http://whqlibdoc.who.int/hq/2000/a68673_tech_aspects_4.pdf

¹³ Jones, Robert “Living in the Shadow of the Asbestos Hills (The Need for Risk Based Cleanup Strategies for Environmental Asbestos Contamination in South Africa).” Environmental Exposure, Crisis Preparedness and Risk Communication, Global Asbestos Congress, Tokyo, Japan, November 19 - 21, 2004.

http://park3.wakwak.com/~gac2004/en/index_abstract_e.html. See also Oberta, AF “Case Study: An Asbestos Cement Plant in Israel -- Contamination, Clean-up and Dismantling.” Hellenic Asbestos Conference, Athens, Greece, October 29 - 31, 2002. http://www.ibas.btinternet.co.uk/Frames/f_lka_hellen_asb_conf_rep.htm

¹⁴ Boer, A.M., L.A. Daal, J.L.A. de Groot, J.G. Cuperus “The Combination of the Mechanical Separator and the Extraction Cleaner Can Process the Complete Asbestos-containing Waste-stream and Make it Suitable for Reuse.” European Conference on Asbestos Risks and Management, Rome, Italy, December 4 -6, 2006.

<http://venus.unive.it/fall/menu/Boer.pdf>

¹⁵ R. Virta, US Geological Survey, 2007.

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Олон улсын конвенц

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага нь (ОУХБ) аливаа улс орнуудад “ажил мэргэжлээс шалтгаалан асбесттай харьцсанаас ажилчдын эрүүл мэндэд аюул учрахаас урьдчилан сэргийлэх, хянах, хамгаалахад” чиглэсэн хууль, тогтоомжийг хөхүүлэн дэмжихийн тулд Асбестын Конвенцыг (C162) 1986 онд санаачилжээ.¹⁶ Энэхүү конвенцид: хамрах хүрээ ба тодорхойлолт, ерөнхий зарчим, хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ажлын орчин ба ажилчдын эрүүл мэндийн хяналтын талаар тэргүүн туршлагыг тоймлон дурдсан байдаг. 2008 оны 3-р сарын 4-ний байдлаар нийт 31 улс орон тус Конвенцид нэгдэн орсноос¹⁷ 17 нь асбестыг хориглосон байдаг.

ОУХБ-ын асбестын тухай конвенцын зарим шаардлагуудаас дурдвал:

- Ажил олгогчид ажлын хувцсаар хангах;
- Тоос хувцсаар дамжин айл гэрийг бохирдуулахаас урьдчилан сэргийлж гадуур хувцсаа солих өрөө, ажлын хувцсаа солих өрөө тусдаа байх, угаалгын өрөө, байгууламжтай байх;
- Ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд учруулж болох эрүүл мэндийн аюулын талаар ажилчдад сургалт явуулах;
- Ажилчдыг тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулах;
- Ажлын орчны агаарын хяналтыг тогтмол хийх, хяналтын мэдээллийг 30 жил хүртэл хугацаанд хадгалах;
- Ажилчдыг хамгаалж, хог хаягдлыг зохистой зайлуулж хаях шаардлагын улмаас буулгаж нураах
- ажлаас өмнө ажлын төлөвлөгөө боловсруулах; ба
- Эрүүл мэндэд ноцтой аюул учруулах эрсдэлийн үндэслэлээр ийм ажлаас өөрсдөө сайн дураараа гарсан ажилчдыг гадуурхах, “сахилгын арга хэмжээ” авахаас ажилчдыг хамгаалах.

Ихэнх төслийн хувьд ААМ-тай ажиллах, худалдаж авахтай холбоотой харгалзан үздэг стандарт бий. Баримт бичгийн Хавсралт 5-д заасан зарим стандартын тухай танилцуулгыг үзнэ үү.

Олон улсын стандарт ба улс орны дотоодын зохицуулалт

Асбест-агуулсан материалтай (ААМ) холбоотой ажлын талаарх стандарт ба зохицуулалтыг төрийн бус байгууллагууд, төрийн байгууллагууд хэвлэн нийтэлсэн байдаг. Баримт бичгийн Хавсралт 3-аас эдгээр байгууллагуудын тухай зарим эх сурвалжийн жагсаалт (ДЭМБ, Олон Улсын Стандарчлалын Байгууллага, ASTM), (Их Британи, АНУ, Канад, Өмнөд Африк гэх мэт) -ыг үзэж болно. Эдгээр эх сурвалжид гарын авлага болон тухайлсан стандарт гэх мэт олон төрлийн материалыг жагсаасан байдаг бөгөөд судалгаа, тодорхойлолт, хяналт шалгалт, засвар үйлчилгээ, шинэчлэн засах, сэлбэх,

¹⁶ www.ilo.org/ilolex

¹⁷ <http://www.ilo.org/ilolex/english/convdisp1.htm>

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

хаях, зайлуулах ажилтай холбоотой олон янзын ажлын удирдамж бий. Эдгээр стандарт, зохицуулалтад дурдагдсан зарим гол асуудлуудаас дор дурдвал:

- **Ажил мэргэжилтэй холбоотой үүсэх аюулын цар хүрээ.** Эрүүл мэндийн эрсдэл нь ААМ-ын шинж чанарын үйлчлэлээр л үүсдэг хялбар зүйл биш бөгөөд хийж буй ажлын төрөл болон хяналтаас мөн хамаарна. Хэдийгээр Асбест-Цементэн (А-Ц) бүтээгдэхүүнүүд нь галд тэсвэртэй бүтээгдэхүүнтэй харьцуулбал бодит эрсдэл багатай мэт санагдах боловч агаарын мониторингийн дүнгээс харахад жишээ нь А-Ц-н хуурай хавтанг цахилгаан хөрөөгөөр зүсэхэд агаарт дэгдэх хөвөн биетийн хэмжээ галд тэсвэртэй, нойтон, чийглэж дэвтээсэн дамнуур зүлгэснээс илүү хэмжээгээр агаарт дэгдэж байгааг тогтоожээ. Асбест-цементэн бүтээгдэхүүний мөн чанар болон тухайн ажлыг хэрхэн гүйцэтгэх, нарийхан хөвөн биет буюу хаягдал үйрмэг агаарт дэгдэхээс сэргийлэх хяналт зэргийн хоорондын уялдаа холбоо чухал. (ASTM байгууллагын E2394 ба HSG189/2-т хэлэлцсэн¹⁸).
- **Агаарт дэгдсэн маш нарийхан утсархаг хөвөн биетийн нөлөөллийг хянах.** Асбестын маш нарийхан утсархаг хөвөн биет, маш өчүүхэн тоосоор амьсгалах нь гол аюул учраас стандарт, зохицуулалтын үндсэн зорилго нь ажилчид болон бусад хүмүүс агаарт дэгдсэн асбестын утсархаг хөвөн биет, тоосоор амьсгалж болзошгүй концентрацыг хянахад оршино. Олон улс оронд ААМ-тай харьцахыг шаарддаг ажил үүрэг гүйцэтгэж буй ажилчдын хувьд ийм концентрацын хязгаарыг журмаар зохицуулж тогтоосон байдаг ч энэ нь асбестын улмаас үүсгэх өвчний эрсдэлийг зөвхөн бууруулахаас бус бүрэн арилгаж чадахгүй. Ажилчдаас гадна бусад хүмүүс жишээлбэл тухайн барилга байгууламжийн оршин суугчид, иргэд олон нийтийн хувьд тавигдах асбестын концентрацын хязгаар нь ажилчдынхаас бага байхаас гадна залуучууд болон өндөр настан, түүнчлэн бие махбодын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд өөр өөр байдаг.
- **Агаарт дэгдсэн маш нарийхан утсархаг хөвөн биетийн нөлөөллийг хэмжих.** Ажилчдын амьсгалдаг орчин эсвэл нөлөөлөлд өртсөн иргэдийн байрлаж буй орон зай дахь агаараас дээж авч дээжийг электрон эсвэл дурангийн микроскопоор харж шинжилдэг. Энэ тухай баримт бичгийн Хавсралт 3-т өгүүлсэн болно. Асбестын хэмжээг бууруулсны дараа тухайн байшин барилгыг дахин ашиглаж, хүн байрлаж болох эсэхийг асбестын хэмжээг бууруулах тухай протоколд заасан байдаг.
- **Хаягдлыг зохистой зайлуулах.** Асбест агуулсан материалыг (ААМ) зохистой цуглуулж зайлуулж хаях нь олон нийт болон орчныг хамгаалах төдийгүй хаяж зайлуулсан материалын хогийг ухах, дахин ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. ААМ-ын хог хаагдлыг тээвэрлэхдээ агаарыг бохирдуулж болзошгүй эрсдэлээс урьдчилан

¹⁸ Хавсралт 3-ыг эндээс харна уу
<https://siteresources.worldbank.org/EXTPOPS/Resources/AsbestosGuidanceNoteFinal.pdf>.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

сэргийлэхийн тулд гоожиж алдагдахааргүй саванд аюулгүйгээр тээвэрлэж зориулалтын хог хаях газарт булах ёстой. Асбестын утсархаг хөвөн биет боловсруулагдсан буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн уурхай, бутлуур, үйлдвэр гэх мэт талбайд нөхөн сэргээлт хийхдээ мөн ижил шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай. (Дараах веб хаягаар орж Хавсралт 3-аас EPA NESHAР-ын зохицуулалтыг үзнэ үү)

- **Хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэн зөөх.** Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенцийн дагуу хаягдал асбест нь (тоос ба хөвөн биет) аюултай хог хаягдалд тооцогддог. Базелийн Конвенци нь ийм хог хаягдлыг олон улсын хил дамжуулан тээвэрлэх, зайлуулах үйл явцын талаар урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Урьдчилан мэдэгдэлгүйгээр тээвэрлэлт хийх нь хууль бус. Аюултай хог хаягдлыг орчинд ээлтэй байдлаар хаяж, зайлуулах явдлыг талууд хянан баталгаажуулсан байх ёстой. (Орчинд ээлтэй. Хог хаягдал гарах тухайн үеэс эхлэн түүнийг хадгалах, тээвэрлэх, харьцах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, эцэст нь хаяж зайлуулах явцад хатуу хяналт тавьж ажиллах ёстой.)¹⁹
- **Асбест бүхий бүтээгдэхүүнийг олж тогтоох.** Асбест-цементэн бүтээгдэхүүнд хавтгай фанер хавтангууд, дээврийн ажилд ашигладаг долгионтой хавтангууд, ус хадгалах сав, даралтын болон ус, бохирын хоолойнууд хамаарна. Зарим улс оронд асбестыг ханын хавтан, үйлдвэрт ашиглах халуунд тэсвэртэй бээлий болон ажлын хувцас, тээврийн хэрэгсэлд ашигладаг тоормос ба консны (авцуулах холбоос) үрэлтийн элементүүд, жийргэвч үйлдвэрлэхэд ашигласаар байна.²⁰ Дулаан дамжуулахгүй, тусгаарлагч агуулсан асбест, дулаалгын буюу дуу чимээг бууруулах зориулалтаар ашигладаг асбестыг 1970-аад оноос эхлэн өргөн ашиглаж ирсэн бөгөөд үүнийг аливаа бойлер, дулаалгатай шугам хоолой бүхий төсөлд зайлшгүй анхаарах ёстой. 1980 оноос өмнөх үеийн дулаалгын материалыг шинжилж үзээд илрүүлээгүйгээс бусад бүх тохиолдолд асбест агуулсанд тооцож болно. Аж үйлдвэр хөгжсөн орнуудад асбест байгаа эсэхийг тогтоохын тулд дээжийг багцаар нь шинжлэх микроскопын аргыг өргөн ашиглаж ирсэн бөгөөд өндөр өртөг шаарддаггүй боловч энэ аргыг хөгжиж буй орнуудад төдий л өргөн ашигладаггүй. Хөгжиж буй орнуудын хувьд дээжийг сорилтод илгээх эсвэл тухайн орны лабораторийн ажилтнуудыг сургах гэсэн хоёр аргаар шийдэх боломжтой.
- **Сургалт.** Хяналт шалгалт, засвар үйлчилгээ, хаягдал зайлуулах эсвэл лабораторийн шинжилгээ хийх гэх мэт ААМ-тай харьцахыг шаардсан бүхий л нөхцөлд хэрхэн харьцахыг сургах нь нэн чухал ач холбогдолтой. Сургалтын хугацаа, агуулга нь тухайн хувь хүний хийж гүйцэтгэх ажлын төрлөөс шалтгаална. Лабораториуд болон аналит шинжээч бүрийн чанарын хяналт, ур чадварын сорил тест ч мөн чухал юм.

¹⁹ See Basel Convention Secretariat <http://www.basel.int/>

²⁰ In 2004, Russia, China, India, Kazakhstan, Thailand, and Ukraine together accounted for about three-quarters of world asbestos consumption. Other major consumers of asbestos are Iran, Brazil, Vietnam, and Indonesia.

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

4. АСБЕСТ-АГУУЛСАН МАТЕРИАЛЫГ ОРЛУУЛЖ БОЛОХ ХУВИЛБАР

Өсөн нэмэгдэж буй зах зээл

Асбест бүхий бүтээгдэхүүнийг орлуулж болох төрөл бүрийн аюулгүй бүтээгдэхүүнүүд элбэг болсоор байна (Хавсралт 4-ийг үзнэ үү). Үүнд ургамлын гаралтай утсархаг файбер болон синтетик файберын нэгдэл ашиглан файбер-цементэн бүтэцтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж болно. Мөн ийм зорилгоор ашиглаж болох өөр олон бүтээгдэхүүн бий.²¹ ДЭМБ нь орлуулан ашиглаж болох өөр хувилбаруудыг үнэлж тогтооход идэвхтэй оролцдог.²²

Өртөг ба гүйцэтгэлийн асуудлууд

Поливинилын спирт (PVA) эсвэл полипропиленыг целлюлозтой хольж хийх замаар файбер-цементэн дээврийн хавтан үйлдвэрлэх нь А-Ц-н хавтанг үйлдвэрлэх өртөг зардлаас 10-15% илүү өртөгтэй байна. Полипропилен-целлюлоз-цементэн дээврийн хавтанцар нь шинэ бүтээгдэхүүн бөгөөд А-Ц-н дээврийн хавтанцартай харьцуулахад үйлдвэрлэлийн өртөг нь 12 орчим хувиар илүү байгаа нь түүнийг ашиглахаас татгалзахад гол нөлөө үзүүлж байна. Асбестгүй файбер-цементэн хавтангууд нь А-Ц-н хавтангуудтай харьцуулбал арай хөнгөн, амархан хугарах нь бага, олдоц сайтай. Эдгээр бүтээгдэхүүнийг ашигласнаар барилгын нийт өртөг зардал нэмэгддэг ч энэ нь угсралт суурилуулалт/засвар үйлчилгээ/шинэчлэн засварлах ажилд зарим тохиолдолд эрүүл ахуйн тусгай арга хэмжээ авах шаардлагагүй болох, барилгын ажилчид, тухайн барилга байгууламжид оршин суугчдад учруулах аюул ослыг бууруулах, хог хаягдлыг тээвэрлэн зайлуулахтай холбоотой гарах зардлыг бууруулах гэх мэт зардалтай бараг дүйцэхүйц байна. Бичил цементэн плита, хавтанцар үйлдвэрлэх нь А-Ц-ын үйлдвэрлэлтэй харьцуулахад хямд бөгөөд тэдгээрийг барилгын талбайн ойролцоо байрлах цехэд үйлдвэрлэх боломжтой, дотоодын жижиг үйлдвэр, нийлүүлэгчдээс нэмэлт тээврийн зардал гаргалгүйгээр нийлүүлэх боломжтой. А-Ц-н хоолойтой харьцуулбал төмөр хоолойг төвөггүй тээвэрлэж, хугалж гэмтээлгүй суурилуулах боломжтой ба төмөр хоолой нь компрессын ачаалал сайтай, ашиглалт удаантай.

5. АСБЕСТЫН ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД ДЭЛХИЙН БАНК ГРУППИЙН ХАНДАХ ЧИГ ХАНДЛАГА

ДБГ-ийн Орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй Байдлын (ОЭМАБ) Удирдамж, шаардлага нь Олон Улсын Үйлдвэрийн Сайн Туршлагын (ОУУСТ) тухай ерөнхий болон тухайн салбарт хамааралтай тусгай шаардлагуудын жишээ бүхий техникийн

²¹ 7. 7. Их Британийн Эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэх байгууллага нь асбестын орлуулагч үндсэн материал файбер-цементийн бүтээгдэхүүн, тоормосны хризотил асбестоос хамаагүй бага аюултай гэсэн дүгнэлтийг гаргажээ. See Harrison PTC, *et al.* "Comparative Hazards of Chrysotile Asbestos and Its Substitutes: A European Perspective." *Envir. Health Persp.* 107: 607-611 (1999).

<http://www.ehponline.org/members/1999/107p607-611harrison/harrison-full.html>

²² <http://www.who.int/ipcs/assessment/asbestos/en/>

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

лавлах баримт бичиг юм.²³ Хэрвээ төсөлд ДБГ-ийн нэг эсвэл түүнээс дээш тооны гишүүд оролцож байгаа бол холбогдох бодлого, стандартын дагуу ОЭМАБ-ын удирдамж, шаардлагыг хэрэгжүүлэх ёстой байдаг.

ДБГ-ийн ОЭМАБ-ын Удирдамж, шаардлага нь²⁴ шинэ барилга байгууламж барих эсвэл барилгыг шинэчлэн засах, загварыг өөрчлөн шинэчлэх үйл ажиллагаанд шинэ материал ашиглахдаа ААМ ашиглахаас зайлсхийхийг тусгайлан заасан байдаг. Нэгэнт баригдсан байгаа ААМ бүхий барилга байгууламжийн хувьд асбестын удирдлагын төлөвлөгөөг боловсруулж ашиглах ёстой бөгөөд үүнд ААМ бүхий байршлыг тогтоож, түүний нөхцөл байдал (жишээ нь ААМ нь шахмал хэлбэртэй байгаа эсэх эсвэл утсархаг хөвөн биет агаарт дэгдэх магадлалтай байгаа эсэх гэх мэт), нөхцөл байдлыг хянаж мониторинг хийх журам, ААМ бүхий байршлыг гэмтээж нураахаас сэргийлж тухайн байршил уруу нэвтрэх журам, ААМ-тай тулгарч болзошгүй ажилчдыг ААМ агуулсан материалыг гэмтээж, асбестаг өртөхөөс сэргийлэх сургалтад хамруулах гэх мэт асуудлыг тодорхой тусгана. Ийм төлөвлөгөөг үйл ажиллагааны болон засварын бүхий л ажилд оролцож буй бүх хүмүүст танилцуулах нь зүйтэй. Байшин барилгад байгаа ААМ-ыг засах эсвэл зайлуулж хаях эсвэл зөөж гаргах ажлыг тухайн орны дүрэм журмын шаардлагын дагуу эсвэл ийм шаардлага байхгүй бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн журмын дагуу²⁵ зөвхөн тусгай сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн ажилчид гүйцэтгэнэ.²⁶ Асбест бүхий дулаалгын материал, барилга, байгууламжийн тодорхой бүрэлдэхүүн элементийг буулгах эсвэл нураахаас өмнө энэ ажлыг гүйцэтгэх ажилтнуудыг тусгайлан сургаж асбестын эрсдэлийн нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ёстой.²⁷

ХАВСРАЛТ 1. АСБЕСТ АШИГЛАХЫГ ХОРИГЛОСОН УЛС ОРНУУД

- 1. Аргентин**
- 2. Австрали**
- 3. Австри**
- 4. Бельги**
- 5. Болгар**
- 6. Чили**
- 7. Кипр**
- 8. Чех**
- 9. Дани**

²³ Defined as the exercise of professional skill, diligence, prudence, and foresight that would be reasonably expected from skilled and experienced professionals engaged in the same type of undertaking under the same or similar circumstances globally. The circumstances that skilled and experienced professionals may find when evaluating the range of pollution prevention and control techniques available to a project may include, but are not limited to, varying levels of environmental degradation and environmental assimilative capacity as well as varying levels of financial and technical feasibility

²⁴ [http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_GeneralEHS/\\$FILE/Final+-+General+EHS+Guidelines.pdf](http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_GeneralEHS/$FILE/Final+-+General+EHS+Guidelines.pdf) (pp. 71, 91, 94)

²⁵ Training of specialized personnel and the maintenance and removal methods applied should be equivalent to those required under applicable regulations in the United States and Europe (examples of North American training standards are available at: <http://www.osha.gov/SLTC/asbestos/training.html>)

²⁶ Examples include the ASTM International E1368 - Standard Practice for Visual Inspection of Asbestos Abatement Projects; E2356 - Standard Practice for Comprehensive Building Asbestos Surveys; and E2394 - Standard Practice for Maintenance, Renovation and Repair of Installed Asbestos Cement Products.

²⁷ [http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_GeneralEHS/\\$FILE/Final+-+General+EHS+Guidelines.pdf](http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_GeneralEHS/$FILE/Final+-+General+EHS+Guidelines.pdf) (pp. 71, 91, 94)

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

10. Египет
11. Эстони
12. Финлянд
13. Франц
14. Габон
15. Герман
16. Грек
17. Хондурас
18. Унгар
19. Исланд
20. Ирланд
21. Итали
22. Япон
23. Иордан
24. Кувейт
25. Латви
26. Литва
27. Люксембург
28. Мальта
29. Нидерланд
30. Норвег
31. Польш
32. Португал
33. БНСУ
34. Румын
35. Саудын Араб
36. Сейшелийн арлууд
37. Словак
38. Словени
39. Өмнөд Африк
40. Испани
41. Швед
42. Швейцар
43. Нэгдсэн Вант Улс
44. Уругвай

ХАВСРАЛТ 2. ДЭЛХИЙН БАНК ГРУППИЙН АСБЕСТЫН ТАЛААР ИШ ТАТСАН
МАТЕРИАЛ

| <i>Бодлогын удирдамж</i> | <i>Иш татсан материал</i> |
|--|---|
| <p>ААМ-ыг шинэ барилга байгууламж барих, эсвэл шинэчлэн засварлахдаа ашиглахаас зайлсхийх</p> <ul style="list-style-type: none">• Одоо байгаа барилгуудад: ААМ-ын судалгаа, менежментийн төлөвлөгөө шаардлагатай.• ААМ-ыг зайлуулж устгах ажлыг тусгайлан бэлтгэгдсэн хүмүүс зөвхөн хүлээн авагч орны шаардлагын дагуу, эсвэл байхгүй | <p>Удирдамж: Байгаль орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын ерөнхий удирдамж 2007 оны 4 - р сар, х 34 ба 71.</p> |

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|--|--|
| тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн журмын дагуу хийж гүйцэтгэнэ. | |
| Төслийн шаардлагын зарим жишээ: <ul style="list-style-type: none">Асуудлын цар хүрээг тодорхойлох эрсдэлийн үнэлгээ; асбестын хор нөлөөг бууруулах судалгаа; менежментийн төлөвлөгөө; мэргэжлийн хүнээр асбестыг устгаж зайлуулах; ААМ-ыг хориглох; асбесттай харьцах, холдуулах, тээвэрлэх, устгах журам. | <ul style="list-style-type: none">Украин -Чанартай боловсролд тэгш хамрагдах (төслийн ID P077738)КН- Эрүүл мэндийн салбарын дэмжлэг (Төслийн ID: P070542)ID- Эрүүл мэндийн салбарын ажиллах хүч ба үйлчилгээ (Төсөл. ID: P073772)Чанчун, Хятад -ТВК Shili Auto Parts Co., (IFC, 2005) |

ХАВСРАЛТ 3. АСБЕСТЫН СТАНДАРТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ЖАГСААЛТ

ТАЙЛБАР: Энэхүү жагсаалт нь бүх мэдээллийг багтаагаагүй бөгөөд боломжит мэдээллийн түүвэр болно.

| ОЛОН УЛСЫН СТАНДАРТ |
|---|
| ДЭМБ -ын бодлого, удирдамж (www.who.org) <ul style="list-style-type: none">www.searo.who.int/LinkFiles/Publications and Documents prevention guidelines.pdf (хуудас 70)www.searo.who.int/en/Section23/Section1108/Section1835/Section1864_8658.htm |
| Олон улсын стандартчиллын байгууллага (ОУСБ) (www.iso.org) <ul style="list-style-type: none">ISO 10312 (1995): Гадаад орчны агаар - Асбестын ширхгийг тодорхойлох - Шууд дамжуулах электрон микроскопын арга. [ASTM D6281-тэй төстэй арга]ISO 13794 (1999): Гадаад орчны агаар -Асбестын ширхгийг тодорхойлох-Шууд бусаар дамжуулах электрон микроскопын арга.ISO/FDIS 16000-7: Тасалгааны агаар-Хэсэг 7: Агаар дахь асбестын ширхгийн концентрацыг тодорхойлох дээж авах арга.ISO 8672: Агаарын чанар - Фазын тодосгогч оптик микроскопоор агаарт агуулагдах органик бус асбестын ширхгийн концентрацыг тодорхойлох - Мембран шүүлтүүрийн арга (1993) [AIA RTM1 -тэй төстэй арга] |
| Аюултай хог хаягдлын хил дамнасан тээвэрлэлтийг хянах, устгах тухай Базелын конвенц <ul style="list-style-type: none">Базелын конвенцын нарийн бичгийн дарга нарын газар (www.basel.int) |
| Олон улсын хөдөлмөрийн байгууллага (www.ilo.org) <ul style="list-style-type: none">Химийн аюулгүй байдлын карт, ICSC 0014: www.ilo.org/public/english/protection/safework/cis/products/icsc/dtasht/_icsc00/icsc0014.htm |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Европын Холбоо

(europa.eu.int/smartapi/cgi/sga_doc?smartapi!celexapi!prod!CELEXnumdoc&lg=EN&numdoc=32003L0018&model=guichett)

- 2003/18/ЕС-ны удирдамж Ажилчдыг асбестын хортой нөлөөнөөс үүдсэн аливаа эрсдэлээс хамгаалах тухай 83/477/ЕЕС-ийн удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулсан. (2003 оны 3 -р сар). Ажилчдыг хамгаалах, сургах, эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг зохицуулалтыг хангаж өгдөг; асбест агуулсан материалын үзлэг; асбестын ажлын талаарх мэдэгдэл; агаараас дээж авах; Фазын тодосгогч микроскопоор хэмжсэн өртөлтийн хязгаар 1 см³ тутамд 0.1 файбер (8 цагийн ЦЖД).

УЛС ОРНЫ ДОТООДЫН СТАНДАРТ

ASTM International (www.astm.org)

- Асбестын хяналтын гарын авлага: Судалгаа, асбестыг зайлуулах болон асбестын менежмент - Хоёр дахь хэвлэл (2005 оны 3 -р сар). Зохиогч: Эндрю Ф. Оберта, MPH, CIH. Асбестын менежментийн хөтөлбөрийг дэмжихийн тулд E2356, E2394, E1368 стандартуудыг хэрхэн ашиглах талаар нарийвчлан хэлэлцсэн.
- Барилгын асбестын судалгааг хийх E2356 стандарт . 2004 оны 7 -р сар. Асбестыг зайлуулах болон ашиглах шийдвэр хоорондыг эрэмбэлэх үнэлгээний протоколыг хамарсан ААМ-ын менежментийн талаарх суурь судалгааг багтаасан. ASTM E2356 стандарт нь суурь судалгаанд байгаа ААМ-ын урт хугацааны менежмент, түүнийг зайлуулах төслийн техникийн нөхцөл болон төлөвлөгөөг бэлтгэх мэдээллийг агуулсан. Энэ стандартад түгээмэл байдаг сэжигтэй ААМ-аас өргөн хэмжээний дээжийг авахад шаардлагатай нарийвчилсан журам, тоног төхөөрөмж (ихэвчлэн ердийн тоног төхөөрөмжийн зүйлс)-ийг агуулдаг. Бүх бутардаг болон бутардаггүй материалын өнөөгийн нөхцөл байдал, эвдрэлийн боломжит байдлын тоон үнэлгээ нь ААМ-ыг зайлуулах дарааллыг хүснэгтэлж, тодорхой харуулах боломжийг олгодог. Тоон үнэлгээний үндсэн дээр зайлуулах төсвийн тооцоог гаргаж болно.
- Асбест цементийн бүтээгдэхүүнийг ашигласан засвар үйлчилгээ, заслын ажлын E2394 стандарт практик (2004 оны 10 -р сар). Материал, аюултай үйл ажиллагаа, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дэд бүтцийн шаардлагыг нарийвчилсан үйл явцын хамт хавсралтад тайлбарласан болно. Асбест-цементийн бүтээгдэхүүнийг шинэ барилга, засварын ажилд суурилуулах санааг агуулаагүй болно.
- Асбестыг бууруулах нүдэн баримжаагаар харж, шалгалт хийх E1368 стандарт практик (2005 оны 5 -р сар). Энэ стандарт нь эцсийн шалгалтад тэнцэх болон агаараас дээж авах боломжийг сайжруулах зорилгоор асбестыг зайлуулах төслийг удирдах арга барилаар хангаж өгдөг. Бэлтгэх, зайлуулах, шалгах журам, шалгуурын талаар тайлбарласан.
- Барилгын хязгаарлагдмал далд асбестын тухай E2308 стандартын гарын авлага (2005). Үл хөдлөх хөрөнгийн арилжааг хөнгөвчлөхөд шаардлагатай хамгийн бага мэдээллээр хангадаг.
- Гадаад орчны болон тасалгааны агаар мандлыг дамжуулагч электрон микроскопоор шууд дамжуулах замаар тодорхойлж агаарт дэгдсэн

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

асбестын агууламжийг шалгах D6281 Стандарт. Агаарын дээжийн шүүлтүүрт байгаа асбест агуулаагүй утаснаас асбестыг ялгах, фазын тодосгогч микроскопоос арай жижиг, нимгэн утаснуудыг тодорхойлох, тоолох арга.

- D7201: Ажлын байранд Фазын тодосгогч микроскопоор асбестын хөвөн утсыг оролцуулан агаарт дэгдсэн хөвөн утаснуудаас дээж авах, тоолох дадлага хийх стандарт
- NIOSH 7400 ба 7402 -ийн аргачлалыг хослуулсан.

Австрали

(www.ascc.gov.au/ascc/AboutUs/Publications/NationalStandards/ListofNationalCodesofPractice.htm)

- Асбестыг аюулгүй зайлуулах, 2 -р хэвлэл [NOHSC: 2002 (2005)]
- Ажлын байран дахь асбестыг хянах болон удирдах талаар дадлага хийх дүрэм [NOHSC: 2018 (2005)]

Их Британийн Эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэх байгууллага

(<http://www.hse.gov.uk/asbestos/index.htm>)

- Асбестын журам (<http://www.opsi.gov.uk/si/si2006/20062739.htm>)
- Асбестын үндэс (<http://www.hse.gov.uk/asbestos/essentials/index.htm>). Удирдлагын даалгавар, арга барил, тоног төхөөрөмжийн хэсгүүдийг багтаасан болно.
- Нийтлэлд дараах зүйлсийг багтаасан:
- Барилга байгууламжид асбесттай ажиллах INDG289 08/01 C600. Асбестын аюул ба урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тойм (16 хуудас)
- MDHS 100 Асбест агуулсан материалын судалгаа, дээж авах, үнэлэх (2001). Энэ стандартад асбест агуулсан бүтээгдэхүүний олон жишээнүүдийг дурдсан бөгөөд дээж авах, задлан шинжлэх аргуудыг багтаасан. MDHS100 нь бүтээгдэхүүний төрөл, эвдрэлийн хэмжээ, гадаргуугийн боловсруулалт, асбестын ширхэг, төрөл зэргийг үндэслэн тоон алгоритм ашиглан ААМ-ын судалгаа, үнэлгээг зохион байгуулж, бөөнөөр нь түүвэрлэх техник, тоног төхөөрөмжийн талаар хэлэлцдэг бөгөөд олон тооны гэрэл зургуудыг мөн багтаасан байдаг.
- HSG189/2 Асбестын цементтэй ажиллах стандарт (1999). Хяналттай болон хяналтгүй хийгдэж буй үйл ажиллагааны асбестын хөвөн утасны концентрацийг оруулаад Асбест-цементийн бүтээгдэхүүн, тэдгээрийг засах, зайлуулах аргыг тайлбарласан.
- Ажлын байран дах дүрэм журмаар асбестыг хянах (2002). Асбестт өртөж буй хүмүүсийг хамгаалах шаардлага, түүний дотор дотоодын бус байр, байшинг засварлах ажил гүйцэтгэдэг иргэдийг хамгаадах шаардлагыг багтааж, ажлын байранд дах асбестаас үүсэх эрсдэлийг олж тогтоох, удирдах талаар дурдсан.

Барилгын шинжлэх ухааны үндэсний хүрээлэн

(<http://www.nibs.org/pubsasb.html>)

- Удирдамжийн гарын авлага: Асбест ажлын практик, 2 дах хэвлэл (1996). Асбест-цементийн бүтээгдэхүүн, түүний дотор бутардаг, бутардаггүй ААМ-ын жижиг хэмжээний засвар, заслын ажлыг хэрхэн хийх үйл явцын талаар дурдсан.
- Барилга салбар дахь асбестын бууралт ба менежмент: Загвар гарын авлагын тодорхойлолт. Гурав дахь хэвлэл (1996). Төслийн зураг төсөл,

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| |
|---|
| <p>тандалтын талаарх мэдээлэл болон АНУ -ын холбогдох дүрэм журам, түүнчлэн бууруулах чиглэлээр гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг тодорхойлолт хэлбэрээр агуулсан болно.</p> |
| <p>Австрийн стандартын институт (http://www.on-norm.at/index_e.html)</p> <ul style="list-style-type: none">• ONORM M 9406, Сул бэхлэгдсэн асбест агуулсан бүтээгдэхүүнтэй харьцах, 01 08 2001. Асбест агуулсан сэвсгэр материалаас хөвөн утас ялгарах нөхцөл, боломжит байдлыг үнэлэх протокол, алгоритмыг агуулсан болно. |
| <p>Олон улсын хризотилийн холбоо (www.chrysotile.com). [Энэ байгууллага нь асбестын үйлдвэрлэл болон бизнесийг төлөөлдөг болохыг анхаарна уу]</p> <ul style="list-style-type: none">• Санал болгож буй техникийн 1-р арга (RTM1), Ажлын байран дахь агаарт дэгдсэн асбестын хөвөн утасны агууламжийг гэрлийн микроскопоор тодорхойлох лавлах арга (Мембран шүүлтүүрийн арга). Фазын тодосгогч микроскопыг ашиглан Асбестыг бусад хөвөн утаснаас ялгадаггүй агаараас дээж авдаг шүүлтүүр дээрх хөвөн утсын тоолох• Санал болгож буй техникийн 2 -р арга (RTM2) Электрон микроскопоор сканнердах замаар агаарт байгаа асбестын утас ба бусад органик бус утсыг тодорхойлох арга. Фазын тодосгогч микроскопоос жижиг хэмжээний хөвөн утсыг тодорхойлж, төрлийг ялгадаг арга. |
| <p>АНУ -ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хүрээлэн (www.cdc.gov/niosh/topics/asbestos)</p> <ul style="list-style-type: none">• Асбестын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар (www.cdc.gov/niosh/pdfs/0041.pdf)• Хөдөлмөрийн өртөлтөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж (www.cdc.gov/niosh/topics/asbestos/#prevention)• 7400-р арга, асбест ба бусад утаснууд PCM (1994). 5мм -ээс их урттай бүх утаснуудыг 3:1 харьцаатай тоолох AIA RTM1 -тэй төстэй фазын тодосгогч микроскопын арга.• TEM -ийн 7402 асбестын арга (1994). 5мм -ээс их урттай, 0.25мм -ээс их диаметртай асбестын утаснуудыг 3: 1 харьцаатай тодорхойлж тоолох дамжуулагч электрон микроскопыг ашиглах арга. |
| <p>АНУ -ын Байгаль орчныг хамгаалах агентлаг (www.epa.gov/asbestos)</p> <ul style="list-style-type: none">• Барилга, сургууль, автомашины үйлдвэрлэлийн салбар дахь асбест агуулсан материалыг удирдах арга хэрэгслийг багтаасан. Хяналт шалгалт хийх, их хэмжээний дээжид дүн шинжилгээ хийх, бутардаг АСВМ -ийг үнэлэх, хариу арга хэмжээ авах (зайлуулах, битүүмжлэх, хаах), үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, агаараас дээж авах журмыг багтаасан болно.• Агаарын аюултай бохирдуулагч бодисын ялгаруулалтын үндэсний стандарт: М хэсэг - Асбест. 40 CFR 61 -р хэсэг. (1990). Уг стандартад дараах зүйлс орно: бутардаг болон бутардаггүй асбест агуулсан материалын тодорхойлолт; ААМ агуулсан барилга байгууламжийг сэргээн засварлах, буулгах тухай мэдэгдэх шаардлага; нүдэнд харагдах утаанаас урьдчилан сэргийлэх ажлын практик; ААМ болон хаягдал материалыг зөвшөөрөгд хогийн цэгт хаях; болон хогийн цэгийг ажиллуулах, хаах.• 20Т-2003 Асбестыг газар дээр нь удирдах: Барилга эзэмшигчид зориулсан асбест агуулсан материалын ашиглалт, засвар үйлчилгээний хөтөлбөр "Ногоон ном" (1990) |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

- Удирдамжийн баримт бичиг: ХАБ -ын ажилчдыг сургах үйл ажиллагаа, засвар үйлчилгээний хөтөлбөрийг зохион байгуулах; засварын ажлын төрлийг таних; засварын ажлын дадлага, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар энэхүү бичиг баримтад дурдсан.
- EPA-600/R-93/116 Их хэмжээний барилгын материалын асбестыг тодорхойлох арга (1993) Поларизаци гэрлийн микроскопи, гравиметр, рентген дифракци ба дамжуулагч электрон микроскопын аргаар их хэмжээний барилгын материал дахь асбестын ширхэгийг тодорхойлох, тоолох арга. ААМ-ыг тодорхойлох ажлыг ихэвчлэн гэрлийн микроскоп ашиглан их хэмжээгээр авсан дээжийн шинжилгээгээр хийдэг. Тодорхойлсон аналитик журам, шинжилгээ хийх тоног төхөөрөмж нь академик болон арилжааны геологийн лабораторид байдагтай төстэй боловч бөөнөөр нь барилгын материалд байгаа асбестын ширхэгийг тодорхойлох, тоон үзүүлэлтээр хангах тусгай сургалт, чанарын хяналт, ур чадварын шалгалтын хөтөлбөр шаардлагатай.
- Туйлширсан гэрлийн микроскопи, гравиметр, рентген дифракци ба дамжуулах электрон микроскопын аргаар их хэмжээний барилгын материал дахь асбест ширхэгийг тодорхойлох, тоо хэмжээг тоолох.

АНУ -ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн газар (Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс)

(www.osha.gov/SLTC/asbestos/)(www.osha.gov/SLTC/asbestos/standards.html)

- Асбестын хөдөлмөрийн өртөлт (Барилгын үйлдвэрлэлийн стандарт) 29CFR1926.1101. (1994). Зохицуулалт: асбестод өртөж болох зөвшөөрөгдөх хэмжээ нь бүтэн ажлын цагийн турш 0.1 шг/см³ (дунджаар 8 цаг) ба богино хугацааны өртөлт буюу 30 минутын турш 1.0 шг/см³ байна; ажилтнуудын PELs -г дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих; бутардаг болон бутардаггүй ААМ-тай ажиллах дадлага ажил; амьсгалын замын хамгаалалт; ажилчдын халдваргүйжүүлэх, эрүүл ахуйн байгууламж; ажилчид болон ажил олгогчдын мэдэгдэл; эрүүл мэндийн үзлэг; албан хэрэг хөтлөлт болон сургалт.
- OSHA Аргын ID 160 агаарт байгаа асбест (1994). NIOSH 7400 -тай төстэй фазын тодосгогч микроскопын арга

Онтарио мужийн Хөдөлмөрийн яам (Канад)

(www.elaws.gov.on.ca/DBLaws/Source/Regs/English/2005/R05278_e.htm)

- Онтарио мужийн зохицуулалт 278/05 Зориулагдсан бодис - барилгын ажлын төсөл, барилга, засварын ажил дахь асбест (2005). Дүрэм: амьсгалын замын хамгаалалт, ажлын журам; асбестыг шалгах үзлэг; бутардаг болон бутардаггүй асбестын менежмент; урьдчилан бичсэн мэдэгдэл; асбестыг их хэмжээгээр түүвэрлэж дүн шинжилгээ хийх; бээлийний уутны шаардлага, журам; даралт багатай агаарын өрөө; ба цэвэр агаарын тестийн шаардлага (фазын тодосгогч микроскопоор 0.01 Нэг куб метр тутамд байх фибер).

Аюулгүй ажиллагаа Англи, Колумб (Канад)

(www2.worksafefbc.com/publications/OHSRegulation/Part6.asp)

- 6 -р хэсэг Бодисын тусгай шаардлага: Асбест. Дүрэм: асбест агуулсан материалыг тодорхойлох; асбестын бус материалаар орлуулах; ажилчдын сургалт; өртөлтийн хяналт; ажлын талбайн агааржуулалт; ажлын дадлага; халдваргүйжүүлэх; амьсгалын аппарат, хамгаалалтын хувцас.

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

**Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Хөдөлмөр эрхлэлтийн газар
(www.acts.co.za/ohs/index.htm - хайлтын талбарт 'асбест' гэж бичнэ үү)**

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын тухай хууль, 1993; Асбестын журам, 2001. Хамрах хүрээ: Мэдэгдэл; өртөлтийн үнэлгээ ба хяналт; Мэргэжлийн өртөлтийн хязгаар фазын тодосгогч микроскопоор хэмжсэн хэмжээ 0.2 шг/см³ - 4 цаг ЦЖД; сургалт; агаарын хяналт; эмнэлгийн үзлэг; ажлын бус өртөлт; амьсгалын аппарат, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж; асбест агуулсан барилгын материал, үүнд асбест цементэн хавтан ба холбогдох бусад бүтээгдэхүүн; асбест устгал.

ХАВСРАЛТ 4. АСБЕСТ АГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ОРЛУУЛАХ БОЛОМЖ

| Асбест агуулсан бүтээгдэхүүн | Орлуулж болох бүтээгдэхүүн |
|---|--|
| Асбест-цементийн долгионтой дээвэр | Синтетик утас (поливинил спирт, полипропилен) ба хүнсний ногоо/целлюлозын утас (зөөлөн модны крафт целлюлоз, хулс, sisal, coir, нишингийн хальс, тамхины иш гэх мэт) ашиглан fiber цементэн дээврийг хийх; нэмэлтээр цахиурын утаа, үнс эсвэл будааны хальсны үнстэй хамт. Бичил бетон (Parry) хавтан; цайрдсан металл хавтангууд; шавар хавтан; асфальт дахь ургамлын утас; шифер; бүрсэн металл хавтан (Harveytile); хөнгөн цагаан дээврийн хавтан (Dekra хавтан); шахагдсан uPVC дээврийн хавтан; дахин боловсруулсан полипропилен ба өндөр нягтралтай полиэтилен, буталсан чулуу (Worldroof); хуванцар бүрсэн хөнгөн цагаан; хуванцар бүрж цайрдсан ган. |
| Асбест-цемент хавтгай хавтан (тааз, фасад, хаалт) | Хүнсний ногоо/целлюлоз утас (дээрээс үзнэ үү), хаягдал цаас, нэмэлтээр синтетик утас ашигласан fiber цемент; таазны гипсэн хавтан (BHP гипс); полистирол тааз, карниз, хаалт; полистирол бүтцийн хананд фасадны хэрэглээ (гипсээр бүрсэн); хөнгөн цагаан бүрээс (Alucabond); тоосго; гипсэн хавтан эсвэл кальцийн силикат хавтан бүхий цайрдсан хүрээ; гипсэн хавтан эсвэл кальцийн силикат хавтантай зөөлөн модон хүрээ. |
| Асбест-цемент хоолой | Өндөр даралт: Цутгамал төмөр ба уян төмөр хоолой; өндөр нягтралтай полиэтилен хоолой; поливинил хлоридын хоолой; ган төмөр бетон хоолой (том хэмжээтэй); шилэн арматуртай полиэфир хоолой. Бага даралт: Целлюлоз-цемент хоолой; целлюлоз/PVA fiber цемент хоолой; шавар хоолой; шилэн арматуртай полиэфир хоолой; ган төмөр бетон хоолой (том диаметртэй ус зайлуулах хоолой). |
| Асбест-цемент ус хадгалах сав | Целлюлоз-цемент; полиэтилен; fiber шил; ган; цайрдсан төмөр; PVA-целлюлозын fiber-цемент |
| Асбест-цементийн | Цайрдсан төмөр; хөнгөн цагаан; гараар цутгасан целлюлоз-цемент; |

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|--|--|
| борооны ус зайлуулах суваг; нээлттэй ус зайлуулах хоолой (уул уурхайн салбарт) | |
|--|--|

**ХАВСРАЛТ 5. АСБЕСТ АГУУЛСАН МАТЕРИАЛТАЙ АЖИЛЛАХ ҮЕД АНХААРАХ
ЗҮЙЛС**

А. Орлуулж болох хувилбаруудын үнэлгээ

1. Төслийн үйл ажиллагаанд дараах зүйлийг суурилуулах, солих, засварлах, буулгах ажил багтсан эсэхийг тодорхойл:

- Дээвэр, салаа, суваг эсвэл хананы хавтан
- Хоолой, бойлер, сувгийн дулаан тусгаарлалт
- Гипс эсвэл галд тэсвэртэй байх зүйлс
- Уян хатан шалны материал
- Асбест агуулсан байж болзошгүй бусад материал

1. Хэрэв асбест агуулсан материалыг ашиглан шинээр барилга байгууламж барих, засварлахаар төлөвлөж байгаа бол асбестыг орлуулж болох бусад материал, тэдгээрийн олдоц бэлэн байдлын талаар мэдээлэл өгнө үү. Шинээр барих барилгын хувьд ААМ-ыг өөр материалаар орлуулахдаа (импортын түүхий эд материалын хэрэгцээг харгалзан үзэх) төслийн хүрээнд анхны зардал болон ашиглалтын зардал, ажил эрхлэлт, чанар, хүлээгдэж буй үйлчилгээний хугацаа болон бусад хүчин зүйлсийн талаарх ялгаануудыг тодорхойлж гаргах хэрэгтэй.
2. Ихэнх тохиолдолд ААМ нь эвдэрч болзошгүй дэд бүтцийн нэг хэсэг гэж тооцогддог. Хэрэв одоо байгаа материалын дээжийг асбест агуулсан эсэхийг шинжлэх шаардлагатай бол үүнийг хэрхэн, хаана шинжлүүлэх талаар мэдээлэл өгнө үү.
3. Одоо баригдсан байгаа байгууллагад ААМ байгааг таамаглаж, баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу барилгын ажлын тендерт дараах шаардлагыг тусгана.

В. Зохицуулалтын хүрээг ойлгох

1. Асбест байгаа газарт барилгын ажил, хог хаягдлыг зайлуулах явцад ажилчин болон асбестын хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлыг хянах талаар хүлээн авагч орны хууль тогтоомж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ (жишээлбэл, ОУХБ, Базелийн конвенц) хянаж үзнэ үү. ААМ - тай харьцах, зайлуулах ажлыг хийж гүйцэтгэх гэрээт гүйцэтгэгч болон ажилчдын ур чадварыг хэрхэн тогтоож, хэмжиж, мөрдүүлж байгааг тодорхойлох хэрэгтэй.
2. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас тусгай лиценз, зөвшөөрөл авах шаардлагатай эсэхийг тодорхойлох.

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

3. Зайлуулж салгасан ААМ-ын бохирдол, хог хаягдлыг дахин ашиглах боломжийг багасгахын тулд ААМ -ыг хэрхэн яаж устгахыг хянаж үзэх хэрэгтэй.
4. ААМ -ыг зайлуулах, засварлах, устгахтай холбоотой тендерт дараах шаардлагыг тусгана.

С. Асбесттай холбоотой ажил хийх үед анхаарах үйл ажиллагааны шаардлага

1. Гүйцэтгэгч талын мэргэшсэн байдал

- Ажилчид болог хянагчдыг сургах, төлөвлөсөн ажлуудын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, хангамжийг эзэмшсэн байх, энэ талаар өмнөх ажил олгогчийн тодорхойлолттой байх зэрэг асбесттай холбоотой олон улсын сайн туршлагын стандартыг дагаж мөрдөх туршлага, чадвартай болохоо харуулахыг гэрээлэгчдээс шаардах.

2. Ажлын техникийн шаардлагуудтай холбоотой асуудлууд

- ААМ-ыг зайлуулах, засварлах, устгах ажлыг ажилчид болон олон нийтийн асбестын хор хөнөөлийг багасгах байдлаар хийх ёстой бөгөөд үүнийг хийхээс өмнө инженерээс зөвшөөрсөн тохиолдолд төлөвлөгөө боловсруулж, ирүүлэхийг гүйцэтгэгч талаас шаардах.
- Тухайн газар, төсөлд зориулан бэлтгэсэн төлөвлөгөө, техникийн тодорхойлолтод дараах зүйлийг багтаасан боловч үүгээр хязгаарлагдахгүй.
 - ААМ-ыг салгаж байрлуулах газарт агаарын даралт багатай байхаар хашлага хийсэн байна.
 - Хана, шал болон бусад гадаргууг хуванцар хавтангаар хамгаалах;
 - Ажилчид болон тоног төхөөрөмжийг ариутгах зориулалттай байгууламж барих;
 - ААМ-ыг норгох аргаар зайлуулж, материалыг ус үл нэвтрэх саванд нэн даруй хийх;
 - Тусгай тоос сорогчоор эцсийн цэвэрлэгээг хийж, тусгай өрөө болон ариутгалын байгууламжийг буулгах;
 - Салгаж зайлуулсан ААМ болон бохирдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаях²⁸;
 - ААМ-ыг зайлуулах ажлыг гүйцэтгэж байгаа гэрээлэгч тал ажлын явцад үзлэг шалгалт хийх болон агаарын чанарыг хянах, түүнчлэн агаар цэвэршсэн эсэхийг тодруулахын тулд сүүлийн удаа агаараас дээж авах ажлыг бие даан гүйцэтгэнэ.
- Тодорхой төрлийн ААМ-ын барилга, байгууламжийн тохиргоо, шинж чанар, ажилд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд тавигдах бусад шаардлагыг төлөвлөгөөнд тусгасан болно. Холбогдох дүрэм журам, зөвшилцөл хийж болох стандартыг тусгайлан жагсаасан болно.

²⁸ Асбест гэх мэт аюултай бодисыг устгах зөвшөөрөгдсөн хогийн цэг байхгүй тохиолдолд энэ талаархи бусад удирдамжийг Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын ерөнхий зааварчилгаа, түүнчлэн Хог хаягдлын менежментийн зааварчилгаанд өгсөн байдаг.
[http://www.ifc.org/ifcext/sustainability.nsf/attachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_Wastemanagement/\\$File/Final/+Waste+management+facilities.pdf](http://www.ifc.org/ifcext/sustainability.nsf/attachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_Wastemanagement/$File/Final/+Waste+management+facilities.pdf)

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

3. Гэрээний заалттай холбоотой зарим асуудлууд²⁹

- Сонгогдсон гэрээт ажил гүйцэтгэгчээс асбесттай харьцад буй ажилчдаа амьсгалын аппарат, нэг удаагийн хувцас зэрэг зохих хамгаалалтын хэрэгслээр хангахыг шаардах.
- Сонгогдсон гэрээт ажил гүйцэтгэгч талыг техникийн шаардлагад заасан холбогдох журмын дагуу асбестыг зайлуулах, устгах талаар холбогдох байгууллагад мэдэгдэж, бүх хяналт шалгалтын явцад холбогдох байгууллагын төлөөлөгчидтэй бүрэн хамтран ажиллахыг шаардах.

4. Сургалт болон чадавх бэхжүүлэх

- Орон нутгийн гэрээт ажил гүйцэтгэгчид баригдсан барилга, байгууламжийн ААМ-тай ажиллах зохих хамгаалалтын арга хэмжээг дагаж мөрдөх талаар мэдлэг, мэдээлэлтэй байгааг баталгаажуулахын тулд үйлдвэрлэлийн эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн ажиллуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох.

Зохиогч: Дэлхийн банк, Үйл ажиллагааны бодлого ба улс орны үйлчилгээ

²⁹ Асбесттай ажиллах ажлын гэрээний стандартын заалтууд байдаг боловч энэхүү богино тэмдэглэлд дурдахад хэтэрхий их хэмжээтэй байна. Тиймээс жишээг зохиогчийн эрхийн формыг бөглөж АНУ-ын Барилгын шинжлэх ухааны үндэсний хүрээлэн "Барилга дахь асбестын бууралт ба менежмент: Загварын гарын авлагын тодорхойлолт" хэсгээс орж үзэж болно.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Хавсралт 3

Байгаль орчны үлгэрчилсэн дүрэм

Энэхүү байгаль орчны үлгэрчилсэн дүрмийг ОБҮДХЭТ-ийн хүрээнд хийгдэж буй жижиг хэмжээний засвар, заслын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээлэгч тал дагаж мөрдөнө.

| Зүйлс | Бууруулах арга хэмжээ |
|---|--|
| Хориглох зүйлс | Барилгын талбай болон талбайн ойролцоо дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: <ul style="list-style-type: none">• Зөвшөөрөгдсөн барилгын талбайн хэсгээс гадна ямар ч шалтгаанаар мод тайрах;• Барилгын хог хаягдал материалыг хууль бусаар хаях;• Зөвшөөрөгдөөгүй хортой бодис ашиглах, үүний дотор хромын орцтой будаг, асбест г.м;• Уран барилгын болон түүхэн үнэт зүйлсийг түйвээх;• Хог хаягдлыг шатаах |
| Ажлын цаг | Ажлын өдрүүдэд ажлын үндсэн цаг 0800 – 1800; бямба, ням гарагуудад 0800 - 1300 байна. ТХН болон холбогдох эрх бүхий газруудаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр эдгээр цагаас хойш дуу чимээтэй үйл ажиллагаа явуулах ёсгүй. Тухайн барилгын талбайд тавигдах дээр дурдсанаас ялгаатай шаардлагуудыг тухайн барилгын талбай тус бүрээр харгалзан тогтоож болно. |
| Ажлын байрны сайн эмх цэгц | Гэрээ гүйцэтгэгч тал нь цаг ямагт “Ажлын байрны сайн эмх цэгцийн” бодлогыг дагаж мөрдөх ёстой. Үүнд, гэвч үүгээр хязгаарлагдахгүй: <ul style="list-style-type: none">• Гэрээ гүйцэтгэгч талын ажилтнуудын орчиндоо хандах байдал анхааралтай, сонор соргог байх нөхцөлийг хянан баталгаажуулах;• Ил задгай гал гаргахыг хориглох;• Тоосны хяналтын тухай зохих зүйл заалтыг хангаж, замын цэвэр байдлыг хангаж хэрэгжүүлэх;• Хог хаягдлыг тогтмол давтамжтайгаар гаргаж хаях буюу барилгын талбайг цэвэр цэмцгэр үлдээх;• Хоол хүнсний үлдэгдлийг гаргаж хаях;• Барилгын талбай дахь бүх зарлалын самбар, тэмдэглэгээг тогтмол хянан шалгаж, шаардлагатай тохиолдолд засаж сэлбэн будах;• 24 цагийн дотор мэдэгдэж хэрэгжүүлэх боломжтой болмогц дээгүүр байрласан бүх зарлал/самбаруудыг буулгаж хаях;• Ажилчдад зориулсан бие засах газар болон бусад ахуйн хэрэгцээний байгууламжийг ажиллуулах; |
| Олон нийтэд зориулсан мэдээлэл ба талбайд нэвтрэх | Барилгын талбайд зөвшөөрөлгүй орж гарахыг аль болох хориглох ёстой. Барилгын ажлын тухай (эхлэх дуусах огноо) олон нийтэд зориулсан мэдээлэл, олон нийттэй харилцах ба/эсвэл хүсэлт хүлээн авах албан тушаалтны утсыг хүсэлт гаргасан үед Гэрээ Гүйцэтгэгч тал танилцуулах ёстой. |
| Барилгын талбай ба байгууламжууд | Аливаа түр хуаран, оффисын байгууламж, бие засах газар бусад ахуйн байгууламжийг барилгын ажлын талбайд барьж байгуулна. |
| Нийгмийн хэв журам, агаарын тоос тоосонцор, чимээний | Гэрээ гүйцэтгэгч тал нь нийгмийн хэв журам, агаарын тоос, тоосонцор, дуу чимээг хянахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд: <ul style="list-style-type: none">• Их дуу чимээ гаргаж болзошгүй үйл ажиллагааг өдрийн цагаар хийж, олон нийтийн тайван байдлыг аль болох бага алдагдуулахын тулд аливаа үйл ажиллагааг ТХН эсвэл холбогдох эрх бүхий байгууллага, агентлаг, |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|---|---|
| <p>хяналт</p> | <p>барилгын эзэмшигч ба/эсвэл орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж төлөвлөх.</p> <ul style="list-style-type: none"> • Нөлөөлөл үзүүлэх, тэсэлгээний үйл ажиллагаанд дуу чимээг хаах түр хашаа ба дефлектор хэрэгсэл гэх мэт дуу чимээний хяналтын хэрэгслүүдийг ашиглах ба дотоод шаталтат хөдөлгүүрт дуу намсгах төхөөрөмжийг ашиглах. • Олон нийтийн газруудад төслийн хүнд машин механизмын хөдөлгөөнийг бууруулах эсвэл зайлсхийх. • Бүх машин, тоног төхөөрөмжтэй холбоотой дуу чимээний түвшнийг аль болох 90 дицбел эсвэл түүнээс доош хэмжээнд тогтоон барих. • Барилгын үйл ажиллагааг явуулах явцад гарах чичиргээ болон дуу чимээг бууруулах зохих арга хэмжээ авах; • Эмзэг орчинд (үүний дотор эмнэлэг, асрамжийн газар, орон сууцны хороолол дунд) барилгын ажил явуулах тохиолдолд дуу чимээ хязгаарлах хатуу арга хэмжээ авах; Барилгын тоос, тоосонцрын хэмжээг барилгын ажлын явцад ямагт хязгаарлаж, хүүхэд, хөгшид гэх мэт эмзэг бүлгийн хүмүүст нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх; • Асбест гэх мэт агаар бохирдуулагч хортой бодисыг тухайн барилгыг нурааж буулгахаас өмнө дэд бүтцээс зайлуулж гаргах; • Тоосны хамгаалалт, тор болон барилгын талбайн хашааг орон сууц, аж ахуйн нэгж, цэцэрлэгт хүрээлэнтэй залгаа барилгын хэсэгт хийж барьж байрлуулан хөрш зэргэлдээ этгээдийг утаа тоосны нөлөөлөлд өртөхөөс сэргийлэх; • Барилгын талбайд, ялангуяа оршин суугчдын хорооллын ойр байрлах барилгын талбайд шаардлагатай тохиолдолд тогтмол ус шүршиж байх |
| <p>Барилгын хог хаягдлын удирдлага</p> | <p><i>Хог хаягдлын удирдлагын төлөвлөлт.</i> Барилгаар гарах хог хаягдлыг бүтэц, гарал, хог хаягдлын төрөл, гарцын хэмжээ, эсвэл орон нутгийн дүрэм журам, тогтоомжийн шаардлагын дагуу ангилах ёстой. Аливаа хог хаягдлын хэмжээ болон хог хаягдалтай холбоотой үүсэж болох аюулыг аль болох бууруулж, урьдчилан сэргийлэхийн тулд үйл явцыг төлөвлөж ажиллуулах ёстой. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Аюул эсвэл хор хөнөөл багатай материал бүхий түүхий эд эсвэл орцыг оруулан ашиглах; • Ажлын байрны сайн эмх цэгц ба үйл ажиллагааны журмыг баримталж ажиллах; • Сав гэх мэт дахин ашиглах боломжтой материалыг эргүүлэн ашиглах боломжийг хангасан худалдан авах ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэх; • Аюултай ба аюулгүй хог хаягдлыг холилдохоос урьдчилан сэргийлэхийн тулд хог хаягдлыг нарийн ялгах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах. <p><i>Дахин ашиглалтыг төлөвлөх.</i> Дахин ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар нийт хог хаягдлын хэмжээг ихээхэн бууруулах боломжтой. Тухайлбал ийм төлөвлөгөөнд хог хаягдал гарах үйл явцыг үнэлж, дахин ашиглах боломжтой материалыг тогтоох гэх мэт үйл ажиллагааг хамруулж болно.</p> <p><i>Цэвэрлэгээ хийх журам, процедур.</i> Гэрээ Гүйцэтгэгч тал нь ажлын талбайг өдөр бүр цэвэрлэх журмыг боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд үүнд хүний эрүүл мэнд, орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллөөс зайлсхийхийн тулд барилгын хог хаягдлыг зохистой агуулах, хадгалах, харьцах/зайлуулах байгууламжийн засвар үйлчилгээ хийх гэх мэт асуудлыг тусгана. Удирдлагын арга барил нь хог хаягдлыг зайлуулах хадгалахтай холбоотой орон нутгийн дүрэм журамд нийцсэн байхын зэрэгцээ дор дурдсан нэг ба түүнээс дээш тооны зарчмыг тусгасан байж болно:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын талбай дээрх эсвэл ажлын талбайгаас гаднах биологийн, химийн эсвэл биет хог хаягдал материалыг зайлуулж хаяхын өмнө аюулгүй болгох арга хэмжээг авах эсвэл хог хаягдал хүлээн авахад зориулан барьсан тусгай зөвшөөрөгдсөн байгууламжид тээвэрлэн |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|---|---|
| | <p>хүргэж хаях ёстой.</p> <ul style="list-style-type: none"> • Хуучин байгууламжийг нурааж буулгасны улмаас гарах барилгын хог хаягдлыг боломжтой бол зохих ёсоор дахин ашиглана. Үлдэгдэл барилгын хог хаягдлыг зөвхөн орон нутгийн эрх бүхий байгууллагаас баталж тогтоосон газруудад л зайлуулан хаяна. • Орчны эмзэг бүсэд аливаа материал хаяхаас Гэрээ Гүйцэтгэгч тал нь ямар ч нөхцөлд зайлсхийнэ. • Барилгын ажлын явцад гарсан бүх хог, метал, ашигласан тос, илүүдэл материалыг дахин ашиглах системд оруулах, материалыг ангилж цуглуулахын зэрэгцээ зөвшөөрөгдсөн газруудад л хаяна. • Хөрш зэргэлдээ газарт байгаа барилгын хог хаягдал эсвэл лаг шаврыг Гэрээ Гүйцэтгэгч тал нь нэн даруй зайлуулах бөгөөд тухайн нөлөөлөлд өртсөн газрыг ТХН эсвэл эрх бүхий байгууллага, агентлагийн шаардлагад нийцүүлэн хуучин байдалд нь оруулан сэргээн засна. |
| <p>Бага хэмжээний аюултай материал</p> | <ul style="list-style-type: none"> • Барилгын ажил гүйцэтгэх, дуусгах явцад бага хэмжээний аюултай материал алдагдах магадлалтай. Гэрээ Гүйцэтгэгч тал нь барилгын систем (жишээлбэл. цахилгаан тоног төхөөрөмж бүхий РСВ, асбест агуулсан барилгын материал, гэрэл эсвэл гэрлийн балласт, ашигласан баттерей-зай, будгийн хоосон сав гэх мэт) ба үйл явцын тоног төхөөрөмжид аюултай материал, бензин агуулсан бүтээгдэхүүн байгаа эсэх, тэдгээрийн агууламжийг үнэлж тогтоох, улмаар тэдгээрийг барилгын ажлыг дуусгахаас өмнө зайлуулах, тэдгээртэй харьцаж, зайлуулахдаа Дэлхийн Банкны Группийн Орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдлын ерөнхий шаардлага, удирдамжийн Аюултай материалын тухай Бүлэг 1.5 ба Аюултай хог хаягдлын удирдлагын тухай Бүлэг 1.6-ийн дагуу удирдана (www.ifc.org/ehsguidelines). Ялангуяа, аюултай хог хаягдлыг аюулгүй хог хаягдлаас ямагт ялгаж заагтай байлгах ёстой. Хэрвээ дээр дурдсан хог хаягдлын удирдлагын ерөнхий практикийг хэрэгжүүлснээр аюултай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлж чадахгүй бол уг хог хаягдлын удирдлага нь дор дурдсан нэмэлт зарчмын дагуу эрүүл мэнд, аюулгүй байдал, орчинд үзүүлэх хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарлаа хандуулах ёстой. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Аюултай хог хаягдлыг бүрэн устгалд оруулах хүртэл удирдах явцад үүсэх эрсдэл, болзошгүй нөлөөллийг ойлгох • Аюултай хог хаягдалтай харьцах, зөвөөрлөх, зайлуулах ажлыг хариуцсан Гэрээ Гүйцэтгэгч тал нь холбогдох эрх бүхий байгууллага, агентлагийн зөвшөөрөлтэй, нэр хүндтэй, хууль ёсны аж ахуйн нэгж байхын зэрэгцээ хог хаягдалтай харьцахдаа олон улсын үйлдвэрийн сайн практикийг дагаж мөрддөг эсэхийг хянан баталгаажуулах • Холбогдох орон нутгийн болон олон улсын дүрэм журамтай нийцэж буй эсэхийг хянан баталгаажуулах. • Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахыг хянах тухай Базелийн Конвенци (http://www.basel.int/) болон Олон улсын худалдаанд зарим хортой химийн бодис, пестицидын талаар урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын Конвенцийн (http://www.pic.int/) дагуу тухайн улс орны хүлээх үүргийг олон улсын шаардлагад багтааж болно. |
| <p>Хаягдал усыг зайлуулах</p> | <p>Гэрээ Гүйцэтгэгч тал нь хог хаягдлыг (хатуу ба шингэн) бүх төрлийн гол, суваг уруу урсан орохоос урьдчилан сэргийлж, хөрс ба гүний усыг бохирдох болон усны түвшин, урсгалд өөрчлөлт орох, усны ерөнхий чанар өөрчлөгдөх гэх мэт бусад сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллах ёстой. Боломжтой нөхцөлд Гэрээ Гүйцэтгэгч тал нь хаягдал усны хэмжээг хамгийн бага хэмжээнд бууруулж, хаягдлыг зайлуулах өөр хувилбарыг эрэлхийлж ажиллах нь зүйтэй. Төслийн талбайд асгарсан тосолгооны материал, түлш, тос гэх мэт шингэн нь гүний ус, газрыг бохирдуулахаас өмнө аль</p> |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|--|--|
| | <p>болох эрт үед нь оношилж зохистой арга хэмжээ авсан байна. Гэрээ Гүйцэтгэгч тал нь ажлын улмаас үүсэх аливаа хаягдал ус, шүүрлийг зохих сав, цистерн ашиглан цуглуулж, зайлуулах үйл ажиллагааг хянан баталгаажуулсан байх ёстой. Ус зайлуулах хоолойны загварыг боловсруулахдаа барилгын талбай болон хүрээлэн буй орчинд эрүүл ахуйн таагүй нөхцөл, муухай үнэр гаргаж болзошгүй тогтонги ус үүсгэх загвараас зайлсхийвэл зохино.</p> |
| <p>Барилгын аюулгүй байдал</p> | <p><i>Яаралтай арга хэмжээ авах журам:</i> Гэрээ Гүйцэтгэгч тал нь эрүүл мэндийн/галын яаралтай нөхцөл байдал түүнчлэн орчны бохирдлын (бензин, ашигласан тос ба/эсвэл хортой химийн элемент гэх мэт бодис ихээр асгарах гэх мэт) үед яаралтай арга хэмжээ авах журмыг боловсруулсан байх ёстой. Яаралтай арга хэмжээ авах журамд яаралтай тусламж хүсэх утасны дугаар болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх аргыг дурдсан байвал зохино. Гэрээ Гүйцэтгэгч талын гол албан тушаалтны утасны дугаарыг мөн дурдсан байх ёстой.</p> <p><i>Галаас урьдчилан сэргийлэх ба хянах:</i> Барилгын бүх талбай, холбогдох орон сууц эсвэл ахуйн хэрэглээний байгууламжууд нь галаас урьдчилан сэргийлэх зохих төлөвлөгөө, удирдлагын хяналттай байх ёстой. Талбайн галын аюулаас сэргийлэх төлөвлөгөөг төрөөс энэ чиглэлээр баримтлах дүрэм журмын дагуу бэлтгэсэн байх ёстой. Тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл ажиллуулах, засварлах явцад Гэрээ Гүйцэтгэгч тал нь эдгээр үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг ажилчид сайн ойлгосон, тэдгээрийг дагаж мөрдөх хангалттай мэдлэгтэй эсэхийг хянан баталгаажуулах ёстой. Галд тэсвэртэй материал, бүтээгдэхүүн, сав баглаа боодлыг ашиглах боломжтой тохиолдолд ашиглах нь зүйтэй. Гэрээ Гүйцэтгэгч тал нь тухайн барилгын талбайд хамааралтай төрөөс тавигдах бусад шаардлагыг дагаж мөрдөх ёстой.</p> <p><i>Тоног төхөөрөмжийг ажиллуулах:</i> Гэрээ Гүйцэтгэгч тал нь аливаа тоног төхөөрөмжийг ажиллуулахдаа орчны оршин суугчид ба байгууллага, иргэдэд аюулгүй байдлын эрсдэл үүсгэхгүй ба/эсвэл нийгмийн хэв журмыг алдагдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахын тулд шаардлагатай бүхий л урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байх ёстой. Кран болон бусад том тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг нягт хянаж ажиллах нь зүйтэй. Зөвшөөрөл авах шаардлагатай байж болно.</p> <p><i>Ослоос урьдчилан сэргийлэх.</i> Гэрээ гүйцэтгэгч тал нь бүх ажилчдыг болон ойр орчмын өмч хөрөнгийг барилгын ослоос хамгаалах үүрэгтэй болно. Гэрээ гүйцэтгэгч тал нь аюулгүйн ажиллагааны хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллах үүрэгтэй бөгөөд барилгын осол гаргахаас урьдчилсан сэргийлэх бүхий л арга хэмжээг авна, үүний дотор дараах арга хэмжээнүүдийг авна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Барилгын талбайд мэдээлэх тэмдэг/тэмдэглэгээ, самбарыг зохих байдлаар байрлуулах; • Барилгын талбайн ойр сургуулийн насны хүүхдүүд явдаг тохиолдолд сургуулийн хичээлийн цагаар замын аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах аюулгүйн ажиллагааны ажилтнууд томилон ажиллуулах; • Барилгын ажил эхлэхээс өмнө барилга дээр ажиллах ажилтнуудад аюулгүй ажиллагааны сургалт явуулах; • Барилгын ажилтнуудыг шаардлагатай хувь хүний хамгаалах хэрэгслээр хангах /хамгаалалтын нүдний шил, бээлий, маск, тоосны хамгаалалтын маск, хамгаалалтын каск/малгай, зориулалтын хамгаалалттай гутал гэх мэт/ ба хамгаалалтын хэрэгслүүдийн ашиглахыг шаардах; • Асбест агуулсан материал эсвэл бусад хортой бодисыг зөвөөрлөн зайлуулах болон устгалыг тусгайлан бэлтгэгдсэн ажилчдаар хийлгэх явдлыг хянан баталгаажуулах; • Аливаа яаралтай тусламж шаардлагатай болсон үед бүх ажлыг түр зогсоох. |
| <p>Ажиллах хүч ба ажилчдын эрүүл ахуй</p> | <p>Гэрээ Гүйцэтгэгч тал нь боломжтой тохиолдолд ажиллах хүчнийхээ дийлэнхийг орон нутгаас сонгон авч ажиллуулах буюу тэднийг шаардлагатай зохих сургалтад хамруулах ёстой.</p> <p>Гэрээ Гүйцэтгэгч тал нь барилгын талбай эсвэл орчны бүс нутагт хоол хийх</p> |

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|---|---|
| | <p>эсвэл дулаацах зориулалтаар түлээний мод ашиглахыг хориглох ёстой. Гэрээ Гүйцэтгэгч тал нь талбай дээрх хээрийн оффис, өртөө, агуулах, цехийг зохих газруудад байрлуулах нөхцөлийг хянан баталгаажуулна. Цэвэр, сайн ажиллагаатай бие засах газруудыг ашиглах нөхцөлөөр хангана. Гэрээ Гүйцэтгэгч тал нь ажилчдыг цэвэр усаар хангана.</p> |
| Олон нийтийн харилцаа | <p>Гэрээ гүйцэтгэгч тал нь олон нийтийн харилцааг зохих ёсоор дээшлүүлэх: Оршин суугчдад барилгын ажлын талаар болон барилгын ажлын хуваарь, төлөвлөгөөний талаар мөн үйлчилгээ, дэд бүтцийн хязгаарлалт, зам, гарц болон нийтийн тээврийн хэрэгслийн маршрутын өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгөх; Барилгын үйл ажиллагааг шөнийн цагаар хязгаарлах.</p> |
| Биет соёлын өмч болон олдворуудтай харьцах | <ul style="list-style-type: none">• Биет соёлын өмчийн олдворуудыг олж илрүүлэх ховор тохиолдолд цаашид авах арга хэмжээг шийдэхээс өмнө археологийн, түүхэн газрууд, туурь олдворуудыг хамгаалж хадгалах асуудал хариуцсан орон нутгийн эрх бүхий байгууллагууд энэ асуудлыг хариуцна. Олдворын чухал ач холбогдлыг соёлын өвийн холбогдох төрөл бүрийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх ёстой. Үүнд гоо сайхны, түүхийн, шинжлэх ухааны эсвэл судалгаа шинжилгээний, нийгмийн болон эдийн засгийн үнэ цэнийг тогтоох явдал багтана. Олдвортой хэрхэн харьцах шийдвэрийг энэ асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллага гаргана. Энэ шийдвэрт байршлыг өөрчлөх (тухайлбал соёлын эсвэл археологийн чухал ач холбогдолтой хөдөлгөж болшгүй дурсгалыг олж илрүүлсэн тохиолдолд) хамгаалах, хадгалах, сэргээх ба аврах тухай заасан байна. Гэрээ гүйцэтгэгч тал нь барилгын талбайг ухах болон барилгын үйл ажиллагааны явцад эртний, археологийн түүхэн туурь, олдвор, эд зүйлс олсон тохиолдолд дараах арга хэмжээ авна. Үүнд:<ul style="list-style-type: none">• Олдвор олдсон хэсэг газарт барилгын үйл ажиллагааг зогсоох;• Олдвор олдсон хэсэг газар дээр хүрээ татах;• Олдвор гэмтэж, үрэгдэхээс сэргийлэх арга хэмжээг авах. Олдвор алга болох магадлал өндөр тохиолдолд шөнийн цагаар, зохих орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгтөл хамгаалалтын ажилтан гаргаж ажиллуулах;• Хариуцсан инженер олдворын талаар мэдээлж, инженер нь зохих орон нутгийн засаг захиргаанд 24 цагийн дотор мэдээлэх үүрэгтэй;• Олдворын талбайн хамгаалалт хариуцсан орон нутгийн засаг захиргаанаас барилгын ажил эхлүүлэх |
| Ажил дууссаны дараа барилгын талбайг цэвэрлэж үлдээх | <p>Ажил гүйцэтгэж дууссаны дараа Гэрээ Гүйцэтгэгч тал нь бүх төрлийн түр ажлууд, хог хаягдал, материалыг цэвэрлэж, зориулалтын бүсэд зөөвөрлөн гаргаж хаясан байх ёстой. Барилгын талбайг ТХН эсвэл холбогдох эрх бүхий байгууллага, агентлагийн шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд цэвэрлэж үлдээх ёстой.</p> |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Хавсралт 4

**Засварын ажлын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон
нийгмийн нөлөөллийн байдлыг үнэлэх хуудас**

Энэхүү үнэлгээний хуудсыг ТХН-ийн ХШҮ-ний ажилтан болон засварын ажлын хяналтын инженер нар төслийн БОНУХ-ын хүрээнд Байгаль орчны үлгэрчилсэн дүрэм, “Асбест-Ажил мэргэжлийн болон олон нийтийн эрүүл мэндийн асуудлууд” (Хавсралт 3) болон бусад холбогдох баримт бичиг, дүрэм журамтай холбоотойгоор гэрээг гүйцэтгэгч талын гүйцэтгэлийг шалгахад ашиглана. Үнэлгээний хуудасны зорилго нь барилгын ажилтай холбоотой байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал болон нийгмийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зохих удирдамж, зөвлөмжөөр хангахад оршино.

| № | Үзүүлэлтүүд | Шалгах асуулт | | Тэмдэглэл | |
|---|---|--|------|-----------|---|
| 1 | Асбест-ажил мэргэжлийн болон олон нийтийн эрүүл мэндийн асуудлууд | Гүйцэтгэгч асбест агуулсан материалтай ажиллахдаа (олдсон тохиолдолд) Дэлхийн банкны гаргасан “Асбестын талаар баримтлах сайн туршлагын тэмдэглэл”-ийг дагаж мөрдсөн үү? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 2 | Хориглох зүйлс | Гүйцэтгэгч барилгын талбай дээр болон барилгын ойролцоо “Хориглох зүйлс”-ийн алийг ч хийгээгүй болохыг баталгаажуулна уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 3 | Ажлын цаг | Гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн хуульд заасан ажлын цагийг мөрдөж ажилласан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 4 | Барилгын талбай дээрх сайн туршлага | Гүйцэтгэгч барилгын талбай дээрх сайн туршлагыг цаг ямагт мөрдөж ажилласан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 5 | Олон нийтэд зориулсан мэдээлэл ба талбайд нэвтрэх | Гүйцэтгэгч засварын ажлын талбай дээр олон нийтэд зориулсан мэдээллийг байршуулсан уу? (эхлэх дуусах хугацаа, утасны дугаар) | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 6 | Нийгмийн хэв журам, агаарын тоос, тоосонцор, дуу чимээ | Гүйцэтгэгч барилгын талбай дээр нийгмийн хэв журам, агаарын тоос, тоосонцор, дуу чимээг хязгаарлах, хянах арга хэмжээ авсан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 7 | Барилгын хог хаягдлын удирдлага | Гүйцэтгэгч барилгын хог хаягдлын удирдлагын төлөвлөлт, дахин ашиглалтыг төлөвлөх болон цэвэрлэгээ хийх журмыг дагаж мөрдсөн үү? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | | | | | |
|----|--|--|------|------|---|
| 8 | Бага хэмжээний аюултай материал | Гүйцэтгэгч барилгын ажлын явцад ашиглагдах аюултай материал болон бензин агуулсан бүтээгдэхүүнүүдийн агууламжийг үнэлж тогтоосон уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 9 | Барилгын аюулгүй байдал | Гүйцэтгэгч барилгын аюулгүй байдлын бодлого, журамд нийцэж ажилласан уу (яаралтай арга хэмжээ авах журам, галаас урьдчилан сэргийлэх ба хянах, тоног төхөөрөмжийг ажиллуулах, ослоос урьдчилан сэргийлэх гэх мэт)? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 10 | Ажиллах хүч, ажилчдын эрүүл ахуй | Гүйцэтгэгч шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслүүдээр ажилчдаа хангасан уу? i) Хамгаалалтын каск ii) Бээлий iii) Асбест агуулсан материалтай ажиллах үед: a. Хамгаалалтын хувцас b. Хамгаалалтын амны хаалт c. HEPA шүүлтүүр iv) Амрах байраар хангагдах v) Ундны цэвэр усаар хангагдах | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 11 | Олон нийтийн харилцаа | Гүйцэтгэгч нь олон нийтийн харилцааг зохих ёсоор дээшлүүлсэн үү (орон нутгийн байгууллага, төлөөллүүдэд мэдээлэл хүргэх)? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 12 | Биет соёлын өмч болон олдворуудтай харьцах | Гүйцэтгэгч биет соёлын өмч болон олдворуудтай харьцах журмыг дагаж мөрдөн ажилласан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 13 | Ажил дууссаны дараа барилгын талбайг цэвэрлэж үлдээх | Гүйцэтгэгч ажил гүйцэтгэж дууссаны дараа бүх төрлийн түр ажлууд, хог хаягдал, материалыг цэвэрлэж, зориулалтын бүсэд зөөвөрлөн гаргаж хаясан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 14 | Албадан хөдөлмөр | Гүйцэтгэгч албадан хөдөлмөр эрхлүүлэх чиглэлийн ямар нэг үйл ажиллагаанд холбогдоогүй юу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 15 | Хүүхдийн хөдөлмөр | Гүйцэтгэгч хүүхдийн хөдөлмөртэй холбоотой ямар нэг асуудалд байдлаар холбогдоогүй юу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
| 16 | Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал | Гүйцэтгэгч нийгмийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах чиглэлийн МУ-ын болон Дэлхийн банкны холбогдох стандартыг мөрдөж ажилласан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) Р174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | | | | | |
|----|----------------------------|--|------|------|---|
| 17 | Ажлын байрны ёс зүйн дүрэм | Гүйцэтгэгч талын ажилтнууд Ажлын байрны ёс зүйн дүрэмд гарын үсэг зурсан уу? | Тийм | Үгүй | Үгүй бол гүйцэтгэгчид өгсөн заавар, зөвлөмжөө бичнэ үү? |
|----|----------------------------|--|------|------|---|

Үнэлгээний хуудсыг бөглөсөн: -----

Засвар хийж буй газар: -----

Гүйцэтгэгчийн нэр: -----

Огноо: -----

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Хавсралт 5.

ОБҮДХЭТ-ийн хүрээнд жижиг зээл олгохыг хориглох үйл ажиллагааны
жагсаалт

Энэхүү жагсаалтыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтэс (ХХҮГХ)-ийн Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтан бичил зээлийн төслийг шалгахдаа явцдаа ашиглана. Жагсаалтад дурдсан үйл ажиллагааг хамарсан бизнесийн төслийг ОБҮДХЭТ-ийн хүрээнд санхүүжүүлэх "эрхгүй" байна.

| Хориглох үйл ажиллагаа | |
|--|--|
| Тусгай газар нутаг, байгаль орчин, биологийн төрөл зүйлд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа | Цацраг идэвхт бүтээгдэхүүн болон цөмийн реакторын төхөөрөмж оролцуулсан аливаа үйл ажиллагаа |
| Хотын захиргаанаас тогтоосон ногоон бүсэд орших аливаа үйл ажиллагаа | Хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа |
| Маргаантай газар нутагт хэрэгжих аливаа үйл ажиллагаа | Монреалын Протоколын дагуу хлорфлюорокарбон (CFCs), халон (halons) эсвэл озон задлах бусад бодис агуулсан тоног төхөөрөмж, хэрэгслийн үйлдвэрлэл зэрэг үйл ажиллагаа |
| Хүмүүсийг нүүлгэн суурьшуулах, эсвэл нүүлгэн шилжүүлэлт шаардсан аливаа үйл ажиллагаа | Жингээрээ 0.005 хувиас илүү полихлорт бифенил (PCBs) агуулсан цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл бүхий аливаа үйл ажиллагаа |
| Соёлын өвд гэмтэл, хохирол учруулж болзошгүй аливаа үйл ажиллагаа | Хориглосон пестицид, гербицид үйлдвэрлэх, худалдан авах, түгээх, борлуулахтай холбоотой аливаа үйл ажиллагаа |
| Уугуул нутгийн болон бусад эмзэг бүлгийн иргэдийн газар нутаг, эрхэд халдсан аливаа үйл ажиллагаа | 2008 онд ХНХЯ-ны сайдын баталсан насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг зөрчиж насанд хүрээгүй хүн ажиллуулах аливаа үйл ажиллагаа |
| Нийгэмд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх болон нийгмийн томоохон зөрчил үүсгэж болзошгүй аливаа үйл ажиллагаа | Зэрлэг ан амьтан, ургамлын нэн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хүрээнд хориглосон зэрлэг амьтан ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний арилжаа худалдаа бүхий аливаа үйл ажиллагаа |
| Монгол Улсын хуулиар хориглосон аливаа үйл ажиллагаа | Генетикийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг байгаль орчинд нийлүүлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаа |
| Байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа | Аюултай хог хаягдлыг хадгалах, ашиглах, зайлуулахтай холбоотой аливаа үйл ажиллагаа |
| Оршин суух эсвэл хувийн хэвшлийн худалдааны зориулалттай байшин барилгыг буулгах эсвэл газрыг чөлөөлөх асуудал бүхий аливаа үйл ажиллагаа | Дараах салбаруудад хамаарах аливаа үйл ажиллагаа: <ul style="list-style-type: none">• Мод бэлтгэх• Уул уурхай болон олборлолт• Тамхины бүтээгдэхүүний үйлдвэрлэл• Цэргийн техник хэрэгслийн үйлдвэрлэл• Кокс, химийн бодис, хуванцар эсвэл эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх |
| Хөдөлмөрийн удирдлагын ноцтой эрсдэлтэй, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулах эсвэл албадан болон хүүхдийн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаа | Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулах аливаа үйл ажиллагаа (замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн, халдварт өвчний тархалт, аюултай материалд өртөх зэрэг) |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Хавсралт 6

Хүснэгт 6.1: Байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий шаардлага

Энэхүү Байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий шаардлагыг ОБҮДХЭТ-ийн хүрээнд санхүүжүүлсэн жижиг зээлийг авсан бичил бизнес эрхлэгч нар дагаж мөрдөнө.

| Нөлөөлөл болон Эрсдэл | Анхаарах хүчин зүйлс |
|--|--|
| <p>Байршил: Хот, суурин газрын байгаль орчныг доройтуулах, хэт бөөгнөрөл, дуу чимээг нэмэгдүүлэх, ялангуяа явган зорчигчдын замын хөдөлгөөнд саад болж хүндрүүлэх, ногоон бүс болон бусад орчны тохижилт, чиг үүрэгт сөргөөр нөлөөлөх, осол гарах буюу эрүүл мэнд, аюулгүй байдлын бусад эрсдэлд хүргэх</p> | <p>Ажлын талбайг сонгохдоо дараах зүйлсийг анхаарна:</p> <ol style="list-style-type: none"> (1) Ус ба эрүүл ахуйн үйлчилгээ нь бичил үйлдвэрийг хангахуйц хангалттай байх. (2) Бичил үйлдвэр нь арьс ширний үйлдвэр, электролизийн аргаар металлаар бүрэх үйл ажиллагаа бүхий эсвэл бохирдуулалт ихтэй бусад бичил үйлдвэртэй ойрхон байрладаггүй байх. (3) Үйлдвэр нь иргэд, хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхийг шаардахгүй байх. (4) Үйлдвэр нь явган хүний зам эсвэл бусад төрлийн замууд эсвэл замын хөдөлгөөний бөглөрөл, түгжрэл, гацаанд ихээр нөлөөлж, нэмэрлэдэггүй байх. (5) Үйлдвэр нь орон байр, хөдөө аж ахуй гэх мэт эмзэг газар ашиглалтаас хол зайтай байрладаг байх (6) Орон байр эсвэл хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаагүй л бол үйлдвэр нь орон байр, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглахад тохиромжгүй эсвэл тохиромж муутай газар байх (7) Тухайн газар нь гоо зүйн эсвэл соёлын ач холбогдол багатай эсвэл ногоон бүс гэж үнэлэгдээгүй байх. (8) Шинэ бичил үйлдвэрийн байршил эсвэл үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй байгаатай холбоотой асуудлыг орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх. (9) Хамгийн үр ашигтай, бохирдолгүй эх үүсвэр бүхий эрчим хүчийг ашиглахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх. |
| <p>Амьдрах орчин, онгон зэрлэг байгаль</p> | <ol style="list-style-type: none"> (1) Газрын төрх байдлыг аль болох хамгийн бага түвшинд өөрчлөх (2) Төслийн бүсийн байгалийн суваг шуудууг өөрчлөхгүй хэвээр үлдээх, хөндөхгүй байх (3) Тухайн бүсэд ховор эсвэл нэн ховордсон ургамал эсвэл амьтны төрөл зүйл байгаа нь мэдэгдсэн эсвэл байгаа гэж тооцдог бол амьд байгаль, түүний ан амьтдыг сүйтгэхгүй байх. (4) Модыг боломжит хамгийн их хэмжээгээр аврахын тулд тохируулга өөрчлөлт хийх (5) Мод тарихаар төлөвлөх |
| <p>Байгалийн нөөцийн ашиглалт</p> | <ol style="list-style-type: none"> (1) Боломжит хамгийн бага хэмжээтэй орц/ материал ашиглах (2) Эрчим хүчний өөр эх үүсвэр ашиглахыг зорих (3) Дахин ашиглах, дахин боловсруулах (4) Гүний усыг хамгаалах |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|--|--|
| <p>Хог хаягдлын удирдлага/асгарч гоожсон зүйлээс бохирдох</p> | <ol style="list-style-type: none"> (1) Болзошгүй хог хаягдлыг тодорхойлох (2) Хог хаягдлын хэмжээг боломжит хамгийн бага түвшинд байлгах (3) Өөр зориулалтаар ашиглах (4) Хог хаягдлыг дахин ашиглах төлөвлөгөө бэлтгэх (5) Орчинд зохистойгоор агуулах, хадгалах, харьцах (6) Үндэсний дүрэм журам, Дэлхийн Банкны Орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй байдлын шаардлага, удирдамжийн дагуу аюулгүй зайлуулах (7) Ослын үед ямар арга хэмжээ авах тухай төлөвлөгөө боловсруулах (8) Бүх төрлийн хорт утаанд хяналт тавих (9) Боловсруулаагүй, түүхий & бохирдсон усыг ширгэдэггүй, ширгэдэг усны сувагт эсвэл аливаа усны эх үүсвэр & усан сангийн ойролцоо гадагшлуулахыг хүлээн зөвшөөрөх ёсгүй. (10) Байгууламжийн үйл ажиллагааны хог хаягдлын байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг боломжит хамгийн бага хэмжээнд байлгах явдлыг хангах. (11) Үйлдвэрийн бохир ус, хог хаягдал материалыг хадгалж харьцах байршлыг оноох. (12) Ажлын байрыг цэвэр байлгаж, ажлын байрнаас бүх хогийг зайлуулах, хог хаягдлын сав байрлуулах, барилгын хогийг зохих байршилд зайлуулж хаях. (13) Ашиглахгүй орхисон худагт эсвэл ойр орчимд хог хаягдал шидэх, хаях эсвэл булахыг хатуу хориглох. (14) Түүхий эд материал, эцсийн бүтээгдэхүүн, багаж хэрэгсэл болон эд зүйлсийг хадгалах тусгай газрыг сонгох, (15) Орчны шалан дээр ус, тос, шингэн хаягдал асгарч үлдэхээс урьдчилан сэргийлж тэвш, хаалт ашиглах. |
| <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй</p> | <ol style="list-style-type: none"> (1) Тоос, утаа, дуу чимээ, үнэр эсвэл бохидуулагч бодисын улмаас ажилчдад учирч болох хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж, тэдгээрийг бууруулах арга хэмжээг эрүүл мэнд, аюулгүй байдлын үндэсний холбогдох стандарт, Дэлхийн Банкны байгаль, орчин ба нийгмийн аюулгүй байдлын ерөнхий шаардлага, удирдамжтай нийцүүлэн санал болгох (2) Ажлын байранд хог хаягдлыг гадагшлуулах ба зайлуулахад зориулагдсан хангалттай байгууламжийг байршуулж; аюултай хортой бодис, аюултай хог хаягдалтай хэрхэн харьцах журмыг боловсруулан мөрддөг байх ёстой. (3) Эрсдэлийг бууруулахын тулд ажиллах орон зайг дахин зохион байгуулж, эмх цэгц, цэвэр байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх. (4) Барилга байгууламж доторх үйл ажиллагааг зохих агааржуулалтаар хангасан байх. (5) Тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох. (6) Ядарсны улмаас осол эндэгдэл гаргахгүйн тулд буюу хэт их дуу чимээ, машин механизмын чичиргээ доргионоос үүсэх тавгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахын тулд ажиллах хугацааг бууруулах; түр амрах хугацаа гаргах. (7) Зохистой гэрэлтүүлгээр хангах (8) Гэмтээх эсвэл хортой бодистой харьцсаны дараа гараа сайтар угаах, хоол идэх, шингэн зүйл уух, тамхи татах эсвэл бие засах газарт орсны дараа гараа сайтар угаах. (9) Бензинийг цэвэрлэгээний зориулалтаар огт ашиглахгүй байх. (10) Ихэнх гэмтэл ажилчдын бие махбодын ялгаатай байдлын улмаас үүсдэг. Хүмүүсийн биеийн өндөр, хүч чадал, оюуны стресс даах чадвар зэргийг харгалзах (11) Хортой бодистой харьцах үед зохих хамгаалах хэрэгсэл ашиглаж буй эсэхийг хянан баталгаажуулах. |

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | |
|--|--|
| | <p>(12) Тохиолдлоор хордсон тохиолдолд аврах бэлтгэлийг хангаж ойрхон цэвэр ус хадгалах, хамтран ажиллагчдадаа ямар төрлийн пестицид ашиглаж буй болон шошго тэмдэглэгээ нь хаана байгааг хэлэх.</p> <p>(13) Хэрвээ пестицидээр амьсгалсан бол, тухайн ажилчныг нэн даруй цэвэр агаарт гаргах.</p> <p>(14) Сав баглаа боодолд сонин болон бусад галд амархан шатах материал ашиглахаас зайлсхийх.</p> |
| Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | <p>(1) Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын Үндэсний холбогдох стандарт, Дэлхийн Банкны орчин ба нийгмийн аюулгүй байдлын ерөнхий шаардлага, удирдамжтай нийцсэн байх</p> |
| Ажиллах нөхцөл | <p>(1) Хөдөлмөрийн болон ажиллах нөхцөлтэй холбоотой үндэсний хөдөлмөрийн стандартуудыг дагаж мөрдөх</p> <p>(2) Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үндэсний хөдөлмөрийн стандартуудыг дагаж мөрдөх</p> <p>(3) Орон нутгийн иргэд, олон нийттэй сайн харилцаа тогтоох</p> <p>(4) Монгол Улсын хуулийн дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрөгдсөн наснаас бага насны хүүхэд ажиллуулахгүй байх</p> <p>(5) 2008 онд баталсан жагсаалтын дагуу хүүхэд ажиллахыг хориглосон ажил мэргэжилд бага насны хүүхэд ажиллуулахгүй байх</p> |

Хүснэгт 6.2: Тухайн салбарт хамааралтай орчин ба нийгмийн аюулгүй байдлын тусгай шаардлага, удирдамж

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБУДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| Салбар | Орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын | Нөлөөллийг бууруулахаар зөвлөж буй хувилбарууд |
|---|---|---|
| <p>Хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ</p> | <p>(1) Усан зам сувагт бохирдуулагч орох эсвэл ус зайлуулах хоолойг бөглөх. Тос, хөргөлтийн шингэн, уусгагч, цэвэрлэгээний бусад шингэн гэх мэт шингэн бодис асгарснаас ийм эрсдэл үүсэж болно.</p> <p>(2) Газар доорх агуулах сав буюу цистернээс гоожих хаягдал тос болон бусад шингэний улмаас хөрс, гүний ус бохирдоно.</p> <p>(3) Хөргөх бодис, уусгагч, шингэрүүлсэн хийн түлш, хорт утаа ялгарсны улмаас агаарын бохирдол (үнэр гэх мэт).</p> <p>(4) Үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгслийг засаж сэлбэх явцад цехэд эрчим хүч ашигласнаас үүсэх хүлэмжийн хийн утаа.</p> <p>(5) Тээврийн хэрэгслийн хорт утаа ялгаруулалт эсвэл бохирдлын хяналт, яндангийн системийг дагтаршуулснаас үүсэх агаарын бохирдол.</p> <p>(6) Ажилчид, хөршүүдэд нөлөөлөх дуу чимээ.</p> <p>(7) Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл</p> | <p><u>Усны чанар</u></p> <p>1. Засварын цехийн ойролцоо байрлах ус зайлуулах хоолойг тогтмол шалгаж цэвэрлэн, хог хаягдалгүй цэвэр байлгах.</p> <p>2. Засварын цехийн шалыг усаар шүршихийн оронд зүлгэж угаах.</p> <p>3. Зам эсвэл гаднын талбайг усаар шүршихээс зайлсхийх</p> <p>4. Асгарсан шингэнийг арчиж цэвэрлэх хэрэгслийг шингэн асгарч болзошгүй хэсэгт хадгалж, бүх ажилчдыг тухайн хэрэгслийг хэрхэн ашиглахад сургах</p> <p>5. Байшин барилга, тоног төхөөрөмжийг цэвэр хадгалж, сайтар тордох.</p> <p><u>Аюултай бодис ба шингэн хаягдал</u></p> <p>1. Тос, химийн бодис, будаг, уусгагч бодисуудыг асгарсан ч хүрээлэн буй орчин тойронд урсаж тархахгүй газарт хадгалах:</p> <p>а. Цехийн эргэн тойрон босоо хаалттай хэсэг дотор</p> <p>б. Битүү орчинд ирмэгээрээ хаалттай тавиур, дэвсгэр ханзан дээр</p> <p>с. Химийн бодис хадгалах агуулахын хэсэгт</p> <p>2. Савнаас гоожиж шүүрээгүй болохыг тогтмол шалгах</p> <p>3. Хашаа хаалттай газарт цугларсан шингэнийг цэвэрлэж, тос, усыг ялгагч хэсэгт угаах</p> <p>4. Ус зайлуулах хоолой уруу химийн бодисыг огт зайлуулж хаяхгүй байх</p> <p>5. Хог хаягдлыг салхи хийсгэхээс урьдчилан сэргийлж хогийн савны тагийг тогтмол таглах эсвэл битүү газар хадгалах</p> <p>6. Ашигласан химийн бодис болон бусад шингэн хаягдлыг зайлуулах ажлыг шингэн хог хаягдлыг зайлуулах гэрээлэгч ажиллуулах замаар шийдвэрлэх. Тостой даавуу эсвэл шүүлтүүр</p> |

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | | |
|--|---|---|
| | | <p>гэх мэт шингэн хог хаягдлыг хогийн саванд хийхгүй байх.</p> <ol style="list-style-type: none">7. Хогийн савыг явган хүний зам эсвэл бусдын эзэмшлийн өмчид хадгалахаас зайлсхийх8. Боломжтой тохиолдолд хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах үйл ажиллагааг хялбарчлахын тулд ялгаж хаях <p><u>Агаарын чанар</u></p> <ol style="list-style-type: none">1. Ажилчид хөдөлгүүрийн боломжит хамгийн бага хугацаагаар ажиллуулж буй эсэхийг хянан баталгаажуулах2. Ууршилтыг бууруулахын тулд уусмал химийн бодисыг тагтай саванд хадгалах3. Агаар хөргөх төхөөрөмж буюу эйр-кондишний системээс гарах хөргөх бодисуудыг авч дахин ашиглах буюу тэдгээрийг хуулийн дагуу зайлуулж хаях. Ийм бодисуудыг агаар мандалд шууд чөлөөлж болохгүй.4. Тоормос цэвэрлэхдээ даралттай агаараар бус чийгтэй даавуу, утаагаар шүршигч эсвэл тоос сорогч ашиглах5. Тээврийн хэрэгслийн утаа ялгаруулах системийг огт өөрчилж эсвэл оролдож болохгүй <p><u>Дуу чимээ</u></p> <ol style="list-style-type: none">1. Дуу чимээг хязгаарлахын тулд бүх ажлыг цехэд хийж гүйцэтгэх2. Хийн (агаарын) компрессор гэх мэт тоног төхөөрөмжийг тордож дуу чимээ гаргахаас урьдчилан сэргийлэх3. Тээврийн хэрэгслийг дуу чимээ ихтэй болгон өөрчлөхгүй байх4. Дуу чимээ ихтэй тоног төхөөрөмжийг хаалга, цонхноос хол байрлуулах |
| <p>Хүнсний бүтээгдэхүүн эсвэл ундааны үйлдвэрлэл;</p> | <p>Хоол боловсруулалтаас үүсэх эрсдэл</p> <ul style="list-style-type: none">• Амархан мууддаг орц материалыг (ялангуяа мах, тахиа шувууны мах, загас) | <ol style="list-style-type: none">1. Ажлын орчныг цэвэр байлгах2. Цаг ямагт гар болон багаж хэрэгслийг угаах3. Зөвхөн цэвэр ус ашиглах4. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх |

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСӨЛ
(ОБҮДХЭТ) P174116**

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

| | | |
|---|---|--|
| Хүнс ба ундааны үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа | сэрүүн шинээр нь хадгалаагүй | |
| | <ul style="list-style-type: none"> Эрүүл ахуйн үндсэн суурь практикийг биелүүлээгүй (гараа угаах, багаж хэрэгслийг цэвэрлэх, цэвэр ус) | |
| | Машины ашиглалтаас үүсэх эрсдэл <ul style="list-style-type: none"> Осол Шүүрэл, хаягдал, шингэн хог эсвэл хаягдал бохир ус/гол/горхи/цөөрөм/хөрсөнд урсан орох | <ol style="list-style-type: none"> Машиныг аюулгүй газарт байрлуулж, аюултай хөдөлгүүрт хэсгүүдийг бүтээж байх Засвар үйлчилгээний дэглэм баримталж, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрт хэсгүүдийг засаж сэлбэх, тослох үйл ажиллагааг зааврын дагуу ягштал хийж гүйцэтгэх Машиныг ямагт цэвэр, сайн ажиллагаатай байлгах Зөвхөн туршлагатай ажилчдыг ажиллуулах Хамгаалалтын шил, бээлий, маскаар хангаж, ашиглах Төмрийн хог/хаягдлыг дахин ашиглах Шингэн хаягдлын шүүрэл, урсалтыг зогсоох Ослын үед хэрэгжүүлэх эрсдэлийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах Гал унтраах хэрэгсэл, эмнэлгийн анхан шатны туслалцаа үзүүлэх хэрэгсэлтэй байх |
| | <ul style="list-style-type: none"> Түлшний шаталтын улмаас хорт утаа ялгаруулах | <ul style="list-style-type: none"> 10-15 фитээс багагүй өндөртэй яндар суурилуулах |
| | <ul style="list-style-type: none"> Боловсруулалтын явцад гарах хаягдал бохир ус органик хэт ачааллыг бий болгох | <ul style="list-style-type: none"> Хог хаягдлыг бордооны зориулалттай эсвэл амьтан/шувууны хоол, загасны хоолны зориулалтаар ашиглах гэж ангилах нь зүйтэй. |
| | <ul style="list-style-type: none"> Хатуу хог хаягдлын хэмжээ хязгаарлагдмал болох | <ul style="list-style-type: none"> Хог хаягдлыг зохих ёсоор цуглуулж, зайлуулах |
| | <ul style="list-style-type: none"> Ялангуяа зуны улиралд халуунд урт цагаар ажилласны улмаас ажилчдын эрүүл мэндэд аюул учруулах магадлалтай | <ul style="list-style-type: none"> Зохистой хөргөх төхөөрөмж-эйр кондишн ашиглах замаар хэмийн хяналтыг хангах |
| | <ul style="list-style-type: none"> Халдварт өвчинтэй ажилчин/албан хаагчид хоол хүнсэнд халдвар тараах | <ul style="list-style-type: none"> Ажилчин/албан хаагчдыг тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулах нь зүйтэй. |

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ (БОНУХ)

Хавсралт 7

Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)

Шинэчилсэн: 2020 оны 11 сарын 06

1. Удиртгал

Бусад олон орны нэгэн адил Монгол улс КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл, хөдөлмөр эрхлэлтийн сорилтуудтай тулгараад байна. 2019 оны 12-р сард Хятад улсын Хубэй мужийн Вухан хотод КОВИД-19 вирусын анхны тохиолдол оношлогдсоноос хойш дэлхий даяар хурдацтай тархаж байна.

Монгол Улс нь БНХАУ-ын эдийн засаг, ялангуяа худалдаа, аялал жуулчлал, гадаадын хөрөнгө оруулалттай илүү ойр, уялдаатай улс орны хувьд КОВИД-19 цар тахал эдийн засагт нь хамгийн хурдан нөлөөлж буй орнуудын нэг билээ. 2020 оны 1-р сарын сүүл үеэс эхлэн засгийн газрын зүгээс КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хатуу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Дэлхийн олон улсыг хамарсан өнөөгийн хямралт байдлын улмаас хөрөнгийн урсгал хумигдаж, түүхий эдийн үнэ буурч, Монгол улсын экспорт болон аялал жуулчлалын эрэлт буурч байна. Монгол улсын статистикийн хорооны мэдээлснээр 2019 оны эхний улиралд, эрдэс баялгийн салбарын орлого 33.8 хувиар, улсын нийт орлого 8 хувиар буурсан. Монгол Банк 2020 оны эхний хагаст эдийн засаг хумигдаж, хоёрдугаар хагаст өсөлт 1.8 хувь орчим байна гэж тооцоолжээ. Дэлхийн эдийн засгийн хямрал гүнзгийрэх хирээр Монгол улсын эдийн засгийн байдал хурцдахаар байна.

КОВИД-19 цар тахлаас шалтгаалан эдийн засгийн нөхцөл байдал муудаж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж эхэллээ. 2018 онд нийт хөдөлмөр эрхлэгчдийн 12 хувийг эзэлж байсан уул уурхай, тээврийн салбарууд COVID-19 цохилт эхлэх үеэс бууралт эхэлсэн. Харин 2018 оны ажил эрхлэлтийн 23 хувийг эзэлж байсан аж үйлдвэрийн салбарын хувьд эхний улиралд агшиж эхэлжээ. Одоогийн болон ирээдүйн хязгаарлалтын арга хэмжээ нь 2018 онд ажил эрхлэлтийн 53 хувийг эзэлж буй үйлчилгээний салбарыг илүү багасгаж дотоодын пүүсүүдэд улам их дарамт үзүүлэх болно. Эдийн засгийн нөхцөл байдал сулрахын хэрээр хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал дордож, улмаар ажлын байр цөөрөх, олон ажилчид цомхотголд орох, цалин буурах зэрэг үзэгдэл нэмэгдэх хандлагатай байна.

Эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэхийн хэрээр зарим бүлэгт ирэх цохилт хүндрэхээр байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, түр гэрээт ажилчид болон албан бусаар хөдөлмөр эрхлэгчид эдийн засгийн энэхүү цочролыг даван туулах арга хэрэгсэл, боломж багатай тул цочрол тэдэнд хамгийн хүндээр тусах магадлалтай. Эрүүл мэндийн эрсдэл багасгаж, бизнес болон хөл хөдөлгөөний хязгаарлалтууд суларсны дараа ч цар тахлын нөлөөнд өртсөн ажилчид, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа сэргээж, хэвийн байдалдаа эргэж ороход илүү урт хугацаа шаардагдана. Иймд эдгээр бизнес эрхлэгчдэд болон тэдний ажилчдад яаралтай дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Үр дүнтэй, цагаа олсон дэмжлэг үзүүлснээр хямралын илүү хүнд сорилттой тулгарахаас сэргийлж чадна.

Монгол Улсын Засгийн газраас КОВИД-19- цар тахлын эдийн засаг дахь сөрөг үр нөлөөг бууруулахын тулд төсвийн болон мөнгөний бодлогын хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Аж ахуйн нэгж, ажиллагсдыг яаралтай дэмжих хэрэгцээ шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын зүгээс эдийн засгийг идэвхжүүлэх 1.8 тэрбум ам. доллар (ДНБ-ий 13%) орчим өртөг бүхий багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр зарлаж, 2020 оны 4 дүгээр сарын 9-нд Улсын Их Хурлаас холбогдох хууль тогтоомжийг баталсан билээ. Энэ багц арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх (төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд хамаарахгүй), аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх (зөвхөн жижиг, дунд бизнесүүд), нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх (хүүхэд болон ажилгүй болох эрсдэлтэй ажиллагсдад дэмжлэг үзүүлэх), ноолуурын компаниуд болон жижиг дунд бизнесүүдэд малчдаас ноолуур худалдаж авахад зориулсан хөнгөлөлтэй зээлийн эх үүсвэр гаргах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

КОВИД-19 цар тахлын хямралт байдлаас гарах, эдийн засгийг сэргээхэд Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь (НДТ) бодлогын хүчтэй хэрэгсэл болох юм. Монгол Улсад нийгмийн даатгалын нэлээд өндөр, 2018 оны байдлаар нийт ажиллах хүчний 81.3 хувь нь хамрагдсан байна.¹ Эрүүл мэндийн даатгалыг оруулахгүй бусад даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь сайн дурын даатгуулагчдын хувьд сарын орлогын 13.5 хувьтай тэнцэж байгаа бол албан журмын нийгмийн даатгалд даатгуулагч болон ажил олгогчийн төлж буй шимтгэлийн хэмжээ нь нийлээд ажилтны цалин орлогын 22 хувьтай тэнцэж байна. Даатгуулсан иргэд нь өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдалтын болон өвчний, мөн ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсдэг. Нийгмийн Даатгалын Сан (НДС)-д нийгмийн даатгалын шимтгэл цуглуулах, сангаас холбогдох тэтгэвэр тэтгэмж тавих асуудлыг НХХЯ-ны харьяа Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар (НДЕГ) хариуцдаг. Өнөөгийн нөхцөл байдал шиг гэнэтийн хямралын үед ажилчид болон ажил олгогчдын хувьд нийгмийн даатгалын шимтгэл үргэлжлүүлэн төлөхөд санхүүгийн бэрхшээл тулгардаг. Ажил олгогчид ажиллагсдынхаа цалин хөлсний 13 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл төлж байна. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлж байгаа, эдийн засаг суларч байгаа энэ цаг хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг үргэлжлүүлэн төлөх шаардлагын улмаас аж ахуйн нэгжүүд ажилчдаа цомхотгох болон цаашлаад бизнесээ хаахад ч хүргэж болзошгүй юм. Бизнесээ түр хугацаагаар зогсоох нь ч тэдэнд зардал ихтэй тусдаг. Учир нь бизнесийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлээ сэргээж хэвийн түвшинд хүргэхийн тулд шинэ ажилчид авч сургах шаардлагатай болно. Ажиллагсад болон ажил олгогчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх арга хэмжээ нь бизнесийн үйл ажиллагаанд тавигдсан хязгаарлалтуудыг зогсоосны дараа бизнесээ хурдан сэргээж, хямралт байдлыг даван туулахад нь туслах юм.

Дээрх хэрэгцээ шаардлагыг харгалзан, Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих багц арга хэмжээнд аж ахуйн нэгж болон ажиллагсдыг нийгмийн даатгалын шимтгэлээс тодорхой хугацаанд чөлөөлөх арга хэмжээ чухлаар туссан хэдий ч хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээл тулгараад байна. Монгол Улсын Их Хурал 2020 оны 4-р сарын 9-нд “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль” баталснаар сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан бүх даатгуулагчид, болон корона вируст халдварын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого

¹ Монгол улсад нийгмийн даатгал нь тэтгэвэр, тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, ажилгүйдлийн даатгалаас бүрдэнэ. Онцгой байдлын үеийн дэмжлэг нь эрүүл мэндийн даатгалд хамаарахгүй.

нь буурсан боловч ажлын байрыг хадгалсан, хуульд заасан тодорхой шалгуурыг хангасан аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн ажиллагсдыг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлсөн. Энэ арга хэмжээнд төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагчид болон төрийн өмчит хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчид хамрагдахгүй юм. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх энэ арга хэмжээнд сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан нийт 120 мянга орчим даатгуулагчид, албан журмын нийгмийн даатгалд хамрагдсан 540 мянга орчим даатгуулагчид хамрагдах тооцоотой байна. Энэ арга хэмжээний өртөг нь ойролцоогоор 228 сая ам.доллар (буюу ДНБ-ий 1.6%) болох бөгөөд арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд Засгийн газарт санхүүгийн бэрхшээл тулгарч байна.

Төслийн танилцуулга

Төслийн хөгжлийн зорилго нь Монгол Улсын ажил хайгч иргэд болон бичил бизнес эрхлэгчид хөдөлмөрийн зах зээл дэх боломжуудыг илүү хүртээмжтэй ашиглах нөхцөлийг сайжруулж, КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд шаардлага хангасан ажиллагсдад түр хугацааны дэмжлэг үзүүлэх явдал юм.

ОБҮДХЭТ нь дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Үйлчлүүлэгч-төвтэй төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих

Энэ бүрэлдэхүүн хэсэг нь үйлчлүүлэгч төвтэй төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжсэнээр, мэдээллийн хомс байдал болон хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдлын хязгаарлагдмал байдлаас үүдэн ажил хайхад тулгардаг хүндрэлүүдийг шийдвэрлэнэ. Хямралтай цаг үед олон ажил хайгчид цөөн тооны ажлын байранд өрсөлдөж, ажил олгогчид ажилтан шалгаруулж авахад төдийлөн хөрөнгө зарцуулах боломжгүй нөхцөлд ажлын байрны мэдээллийн ач холбогдол улам чухал болдог. Тус бүрэлдэхүүн хэсгийн гол зарчим нь ажил мэргэжлийн зөвлөхүүд үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг илүү хөгжүүлэх, өөрөөр хэлбэл ажил хайгчид болон ажил олгогчдын хэрэгцээнд төвлөрч, ажил хайгчдын хувьд хамгийн тохиромжтой ажлын байр болон боломжуудыг олж өгөх, ажил олгогчдод чадварлаг ажилчдыг олж авахад нь дэмжлэг үзүүлэх явдал юм.

Одоо хэрэгжиж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (ХЭДТ) нь үйлчлүүлэгч төвтэй төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлд чухал алхмуудыг хийсэн. Үүнд: (а) төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хэв маяг, стандарт, ажиллагаа, гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх; (b) холбогдох албан тушаалтнуудыг олон улсын форум, уулзалтад оролцуулах, олон улсын шилдэг туршлагатай танилцуулах зэрэгт тогтолцооны чадавх бэхжүүлэх ажлыг системтэй хийх; (c) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг хөгжүүлж, төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлснээр ажил мэргэжлийн зөвлөхүүдэд ажил олоход хүндрэлтэй иргэдэд илүү төвлөрч ажиллах боломж олгох зэрэг багтана. Мөн Бүгд Найрамдах Солонгос улсын хөгжлийн тусламжийн хүрээнд мэдээлэл харилцааны технологид суурилсан ажилд зуучлалын платформыг боловсруулж нэвтрүүлж, ажилд зуучлалын цахим, мобайл хэлбэрийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм. ХЭДТ-ийн хүрээнд сонгогдсон 14 хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн 8-д нь дотоод заслын ажил хийж, үйлчилгээг харилцагчдад илүү ээлтэй, ойр болгох ажлыг хийсэн.

Энэхүү шинэ төслийн тус бүрэлдэхүүн хэсэг нь дээрх санал санаачлагыг хоёр түвшинд үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Нэгдүгээрт, зарим хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн үйлчилгээний орчныг сайжруулан шинэ шатанд гаргахад дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (a) төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хийсэн үнэлгээний зөвлөмжүүдэд үндэслэн үйлчилгээний зохистой зохион байгуулалтыг туршиж, нэвтрүүлэх; (b) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем (ХЭДТ-ийн хүрээнд хөгжүүлэх) болон мэдээлэл харилцааны технологид суурилсан ажилд зуучлалын платформыг (Солонгос улсын хөгжлийн тусламжийн хүрээнд хөгжүүлэх) харилцан уялдаатай, нэгдсэн зохион байгуулалттай туршиж, ашиглах; (c) ХХҮЕГ-т сайжруулсан Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг байршуулах нөхцлийг сайжруулах засварын ажил хийх, хөдөлмөрийн үйлчилгээний сайжруулсан зохион байгуулалт болон сургалт явуулах орчин нөхцлийг сайжруулах; мөн (d) техникийн туслалцаа, ажилтнуудын сургалтаар дамжуулан төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавх бэхжүүлэх. Хоёрдугаарт, хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий тогтолцоог дэмжих нэмэлт арга хэмжээгээр дамжуулан төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон хувийн биржүүдийн түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар үйлчилгээний үр ашиг, хамрагдалтыг нэмэгдүүлнэ. Үүнд: (a) хувийн хөдөлмөрийн биржүүдийн үйлчилгээний стандарт, үйл явц болон гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх; (b) сул ажлын байрны мэдээлэл хуваалцах болон бусад арга хэмжээнүүдээр дамжуулан төрийн болон хувийн хөдөлмөрийн биржүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах; and (c) хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн үйлчилгээг таниулан сурталчлах зорилгоор олон нийтэд хүргэх мэдээлэл сурталчилгааны арга хэмжээ авах зэрэг орно.

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд хувийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд үнэлгээ хийх, ажлын зохион байгуулалт, шинэлэг үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, ХХҮЕГ-ын засварын ажил болон тавилга, мэдээлэл сурталчилгааны материал, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, жижиг хэмжээтэй дотоод засал, мэдээлэл сурталчилгааны компанит ажил, сургалт, чадавх бэхжүүлэх зэрэг үйл ажиллагаануудад дэмжлэг үзүүлэх зөвлөмжүүдийг ажиллуулна. Ялангуяа бүрэн бус мэдээлэлтэй, хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдал муу, хөгжиж буй эдийн засагтай оронд эдгээр бүх үйл ажиллагааг олон улсын сайн туршлагад үндэслэсэн, хүний нөөц, танхим, технологийн хөрөнгө оруулалт хийхдээ хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих нь чухал юм.

Бүрэлдхүүн хэсэг 2. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх

Энэ бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэнд нийцсэн байдлыг бэхжүүлнэ. Олон улсын шилдэг туршлага, ХЭДТ-ийн хэрэгжилтээс авсан сургамжид үндэслэн зах зээл дэх зарим техникийн болон нийгэм сэтгэл зүйн ур чадварын хомсдол болон ялангуяа КОВИД-19-ын хямралт байдлаас шалтгаалан ажиллах хүчний эрэлт буурч байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлнэ. Тус бүрэлдхүүн хэсэгт хоёр дэд хэсэгтэй.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.1 Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих

Энэ дэд бүрэлдэхүүн хэсэг нь цаашид тогтвортой үргэлжлэх бичил бизнесийг эхлүүлэх, өргөжүүлэх шинэ боломжуудыг дэмжих зорилгоор санхүүгийн болон санхүүгийн бус цогц дэмжлэг үзүүлнэ.² Энэ дэд бүрэлдэхүүн хэсэг нь цаашид тогтвортой үргэлжлэх бичил бизнесийг эхлүүлэх, өргөжүүлэх шинэ боломжуудыг дэмжих зорилгоор санхүүгийн болон санхүүгийн бус цогц дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх хоёр чухал саад бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэнэ. Нэгдүгээрт, КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хямралын эдийн засгийн сөрөг нөлөөнд автах магадлал өндөртэй бичил бизнес эрхлэгчид болон хөдөлмөрийн зах зээл дэх ирээдүйн боломжууд нь ихээхэн бүрхэг байгаа шинээр бичил бизнес эрхлэх хүмүүст дэмжлэг үзүүлнэ. Хоёрдугаарт, ажиллах хүчний эрэлт бага, мөн бичил бизнесийн салбарын хөгжил удаашралтай байгаа гэх мэт хөдөлмөрийн зах зээл дэх ужиг хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулна. Сургалт болон санхүүжилт, бусад дэмжлэгийг цогц байдлаар үзүүлэх нь (ялангуяа эмэгтэй бичил бизнес эрхлэгчдэд) илүү үр дүнтэй болохыг нотолсон олон улсын туршлагад үндэслэн, хэд хэдэн төрлийн санхүүгийн бус дэмжлэг болон боломжийн нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг хамтад нь үзүүлэх юм. Ийм цогц байдал нь Монгол Улсад одоо хэрэгжүүлж байгаа бичил бизнесийн дэмжлэгээс гол ялгагдах шинж чанар болно. Дэд бүрэлдэхүүн хэсэг дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ: (i) үр шим хүртэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн уян хатан нөхцлөөр зохион байгуулагдах санхүүгийн бус дэмжлэг буюу бизнесийн ур чадвар олгох болон бизнес хөгжлийн сургалт, тусгай сургалтын модулиуд, зөвлөн туслах үйлчилгээ, бие биенээсээ харилцан суралцах төгсөгчдийн сүлжээ, мөн зах зээлд холбох дэмжлэг зэрэг үйлчилгээ үзүүлэх; (ii) шинээр эхлэх болон үйл ажиллагаа явуулж байгаа бичил бизнес эрхлэгчдэд бичил зээлийн дэмжлэг олгох, КОВИД-19 цар тахлын хямралын үед зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх². Тус дэд бүрэлдэхүүн хэсэг нь ХЭДТ-ийн нэг адилаар ХНХЯ-ны ажилтнууд болон сургалтын байгууллагуудын чадавх бэхжүүлэх, зорилтот бүлэг болон олон нийтэд тухайлан мэдээлэл хүргэх арга хэмжээ зохион байгуулах, үр шим хүртэгчдийг сонгон шалгаруулах, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг техник туслалцааны дэмжлэг мөн үзүүлнэ. Бичил бизнес эрхлэгчдэд бичил зээл олгох үйл ажиллагааг арилжааны банкнуудаар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд санхүүгийн зуучлалын үйлчилгээний талаарх Дэлхийн банкны холбогдох бодлогыг баримтална.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.2: Ур чадварын шинэчлэл хөтөлбөр

Энэ дэд бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй ур чадварыг хөгжүүлэх зорилготой хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрийг шинэлэг, уян хатан байдлаар туршин хэрэгжүүлэх боломжийг ХНХЯ-нд олгоно. Турших шинэлэг хөтөлбөрийг Дэлхийн банктэй зөвшилцөж сонгох бөгөөд (a) хөдөлмөр эрхлэлтэд сайнаар нөлөөлдөг болох нь олон улсад туршлагад нотлогдсон байх; (b) одоо байгаа хөтөлбөрүүдээс ялгарсан шинэлэг байх; (c) орон нутгийн нөхцөлд туршин хэрэгжүүлэх боломжтой байх; (d) санамсаргүй хяналтын үр нөлөөний үнэлгээний аргачлалыг ашиглан үнэлгээ хийгдэх; (e) төсөл дууссаны дараа ХНХЯ хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн нэг болгон хэрэгжүүлэх хөтөлбөр байх юм. Энэхүү дэд бүрэлдэхүүн хэсгийг ТХН шууд

² According to the Employment Promotion Law, microenterprises can have invested capital and annual sales of up to MNT 50 million (US\$18,000 at current exchange rates). Most beneficiaries are expected to run much smaller microenterprises.

хариуцан хэрэгжүүлэх бөгөөд ирээдүйд хэрэгжүүлж болох хөтөлбөрийн шинэлэг санааг баталгаажуулах юм.

3. Хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээ ба төслийн удирдлагад дэмжлэг үзүүлэх:

Бүрэлдэхүүн хэсэг 3 нь байгууллагын болон хувь хэрэглэгчдийн ашиглах хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулж, мэдээлэлд үндэслэн зөв шийдвэр гаргахад нь тусална. Үүний зэрэгцээ хяналт-шинжилгээ үнэлгээ, төслийн удирдлагад дэмжлэг үзүүлэх бөгөөд хоёр дэд бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

бүрэлдэхүүн хэсэг 3.1: Хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээ

Хөдөлмөрийн зах зээлийн илүү хүртээмжтэй, цогц мэдээлэл нь мэдээллийн хомс байдлаас үүдэлтэй ажил хайлтын асуудлуудыг шийдвэрлэх, ажил мэргэжлийн сонголт хийж байгаа ажил хайгчид болон оюутнуудыг ажил хайх болон ур чадвараа сайжруулахад чиглүүлэх, бодлого боловсруулагч нарт боловсролын болон хөдөлмөрийн бодлого, хөтөлбөрүүдийг нотолгоонд суурилан шинэчлэн өөрчлөхөд тусалдаг. Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.1 нь ХЭДТ-ийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудыг үргэлжлүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүрээ, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. ХЭДТ-тэй уялдаатайгаар, хөдөлмөрийн зах зээлийн дараах мониторинг, дүн шинжилгээг хийнэ: (а) дэд бүрэлдэхүүн хэсэг 2.2-ийн хүрээнд хэрэгжүүлсэн хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээ; (b) ХЭДТ-ийн хүрээнд эхлүүлсэн ажилгүйдлийн судалгааг дуусгана.³ Энэ дэд бүрэлдэхүүн хэсэг нь үр нөлөөний үнэлгээ хийх зөвлөхийн үйлчилгээ болон ажилгүйдлийн судалгааны тайлан боловсруулах, түгээх үйл ажиллагаа болон үр нөлөөний судалгааны хүрээнд талбар дээр хийгдэх ажлуудыг санхүүжүүлнэ.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.2: Төслийн удирдлага ба мониторинг

Энэ дэд бүрэлдэхүүн хэсэг нь ХНХЯ-нд төслийн өдөр тутмын хэрэгжилт ба үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж, төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцах Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Үүнд хяналт-шинжилгээ үнэлгээний үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг, ТХН-ийн зохицуулалт, төслийн удирдлагын үйл ажиллагааны санхүүжилт багтана.

Бүрэлдэхүүн хэсэг 4. КОВИД-19 цар тахлын үүдэлтэй хямралын хариу арга хэмжээний хүрээнд шаардлага хангасан ажиллагсдад түр хугацааны дэмжлэг үзүүлэх

Энэ бүрэлдэхүүн хэсэг нь КОВИД-19 цар тахлын үүдэлтэй хямралын хариу арга хэмжээ болгож, хуульд заасан шаардлага хангасан аж ахуйн нэгжүүд, тэдний ажиллагсдад түр хугацааны дэмжлэг үзүүлнэ. Хямралын энэ цаг үед сар тутам нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг хариуцлага нь ажил олгогч ба даатгуулагчдын хувьд тодорхой хэмжээний санхүүгийн ачаалал үүсгэж, энэ нь

³ ХЭДТ-ийн хүрээнд ХНХЯ ажилгүйдлийн судалгаа хийхээр сонгосон бөгөөд КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хямралын энэ цаг үед энэхүү судалгааны сэдвийн ач холбогдол улам нэмэгдлээ. Жилийн турш хийгддэг Ажиллах хүчний судалгааны асуулганд шинэ модул нэмэх арга замаар судалгааг зохион байгуулсан. ХЭДТ-ийн хүрээнд судалгааны дизайн хийх зөвлөх үйлчилгээ болон судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг санхүүжүүлсэн бол энэхүү төслийн хүрээнд дээрх судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээг санхүүжүүлэх юм.

цаашлаад ажлын байрыг цомхотгох, бизнесийн үйл ажиллагаа хаагдах эрсдэлд шууд бусаар нөлөөлж болох юм. Монгол Улсын Их Хурлаас нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмаар болон сайн дурын үндсэн дээр төлдөг, шаардлага хангасан аж ахуйн нэгжүүд, тэдний ажиллагсдыг нийгмийн даатгалын шимтгэлээс түр хугацаанд чөлөөлөх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх энэ арга хэмжээ нь холбогдох тэтгэвэр тэтгэмжийг байнга төлж байх ёстой байдаг Нийгмийн даатгалын сан (НДС)-гийн санхүүгийн байдалд нөлөөлнө. Тиймээс тус бүрэлдэхүүн хэсгийн хүрэнд НДС-нд хөрөнгө шилжүүлэх нь хямралын үед тус сангаас ажилгүйдлийн тэтгэмж гэх мэт богино хугацааны тэтгэмжүүдийг цагт хугацаанд нь олгох боломжийг нэмэгдүүлж, сангийн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулах юм. Энэ бүрэлдэхүүн хэсэг нийгмийн даатгалын шимтгэл албан журмаар төлдөг, хуульд заасан шаардлага хангасан аж ахуйн нэгжүүд болон тэдний ажиллагсдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх арга хэмжээг дэмжинэ. ХЭДТ-ийн хүрээнд мөн сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдыг шимтгэлээс чөлөөлөх арга хэмжээг мөн дэмжиж байгаа юм.

Шимтгэлээс чөлөөлөгдөх аж ахуйн нэгж буюу ажил олгогчдын шалгуурыг “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх”⁴ тухай хуулиар тодорхойлж, хэрэгжилтийн зохицуулалтуудыг засгийн газрын холбогдох журмаар зохицуулсан.⁵ Төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагчид, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчид үүнд хамаарахгүй. Шаардлага хангасан ажил олгогчид гэдэгт дээрх хууль, журамд тодорхойлсны дагуу КОВИД-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байраа хадгалсан, шимтгэлээс чөлөөлөгдөх арга хэмжээнд хамрагдах нөхцөл хангагдсан болохыг нь НДЕГ болон түүний аймаг, дүүргийн салбар байгууллагууд хянан тогтоосон аж ахуйн нэгжүүдийг хэлнэ. Хуулийн хүрээнд 6 сарын хугацаанд шимтгэлээс чөлөөлөгдөх үр шим хүртэгчдийг хамруулахад төслийн хөрөнгө хүрэлцэхгүй тул, нэг сарын хугацаанд аль болох олон үр шим хүртэгчдийг дэмжинэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үр шим хүртэгчид нь орон нутгийн ядуурлын түвшин, нийт шимтгэлийн хэмжээ, хамрагдах хүний тоо ба төслийн төсөв зэргийг харгалзан сонгох аймаг, дүүргийн ажил олгогч болон даатгуулагчид байна.

Төслийг Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээний (БОНХ) бодлогод нийцүүлэн боловсруулсан. Талуудын оролцоог хангах болон мэдээллийг ил болгох тухай Байгаль орчин, нийгмийн нөлөөний стандарт БОНС 10-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь оролцогч талуудыг цаг тухайд нь, хамааралтай, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллээр хангаж, тэдний соёл зан заншлын онцлогт зохистой байдлаар, аливаа булхай, хөндлөнгийн оролцоо, албадлага, ялгаварлан гадуурхалт, айлган сүрдүүлэгээс ангид харилцан зөвлөлдөх ёстой.

2. Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)

Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний үндсэн зорилго нь төсөл хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид олон нийтэд нээлттэй мэдээлэх, олон нийттэй

⁴ <https://www.legalinfo.mn/law/details/15244?lawid=15244>

⁵ <https://www.legalinfo.mn/law/details/15274>

зөвлөлдөх зэргээр талуудын оролцоог хангах явдал юм. ТОХТ нь төслийн баг талуудтай хэрхэн харилцах арга замыг нарийвчлан тодорхойлох бөгөөд иргэд төсөл болон төслийн аливаа үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдол гаргах механизмыг тусгана. Төслийн ажилтнууд болон нутгийн иргэд хоорондын харилцан уялдаатай хамтын ажиллагааг хангах, төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдлийг бууруулахын тулд төслийн хэрэгжилтэнд орон нутгийн иргэдийг оролцуулах нь зайлшгүй чухал юм. Ялангуяа халдварт өвчний тархалтын нөхцөл байдалд халдварт өвчинтэй холбоотой аливаа эрсдлийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг өргөн цар хүрээнд, нутгийн иргэдийн зан заншил, соёлд нийцтэй байдлаар зохион байгуулах, олон нийтэд зөвөөр ойлгуулах нь онцгой ач холбогдолтой.

2.1. Оролцогч талуудыг тодорхойлж, шинжлэх

Төслийн оролцогч талууд гэдэгт:

- (i) Төслийн үйл ажиллагаанаас шууд болон шууд бус хэлбэрээр, эерэг болон сөрөг нөлөөлөлд өртсөн эсвэл өртөх магадлалтай (“нөлөөлөлд өртсөн тал”);
- (ii) Төслийг сонирхож буй буюу төслийн үйл ажиллагааны улмаас ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй, эсвэл Төсийн үр дүнд ямар нэг байдлаар нөлөөлөх боломжтой (“сонирхогч талууд”) хувь хүн, бүлэг хүмүүс, бусад этгээдийг багтаан ойлгоно.

Төсөл боловсруулах шатанд оролцогч талуудтай ойлголцох, хамтран ажиллахын тулд тухайн оролцогч тал болох бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх нөлөө бүхий хүмүүсийг тодорхойлох, өөрөөр хэлбэл төсөлтэй хамтрах ажиллах явцад тухайн бүлгийн эрх ашгийг хамгаалж чадах, бүлгийн гишүүдийн итгэл дэмжлэгийг хүлээсэн итгэмжит хүмүүсийг олж тодорхойлох нь чухал. Олон нийтийн төлөөлөл нь тухайн орон нутгийн нөхцөл байдлыг илүү сайн ойлгоход туслах бөгөөд төсөлтэй холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх, төсөл орон нутгийн зорилтот бүлэг, олон нийт, тэдгээрийн тогтсон сүлжээтэй уялдаа холбоотой ажиллах, харилцах үндсэн суваг болно. Оролцогч талуудын төлөөллийг баталгаажуулах (тухайн хүмүүс нь төлөөлж буй олон нийт, бүлгийн эрх ашгийг хамгаалж, төлөөлж чадах эсэхийг баталгаажуулах үйл явц) нь олон нийтийн оролцогч талуудтай харилцаа холбоо тогтооход чухал үүрэгтэй байна. Үүний тулд тухайн олон нийтийн гишүүдээс санамсаргүй байдлаар сонгож албан бус яриа өрнүүлэх ба ингэхдээ тэдний эрх ашгийг хэн хамгийн сайн хамгаалж, тэднийг төлөөлж чадахыг асууж болно. КОВИД-19 цар тахлын улмаас олон нийтийн цугларалтыг хязгаарласан эсвэл хориглосон үед оролцогч талыг тодорхойлох үйл явц нь хувь хүмүүстэй илүү харилцах, нөлөөлөлд өртсөн иргэдтэй төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан харилцах шаардлагатай болж байна.

2.1.1. Аргачлал

Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд төсөл нь оролцогч талуудын оролцоог хангахад дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- *Төсөл хэрэгжүүлэх үе шатанд нээлттэй байдлыг хангах:* төсөл хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид төслийн талаар олон нийтийн зөвлөлдөөн, хэлэлцүүлгийг нээлттэй, аливаа булхай, хөндлөнгийн оролцоо, дарамт шахалт, албадлага эсвэл айлган сүрдүүлэлтээс ангид зохион байгуулна.

- *Мэдээлэлд суурилсан оролцоог хангаж, эргэх холбоо үүсгэх:* мэдээллийг зохих загвар, форматын дагуу бүх оролцогч талуудад өргөн цар хүрээтэй түгээнэ; оролцогч талуудын аливаа санал, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэрлэхэд туслах зорилгоор байр сууриа илэрхийлэх боломжийг олгоно.
- *Тэгш оролцуулах ба мэдрэмжтэй хандах:* Мэдээлэл солилцох болон хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд төслийн үйл ажиллагаанд талуудын оролцоог тэгш хангах зарчмыг баримтална. Бүх оролцогч талууд мэдээллийн хүртээмжийн тэгш эрхтэй байна. Оролцооны аргыг сонгохдоо оролцогч тал тус бүрийн тусгай хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй хандаж, тэдний оролцоог хангах зохистой арга замыг сонгоно. Эмзэг бүлгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, ажил олоход бэрхшээлтэй иргэд, коллеж, их дээд сургууль төгсөгчид, өндөр настан болон үндэсний цөөнхийн соёл, зан заншил зэрэгт онцгойлон анхаарч мэдрэмжтэй ажиллана.
- *Уян хатан байдал:* Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний хүрээнд зайнаас харьцах шаардлага тавигдаж байгаа нь оролцооны уламжлалт хэлбэрийг ашиглахад бэрхшэл учруулж байгаа бол интернетээр харилцах гэх мэт оролцооны өөр бусад арга хэлбэрийг ашиглах зэрэг уян хатан байдлаар ажиллана (3.2 хэсгийг харна уу).

Төслийн хэрэгжилтэд талуудын үр дүнтэй, бүтээлч оролцоог хангахын тулд төслийн оролцогч талуудыг дараах байдлаар бүлэглэн үзэж болох юм. Үүнд:

- **Нөлөөлөлд өртсөн тал** – Төслийн шууд нөлөөлөлд өртсөн (бодитой өртсөн эсвэл өртөж болзошгүй) эсвэл төсөлтэй холбоотой аливаа өөрчлөлтөд өртөх магадлалтай гэж тодорхойлогдсон бөгөөд төслийн аливаа нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох, бууруулах, удирдах арга хэмжээний талаар шийдвэр гаргахад нягт хамтран ажиллах шаардлагатай Төслийн нөлөөллийн бүсэд (ТНБ) байгаа хувь хүн, бүлэг хүмүүс болон бусад этгээд,
- **Бусад сонирхогч тал** – Төслийн шууд нөлөөлөлд ороогүй хэдий ч төсөл эрх ашгийг нь хөндсөн гэж үзэж буй эсвэл төсөл хэрэгжүүлэх үйл явцад тодорхой байдлаар нөлөөлж болзошгүй хувь хүн, бүлэг, этгээд;
- **Эмзэг бүлгүүд** – Бусад бүлэг хүмүүстэй харьцуулбал төслийн нөлөөлөлд илүү өртөх эсвэл цаашид ядуу эмзэг байдал нь нэмэгдэх магадлалтай иргэд 6 байх ба төсөлтэй холбоотой зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явцад тэдний тэгш оролцоог хангахын тулд тусгайлан хүчин чармайлт гаргах шаардлагатай.

2.1.2. Нөлөөлөлд өртсөн тал

Төслийн шууд нөлөөлөлд бодитой өртсөн эсвэл өртөж болзошгүй орон нутгийн иргэд, гишүүд болон бусад талууд багтана. Жишээлбэл:

1. Төслийн Удирдах Хороо
2. Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
3. Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний Ерөнхий Газар (ХХҮЕГ)
4. Бүх ажил хайж буй иргэд эсвэл бичил бизнес эрхлэгчид
5. Ажил олоход бэрхшээлтэй байгаа иргэд
6. 18-34 насны залуучууд
7. МСҮТ, коллеж, их дээд сургууль төгсөгчид
8. Ядуу өрх (ООТА-ын оноогоор хэмжсэн)
9. Эмэгтэйчүүд
10. Хөдөө орон нутгийн хоршоо, нөхөрлөлийн гишүүд
11. Иргэдийн бүлгүүд

12. Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчид
13. Хөдөлмөр, нийгмийн халамжийн газрууд
14. Мэргэжлийн сургалтын сургагч багш нар
15. Сонгон шалгаруулах хорооны гишүүд
16. Оролцогч санхүүгийн байгууллагууд (ОСБ)-ын ажилтнууд

2.1.2. Бусад сонирхогч тал

Төслийн шууд нөлөөлөлд өртсөн олон нийтээс гадна дор дурдсан этгээдийг төслийн оролцогч талд хамааруулна. Үүнд:

1. Шалгуурт тэнцсэн өргөдөл гаргагчийн гэр бүлийн гишүүд
2. Үйлчилгээ үзүүлэгчид болон борлуулагчид
3. Бодлого боловсруулагчид
4. Судалгааны хүрээлэн, олон улсын болон үндэсний зөвлөхүүд
5. Дотоодын болон олон улсын бусад байгууллагууд
6. Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээллийн компаниуд
7. Олон нийт

2.1.3. Эмзэг бүлгийн иргэд

Дуу хоолойгоо илэрхийлэх боломж хомс байдаг эмзэг бүлгийн иргэд, бүлгүүдэд төслийн үйл ажиллагаа ямар үр нөлөө үзүүлэхийг сайн ойлгох нь чухал ач холбогдолтой бөгөөд тэдний ойлголт, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайлбал, халдварт өвчин болон эмчилгээний талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулахдаа эмзэг бүлгийн иргэд, бүлгийн онцлог нөхцөл байдал, санаа зовнисон асуудлууд, соёл зан заншлын өвөрмөц онцлогийг харгалзан, зохистой арга замыг ашиглана. Эмзэг байдал нь хувь хүний угсаа гарал, хүйс, нас, эрүүл мэндийн байдал, эдийн засгийн хомсдолтой болон санхүүгийн гачигдалтай байдал, нийгэм олон нийтийн дундах байр суурь (жишээ нь үндэстний цөөнх, бусад онцлог бүлэг гэх мэт), бусад хүмүүс болон байгалийн баялгаас хараат байдал зэргээс улбаалсан байж болно. Төслийн талаар шийдвэр гаргахад эмзэг бүлгийн иргэд, бүлгийн оролцоог бусад оролцогч талуудтай ижил түвшинд хангахын тулд ялангуяа, зөвлөлдөх, хэлэлцэх бүхий л үйл явцад тэдний оролцоог хангахад зохистой арга хэрэгслийг тухайлан ашиглана.

Төслийн хүрээнд эмзэг бүлэгт дараахи хүмүүсийг хамруулж ойлгож болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

1. Ажил хайж буй иргэд болон бичил бизнес эрхлэгчид
2. Ажил олоход бэрхшээлтэй байгаа иргэд
3. 18-34 насны залуучууд
4. МСҮТ, коллеж, их дээд сургууль төгсөгчид
5. Ядуу өрх (ООТА-ын оноогоор хэмжсэн)
6. Эмэгтэйчүүд
7. Хөдөө орон нутгийн хоршоо, нөхөрлөлийн гишүүд, суурин газар амьдарч буй малчид
8. Үндэстний цөөнх
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)

Цаашид төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн эмзэг бүлгийн иргэдийг тодорхойлж, зохих арга хэрэгслийг ашиглан тэдэнтэй зөвлөлдөнө. Төслийн зүгээс ашиглах оролцооны аргачлалуудыг дараах хэсгүүдэд тусгасан болно.

БОНС7

Монгол Улсын нийт хүн амын 85 гаруй хувь нь халх Монгол үндэстэн бөгөөд үлдсэн хувь нь хэл, соёлын хувьд ялгаатай олон ястны иргэд байдаг. Хүн амын нэг онцлог бүлэг бол Тува хэлээр ярьдаг цаатан ард түмэн юм. Цаатан иргэд алслагдсан хөдөө орон нутаг амьдардаг бөгөөд төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа нь звөхөн хот суурин газарт хэрэгжих тул энэ бүлэгт хамааралгүй. Баруун бүсийн Баян-өлгий аймгийн төвд амьдран суудаг казак иргэд дээрх үйл ажиллагаанд хамрагдах боломжтой. Хүн амын бусад бүлгүүд Монгол хэлээр ярьдаг.

Талуудын оролцоог хангах төлөвлөгөөг нутгийн уугуул иргэдийн асуудлын талаарх БОНС-7- той нийцүүлэн зохих хэлэлцүүлэг явуулах нөхцөл бүрдүүлэх, ялангуяа казак иргэдийг бичил бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаанд амжилттай оролцуулахын тулд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд төслийн холбогдох мэдээлэл материалыг Монгол болон Казак хоёр хэл дээр гаргах, КОВИД-19 цар тахлын нөхцөлд тэдэнд мэдээллийг хүргэх, эргэх холоо үүсгэх орон нутгийн сувгуудыг бий болгоно. Ялгаатай соёлын хувьд зохистой байдлаар үйл ажиллагааг зохион байгуулна.

3. Талуудын оролцоог хангах хөтөлбөр

3.1. Төсөл бэлтгэх үед оролцогч талуудын оролцоог хэрхэн хангасан тухай

КОВИД-19 цар тахлын эрсдлийн түвшний улмаас төслийг нэн яаралтай боловсруулах шаардлага хэрэгцээ болон Монгол Улсын Онцгой байдлын комисс 2020 оны 4-р сарын 28-нд улс орныг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн хугацаа болон холбогдох арга хэмжээг 5-р сарын 31 хүртэл сунгах шийдвэр гаргасантай уялдуулан энэхүү төслийг Дэлхийн Банк батлахаас өмнө төслийн ТОХТ-г бүрэн утгаар нь боловсруулах боломж хязгаарлагдмал байв. Төслийн Оролцогч талуудын оролцоог хангах урьдчилсан төлөвлөгөөг төслийн үнэлгээний шатанд боловсруулан нийтэд нээлттэй болгосон бөгөөд энэ нь оролцогч талуудын оролцооны илүү цогц стратеги, төлөвлөгөө боловсруулах үйл явцын эхлэл болсон юм.

Энэхүү төсөл нь одоо хэрэгжиж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (ХЭДТ) дээр суурилан, үйл ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлэх бөгөөд ХЭДТ-ийн хувьд иргэд олон нийттэй зөвшилцөх үйл ажиллагаанууд хийгдсэн. КОВИД-19 цар тахлын нөхцөлд дээрх төслийн холбогдох зөвлөлдөх арга хэмжээг мөн шинэчлэх шаардлага үүсч байна. Энэхүү төслийн ТОХТ (болон БОННХТ)- ийн төсөл дээр ХНХЯ, ХХҮЕГ болон ТХН-ийн ажилтнуудын хүрээнд зөвлөлдсөн. ТХН нь зарим аймаг орон нутгийн хөдөлмөр, халаж үйлчигээний газар хэлтсүүдийн холбогдох хүмүүстэй утсаар зөвлөлдсөн болно. ХНХЯ болон ТХН—ийн санал энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд ХНХЯ-ны вебсайт дээр 2010 оны 5 сарын 21-нд байршуулж (<http://www.mlsp.gov.mn/nnews/736>) олон нийтэд ил болгосон.

3.1. б. Төслийн оролцогч талуудын хэрэгцээ ба тэдний оролцоог хангах арга, хэрэгслийн тухай

Үндэсний Онцгой комиссын шийдвэрээр хэсэгчилсэн өндөржүүлсэн бэлэн байдал, холбогдох арга хэмжээг 2020 оны 11 дүгээр сараас 2021 оны 04 дүгээр сар хүртэл үргэлжилсэн боловч зохицуулах, чиглүүлэх, техникийн баримт бичиг, саналыг

батлах гэх мэт оролцогч талуудыг нэгтгэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд зохицуулах уулзалтуудыг зөвшөөрөгдсөн хамгийн олон оролцогчидтойгоор зохион байгуулсан.

ТОХТ нь төслийн хэрэгжилтийн эхний үе шатанд болон төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ) -ийг боловсруулах үеүүдэд шинэчлэгддэг. Тодруулбал, төслийн Гомдол барагдуулах механизмыг БОУХ-ийг боловсруулах явцад илүү тодорхой болгосон. Төслийн ТОХТ нь нийтийн хүртээл болж, гурван шатны зөвлөлдөх уулзалтаар гол оролцогч талуудтай санал солилцсон. ХНХЯ-ны холбоглох албан тушаалтнуудтай ТОХТ-ийн талаар зөвлөлдөх сүүлийн хэлэлцүүлгийг 2021 оны 4 -р сард хийсэн бөгөөд үүний дагуу ГБМ-ын хэсгийг шинэчилсэн болно. Тодруулбал, ТХН-ийн ГБМ -д гүйцэтгэх үүргийг тодорхой болгосон.

Орон нутгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсүүд нутгийн иргэд болон оролцогч санхүүгийн байгууллагуудтай зохих зөвлөлдөх уулзалтуудыг хийнэ. Шаардлагатай бол орон нутгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсийн ажилтнуудад сургалт зохион байгуулах зөвлөх үйлчилгээ авч болно.

3.2. Төслийн оролцогч талуудын хэрэгцээ ба тэдний оролцоог хангах арга, хэрэгслийн тухай

КОВИД-19 цар тахлын гоц халдварт өвчний нөхцөл байдалд олон нийтийн дунд халдвар тархах эсвэл халдварлахаас урьдчилан сэргийлэхийн тулд олон нийттэй зөвлөлдөх үйл явцад онцгой болгоомжтой хандана. Ийм нөхцөлд харилцаа холбооны дараах сувгийг сонгон ашиглана. Үүнд:

- Олон нийтийн уулзалт, семинар, сонсгол зэрэг олон нийтийн цугларалтаас (үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй хорио цээрийн арга хэмжээ, хязгаарлалт, зөвлөмжийг харгалзсан) зайлсхийх;
- Уулзалт зөвшөөрөгдсөн бол фокус бүлгийн уулзалт гэх мэт цөөн хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах. Хэрэв ийм уулзалт зохион байгуулахыг зөвшөөрөөгүй эсвэл зөвлөөгүй тохиолдолд зөвлөлдөх бүх уулзалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах хүчин чармайлт гаргах;
- Харилцаа холбооны арга хэрэгслийн шинэ төрлүүдээр баяжуулж, олон нийтийн сошиал медиа, онлайн сувгуудыг ихэвчлэн ашиглах. Зорилго болон оролцуулах сонирхогч талуудын төрлөөс хамааран тэдэнд илүү боломжтой, тохиромжтой онлайн платформ, чат бүлгийг бий болгож ашиглах;
- Оролцогч талууд онлайн сувгуудыг ашиглах боломжгүй эсвэл тогтмол ашигладаггүй тохиолдолд харилцаа холбооны уламжлалт сувгуудыг (зурагт, сонин, радио, суурин утас, шуудан) ашиглах. Оролцогч талуудад холбогдох мэдээллийг хүргэх, тэдний санал хүсэлт, зөвлөмжийг авах боломжийг бүрдүүлэхэд харилцаа холбооны уламжлалт сувгууд үр дүнтэй байх боломжтой;
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд эсвэл төслийн үр шим хүртэгчидтэй шууд холбогдох шаардлагатай бол тухайн нөлөөлөлд өртсөн айл өрх тус бүртэй шууд харилцах сувгийг тодорхойлох, тухайлбал и-мэйл мессеж, шуудан,

онлайн платформ, олон нийтийн нийтлэг ашигладаг операторын суурин утас зэргийг ашиглах;

- Оролцоог хангахын тулд ашиглахаар санал болгож буй харилцаа холбооны арга хэрэгсэл тус бүрийн хувьд оролцогч талуудын санал хүсэлт, зөвлөмжийг авах эргэх холбоог хэрхэн үүсгэх, ашиглахыг тодорхой болгоно.

Дээр дурьдсан урьдчилсан арга хэмжээний дагуу оролцооны ялгаатай аргыг санал болгож байгаа бөгөөд оролцогч талуудын янз бүрийн хэрэгцээг дор дурдсан байдлаар хангана.

3.3. Мэдээллийг нээлттэй болгоход ашиглаж болох стратеги

| Төслийн үе шат | Зорилтот оролцогч тал | Танилцуулах мэдээллийн жагсаалт | Санал болгож буй арга, хугацаа |
|----------------|---|---|--|
| Хэрэгжилт | <p>Засгийн газрын байгууллагууд: Улсын Онцгой Байдлын Комисс, СЯ, ХНХЯ, ХХҮЕГ, орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Улаанбаатар хот, аймгийн түвшинд), Сонгон шалгаруулах хорооны гишүүд; Олон нийт: Ажил хайж буй иргэд, бичил бизнес эрхлэгчид; Ажил олоход бэрхшээлтэй байгаа иргэд; 18-34 насны залуучууд; МСҮТ, коллеж, их дээд сургууль төгсөгчид; Ядуу өрхүүд; Эмэгтэйчүүд; Хөдөө орон нутгийн хоршоо, нөхөрлөлийн гишүүд, аймгийн төвд амьдарч буй малчид; Иргэдийн бүлгүүд; Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчид; Аймгийн төвд амьдарч буй малчид, орон нутгийн хүн ам; үндэстний цөөнх; Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)</p> <p>Олон улсын байгууллагууд: НҮБХХ, ОУХБ, АХБ, ЕСБХБ, ГОУХАН зэрэг</p> | <ul style="list-style-type: none"> • Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө • Гомдол барагдуулах механизм /ГБМ/ ба үйл ажиллагааны журам • Төслийн талаарх тогтмол шинэ мэдээлэл | <p>Төслийн вебсайт ба фейсбүүк хуудас</p> <p>ХНХЯ ба ХХҮЕГ-ын вебсайт Улиралд нэг удаа</p> <p>Зурагт/радиоогийн хөтөлбөр (төсөл хэрэгжүүлэх бүх хугацааны туршид)</p> <p>Зурагт хуудас, сурталчилгааны хуудас, бусад хэвлэмэл материал, улиралд нэг удаа</p> |

3.4. Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө

Аргачлалын хувьд үйл ажиллагааг сонирхогч бүх талуудад хүртээмжтэй, соёл зан заншлын хувьд зохистой байдлаар зохион байгуулах нь чухал бөгөөд ингэснээр эмзэг бүлгийн иргэд төслийн үйл ажиллагаанд оролцох үр өгөөжийг хүртэх боломжийг олгоно. Мэдээлэл түгээх гол сувгууд нь ХНХЯ, Дэлхийн банкны вэбсайт, дотоодын телевиз, ФМ радио, аймгийн телевизүүд байна. Орон нутгийн ХХҮГ/Х-үүд төсөлд хамрагдсан хүмүүст шууд хэлбэрээр эсвэл вэбсайт

болон мэдээллийн самбараар дамжуулан мэдээлнэ. Хоёрдугаарт, хэвлэмэл материалыг сум, хорооны Засаг даргын тамгын газар, оролцогч санхүүгийн байгууллагуудын оффис (вэбсайтаа оруулаад) зэрэг олон нийтийн газарт байршуулна. ТХН нь Баян-Өлгий аймгийн ХХҮГ-тай хамтран Монгол болон Казах хэл дээр мэдээлэл, сурталчилгааны материалыг бэлтгэж түгээнэ.

| Төслийн үе шат | Зөвлөгөөн/ мессежний сэдэв | Ашигласан арга | Зорилтот оролцогч тал | Хариуцах эзэн |
|----------------|---|--|--|---------------|
| Бэлтгэл | <p><i>Байгаль орчин, нийгмийн хяналтын хураангуй, БОНУХ, ТОХТ Боловсруулах зорилго ба аргачлал</i></p> <p>ТОХТ-ний төслийг боловсруулж шаардлагатай хүн хүч, санхүүгийн нөөцийг тодорхойлох</p> | <p>Виртуал зөвлөгөөн, хэлэлцүүлэг Танилцуулга мэдээллээр хангах</p> <p>Виртуал зөвлөгөөн, хэлэлцүүлэг, харилцан мэдээлэл, баримт бичиг солилцох.</p> | <p>ХНХЯ</p> <p>ХНХЯ/ТХН</p> | ХНХЯ/ ТХН |
| Хэрэгжилт | <p>БОНУХ/ТОХТ-ний шинэчлэл ба хэрэгжилт</p> <p>Төслийн хэрэгжилтийн талаар тогтмол мэдээлэх, тайлагнах</p> <p>ГБМ-ын мэдээлэл, үүнд гарсан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн эсвэл дараагийн шатанд шилжүүлсэн гомдлын тоо гэх мэт</p> <p><i>БОНУХ</i></p> | <p>Биечлэн оролцох арга хэмжээг хориглосон үед виртуал зөвлөгөөн, хэлэлцүүлэг</p> <p>Баримт бичгийн төслийг ХНХЯ, ХНХ-ийн вэбсайт болон бусад нийгмийн сүлжээний сувгаар түгээх.</p> <p>ГБМ, түүний үйл ажиллагаа, хэрхэн хандах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан постер, тараах материал</p> | <p>Засгийн газрын байгууллагууд: Улсын Онцгой Байдлын Комисс, СЯ, ХНХЯ, ХХҮЕГ, орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Улаанбаатар хот, аймгийн түвшинд), Сонгон шалгаруулах хорооны гишүүд;</p> <p>Олон нийт: Ажил хайж буй иргэд, бичил бизнес эрхлэгчид; Ажил олоход бэрхшээлтэй байгаа иргэд; 18-34 насны залуучууд; МСҮТ, коллеж, их дээд сургууль төгсөгчид; Ядуу өрхүүд; Эмэгтэйчүүд; Хөдөө орон</p> | ХНХЯ/ ТХН |

| | | | | |
|--|--|--|---|--|
| | | | <p>нутгийн хоршоо, нөхөрлөлийн гишүүд, аймгийн төвд амьдарч буй малчид; Иргэдийн бүлгүүд; Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчид; Аймгийн төвд амьдарч буй малчид, орон нутгийн хүн ам; үндэстний цөөнх; Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)</p> <p>Олон улсын байгууллагууд: НҮБХХ, ОУХБ, АХБ, ЕСБХБ, ГОУХАН зэрэг</p> | |
|--|--|--|---|--|

3.5. Эмзэг бүлгийн иргэдийн санал бодлыг тусгах стратеги

Эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээ шаардлага, мэдээлэл болон үйлчилгээний хүртээмж, тэдний гэр, ажлын байр, нийгмийн орчинд тулгарч буй бусад бэрхшээл, санаа зовоож буй асуудлуудыг ойлгохын тулд төсөл тэдгээр оролцогч талуудын оролцоог хангаж ажиллана. Төсөл хэрэгжүүлэх явцад эмзэг бүлгийн иргэдийг үр дүнтэй, бүтээлч оролцоог хангаж, тэдэнтэй харилцаа холбоотой ажиллах стратегийг нарийвчлан боловсруулж ашиглана ⁶.

⁶ Жишээлбэл: (i) эмзэгтэйчүүд: олон нийтийн оролцоог хангах багийн бүрэлдэхүүн жендерийн тэгш байдлыг хангасан байх, багийн удирдлагад эмзэгтэйчүүдийн манлайллыг дэмжих, гэртээ цалингүй ажил эрхэлдэг эмзэгтэйчүүдийн оролцоо боломжийг хангахын тулд онлайн хэлбэрээр болон биечлэн уулзаж авах судалгаа боловсруулах, бусад оролцоо хангах бусад үйл ажиллагааг зохион байгуулах; иргэдтэй биечлэн уулзах тохиолдолд хүүхэд харах үйлчилгээ, тээврийн хэрэгсэл, аюулгүй байдлыг хангахад анхаарах; (ii) Жирэмсэн эмзэгтэйчүүд: жирэмсэн эмзэгтэйчүүдэд зориулан эрүүл ахуйн үндсэн ойлголт, халдвараас урьдчилан сэргийлэх, тэдний сонирхож буй асуулт, санаа зовоосон зүйлсийн талаар хаанаас хэрхэн тусламж үйлчилгээ авч болох талаар сургалтын материал боловсруулах; (iii) Өндөр настан, өвчтэй хүмүүс: тэдний тусгай хэрэгцээ шаардлагын талаар мэдээлэл боловсруулж, тэд яагаад илүү эрсдэлтэй, өөрсдийгөө хэрхэн асрах тухай тайлбарлах; өөрийн эрүүл мэндийн статусаас хамаарч өөрийгөө хамгаалж сэргийлэх талаарх мессежийг биечлэн хийж үзүүлэх (амьдрах орчны байгууламжийг хэрхэн ашиглах гэх мэт); тэдний гэр бүлийн гишүүд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид, асран хамгаалагчдад чиглэсэн тайлбар мэдээлэл өгөх; (iii) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд: брайл, том үсгээр хэвлэх гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэл өгөх; тайлбарыг бичиж оруулсан эсвэл дохионы хэлээр орчуулсан видео бичлэг, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулан текстийн тайлбар, технологийн тусламж ашигладаг хүмүүст зориулсан онлайн материал гэх мэт харилцаа холбооны олон хэлбэрийг ашиглахыг санал болгох; мөн (iv) Хүүхэд: мэдээлэл, харилцааны материалыг хүүхдэд ээлтэй байдлаар боловсруулах, эцэг эхчүүдэд өөрсдийн сэтгэл санааны байдлыг удирдаж, хүүхдүүдээ тайван байж өөрийгөө удирдахад нь туслах үр чадварыг олгох.

3.6. Оролцогч талуудад тайлагнах

Төслийг боловсруулах явцад төслийн талаар, түүний дотор байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага, оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө болон гомдол барагдуулах механизмын хэрэгжилтийн талаар оролцогч талуудыг байнга мэдээллээр хангаж тайлагнана.

4. Оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөөц ба үүрэг хариуцлага

4.1. Нөөц

Оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг ХНХЯ нь ТХН-ээр дамжуулан хариуцна. ОТОХТ-г шинэчлэх, хэрэгжүүлэх зардлыг төслийн Бүрэлдэхүүн хэсэг 3, төслийн удирдлагын төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Удирдлагын чиг үүрэг, хариуцлага

Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт: ХНХЯ нь төслийн хэрэгжилтийг бүхэлд нь хариуцах бөгөөд үүний дотор ерөнхий зохицуулалт, үр дүнгийн хяналт мониторинг хийх, Дэлхийн банкттай төслийн санхүүгийн болон байгаль орчин нийгмийн нөлөөний хамгааллын асуудлаар харилцах зэрэг орно. Төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ТХН-нд дэмжлэг үзүүлж, ТХН-ийн ажилтнуудыг сургах, үүнд ТОХТ ба БОНУХ-ний хэрэгжилтийг удирдан хянах, тухайлбал ХХҮЕГ-ын дэмжлэгтэйгээр хөдөлмөр, халамж үйлчилгээний газар/хэлтсүүд бичил бизнес эрхлэгчдийг сонгон шалгаруулсан үйл ажиллагааг түүвэрлэн хянаж мониторинг хийнэ. Оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааны хэрэгжилтийн асуудлаар хоёр жил тутамд явцын тайлан бэлтгэж баримтжуулах ба Ассоциацид хүргүүлнэ.

5. Гомдол барагдуулах механизм (ГБМ)

Гомдол барагдуулах механизмын гол зорилго нь гомдлыг цаг алдалгүй, бүтээлчээр, үр ашигтай шийдвэрлэхэд туслах явдал юм. Тодруулбал ГБМ нь шударга, үр дүнтэй, урт хугацааны үр өгөөжтэй байх ил тод, хариуцлагатай үйл явц байна. Аливаа алдаа доголдлыг засч залруулахад туслах олон нийттэй зөвлөлдөх, хэлэлцэх үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болох итгэлцэл, хамтын ажиллагааг ГБМ нь бий болгоно. Тодруулбал, ГБМ нь:

- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд гомдол гаргах эсвэл төсөл хэрэгжүүлэх явцад гарсан аливаа маргааныг шийдвэрлэх сувгийг бий болгох;
- Гомдол гаргагчдын гомдлыг барагдуулах зохих талуудын харилцан хүлээн зөвшөөрсөн арга хэмжээг хэрэгжүүлэх, гомдол гаргагч сэтгэл ханамжтай байх
- Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хандахаас зайлсхийх.

5.1. ГБМ-ын тодорхойлолт

Гомдол хүлээн авах сувгууд

Төслийн ГБМ нь доорх Хүснэгт 2-т заасан дөрвөн сувгаар хэрэгжинэ. Гомдол гаргагч нь өөрийн гомдлыг чөлөөтэй илэрхийлэх болон аль сувгаар дамжуулан гомдол гаргахаа сонгох эрхтэй бөгөөд хүлээн авах суваг бүр гомдлыг хүлээн авна.

| Хүснэгт 2. Төслийн ГБМ-ийн сувгууд | | | |
|---|---|--|--|
| <p>Аймаг дүүргийн ХХҮГ, хэлтэс: Холбоо барих:</p> <p>Хариуцсан ажилтан</p> <p>Имэйл: Холбоо барих бүх мэдээлэл бүхий ХХҮГ, хэлтсийн вэбсайттай холбогдох линкийг доор буй ХХҮЕГ-ын вэб хуудаснаас авч болно: http://hudulmur-halami.gov.mn/</p> | <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ):</p> <p>Холбоо барих: Гомдлын ажилтан</p> <p>Имэйл: info@hudulmur-halami.gov.mn</p> <p>Вэб хуудас: http://hudulmur-halami.gov.mn/</p> <p>Утас: +976 77315091</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон</p> | <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)</p> <p>Холбоо барих: ХШҮ ажилтан</p> <p>Төсөл өөрийн www.mesp.mn вэб хуудсан дах гомдол хүлээн авах цонхоор дамжуулан гомдол саналыг хүлээн авна.</p> <p>Мөн гомдлыг дараах утас, хаягаар хүлээн авна:</p> <p>Утас-75057570</p> <p>Имэйл: info@mesp.mn</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, Сан бизнес төв, 5 давхарт, 501 тоот</p> | <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)</p> <p>Холбоо барих: Хариуцсан ажилтан</p> <p>Имэйл: info@mlsp.gov.mn</p> <p>Вэб хуудас: www.mlsp.gov.mn</p> <p>Утас: +976-51-261553 ор +976-51-267635</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нэгдсэн үндэстний гудамж</p> |

ТХН нь төслийн вэбсайт, имэйл хаяг болон утсаар өргөдөл, гомдлыг хүлээж авна. ТХН нь төслийн оролцогч талуудад мэдээлэл хүргэх төслийн вэбсайттай болно. Вэбсайт нь төслийн үр шим хүртэгчдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг бүртгэхэд зориулагдсан тусгай цэстэй байна.

Өргөдөл, гомдлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бичгээр, амаар болон цахим хэлбэрээр гаргаж болно. Бичгээр гаргасан гомдолд цахим хэрэгслээр ирүүлсэн гомдлыг хамааруулна. Холбогдох үндэсний хууль, тогтоомжийн дагуу бичгээр гаргасан гомдолд овог, нэр, оршин суугаа хаяг, шуудангийн хаягийг тодорхой бичнэ. Засгийн газрын шууд утсаар (уг системийн дагуу өргөдөл, гомдлыг ХНХЯ, ХХҮЕГ, НДЕГ болон тэдгээрийн салбар хэлтсүүд рүү дамжуулдаг) болон дээрх дөрвөн сувгийн утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг амаар гаргасан гомдол гэж үзнэ.


Төсөлд ямар төрлийн гомдлыг ямар сувгаар гаргахыг тодорхой заагаагүй. Үндэсний хууль, тогтоомжид заасан ерөнхий зарчим үйлчлэх бөгөөд өргөдөл, гомдлыг дараах байдлаар гаргана. Үүнд i) Гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтныг харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтанд, ii) харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, iii) эсхүл гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллагад гаргана.

Гэсэн хэдий ч гомдол гаргагч аль ч сувгаар гомдол гаргах эрхтэй бөгөөд аль ч асуудлаар, аль ч хэрэгслийг ашиглан гомдол гаргаж болно. Гомдол гаргагч нь гомдлыг шийдвэрлэсэн байгууллагын шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд хуулийн дагуу дээд шатны байгууллага болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Төслийн хүрээн дэх үр дүнтэй ГБМ-ийн гол зарчим нь: i) Засгийн газрын ГБМ-ыг боломжийн хэмжээнд ашиглах; ii) Талууд төслийн вэбсайтаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд өөрсдийн ГБМ-аар дамжуулан шалгаж, шийдвэрлэх гомдлыг төрөл, сэдвийг тохиролцоно.

ГБМ-ийн шат дараалал

Өргөдөл, гомдлыг бичгээр эсвэл амаар (жишээлбэл утсаар) хүлээн авах бөгөөд тухайн өргөдөл, гомдлыг хүлээж авч буй сувгийн ГБМ-ийн өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ. ОБҮДХЭТ-ийн ГБМ нь дараах үе шаттай байна. Үүнд:



ТХН-ийн ХШҮ-ний ажилтан болон холбогдох байгууллага бүрийн өргөдөл, гомдол хариуцсан ажилтан нь өргөдөл, гомдлыг бүртгэх, гомдол гаргагчид анхан шатны хариу өгөх, гомдлыг шийдвэрлэх үйл явцыг зохицуулах, гомдол гаргагчид эцсийн хариу өгөх болон ГБМ-ийн үйл ажиллагааны талаар тайлагнах үүрэгтэй.

Гомдол барагдуулах механизм дах ТХН-ийн үүрэг.

ТХН нь хуулиар үүрэг хүлээсэн байгууллага биш бөгөөд түүний ажилтнууд нь төрийн албан хаагчид биш юм. Иймээс ТХН нь өргөдөл, гомдлыг дангаар бие даан шийдвэрлэх эрхгүй. Гэхдээ ТХН нь ГБМ-ийн хүрээнд дараах үүрэгтэй байна. Үүнд:

- a) ГБМ-тай холбоотой тодорхой мэдээлэл, сурталчилгааны ажлыг дэмжих болон хэрэгжүүлэх;
- b) Өргөдөл, гомдлын сувгийг тасралтгүй ажиллуулах, өргөдөл, гомдлын

- дэвтрийг хөтлөх,
- с) өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх (ХНХЯ, ХХҮЕГ, болон аймаг, дүүргийн ХХҮХ), гомдлыг барагдуулах байгууллагын талаар гомдол гаргагчид мэдэгдэх;
- д) Холбогдох бүх байгууллагуудын ГБМ-ын гол цэгүүдтэй холбогдож өргөдөл, гомдолтой холбоотой мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх болон ГБМ-ын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн талаар тайлагнах.

6. Хяналт ба Тайлагналт

6.1. Хяналт мониторингийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг оролцуулах

ТОХТ-ий хэрэгжилтийг ТХН хариуцна. Орон нутгийн түвшинд ХХҮГ/Х мөн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд ГБМ-аар хүлээн авсан гомдлын тоо, шийдвэрлэсэн арга хэмжээний талаарх мониторинг хяналтын тайлан бэлтгэж хоёр жил тутамд ХХҮГ/Х болон ТХН-д хүргүүлнэ.

6.2. Оролцогч талуудад тайлагнах

Төслийг хэрэгжүүлэх явцад тус төлөвлөгөөнд тусгасан мэдээллийг төслийн хэрэгжилтийн сүүлийн үеийн мэдээллээр баяжуулан, төсөл боловсруулах шатанд төлөвлөж байсан оролцооны аргууд нь зохистой, үр дүнтэй арга хэвээр байгаа эсэхийг хянаж, тогтмол шинэчлэн боловсруулж байна. Төслийн үйл ажиллагаа, хэрэгжилтийн хуваарьтай холбоотой томоохон өөрчлөлтүүдийг ОТОХТ-д тухай бүр зохих ёсоор тусгана. Олон нийтээс ирүүлсэн гомдол, лавлагаа, холбогдох кейсүүд, тухайн гомдлын дагуу авч хэрэгжүүлсэн засаж залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг хариуцсан ажилтнууд нэгтгэж, төслийн удирдлагад танилцуулна. Сар тутмын тайлан нь хүлээн авсан гомдол, мэдээлэл авах хүсэлтийн тоо, агуулгын аль алиныг үнэлэх механизмыг бүрдүүлэхийн зэрэгцээ тэдгээрийг цаг тухайд нь үр дүнтэй шийдвэрлэж чадаж буй эсэх төслийн чадварыг үнэлнэ. Тухайн жил төслийн хүрээнд хийгдсэн олон нийтийн оролцооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг оролцогч талуудад дараах хоёр арга замаар мэдээлэх боломжтой. Үүнд:

- Оролцогч талуудтай хамтран ажилласан төслийн үйл ажиллагааны жилийн тайлан, хэвлэмэл материал,
- Доор дурдсан үзүүлэлтийн дагуу Гүйцэтгэлийн Шалгуур Үзүүлэлтэд (ГШҮ) тавих хяналт

| # | ҮЗҮҮЛЭЛТ | ХАРИУЦАХ ЭЗЭН |
|---|---|-------------------|
| 1 | Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд зориулсан төслийн ГБМ-ын талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн хэвлэмэл материалын тоо | ХНХЯ, ХХҮГ,Х, ТХН |
| 2 | Дэд бүрэлдэхүүн 2.1-ийн сурталчилгаанд ашигласан, давтамжийн тоо | ХНХЯ, ХХҮГ,Х, ТХН |
| 3 | ХНХЯ, ТХН болон ХХҮГ/Х-ийн сувгаар тайлант хугацаанд хүлээн авсан олон нийтийн гомдол хүсэлтийн тоо | ХНХЯ, ХХҮГ,Х, ТХН |
| 4 | ТХН-ээс ХХҮГ/Х-д ГБМ-ын талаар зохион байгуулсан сургалтын тоо | ТНХ |

